


МОНГОЛ СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН
Монгол Улсын Их Сургууль

АСТА МОНГОЛСА

Боть 15 (411)

Монгол Улсын Их Сургуулийн
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

Эрхэлсэн
Ж.Бат-Ирээдүй



МУИС ПРЕСС ХЭВЛЭЛИЙН ГАЗАР



INSTITUTE FOR MONGOLIAN STUDIES
National University of Mongolia

ACTA MONGOLICA

Volume 15(411)

ANNUAL JOURNAL

National University of Mongolia

Edited by
J. Bat-Ireedui

Монгол судлалын хүрээлэнгийн ACTA MONGOLICA сэтгүүлийн зөвлөл

Эрхлэгч:
Гишүүд:

Ж.Бат-Ирээдүй
Алан Ж.Сандерс (Англи)
Д.Заяабаатар (Монгол)
И Сөн Гю (БНСУ)
Ли Нарангоо (Австрали)
Удо Б.Баркманн (ХБНГУ)
Хашимото Масарү (Япон)
Хитоши Күрибаяаши (Япон)
Чимэддорж (БНХАУ)
С.Чулуун (Монгол)
Юү Вон Сү (БНСУ)

Ulaanbaatar
2014

ISSN 2074-1014

*Их Британийн нэрт монголч эрдэмтэн Чарльз Баудены
90 насны ойд энэхүү дугаарыг зориулав.*



**ИХ БРИТАНИЙН НЭРТ МОНГОЛ СУДЛААЧ,
АКАДЕМИЧ ЧАРЛЬЗ БАУДЕНЫ АМЬДРАЛ,
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН ТУХАЙ**

Ж.Бат-Ирээдүй

Энэ 2014 онд Бритиш академийн жинхэнэ гишүүн, хүндэт профессор, нэрт монголч эрдэмтэн Чарльз Бауден гуайн мэндэлсний 90 насны ой тохиож байна. Монголчууд, монгол судлаач нар, монгол судлалынхан энэ хүний намтар түүх, ном бүтээлийн тухай энэ жил ярих учиртай. Тийм учраас МУИС-ийн Монгол Судлалын Хүрээлэнгээс “Монгол судлалын шинэ чиг хандлага II” хурлыг түүний мэндэлсний тэгш ой буюу 90 насны ойд нь зориулан хийсэн билээ.

Завшаанаар үүнийг үгүүлэгч өчүүхэн миний бие 1991-1995 онд түүний удирдаж байсан Английн Лондоны их сургуулийн “Дорно дахин, Африкийн судлалын сургууль”-д зочин багшаар ажиллахдаа энэ хүнтэй нүүр тулан уулзаж, бас хамтран ажиллаж, байнгын харилцаатай, ойр дотно байх завшаан олсон юм. Түүний монгол-англи толь бичиг хийх явцдаа үгийн утга чанар асууж надад бичиж байсан олон арван захидал хадгалагдаж байгаа бөгөөд зөвхөн нэг захидлыг энд дуртган үзүүлэв.

Мөн Бауден гуай манай Л.Чулуунбаатар багшийг Лондоны Их Сургуульд багшилж байхад хамтарч ажиллаж байсан тухайгаа “Mongolian-English Dictionary” номынхоо оршилд бидний тухай¹ дурдан бичиж өгсөн нь өчүүхэн бидний хувьд том урам өгсөн аз завшаантай хэрэг болсон билээ. Мөн Л.Чулуунбаатар багш Ч.Бауден гуайн тухай “Монголч эрдэмтэн Чарльз Бауден”² өгүүллийг 2009 онд бичжээ.

Манайхан түүний 1968, 1989, 2002 онд хэвлүүлсэн «Орчин үеийн монголын түүх»-ийн ном, 1997 онд хэвлүүлсэн «Монгол - Англи толь бичиг»-ээр нь сайн мэдэх учиртай. Мэдээж монгол судлаачид бол бүгд түүнийг дэлхийд нэртэй ахмад эрдэмтэн хэмээн хүндлэн залбирдаг билээ.

Энэ өгүүлэлд³ Чарльз Бауден гуайн эрдэм судлалын ажлыг дүгнэх цэгнэх үнэлэх гэсэн зорилго тавьсангүй, харин монгол судлалын залуу халаа, залуу эрдэмтэн судлаач нарт түүний амьдрал, ажил үйлс, монгол судлалаар хийсэн эрдэм номынх нь их ажлын зах зухаас нь аль болох сонин содон талаас нь цухас боловч танилцуулахаар зорьсон юм.

Алдарт монголч эрдэмтэн Чарльз Бауден гуай 1924 оны 4 сарын 22 нд Английн зүүн урд зүгийн жижигхэн хот Вэймоут (Weymouth)-д төрж өссөн хүн. Тэрбээр 90 насыг зооглож байгаа ч бие тэнхлүүн, ухаан цэлмэг, эрдэм судлалын ажлаа үргэлжлүүлсээр Лондон хотын Хэйтров олон улсын нисэх буудлын ойролцоо амьдран сууж байна.

Түүний аав нь тухайн үеийн 5-14 настай хүүхдүүдийн сурдаг ерөнхий боловсролын сургуульд багш байсан бөгөөд яг тийм ижил төрлийн сургуульд хүүгээ сургажээ. Тэгээд 1941 онд азаар Кембрижийн их сургуулийн босгыг алхан оржээ. Тухайн үеийнхээ Оксфорд, Кембрижийн Их Сургуулиудад элсэн орсон анхны хүүхдүүдийн нэг байжээ. 1943 оны эхээр цэргийн албанд зарлан дуудах авахаасаа өмнө франц, герман хэл сурч байсан гэнэ.

Их сургуульд нэг жил гаруйхан болоод цэрэгт морджээ. Цэргийн алба хаших үедээ далайн цэрэгт алба хааж, япон хэлний курст суралцжээ. 1943 оны дундуур Шотланд руу цэрэгт шилжиж мөн япон хэлний 6 сарын дамжаанд суужээ. Үүний дараа албан хаагч болж Цейлонд япон хэлний орчуулагчаар явсан аж. Дайны сүүлийн жилүүдэд тэрбээр Хонг Конг, Японд хэдэн сараар алба хаан суужээ. Японд Хирошимагийн ойролцоох Күрэ гэдэг газарт алба хааж хэд хэдэн удаа тэнд зочилжээ.

Дайны үеийн туршлага түүнийг дорно дахиныг сонирхох сонирхолыг түрүүлсэн бөгөөд 1946 онд энгийн амьдралд шилжсэний дараа 1947 онд франц, герман судлалаар баклаврын зэргээ хамгаалжээ. Үүний дараа

¹“I owe great debt of gratitude to Mr. L.Chuluunbaatar of SOAS and the State University of Mongolia for his generous help over a period of nearly two years in answering my questions and trying to remove my difficulties. In the last stages of the work I received help from his successor Mr.J.Bat-Ireedui. Needless to say, I alone am responsible for all remaining infelicities in the present work.” Charles R.Bawden, “Mongolian-English Dictionary”, Kegan Paul, 1997, I-II pp.

²Л.Чулуунбаатар, “Монголч эрдэмтэн Чарльз Бауден”, МУИС-ийн МХСС-ийн “Монгол судлал эрдэм шинжилгээний бичиг”, №30(318), 2009, 135-139 дэх тал

³Ж.Бат-Ирээдүй, “Монгол хэл бичиг: утга, соёл хэрэглээ”, Уб., 2013, 224-29 дэх тал

шууд л хятад хэл, хятад судлал сонирхож эхэлсэн бөгөөд энгийн албан хаагч болж засгийн газарт Английн гадаад яамны германы хэлтэст түр зуур ажиллажээ. 1948 онд ажлаасаа гарч Кембрижийн их сургуульдаа хятад судлалаар сурах болжээ. 1950-1951 онд мөн Хонг Конгод очиж хятад хэл сурч бүр Бээжин хот орохоор төлөвлөж байсан боловч Солонгосын дайнаас болж энэ хүсэл мөрөөдөл нь бүтэлгүйтэж буцаж ирээд 1952 оны эхэн хүртэл хятад судлалаараа ажиллажээ. Тэрбээр Унгар гаралтай Англид суурьшиж Кембрижийн Их сургуульд багш асан Д.Синорын сайн шавь байсан аж.

Энэ үеэс монгол судлал руу эргэлт буцалтгүй орсон гэж бүрэн хэлж болно. Энэ бол түүний амьдралдаа хийсэн том эргэлт байжээ. Учир нь тухайн үед тэрбээр дөнгөж гэрлэж, нэг хүүтэй болчихсон, амьдрал эхэлж байсан авч, Монголтой холбоотой ямар ч ажил алба байхгүй ийм үе байжээ. Мөн Монгол, Английн хооронд ямар ч харилцаа холбоогүй, бие биенээ маш бага мэддэг аль ч шугамаар харилцаа холбоо, судалгаа байдаггүй байсан үе байж. Тэрбээр «бидний хооронд дипломат харилцаа тогтоогүй, монголын эрдэмтэдтэй харилцах боломжгүй, тэдний нэрийг ч бараг мэддэггүй байсан. Монгол хэлийг Кембрижийн их сургуульд маш энгийн төвшинд заадгийг эс тооцвол өөр ямар ч сургалт байсангүй» гэж ярьж байсан.

Ингээд тэрбээр Кембрижийн их сургуулийн номын сангаас Өвөр Монголд хэвлэгдсэн Чингис хааны цадигийг олсон бөгөөд орчуулж, редакторлажээ. Сүүлд Б.Ринчен гуай түүнээс “та тийм сайн мэддэг номон дээрээ их цаг зарсаны учир юусан билээ” хэмээн асуухад нь Бауден гуай “үүнээс өөр үзэх юу ч байхгүй байсан юм чинь одоо өөр юу хийх вэ дээ” гэж хариулжээ. Түүний докторын зохиол нь 1955 онд «Монгол түүх бичлэгийн Алтан товч» нэртэй Германы Вейсбаденд хэвлэгджээ.

Доктороо хамгаалсны дараа нэг жил шахам ажилгүй суужээ. Азаар энэ үед Копенгагений их сургуулийн профессор К.Грөнбэх, Германы Гёттингений их сургуулийн др Вальтер Хайссиг нартай танилцахад тэд түүний ажлыг маш их сонирхжээ.

Др В.Хайссиг гуай түүний «Алтан товч»-ийг Гёттингений Азийн судлалын сэтгүүлд хэвлүүлэхээ амлаж, Грөнбэх Копенгагенд гурван сар ажиллаж Жавзандамба хутагтын намтарыг орчуулахыг санал болгожээ. Мөн Гёттингэнд “Алтан товч”-ийг хянах редакторлах ажлаар уригдсан байна. Энэ бол түүний «академик карьер»-ийн эхлэл нь байжээ.

Ч.Бауден гуай 1955 оноос Лондоны их сургуулийн Дорно дахин, африк судлалын сургуулийн дорно дахины салбарт багшаас ахлах багш, профессор болж улмаар 1968 оноос салбарын буюу Дорно дахины тэнхимийн эрхлэгчээр тасралтгүй 14 жил ажиллаж, 1982-1984 онд тус сургуулийн проректорын албыг хашиж байгаад тэтгэвэртээ гарсан билээ. Тэрбээр 1984 онд Лондоны их сургуулийн хүндэт профессор, 1985 онд Британийн Академийн гишүүнээр сонгогдсон юм.

1956 онд дайны өмнөхөн Өвөр Монголоос цуглуулсан эх бичиг, тэнд байх монгол номын каталоги хийх ажлаар Копенгагенд Грөнбэхтэй ажиллаж байж.

Ч.Бауден гуай анх 1958 онд тухайн үед Төв Азийг судлах хааны нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга, Английн хааны газарзүйн нийгэмлэгийн гишүүнээр олон жил ажилласан чөлөөнд гарсан ахмад Д.Смоолвүүд гуайтай хамт Монголд ирсэнээр Монголтой хэлхээ холбоотой болж, эрдэмтэн судлаач нартай танилцжээ.

Монголын энх тайвны хорооны урилгаар ирсэн тэд хөдөө явж, монголын ахуй амьдралтай танилцаж үзээд, “энэ айлчлалд нэгээс хоёр коммунист биш барууныхныг багтаасан нь монголын тухай барууны ертөнцөд танилцуулах гэсэн зорилготой байсан байх» гэж тэрбээр ойлгожээ. Энэ аялал нь Британийн коммунист Игор Монтау гэдэг хүний хүчин чармайлтаар бүтсэн бөгөөд тэрбээр сүүлд «Хөх тэнгэрийн орон» ном бичсэн ажээ.

Тэр үед Монгол орноор 3 долоо хоног айлчлахдаа олон газар орон үзэж, Архангайн Цэцэрлэг, Өвөрхангайн Хужирт, Хархорин, мөн Налайхаар оржээ. Роберт Рупений «Монголчууд ба хорьдугаар зуун» номд смоолвууд, Роберт Рупен, Бауден гуай нарын Налайхын уурхайд хамт авахуулсан зураг байдаг юм байна билээ. Энэ удаагийн аялал судалгаа шинжилгээний чиглэлтэй байгаагүй ч тэрбээр академич Б.Ринчен, Х.Пэрлээ, Д.Сэр-Оджав, Т.Пагва нартай анх уулзаж танилцжээ.

Ч.Бауден гуай ер нь бол монгол хэлээр сүрхий зөв, эмх цэгцтэй сайн ярьдаг ярианы хэл бас их сайтай эрдэмтэн бөгөөд харин тухайн үед тэрбээр монгол хэлээр ярьж чаддаггүй байсан, Монголд англиар ярьдаг хүн ховор байсан учир Чогсом гэж франц хэлтэй зураач, герман хэлтэй зохиолч Д.Наваан-Юндэн нараар орчуулуулж байжээ. Буцах замдаа тэрбээр европоор дайрч Копенгагенд өөрийн каталоги хийсэн эх бичгийн хэдэн зуун микрофильмээ авч ашиглах эрхтэй болж энэ хэрэглэгдэхүүн дээрээ түшиглэн зурхай болон мэргэ төлөгийн судалгаа хийх бололцоотой болжээ. Мөн энэ сэдвээр Германы их сургуульд лекц уншиж, Азийн судлалын гол гол сэтгүүлд сайн сайн өгүүлэл нийтлүүлжээ.

Ч.Бауден гуайн Монгол Улсад хийсэн хоёр дах аялал нь 1959 онд болсон «Олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар их хурал» байсан бөгөөд хуралд оролцохоор ирэх очих замдаа хоёуланд нь галт тэргээр аялжээ. Энэ хурлын үеэр монголч эрдэмтэн Оросын Ю.Н.Рерих, Г.Д.Санжеев, БНХАУ-ын Эрдэнэтөгтох, Чингэлтэй, Германы Поул Рачневский, Польшийн С.Калужински, Унгарын Урай Кохмали Каталан, Чехославакийн Павел Поуха, Италийн Пентти Аалто, Японы Г.Абэмацү, Озава Шигио, К.Сакамото, Энэтхэгийн Рагу Вира

нартай⁴ танилцжээ.

Тэрбээр 1968 он хуртэл монголд ирээгүй бөгөөд энэ хүртэл «Монголын орчин үеийн түүх» номоо бичиж байсан аж. Энэ үед монголын тухай мэдээлэл олж үзэхэд үнэхээр хүнд байжээ. 1962 онд Лондоны их сургуульд монголын тухай лекц уншихаар томилогдож 1970 онд профессор болжээ.

1968 оны намар өвлийг Монголд өнгөрөөсөн байна. Энэ үеэр хоёр удаа хөдөө явахаар төлөвлөж ШУА-ийн профессор Ж.Цолоо гуайтай хамт баруун аймгуудаар явсан байна. Энэ тухай Ж.Цолоо гуай “Хэл зохиолын хүрээлэнд хагас зуу илүү жил” номдоо “... Ховд аймгийн Буянт, Мянгад, Манхан суманд эрдэм шинжилгээний албан томилолтоор хагас сар ажилласан юм. Хүүхэд насаа өнгөрүүлсэн Зэрэгийн голд би Английн монголч эрдэмтэн Ч.Бойдэн, сэтгүүлч А.Дашнямын хамт 1968 оны намар очиж хэд хонов. Бид гурав Зэрэг голын бригадын төв, хуучин хийдийн Шавар гэж нэршсэн сууринд Баясгалант амьдрал нэгдлийн 3-р бригадын контор, улаан буланд байрлаж Нусхай овогт 16 настай үлгэрч хүү Ганданповронгоос “Хүн долоон одны тухай үлгэр”, “Эзэн тэнгэр хаан тууль” сурвалжилж бичсэн болно. Мөн Зэрэг голын Наймдаан Шандад намаржиж байгаа тэмээчин Гүнчин Л.Баатарын зочилж, тэмээний хоормог анх удаа амтархан ууж, эмнэг булигиулж тоглуулахыг үзэв.”⁵ хэмээн бичжээ.

Мөн тэр намар Хөвсгөл руу явахаар төлөвлөж байсан боловч цаг агаарын байдлаас болж оронд нь Дархан явсан нь үзэх юмаар бага, сонирхолгүй байжээ. Бусад цагт нь улсын төв номын санд сууж гар бичмэл, эх бичгээ татаж, хуулж, монгол ярианы хэлний дадлагын хичээлээ академийн Э.Вандуй гуайтай хийж байжээ.

«Тухайн үеийн нийгэм, улс төрийн нөхцөл байдлаас болж жирийн монгол хүмүүстэй уулзахад их төвөгтэй байсан. Улаанбаатар зочид буудалд амьдарч байхад намайг маш олон хүмүүстэй танилцахыг тасалдуулж, уулзах боломжгүй болгож байсан шүү» гэж тэрбээр надад хуучилж билээ.

1960-аад оны үеэс тэрбээр «Монгол-Англи толь бичиг»-ээ эхэлсэн бөгөөд маш их анхаарал тавьж тухайн үед Лондоны Их Сургуулийн Дорно дахин, Африкийн Сургуульд, сүүлд Бонны их сургуульд ажиллаж байсан Магадбүрэн Халтодтой хамтран ажиллаж байсан боловч шуудангаар харилцаж толь бичгийн ажил хийх машид төвөгтэй байжээ. Гэтэл 1978 оны 8 дугаар сард Магадбүрэн залууханаараа зуурдаар өөд болж түүний хийсэн зүйлүүд үрэгдэж толь бичгээ ганцаараа дуусгахаас өөр замгүй болжээ.

Энэ толь бол түүний монгол хэлшинжлэлд оруулсан томоохон хувь нэмэр, суурь судалгаа болох бөгөөд түүний 25 жилийн уйгагүй хөдөлмөр шингэсэн эрдэм шинжилгээний томоохон бүтээл болсон билээ. Уг толь бичигт хамгийн өргөн хэрэглэгддэг 3000 орчим үгийг шилж сонгон багтааж, толгой үгийн үүр, агуулгыг өнөөдөртөө лав ямар ч толинд байхгүй дэлгэрэнгүй хийсэн нь эрдэм шинжилгээ, практикийн маш чухал ач холбогдолтой болжээ. Мөн дэлхийн олон орны монгол судлаачид өндрөөр үнэлж маш сайн толь бичиг болсон гэж хэлж байхыг олонтоо сонсож байлаа.

Энэ он жилүүдэд тэрбээр шашин шүтлэг түүх, соёл, хууль ёсны тухай, газрын харилцааны тухай хэд хэдэн өгүүлэл, ном бичжээ. Тэрбээр 1978 оноос Английн Кристианы төлөөлөгчид Буриад Монголд (1818-1841) сэдвээр судалгаа хийсэн нь хамгийн сонирхолтой судалгаа байсан гэж өөрөө боддог юм билээ. Мөн бөөгийн шашны тухай хэд хэдэн томоохон өгүүлэл бичиж, “SHAMANS, LAMAS AND EVANGELICALS: THE ENGLISH MISSIONARIES IN SIBERIA” монограф хэвлүүлжээ. Бид түүний эрдэм шинжилгээний өгүүлэл⁶ бүтээлүүдээс өөрсдийн эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд цувралаар орчуулан хэвлүүлж, эрдэмтэн судлаач, ялангуяа залуу судлаачдын хүртээл болгоход анхаарч байгааг энд дурдалтай.

Хэл утга зохиолын чиглэлээр хийсэн бүтээлийн дотор 2003 онд Лондонд хэвлүүлсэн «Монголын уламжлалт уран зохиолын дээжис»⁷ (Anthology of Mongolian Traditional Literature) ном чухал байртай. Энэ номд 13- 19 дүгээр зууны монголын эртний уран зохиолыг англи хэлээр орчуулсан нь эрээд олдохгүй эрдэнэ, сураад олдохгүй сувд болсон билээ. Эл бүтээлд Монголын түүхтэй холбоотой аман яриа, түүх бичлэг, үлгэр домог, тууль, мөргөл залбирлын үг, шүлэг, бөөгийн дуудлага, ардын үлгэр, эртний уран зохиол, орчуулгын үлгэрүүд, ерөөл магтаал, дурсамж дуртгал, орчин үеийн уран зохиол хүртэл багтаж маш өргөн агуулгатай болсон юм.

1987 онд хуралдсан монголч эрдэмтдийн ээлжит их хуралд бэлтгэх ажлаар ШУА-ийн урилгаар 1986 онд гэргийтэйгээ айлчилсэн нь түүний хувьд суулчийн айлчлал болоод байгаа ч бид Бауден гуайг дахин монголд морилоно гэдэгт итгэлтэй байна.

Профессор Бауден гуайн эрдэм судлалын бүтээлээс харахад тэрбээр монголын түүхийн эх сурвалж, эх бичиг судлалын шинжлэх ухааны суурь бүтээлээс эхлэн монголын эртний уран зохиол, толь бичиг судлал зэргийг сонирхон судалж байгаа нь түүний сэтгэлгээний цар хүрээ, оюун мэдлэг, эрдэм судлалын далайц хэчнээн өргөн, хэчнээн гүн болохыг нотлоно.

Түүний монгол судлалаар хийсэн хөдөлмөр бүтээлийг манай улс, төр засаг хүндэтгэн үнэлж Монгол Улсын “Найрамдал” медаль, Алтан гадас одонгоо хүртээжээ. Өвгөн профессорын маань хань нь хүнд өвчинд нэрвэгдэн дэргэдээс нь холдохын аргагүй болж тэрбээр олон он жил, цаг хугацааг ханиа асран халамжилахад

⁴ “Олон Улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал” I боть, Ш.Бира, Уб., 2009, 3 дах тал

⁵ Ж.Цолоо, “Хэл зохиолын хүрээлэнд хагас зуу илүү жил”, Уб., 2011, 160-64 дэх тал.

⁶ C.R.Bawden, “Remarks on some contemporary performances of epics in the MPR”, (орчуулсан Б.Мөнхцэцэг) МУИС-ийн МСХ-гийн “Acta Mongolica” сэтгүүл, №13 (385) 2013, 161-172 pp.

⁷ “Mongolian Traditional Literature an Anthology”, Selected and translated by Charles R. Bawden, Kegan Paul, London, 2003

зориулсан ч эрдэм номоо хийсээр, бүтээлээ туурвисаар монгол судлалыг үргэлжлүүлсээр байсан билээ.

Британийн монгол судлалын нэвтэрхий толь болж насан туршийн үнэнч ариун бүтээл хөдөлмөрөөрөө дэлхий дахины монголч эрдэмтэдийн дунд нэрт монголч эрдэмтэн хэмээх алдар хүндийг олсон Чарльз Бауден гуайн мэлмий тунгалаг, өлмий бат оршиж, эрдэм судлалын ажил улам дэлгэрч, урт насалж, шинэ шинэ бүтээл туурвилаараа хүндэтгэн бишрэгч биднийгээ гийгүүлж баясуулж явах өлзийтэй өрөөлийг энэ ялдам өргөн дэвшүүлж өчүүхэн энэ өгүүлэлээ төгсгөө.

НОМЗҮЙ

Ж.Бат-Ирээдүй, “Монгол хэл бичиг: утга, соёл, хэрэглээ”, Уб., 2013

Ch.R.Bawden, “Mongolian-English Dictionary”, Kegan Paul, 1997

C.R.Bawden, “Mongolian Traditional Literature an anthology” Kegan Paul, 2003

C.R.Bawden, “Remarks on some contemporary performances of epics in the MPR”, (орчуулсан

Б.Мөнхцэцэг) МУИС-ийн МСХ-гийн Акта Монголика сэтгүүл, №13 (385) 2013, 161-172 pp.

“Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал”, Эрхлэн хэвлүүлсэн Ш.Бира нар, Уб., 2009

Ж.Цолоо, “Хэл зохиолын хүрээлэнд хагас зуу илүү жил”, Уб., 2011

Л.Чулуунбаатар, “Монголч эрдэмтэн Чарльз Бауден”, МУИС-ийн МХСС-ийн “Монгол судлал эрдэм шинжилгээний бичиг”, №30(318), 2009, 135-139 дэх тал

Ч.Баудений Монгол-Англи толь бичигийн тухай

*Л.Чулуунбаатар**

Товч утга: Лондоны Их Сургуульд багшаас эхлэн салбар сургуулийн захирал, проректорын алба хүртэл амьдралынхаа ихэнх хувийг хашиж явсан тэрбээр дэлхийн монгол судлалд нэр алдраа дуурсгасан олон бүтээл хэвлүүлсний дотор монголын эртний уран зохиол, хуучин сурвалж эх бичгээр дагнан ажиллаж олон бүтээл туурвисны нэг нь 34 жилийн хөдөлмөрөө зарцуулж бүтээсэн Монгол-Англи толь юм. Ч.Баудений энэ “Монгол-англи толь”-ийг дэлхий дахинаа монгол судлалыг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж, урьдах толь зохиогчдын дутууг гүйцээж, дундуурыг дүүргэсэн, энэ цаг үедээ л бидний хэрэгцээг бүрэн хангасан, хэрэглэгч олны таашаал хүлээсэн эрэлт хэрэгцээт толь болсоныг цохон тэмдэглэхгүй байхын аргагүй юм.

Түлхүүр үг: толь зүй, Монгол-Англи толь, Ч.Бауден, үйл үг, үгийн оноолт

Олон улсын монголч эрдэмтэдийн анхдугаар хурлын төлөөлөгч, монгол судлалын гарамгай эрдэмтэн, Английн Хатан хааны академийн хүндэт профессор Чарльз Бауден гуайтай хоёр жил хамт ажиллаж, ярьж хөөрч явсан нь миний амьдралд тохиолдсон нэгэн сайхан завшаант хэрэг хэмээн гүнээ талархаж явдаг юм.

Аугаа хөдөлмөрч энэ хүн 1924 оны 4-р сарын 22-ны өдөр дулаан зөөлөн уур амьсгалт, Английн өмнөт эргийн хот болох Веймоут (Weymouth) хотод Чарльз Роскеллийнхний гэр бүлд хоёр дахь хүү нь болон төржээ. Аав, ээж хоёр нь хоёулаа дунд сургуулийн багш байсан болохоор хоёр хүүгээ эрдэм номтой, хүний дайтай хүн болгон өсгөжээ. Тийм болохоор Ч.Бауден Лондонгийн Их Сургуулийн монгол судлалын гавьяат профессор, Британийн Академийн жинхэнэ гишүүн, дэлхийд нэртэй монгол судлалын эрдэмтэн, ах нь далайн цэргийн нэр хүндтэй офицер, инженер хүн болсон байна. Ч.Бауден дэлхийн II дайны гал ид дүрэлзсэн 1943-1946 оны хооронд 3 жил Британийн усан цэрэгт алба хаажээ. Дараа нь Кембрижийн Их Сургуульд орж суралцан төгсгөөд, 1955 онд “Алтан товчийн цаг тооллын бичиг” сэдвээр докторын зэрэг хамгаалжээ. 1950-иад оны эхээр монгол бичгийн хэлээр монгол хэл сурсан болохоор 1955 оноос сонгодог монгол бичгийг сонгох хичээл маягаар зааж эхэлжээ. Тэрээр монгол судлалын нэрт эрдэмтэд Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ш.Нацагдорж, Х.Пэрлээ, Г.Сэр-Оджав, О.Намнандорж, Ц.Дорж, Я.Цэвэл гуайтай танилцаж, уулзаж хуучилж явжээ. Б.Ринчен багштай 1954 онд анх захидлаар холбоо тогтоосон болохоор миний анхны багш нарын нэг хэмээн хэлдэг байсан. Б.Ринчен багшаас хүлээн авсан 12 захидал болон ил захидал байдаг бөгөөд нэг удаа тэдгээрээ надад авчирч үзүүлсэн билээ. 1967 оны 8 сараас 1968 оны 2-р сар хүртэл Монголд байхад нь Э.Вандуй, Ж.Цолоо нар монгол хэлний багш хийж байжээ. Ж.Цолоог залуухан 20 настай, эхнэртэй хийгээд багш болон хөтөч хийдэг байсан¹ хэмээн хуучилж байсан билээ.

Лондоны Их Сургуульд багшаас эхлэн салбар сургуулийн захирал, проректорын алба хүртэл амьдралынхаа ихэнх хувийг хашиж явсан тэрбээр дэлхийн монгол судлалд нэр алдраа дуурсгасан олон бүтээл хэвлүүлсний дотор монголын эртний уран зохиол, хуучин сурвалж эх бичгээр дагнан ажиллаж:

“Алтан товч” (The Mongol Chronicle Altan Tobci. Wiesbaden: Otto Harrassowitz, 1955),

“Хүрээний Жавзандамба хутагт” (The Jebtsundamba Khutukhtus of Urga; text, translation, and notes. Wiesbaden: O. Harrassowitz, 1961),

“Бигирмижид хаан ба шинэхэн түүх” (1968),

“Монголын шинэ түүх” (The Modern History of Mongolia. New York: Praeger, 1968, 1989),

“Монгол номын каталог” (“Catalogue of Mongol books, manuscripts and xylographs”, The Royal library, Copenhagen, 1971)

“Бөө, лам нар болон Евегалистууд” (Shamans, Lamas, and Evangelicals: The English Missionaries in Siberia. London: Routledge & Kegan Paul, 1985),

“Монгол-Англи толь” Mongolian-English dictionary. London: K. Paul International, 1997.

“Өвгөн Жамбалын яриа” (Tales of an old lama, Translated by C.R.Bawden, UK, 1997)

“Монголын уламжлалт утга зохиолын дээжис” (Mongolian Traditional Literature: An Anthology. London: Kegan Paul, 2003) зэрэг ном,

*МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын багш, доктор, профессор

¹ Л.Чулуунбаатар, “Монголч эрдэмтэн Чарльз Бауден”, МУИС-ийн МХСС-ийн “Монгол судлалын эрдэм шинжилгээний бүтээл”, № 30 (318), 2009, 135-139 дэх тал

“Монголын Боржигон овгийн түүх” (History of Borjigon clan in Mongolia),
“Монголын эрт ба одоо” (Mongolian past and present, 1959),
“Сүнс дуудах тухай” („Calling the Soul: A Mongolian Litany”. Bulletin of the School of Oriental and African Studies, University of London 25 (1/3): 81–103, 1962),
“Ид шидтэй нүүр тулах” (Confronting the Supernatural: Mongolian Traditional Ways and Means. Wiesbaden: Harrassowitz Verlag, 111–42, 1994),
“Кембрижийн Их Сургуулийн номын санд байгаа Монгол гар бичмэл номын тухай” („A First Description of a Collection of Mongol Manuscripts in the University Library, Cambridge”. Journal of the Royal Asiatic Society 47: 151–160, 1957),
“Овоо тахихтай холбоотой хоёр монгол бичвэр” („Two Mongol Texts Concerning Obo-Worship”. Oriens Extremus 5 (1): 23–41, 1958),
“Монголын эдийн засгийн ололт” („Economic Advance in Mongolia”. The World Today 16 (6): 257–270, 1960),
“Монгол судлалын саяхны бүтээлүүд” („Some Recent Work in Mongolian Studies”. Bulletin of the School of Oriental and African Studies, University of London 23 (3): 530–543, 1960),
“Юан гүрний үеийн адууны тухай бодлогын зарим тэмдэглэл” („Some Notes on the Horse Policy of the Yuan Dynasty”. Central Asiatic Journal 10 (3–4): 246–268, 1965),
“1919 оны Автономит Монголын Шүүх яаманд өргөсөн хамтын заргын бичиг” („A Joint Petition of Grievances Submitted to the Ministry of Justice of Autonomous Mongolia in 1919”. Bulletin of the School of Oriental and African Studies, University of London 30 (3): 548–563, 1967),
“1756-1757 оны Монголын бослого хөдөлгөөн” („The Mongol rebellion of 1756–1757”. Journal of Asian History 2 (1): 1–31, 1968),
“Монгол дахь XVIII зууны үеийн аллагын шалтгаан” „A Case of Murder in Eighteenth-Century Mongolia”. Bulletin of the School of Oriental and African Studies, University of London 32 (1): 71–90, 1969,
“Монгол дахь XVIII зууны үеийн бүтэлгүйтсэн аллагын шалтгааныг мөшгөсөн нь” „The Investigation of a Case of Attempted Murder in Eighteenth-Century Mongolia”. Bulletin of the School of Oriental and African Studies, University of London 32 (3): 571–592, 1969,
“1756 оны Өвөрмонголын бослоготой холбоотой зарим баримт” („Some Documents Concerning the Rebellion of 1756 in Outer Mongolia”. Bulletin of the Institute of China Border Area Studies, 1, 1–23, 1970),
“Хатуу дарсны хор хөнөөл: XX зууны эхэн үеийн монгол шаштир” („On the Evils of Strong Drink: A Mongol Tract from the Early Twentieth Century”. Walther Heissig (Wiesbaden: Harrassowitz), 61, 1976),
“Шамбалыг дахин хүсэгч” („The wish-prayer for Shambhala again”. Monumenta Serica 36: 453–510, 1984–85)², зэрэг эрдэм шинжилгээний алдартай өгүүлүүдээ хэвлүүлжээ.

Эдгээр бүтээлийн дотроос Монголын олон мянган хэрэглэгчдийн таашаалд нийцсэн Монгол-Англи толь”-ийн нь тухай ярих гэсэн юм.

1989-1991 оны хооронд Лондонгийн Их Сургуульд зочин багшаар уригдан очоод ажиллаж байх цагт Профессор Чарльз Бауден гуай хэдийгээр тэтгэвэртээ гарсан ч 1963 оноос эхэлж 34 жилийн тэсвэр тэвчээр, мэдлэг оюун, шургуу хөдөлмөр зарсан “Монгол Англи толь”-ио ид хийж байсан билээ. Намайг очиход ерөнхийдөө толио дууссан боловч 1980-аад онд гарсан ил тод байдлын дэвшилтэд нөлөөгөөр монгол ёс заншил сэргэн, монгол хэлний үгсийн санд мартагдах шахсан олон хуучирсан үг шинээр орж ирэн тэр бүхнийг толиндоо нэмж тусган оруулахын тулд зөв ухаарч ойлгох хэрэгтэй болоод байсан хэрэг юм. Бид хоёр, долоо хоногт хоёр удаа 90 минутаар хичээллэдэг байв. Ч.Бауден гуай үгээ авчирч би түүний нь монголоор тайлбарлан, дахин дахин ярилцаж сайн ойлгосны дараа дараагийн үгэндээ ордог байв.

Чарльз Бауден гуайд энэ толио бүтээх санаа Боннын Их Сургуулийн багш Магадбүрэн Халтодыг 1963 онд Лондонгийн Их Сургуулийн Ойрх дорнот болон Африкийн судлалын сургуульд 3 сарын хугацаагаар ажиллахаар ирээд байх үед нь төрсөн байна. “Үг олдож үхэр холдлоо” хэмээн Магадбүрэн гуай их хэлдэг байсан хэмээн хуучилдаг байв. Монгол-Англи толь хийхийн тулд БНМАУ-ын орчин үеийн хэлний үгийг хамтдаа цуглуулахаар ярьж тохиролцсон байна. ОДАСС (SOAS) кирил үсэгтэй 2 бичгийн машин болон бичгийн хэрэгсэл зэрэг боломжийн хандив дусламжийг үзүүлсэн байдаг. Цуглуулсан үгнүүдээ шуудангаар харилцан илгээж, шалгаж нягтлан нэгтгэж нийлүүлэх бодолтой байжээ. Хоёр тусдаа хол газар ингэж ажиллах нь үнэн хэрэгтээ тэдний бодсоноос ихээхэн бэрхшээлтэй байсан ч үргэлжлүүлсээр байсан гэдэг. 1978 оны 8-р сард Магадбүрэн гуай гэнэт таалал төгссөнөөр хамтран ажиллах бололцоо дуусгавар болжээ. Тэрээр “Би түүний аугаа их судлаачийн байр сууринд хүрэхгүй боловч толио дуусгахыг амьдралын зорилго болгосон” хэмээн хуучилдаг байсан билээ. Энэ тухайгаа ч толийнхоо оршилд дурдсан бөгөөд энэ ажилд хөтлөн зоригжуулсан Магадбүрэн гуайд талархал илэрхийлээд, мөн 1963-1964 онд ОДАСС-д нэг жилийг өнгөрөөсөн Цэцэн Жагчид болон хожим 1967-1968 онд Улаанбаатар хотод байхдаа Ж.Цолоо, Э.Вандуй нараас их зүйл сурсан хэмээгээд тэдэнд талархалаа илэрхийлсэн байдаг юм. Мөн “МУИС-иас ОДАСС-д ирж ажиллаж

² www. Charles Bawden - Wikipedia, the free encyclopedia

байсан багш Л.Чулуунбаатарт гүн талархлаа илэрхийлэх өртэй бөгөөд бараг 2 жилийн турш өгөөмөр их тус хүргэж, миний асуултад хариулж бэрхшээлийг минь арилгахыг хичээж байсан билээ. Эцэст нь түүний дараа ирсэн Ж.Бат-Ирээдүй багшаас ч бас өгөөмөр их туслалцааг энэ ажилдаа авсан билээ”³ хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг. Толийнхоо оршилд дурдаагүй боловч хууч хөөрөхдөө С.Нямсүрэн багш толий минь уншиж засч их тусалж байсан хэмээн дурддаг байсан билээ. Толио бүтээхдээ урьд өмнө гарсан толиудыг шүүрдэж үзэхийн хамт Монгол улсад гарсан сонин сэтгүүл, шинжлэх ухааны төрөл бүрийн салбарын ном хэвлэлийг уйгагүй шүүрдэн уншиж үгийг карталж тэдгээрийн утгыг тодорхой нарийн харгуулах, дүйцэх үгийг олохын төлөө цаг зав хайрлахгүй маш шургуу, хичээнгүй ажилласны ул мөр болж энэ толийн үйл үгийн оноолт хийгээд монгол англи үгийн оноолт маш сайн болсон байдаг. Түүний тулд л бидний хичээлийн үед нэг үгийн нарийн сайн ойлготлоо дахин дахин асууж тайлбарлуулж яриулдаг байсан билээ.

Энэ толь сайн болсон шалтгаан нь хэдэн зүйлд байгаа юм.

1. Дүйцүүлэх арга буюу Үгийн оноолт ялангуяа үйл үгийн оноолыг маш сайн хийж өгсөн байдаг. Дан гагц би бус олон хүний амнаас энэ үгийг сонссон билээ. Жишээ нь: Лессингийн “Монгол-Англи” тольд овоорох хэмээх үгийг to pile up, to crowd, swarm⁴, Хангиний Гомбожавын тольд to form a pile, to crowd, swarm⁵ хэмээсэн бол Ч.Баудений тольд to gather together, to bunch together, to crowd together, to swarm, to pile up⁶ хэмээн арай олон утга үйл үгийн хэлбэрээр авсан байдаг.

2. Зарим үндэсний онцлогтой үгийг таацуулан оноохоосоо илүү тайлбарлах аргыг илүүтэйд үзсэн байдаг. Жишээ нь: Лессингийн “Монгол-Англи” тольд эзэгий хэмээх үгийг curds, cottage cheese⁷, Хангиний Гомбожавын тольд curds, cottage cheese⁸ хэмээн яг адил тайлбарласан бол Ч.Баудений тольд a milk product made by boiling most of the whey from the curdled milk of sheep, goats or cows and setting the residue to dry on the screen⁹ хэмээн тайлбарлан үзүүлсэн байдаг.

3. Тухайн үгтэй холбоотой өвөрмөц хэлц, хэллэгийг олныг оруулж өгсөн байдаг. Жишээ нь: Лессингийн “Монгол-Англи” тольд аав хэмээх үгийг father, grandfather, esp. applied to an old father(endearing), аав зантай behaving like an adult (of a child)¹⁰, Гомбожавын тольд father, papa¹¹ хэмээсэн бол Ч.Баудений тольд dad, father, буурал аав grandfather, хойт аав stepfather, аавдаа авгай авахыг заах to teach one’s grandmother to suck eggs, аавынд байх to be in gaol, аавын буйд хүнтэй танилцаж, агтын буйд газар үз(аавын бийд уурга барь, ээжийн бийд учиг шингээ) learn to make your way early in life, аавын хүү(аавын хүүхэд) chap, young fellow, аавын цээж show-off, precocious child, аавын цээж болох(аавын цээж гаргах) to teach one’s grandmother to suck eggs¹² хэмээн өвөрмөц хэлц, хэлц үг хувилбаруудтай нь хамт оруулан утга дүйх хэлцээр нь орчуулсан байдаг. Мөн дээр дурдсан эзэгий хэмээх үгний эзэгий буцалгах хэмээх хэлц үгийг to snore like a grampus¹³ хэмээн урьд урьдын тольд байхгүй үгийг оруулж өгсөн нь монголыг судалдаг гадаадынханд болон монгол заншлаа мартаж байгаа хотынхонд ч чухал тайлбар юм.

4. Монголын зан заншил, шашин суртахуун, дорно дахины ухаан, түүх соёлтой олон үгийг шинээр оруулж өгсөн юм. Жишээлбэл: Дорно дахины 10 ухааны талаарх тайлбар Лессинг болон Гомбожавын тольд байхгүй бол Баудений тольд **ухаан** хэмээх үгийн олон тайлбараас гадна **таван ухаан** the five (major) sciences, the five(major) branches of learning (Buddh.), **ухааны арван орон** the ten sciences, the ten branches of learning, **ухааны таван бага орон** (бага таван ухаан) the five minor sciences (зурхай astrology, зохист аялгуу (яруу найраг) poetics, ил ёгт өгүүлэхүй (ёгт үг) eloquence, **холбоо найруулахүй** (холбоо найраг) composition, **жүжиглэхүй** (бүжиглэхүй) acting, dancing), **ухааны таван их орон** (их таван ухаан) the five major sciences (дуун ухаан linguistics, **учир шалтгааны ухаан** logic, **тэжээхүй ухаан** medicine, **урлахүй ухаан** mechanical arts, **дотоод ухаан** theology)¹⁴ хэмээх дэлгэрэнгүй тайлбарлан оруулсан байдаг. Мөн энэ тольд ам хэмээх үгийн маш олон холбоо үг, хэлцийн утгыг оруулж өгсөний нэг нь **уулын ам** mountain valley, valley, **уулын суга** valleys¹⁵ хэмээх үг бөгөөд урьдах хоёр толь болоод монголчуудын хийсэн тольд ч байхгүй байгаа юм.

5. Гадаадаас орсон үг ямар хэлнээс орсон үг болохыг мөн юуны холбоотой үг болохыг оруулж өгсөн байдаг. Жишээ нь Лессингэд байхгүй хийгээд Гомбожавын тольд галбинга a fabulous bird, female phoenix¹⁶

³ Charles Bawden, Mongolian-English dictionary, London and New York, 1997, p I

⁴ Ferdinand Lessing, Mongolian-English dictionary, Bloomington, Indiana, 1973, p 599

⁵ Gombojav Hangin, Mongolian-English dictionary, Indiana University, 1986, p 386

⁶ Charles Bawden, Mongolian-English dictionary, London and New York, 1997, p 253

⁷ Ferdinand Lessing, Mongolian-English dictionary, Bloomington, Indiana, 1973, p 299

⁸ Gombojav Hangin, Mongolian-English dictionary, Indiana University, 1986, p 867

⁹ Charles Bawden, Mongolian-English dictionary, London and New York, 1997, p 575

¹⁰ Ferdinand Lessing, Mongolian-English dictionary, Bloomington, Indiana, 1973, p 5

¹¹ Gombojav Hangin, Mongolian-English dictionary, Indiana University, 1986, p 3

¹² Charles Bawden, Mongolian-English dictionary, London and New York, 1997, p 1

¹³ Charles Bawden, Mongolian-English dictionary, London and New York, 1997, p 575

¹⁴ Charles Bawden, Mongolian-English dictionary, London and New York, 1997, p 393

¹⁵ Charles Bawden, Mongolian-English dictionary, London and New York, 1997, p 16

¹⁶ Gombojav Hangin, Mongolian-English dictionary, Indiana University, 1986, p 109

хэмээн байхад Баудений тольд галбинга 1. The “Indian Cuckoo”, 2. Kalavingka, a fabulous bird (Skr.)¹⁷ хэмээн оруулсан байна. Галай-да хэмээн үг дээрх хоёр тольд байхгүй бөгөөд Бауденд галай-да rank of commander in the watch posts in Manchu times (hist.)¹⁸ хэмээн тайлалан оруулсан байгаа болой.

Мөн нөгөөтэйгүүр энэ толийн хийх мэдлэгийн болон хамтын ажиллагааны маш сайн нөхцөлийг бүрдүүлж чадсан байдаг. Үүнд:

1. “Алтан товч”, “Хүрээний Жавзандамба хутагт”, “Өвгөн Жамбалын яриа” зэрэг олон сурвалж бичгийг судалж орчуулсан хийгээд монголын түүхийн ном бичихийн тулд монголын түүх, соёлтой холбоотой олон сурвалж, материал, хэрэглэгдэхүүнийг уншиж ухаанаа цэнэглэж, мэдлэгийн хүрээгээ гүнзгийрүүлсэн байдаг.

2. Урьд өмнийн гарсан бүх толь бичиг, тайлбар толиудыг шүүрдэн үзсэн байдаг.

3. Гадаадын монголч эрдэмтэд болох Н.Поппе, Х.Шварц, Хайсиг, О.Латтимор Роберт Рупин нарын олон хүнтэй санал солилцдог байсан.

4. Монгол эрдэмтэн Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ш.Нацагдорж, Х.Пэрлээ, Г.Сэр-Оджав, О.Намнандорж, Ц.Дорж, Я.Цэвэл, Магадбүрэн, Цэцэн Жагчид, С.Нямсүрэн, Ж.Цолоо, Э.Вандуй, О.Намнандорж, Эрдэнэпил хамба, Т.Пагва, Чингэлтэй профессор, Инжинаш судлаач Эрдэнэтогтох, Л.Чулуунбаатар, Ж.Бат-Ирээдүй нартай захиагаар харьцаж, асууж лавлаж, үзүүлж засуулж, тайлбарлуулж байсан байдаг.

Ф. Лессингийн “Монгол-англи толь”-ийг 1960 онд хэвлэгдэн гарснаар “... америкийн дорно дахин судлаач нэгэн тэргүүлэгч эрдэмтэний дурсгал болон үүрд мөнх хадгалагдана”¹⁹ хэмээн нэрт монголч эрдэмтэн Ф.В.Кливес (Francis Woodman Cleaves) болон мэргэжил нэгтнүүд нь үнэлсэн байдаг. Тийм болохоор бид Ч.Баудений энэ “Монгол-англи толь”-ийг дэлхий дахинаа монгол судлалыг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж, урьдах толь зохиогчдын дутууг гүйцээж, дундуурыг дүүргэсэн, энэ цаг үедээ л бидний хэрэгцээг бүрэн хангасан, хэрэглэгч олны таашаал хүлээсэн эрэлт хэрэгцээт, нэр алдрыг нь хөшөө болгон мөнхөлсөн толь болсоныг цохон тэмдэглэхгүй байхын аргагүй юм.

ON MONGOLIAN-ENGLISH DICTIONARY BY CHARLES BAWDEN

Charles Bawden is a world-famous Mongolist who compiled and translated many books in his lifetime. Among his valuable works, Mongolian-English Dictionary played an important role. He spent 34 years on compiling this dictionary. At the end of 1980's he almost finished his hard work. However, as Mongolia was in the period of glasnost at that time, many old pieces of vocabulary could be restored in the Mongolian language. Bawden did not want to leave those words and worked hard again for another 10 years. Thus, numerous essential words related to Mongolian customs, tradition, history, nomadic life style, Mongolian Buddhism and shamanism were added. Cleaves F.W., when commenting on a famous scholar Lessing F.D who compiled Mongolian-English Dictionary in 1960, said that “Ferdinand D.Lessing has put Mongolian study at the high level all over the world by his excellent and comprehensive dictionary.”

We, the Mongolians highly prized Bawden's dictionary, considering it to be an invaluable piece of work for the Mongolian studies. The reason for that is that it included lots of words and expressions that have never been included in previous dictionaries. I would like to mention a simple example. As we look up a compound word ‘уулын ам’, the translation which follows is: ‘mountain valley, valley’.

Ном зүй

1. Charles Bawden, Mongolian-English dictionary, London and New York, 1997
2. Ferdinand Lessing, Mongolian-English dictionary, Bloomington, Indiana, 1973
3. Gombojav Hangin, Mongolian-English dictionary, Indiana University, 1986
4. Robert Allen, Consultant editor, The New Penguin English dictionary, Penguin books, 2000
5. www. Charles Bawden - Wikipedia, the free encyclopedia
6. М.И.Гольман. Дэлхийн монгол судлал, УБ., 2005
7. Л.Чулуунбаатар, “Монголч эрдэмтэн Чарльз Бауден”, МУИС-ийн МХСС-ийн “Монгол судлалын эрдэм шинжилгээний бүтээл”, № 30 (318), 2009

¹⁷ Charles Bawden, Mongolian-English dictionary, London and New York, 1997, p 87

¹⁸ Charles Bawden, Mongolian-English dictionary, London and New York, 1997, p 86

¹⁹ М.И.Гольман. Дэлхийн монгол судлал, УБ., 2005, х 7

**“МОНГОЛ НУУЦ ТОВЧОО” ДАХЬ ЗАРИМ АСУУДЛЫГ
ДАХИН СУДАЛЖ АВЧ ҮЗЭХ НЬ**

Л.Баасандорж *

“Монголын Нууц Товчоо”(МНТ) бол монгол үндэстний түүх, соёл, ахуй байдал, уламжлал, зан заншлыг тод томруунаар харуулж чадсан гайхамшигт нэгэн сурвалжит зохиол билээ. “Нууц Товчоон” зохиолд ертөнц дахиныг байлдан дагуулж, хүн төрөлхтнийг нэгэн захиргаан дор оруулж, дипломат ёсыг дэлхий дахинаа гаргаж ирсэн суу их билигт Чингис хааны үйл хэрэг, түүний амьдралын баялаг түүх, алтан ургийнхны ураг удмын холбоо, найр хурим зэрэг язгууртан монголчуудын уламжлалт зан заншлыг бичиж үлдээжээ. Тэдгээрийг өдгөөгийн өнцгөөс харж судлахдаа тухайн үеийн сэтгэхүйн түвшинд нь гаргалгаа хийх нь зүйн хэрэг билээ. Зохиогч зохиолоо нууц газар, нууц байдалтай, зарим үйл явцыг нууц байдлаар бичиж үлдээсэн нь өдгөөгийн өнцгөөс харж, тайлж унших нь чухал байна.

“МНТ”-ны 76, 77-р зүйлд Тэмүжин, Хасар хоёр Бэгтэрийг хоёр талаас нь харваж хороож байгааг дурддаг.¹ Тэмүжин Бэгтэрийг гөхий загас, бялзуухай төдийхөн булаасанд ихэд уурсаж хороов уу? Аль эсвэл олон Монгол овгийг хурааж монгол улсаа байгуулах өндөр их тавилантай хүүгийн амьдрал тэмцлийн эхлэл байв уу?

Тэмүжин, Бэгтэр нарын зөрчлийг овог төрлийн удирдагч болох гэсэн улс төр, эрх мэдлийн төлөөх тэмцэл байсан гэж нэлээдгүй эрдэмтэн судлаачид үзэж байна. Тухайлбал: Рене Груссе “...Хэдийгээр ийм явдал болсон ч цэл залуухан Тэмүжин хөвүүн өөрт нь дур зоргоо тулган хүлээлгэхийг санаархсан дүүгээ цааш харуулж овог төрлийнхөө удирдагч гэдгээ харуулсан байна.”² гэжээ. Райнхолд Нойман-Ходиц үзэхдээ: “Бэхтэр/Бэгтэр.Л.Б/ хэдийгээр амийг нь өршөөхийг гуйсан боловч Тэмүжин түүнийг нь үл тоон, санаатайгаар хөнөөсөн байна. Яагаад гэвэл тэрээр гэрийн эр хүн, эцгийн хамгийн ахмад хөвгүүн, өрхийн толгойлогч байлаа. Тал нутгийн хууль ёс тийм байв”³ гэжээ. Эрдэмтэн П.Рачневский “Бэгтэрийг алсан явдал зөвхөн болжмор загас булаалдсанаас болсон биш. Харин илүү гүн шалтгаантай. Тэмүжин өрх гэрийн толгойлогч байх хүслээс болсон хэрэг бололтой”⁴ гэжээ. Эрдэмтэн Л.Н.Гумилев Тэмүжин дүү Хасартайгаа нийлж (Бэгтэрийг) алсан явдлыг тэрээр Тайчуудтай холбож үзжээ.⁵ Бэгтэрийг Тэмүжин сумаар онилж хөнөөсний дараагаар Тайчууд тэднийхнийг (Есүхэйн орон сууринг) довтолж, Тэмүжинийг барьж авчээ. Л.Н.Гумилев энэхүү үйл явдлыг “...чухамдаа айл гэрийн хэрүүл маргаан тайчуудад ямар падтай юм бэ? Ямар учраас хөндлөнгөөс оролцох болоов? /болов.Л.Б/⁶ гэсэн сонирхолтой асуулт тавьжээ. Тэрээр үзэхдээ: “Бэгтэр туршуул, мэдээ хүргэгч нь байжээ. Тэрвээр Боржигины энэ айлд, Есүхэйн гэрт болсон бүхнийг ховлодог байсан байна. Тэгэхлээр эцгийнхээ үхсэний дараа эрх дархаа булаалгасан хүү нь яаж өсч байгааг тайчууд мэдэхийг хүсч байжээ.”⁷ гэж үзжээ. Сочигэл эх, Бэгтэр нар тайчуудтай ямар нэгэн байдлаар холбоотой байсан ба тэд Есүхэйн гэрт болсон бүхнийг тайчуудад ховлодог байсан учир Тэмүжин Бэгтэрийг хорсож алсан бололтой гэж Л.Н.Гумилев бичжээ. Академич Б.Я.Владимирцов “Энэ бол ураг удмынхан цаг үргэлж завсар хоорондоо муудалцаж тэмцдэг байсан болохоор хүмүүс, тэр байтугай нэг гэр бүлийн хүмүүс хүртэл бие биенээ алж талахыг харсаар байгаад нүд тасч (дасаж.Л.Б), хүн алахыг гэмт хэрэг гэж үзэхээ больсон цаг байжээ. Эрх зүйн хэм хэмжээгүй овгийн

* Өвөр Монголын Их Сургууль

¹ “Монголын Нууц Товчоо”, (Монголын Нууц Товчооны эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, (77 дугаар зүйл), УБ.,2006, т.38.

² Рене Груссе “Орчлонг эзэгнэгч Чингис хаан” (орчуулсан Чойнзонгийн Баатар), ред: Сандуйжавын Одхүү, УБ.,2001, т.64.

³ Райнхолд Нойман-Ходиц “Чингис хаан” Болгар хэлнээс орчуулсан Д.Батсайхан, монгол найруулгыг хянан тохиолдуулсан Б.Даш-Ёндон, УБ.,2002, т.23.

⁴ П.Рачневский “Чингис хаан, түүний амьдрал үйлс”, УБ.,1983, т.8.

⁵ А.И.Курчки, Л.Н.Гумилев “Хар домог”, УБ.,1992, т.69.

⁶ Мөн тэнд

⁷ Мөн тэнд

байгуулалт ноёрхож байсны улмаас хэрүүл, хэл ам таталж зодоон цохион хийх явдал нүүдэлчин монголчуудын дунд газар авч, тэр талаар татарууд бүр ч адтай байжээ”⁸ гэж тухайн үеийн байдлыг өгүүлжээ. Түүхч Ш.Нацагдорж Тэмүжиний багын ааш араншин байдлын талаар өгүүлэхдээ: “...Тэдний дотроос Тэмүжин бусдаасаа нэн ч их эзэнлэг догшин зантай хүмүүжиж байсан нь эх өөр дүү буюу ах Бэгтэрийг болжмор булааж авсан төдийгөөр дүү Хасартай нийлэн алснаас тодорхой байна.”⁹ гэжээ.

“МНТ”-нд өгүүлснээр: <<Есүхэй баатарын Өгээлүн үжинээс Тэмүжин, Хасар, Хачигун, Тэмүгэ эд дөрвөн хөвүүд төрөв. Тэмүлүн нэртэй нэгэн охин төрөв.>>.¹⁰ <<Есүхэй баатарын нөгөө гэргий Сучигэл /Сүчигэл.хөр./ эхээс төрсөн Бэгтэр, Бэлгэтэй хоёр бүлгээ.А.то>>¹¹ гэжээ. Удалгүй эцэг Есүхэй нас нөгчиж, Өэлүн эх хэдэн хөвүүдийн хамтаар арайхийн аж төрөн амьдрах ажээ. Ийм хэцүү үед урьдын Есүхэйн мэдэлд байсан олон овог аймгууд Өэлүнийг хэдэн хөвүүдийн хамтаар орхиж нүүж одов. Ийнхүү олон овог аймгууд Өэлүнийг орхиж нүүснээр түүнийг түүхийн тавцан дээр хэсэг хугацаанд ганцаардуулжээ. “Тэвч Өэлүн ээж санаа сэтгэлээр гутарсангүй, үр хүүхдээ хүмүүжүүлж, удам дамжсан язгууртан гэдгийг тэдэнд ойлгуулж /Тэмүжин, түүний дүү нарт.Л.Б/, язгууртаны ангид хамаарагдах эрхтэй учраас учирсан хүнд байдлыг гэтлэн давж, өсч өндийхийн тулд хичээж чармайх хэрэгтэйг ухааруулж байжээ.”¹² Харин энэ үед Есүхэйн нөгөө гэргий болох Сочигэл эх өөрийн хоёр хөвүүн болох Бэгтэр, Бэлгүтэйн хамтаар тэдэнтэй (Өэлүн болон түүний хөвүүдтэй) үлдэж хамт амьдарч байжээ. Эцгээс өнчирч хоцорсон хөвүүд багаас зовлон зүдгүүр амсаж, цааш амьдрахын тулд юу эсийг үзэв гэлтэй. Энэ цаг мөчид жижиг сажиг маргаан тэднийг тойрсонгүй. Гагц тэрхүү маргааны сэдэл нь юу байв? Ямартай ч нэг эцгийн хоёр өөр эхээс төрсөн хөвүүд тийнхүү хоорондоо үл эвдрэлцэх гэдэг яаж ч бодсон үл төсөөлөгдөх.

Түүхийн тулгаран ирсэн хүнд нөхцөл байдал Есүхэйн /үлдсэн/ гэр бүлийнхнийг бүгдийн сэтгэлийг зовоох¹³ болсон энэ үед Тэмүжин, Бэгтэр нар юунаас үүдэж хоорондоо зөрчилдэх болов. Тэмүжин, Бэгтэр нар хоёул өөрийн гэр бүлийнхнийг тэжээх гэж ихээхэн хичээл зүтгэл гаргах боловч тэдэнд олдож буй нь загас, болжмор шувуу л аж. Учир нь бусад олон овог аймгийн хүмүүс хээрийн ан гөрөөсийг тэднээс өрсөж агнасаар байсан болохоор тэдний дотор ихээхэн уур хилэн буй болж байсан биз ээ. Нөгөөтэйгүүр тэд (Тэмүжин, Бэгтэр нарыг хэлж байна.) насаар харьцангуй бага агаад тэдгээр өөрсдөөс нь өрсөж ан гөрөө хийж буй талын анчдын дэргэд ан агнах дадал зуршил, чадвар хараахан суугаагүй байсантай холбоотой юм. Ийнхүү бусад овгийн эрчүүл Тэмүжин, Бэгтэр нараас илүүтэйгээр хээр талын ан гөрөөсийг агнах болсон энэ үед Тэмүжин, түүний дүү нарын агнасан болжмор шувуу, загасыг Бэгтэр булааж гэрийн дотор хэрүүл маргаан үүсгэжээ. Харин Тэмүжин, Бэгтэр нарын хооронд үүссэн жижигхэн маргаан хурдан хугацаанд ч болов зөрчил болж орхижээ. Энэхүү зөрчилт байдалд хөвүүдийн хүмүүжил, зан араншин, дотоод сэтгэл зүй ихээр нөлөөлсөн нь дамжиггүй юм. Учир нь Тэмүжин, Бэгтэр нар өөр өөрийн эхийн

⁸ Б.Я.Валидимирцов “Чингис хаан”, /Олон улсын Монгол судлалын холбооноос эрхлэн гаргав/, “Дэлхийн Монгол судлалын дээжээс” 1996 цуврал (1), /цувралын эрхлэгч Академич Ш.Бира/, (Орос хэлнээс орчуулсан Б.Дашцэрэн), УБ.,1996, т.15.

⁹ Ш.Нацагдорж “Чингис хааны цадиг”, УБ.,1991, т.28.

¹⁰ “Монголын Нууц Товчоо”, (Монголын Нууц Товчооны эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, (60 дугаар зүйл), УБ.,2006, т.28.

¹¹ Лувсанданзан “Эртний Хаадын Үндэслэсэн Төр Ёсны Зохиолыг Товчлон Хураасан Алтан Товч Хэмээх Оршвой” (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.46.

¹² Б.Я.Владимирцов “Чингис хаан”, /Олон улсын Монгол судлалын холбооноос эрхлэн гаргав/, “Дэлхийн Монгол судлалын дээжээс” 1996 цуврал (1), /цувралын эрхлэгч Академич Ш.Бира/, (Орос хэлнээс орчуулсан Б.Дашцэрэн), УБ.,1996, т.14.

¹³ Өэлүн эх, Сочигэл нар Есүхэй баатраас хойш ядуу зүдүү, гачигдал зовлонтой үлдсэн боловч тэдний хамгийн ихээр сэтгэл зовниж байсан зүйл бол Монгол олон овог аймгийг хэрхвэл нэгтгэж зангидах вэ? гэдэг асуудал байсан (гарч ирсэн) юм. Учир нь тэд (Тэмүжин, Бэгтэр, Бэлгүтэй, Хасар, Хачигун, Тэмүгэ нарыг хэлж байна.) болбол Монголын голлох төв язгууртнууд байсан учир Өэлүн эх түүний хөвүүд дээрх олон монгол овгийг нэгтгэж захирах асуудал дээр нэлээд анхаарлаа хандуулж байлаа. Аливаа угсаатнууд, улс үндэстний язгуурын хаад ноёдууд өөрийн улс үндэстний ирээдүйн /төлөө/ талаар сэтгэл нь ихээхэн зовниж энэ асуудал дээр ухаанаа уралдуулдаг ажээ. Учир нь тэд бол ухаанаараа, сэтгэлгээний хувьд, үзэл хандлагын хувьд оюун тархи аль эрт задарсан байдагт оршино.

хүмүүжлээр хүмүүжиж өссөн ба тэдний ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээ, сэтгэл зүй нь ихээхэн харилцан адилгүй (өвөрмөц) байсан нь тодорхой юм. Иймд тэдний хооронд зөрчил үүсэх үндэс нь хөвүүдийн бяцхан сэтгэхүйд төлөвшиж буй төлөвшилтэй шууд холбоотой байв. Энэ талаар Францын эрдэмтэн Рене Груссе өгүүлэхдээ: “Тэмүжин хийгээд түүний дүү нарын авир араншин санаанд оромгүй бөгөөд ихээхэн харгис хатуу байдаг байсан бөгөөд хүмүүжиж өссөн орчин нөхцөлийг нь бодоход тийм ч гайхмаар зүйл биш байсан юм. Өсвөр насны хөвгүүдийн хувьд атаархах, гомдохын аль алин нь байх л ёстой хэдий ч ганцаардмал зожиг, гачигдал зовлонтой байдал нь энэ бүхнийг улам даамжруулж байлаа.”¹⁴ гэжээ. Тэмүжин, түүний дүү нар ухаант Өэлүн эхийн сургаалаар, талын язгууртны хэв маягаар хүмүүжиж байлаа. Тэд монгол ахуй, монгол зан заншил, нүүдэлчин түмний сэтгэлгээний өвөрмөц байдал дунд өсөн торнигчоож байсан юм. Хөвүүдийн хооронд үүссэн зөрчилт маргааныг тэдний хүмүүжил, зан араншин, ахуйн хүрээнд нь авч үзэх нь зөв боловч чухамхүү /ганцхан/ ингэж үзвэл хараахан буруу юм.

Тэмүжин, Бэгтэр нар оюун санааны хүрээнд тэмцсэн ба өөрөөр хэлбэл оюун санааны хувьд эрх чөлөөг мэдэрсэн хоёр хөвүүний хооронд үүссэн зөрчилт байдлын үүднээс авч үзэх нь зүйтэй юм. Тэмүжин Бэгтэр нар сэтгэлгээний хувьд задарсан, ертөнцийг үзэх үзэл нь аль эрт нээгдсэн басхүү тэлэгдсэн байсан юм. Энэ үүднээс авч үзвэл тэдний тэмцэл бол оюун санааны хүрээнд явагдсан бөгөөд оюун санааны тэмцэл гэж үзэх үндэстэй. Монгол олон овог аймгийг нэгтгэх тухай бодол тэдний оюун санаанд бат шингээстэй байжээ. Тэмүжин, Бэгтэр нарын тэмцэл нь Монголын их хувь заяаг өөрийн ухаан, сэтгэлгээний хурдаар урагшлуулсан /урагшлуулж авч явсан/ тийм л тэмцэл байсан юм. Хэдийгээр Өэлүний хөвүүд ахуйн эрх чөлөөнөөс гарч эдийн засгийн эрх чөлөөнд хүрээгүй байсан ч Тэмүжин болон түүний дүү нар оюун санааны хувьд эрх чөлөөг аль эрт мэдэрсэн байжээ. Иргэншлийн онолоор оюун санааны хувьд эрх чөлөөг мэдэрсэн хүн гутранги үзэлд автагдаж, орчин тойрноо үгүйсгэдэг ба Груссын дүгнэсэнчлэн ганцаардмал, зожиг, гачигдал зовлонтой байдал нь Тэмүжиний хувьд экзистээ нээх нэг томоохон боломж нөхцөл, гарц болж өгснийг энд тэмдэглэх нь зүйтэй /чухал/ юм. Гутранги үзэлд муу тал бий ч гутранги үзлээсээ ангижирч сэтгэхүйн далд хэлбэрийг олсноор экзистээ нээдэг ба орчлон хорвоог өөр өнцгөөс харж чадах ажээ. Энэ бол бодгаль бие хүний жинхэнэ эрх чөлөө ажгуу. Иргэншлийн онолоор Тэмүжин, Бэгтэр нарын зөрчилт тэмцэл тэдний хувьд экзистээ нээх анхдагч сэдэл байсан ч байж болох. Энэ нь цаашлаад дэлхий дахиныг өөрийн оюун санаа, сэтгэлгээний хурдаар зангидаж, түүхийн хүрдийг эргүүлж хүн төрөлхтний өмнө хэзээ ч давтагдашгүй гавъяаг байгуулсан эзэн Чингис хааны үйл хэрэг бүхний эхлэл болсон байж болохыг хэн үгүйсгэх билээ.

Бэгтэрийг харвахдаа Тэмүжин ихэд зоригжиж, тэрээр хорт дайснаа хороож буй мэтээр заналтайгаар хөнөөсөн нь Чингис хааны зарчим, шударга үнэнийг түрүүнд тавьдаг түүний зан характер харагдаж байна. Эцгийг нь хорлож алсан Татарчуудаас хэрхэн яаж өшөө хорсолоо авах тухай бодол өвөртөлж байсан Тэмүжиний хувьд Бэгтэр, Бэлгүтэй нарын түрэмгийлэл нь түүний уур хилэнг хүргэсэн нь мэдээж. Энэ үед олон монгол овог аймгууд тэднээс нүүр бууруулав. Энэ байдал Тэмүжиний уур бухимдлыг улам их бадраав. Ийм нөхцөл байдалд Бэгтэр түүнээс гарах араншин нь Тэмүжинийг асуудлыг түргэн түргэн шийдэхэд хүргэжээ. Энэ талаар Лео Де Хартог “Залуу Тэмүжин өмнөө тулгарч буй асуудлуудыг шинэлэг аргаар түргэн шийдвэрлэж байлаа”¹⁵ гэжээ. Заналт дайснуудаас өшөө авахыг бодолхийлж байсан Тэмүжиний хувьд Бэгтэрийн характер түүнийг дайснаа болгож харахад хүргэжээ. Энэ талаар Академич Ш.Нацагдорж “...Бэгтэрийн доромжлол нь тайчуудын дарлалд хорсон тачаадаж явсан Тэмүжиний бухимдлыг туйлд нь хүргэн эцсийн бүлэгт Бэгтэрийг хороох аймшигтай алхам хийхэд хүргэсэн бололтой.”¹⁶ гэжээ. Эндээс харвал Тэмүжин Бэгтэрийг харваж байхдаа хойшдын үйл хэрэгт нь дайсан болох хүнээ хороож буйгаа мэдэж байсан биз ээ. Энэ тухай “МНТ”-нд өгүүлэхдээ Тэмүжин, Хасар хоёр Бэгтэрийн

¹⁴ Рене Груссе “Орчлонг эзэгнэгч Чингис хаан” (орчуулсан Чойнзонгийн Баатар), ред:Сандуйжавын Одхүү, УБ.,2001, т.61.

¹⁵ Лео Де Хартог “Дэлхийг эзэгнэгч Чингис хаан”, /Эх хэлнээ хөрвүүлсэн Ж.Насанжаргал, хянан тохиолдуулсан Академич Ч.Далай/, УБ.,2004, т.36.

¹⁶ Ш.Нацагдорж “Чингис хааны цадиг”, УБ.,1991, т.29.

дээрэнгүй зан авир гаргаад байгаа тухай Өэлүн эхэд өгүүлдэг билээ.¹⁷ Энэ нь “одоо биднийг ингэж дээрэлхэж байна, хожмын хойно яах вэ?” гэсэн бодлыг өөртөө тээх Тэмүжин хүүгийн санааг сая уншиж ойлгож болох мэт. Ингэж үзвэл Бэгтэрийг харваж алснаас Тэмүжиний өшөөт дайснаа дарах эхлэл тавигджээ гэж хэлж болох юм. Учир нь Бэгтэр, Тэмүжин нар хоёул Боржигин овгийн угсаа залгамжлах хөвүүд байсан агаад энэ дэлхийд нэг л нар хүн төрөлхтөнг гийгүүлдэг гэдгийг бяцхан хоёр хөвүүн ухаан санаандаа аль эрт ойлгосон байжээ.

Бэгтэр бол Тэмүжинтэй эцэг нэг, эх ондоотой, түүний (Бэгтэрийн) зан авир нь ч дээрэлхүү, түрэмгий, тэгээд ч тэрээр Тэмүжинээс хоёр насаар ахмад байв. Бэгтэр Тэмүжинээс насаар ахмад байсныг нотлох баримт монголын түүхийн сурвалж бичгүүдэд үлджээ. Тухайлбал: Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны “Алтан товч”-д өгүүлснээр “... Есүхэй баатар нь Жоу овгийн Мангала-г хатан авч, түүнээс Бэгтэр, Бэлгэтэй хоёр хөвгүүнтэй ажгуу. Тэр цагт Тайжуудын Эршилт хэмээгч Олханууд овгийн Өлэнийг (Өэлүн) хатан авсан ажгуу.”¹⁸ гэжээ. Дарма гүүшийн “Алтан хүрдэн мянган хигээст” зохиолд тэмдэглэснээр “.... {Заримууд Өгүлэн хатны хээлэнд ирсэн хөвгүүн Бэгтэр хэмээмү. Заримууд **урьд хатан Мангилынхаас** бөх Бэлгэтэй (МНТ:Бэлгүтэй) ба Бэрх Бэгтэр үр үгүй} Хоёр лугаа зургаан хөвгүүн хэмээхийн тавны язгуур уг, ихэд дэлгэрвэй.”¹⁹ гэжээ. Ната Гомбованжилын “Алтан эрих” зохиолд “... Есүхэй эзэн нүүх улсын олонхи аймгийг эзэллээ. Түүний зургаан хөвгүүн Чингис хаан, өргөсөн нэр Тэмүжин хэмээмүй. Хавт Хасар, Хажарчи Хачигу (Хачигун), Ойт Очигу(Отчигин), Бэрх Бэгтэр [үргүй], Бөх Бэлгэтэй эд буюу. Олонхи бичигт энэ мэт атал шинжилбээс, зарим бичигт **урд хатны хөвгүүн** Бэгтэр, Бэлгэтэй хэмээн агч (байгч) ариун мэт байнам.”²⁰ гэжээ. Мэргэн гэгээн Лувсандамбийжалцаны “Алтан товч” зохиолд “...Бэхи Бэгтэрийн шарх нь хувилаад, хүнддэж нөгчив. Бөх Бэлгэтэй өгүүллрүүн: “Ах үр үгүй нөгчив. Тэмүлэний үр зээ-г **манай их ахын** улсад эзэн болговоос ямар буй” хэмээсэнд Сүбээдэй баатар энэ үг маш их зөв хэмээгээд ...”²¹ гэж өгүүлжээ. Эдгээр эх сурвалжуудаас харвал Бэгтэрийн эх Сочигэл Өэлүнээс эрт Есүхэйн гэрт ирсэн ба Бэгтэр Тэмүжинээс өмнө төржээ. Гэвч зарим сурвалжуудад арай өөр мэдээлэл байгааг орхиж яахан болох билээ. Тухайлбал: Саган сэцэний “Эрдэнийн товч”-д өгүүлснээр “...Тэр Тэмүжин лүгээ нэгэн эхтэй Хасар, Хачигин, Очигин дөрвөн хөвгүүд, Тэмүлэн гоо авхай ба Дагаши хатнаас төрсөн Бэгтэр, Бэлгүтэй хоёр лугаа зургаан болой.”²² гэжээ. Мөн “Хөх түүх”-д: “... Тэр Чингис хааны **таван дүү нар** нь Хавт Хасар /эзэн/, Бөх Бэлгүдэй, Отчигин, Харт Хачигу /Хачиун/, Бөх Баатар/Бэгтэр/ лүгээ тав болой.”²³ гэжээ. Гончигжавын “Сувд эрих хэмээгдэх шастир оршив” хэмээх зохиолд “... Бас **Өэлэн хатнаас төрсөн Хасар, Очигин, Хачигин ба бага хатан Данашигаас төрсөн Бэгтэр, Бэлгэтэй эд тавуул цөм Тэмүжиний дүү буюу.**”²⁴ гэжээ. Мөн “Хөх түүх”-д өгүүлэхдээ: “Их Өгэлэн хатнаас дөрвөн хөвгүүн, нэг авхай (охин.О.Д), бага Данагш хатнаас хоёр хөвгүүн буйгаас, **их хөвгүүн нь тэнгэрээс заяат Тэмүжин хаан** хөвгүүн /бөгөөд/ тэр нь магад Очирваанийн хувилгаан буюу.”²⁵ гэжээ. Ишбалданы “Эрдэнийн эрих”-д: “Их хатанд хөвгүүн дөрөв, охин нэг, бага хатанд хөвгүүн

¹⁷ “Монголын Нууц Товчоо”, (Монголын Нууц Товчооны эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, (76, 77 дугаар зүйл), УБ.,2006, т.38.

¹⁸ Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан “Алтан товч” (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн Д.Бүрнээ), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.60.

¹⁹ Дарма гүүш “Алтан хүрдэн мянган хигээст”(Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн Т.Жамъянсүрэн, Л.Халиун), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.38.

²⁰ Ната Гомбованжил “Алтан эрих”(Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн доктор (Ph.D), проф Д.Бүрнээ), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.19.

²¹ Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан “Алтан товч” (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн Д.Бүрнээ), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.65.

²² Саган Сэцэн “Эрдэнийн товч”(Сонгомол эх бэлтгэж, хөрвүүлэг, тайлбар зүүлт хийсэн М.Баярсайхан), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.58.

²³ “Чингис хааны үе улирлыг тэмдэглэсэн хаадын үндэсний шастир ХӨХ ТҮҮХ” (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн О.Дэмчигмаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.56.

²⁴ Гончигжав “Дай Юань Улсын суут Богд Чингисийн сувд эрих хэмээх шастир оршвой”(Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн С.Амарбаяр), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.62.

²⁵ “Чингис хааны үе улирлыг тэмдэглэсэн хаадын үндэсний шастир ХӨХ ТҮҮХ” (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн О.Дэмчигмаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.46.

хоёр байсан буй. Түүнээс их хатны их хөвгүүн нь Тэмүжин хэмээх алдартай Очирваанийн хувилгаанд алдаршсан...” гэж²⁶ сурвалжуудад тэмдэглэгдэж үлджээ. Ломи “Монгол боржигид овгийн түүх”-д өгүүлснээр: “Есүхэй баатараас төрсөн нь зургаан хөвгүүн, ахмад хөвгүүн Чингис хаан Тэмүжин, дэд хөвгүүн хавт Хасар, гутгаар хөвгүүн Очугу, дөтгөөр хөвгүүн Гачугу, тавдугаар хөвгүүн Бэгтэр, зургадугаар хөвгүүн Бэлгэтэй.”²⁷ гэжээ. Академич Б.Я.Владимирцов “....Есүхэй баатар **ууган хүүдээ** эхнэр болох охин олж өгөхөөр хүүгээ дагуулан, эхнэрийнхээ төрхөм Олхуноуд аймагт очижээ...”²⁸ гэж дурджээ. Райнхолд Нойман-Ходиц Тэмүжинийг “...Тэрээр гэрийн эр хүн, эцгийн хамгийн **ахмад хөвгүүн**, өрхийн толгойлогч байлаа”²⁹ гэж үзжээ. Дээрх түүхийн эх сурвалжуудаас үзвэл Бэгтэр Тэмүжинээс насаар ахмад бус байсныг харуулж байна. Харин чухамхүү ямар учир шалтгааны үүднээс Тэмүжинийг Бэгтэрээс ах байсан гэж эх сурвалжуудад үлдээв? Түүхийн эх сурвалжуудын нилээд нь “Монголын Нууц товчоо”-г гол цөм эх сурвалжаа болгож ашигласан байдаг. “МНТ” нь Их Эзэн Чингис хааны үүх түүх, түүний дэлхий дахинаа байлдан дагуулсан их үйл хэргийн талаар өгүүлдгээс бус чухам Бэгтэрийн хэн болох, түүний эх Сочигэл Есүхэй баатартай хэдийд хуримласан зэрэг мэдээ тун хомс билээ. Нөгөө талаар “МНТ” бол Чингис хааны хэрэг явдлыг түүхийн тавцанд гаргаж тавьсан хийгээд түүний талаар ихийг өгүүлэх агаад энэ мэтээр харвал түүнд (Эзэн Чингис хаанд) зориулагдсан түүх гэж хэлж болох юм. Энэ талаар эрдэмтэн П.Поуха “Монголын нууц товчоо бол түүх ба уран зохиолын дурсгалт бичиг мөн” гэдэг зохиолдоо бичихдээ: “Нууц товчоо бол бүх ард түмэнд зориулсан зохиол биш, Монголын тэр үеийн тэргүүлэгч Чингис хаан ба түүний гэр бүлд зориулж бичсэн зохиол юм”³⁰ гэж өгүүлжээ. Энэ үүднээс үзвэл дээрх түүхийн эх сурвалжуудад Тэмүжинийг Бэгтэрээс ахмад байсан мэтээр тэмдэглэн үлдээсэн нь Тэмүжиний олон Монгол овгийг нэгтгэж нэгдсэн улс байгуулсан хийгээд дэлхий дахинд байгуулсан түүний гавъяа зүтгэлийг үнэлсэн(үнэлж бичсэн) хэрэг юм.

Есүхэй баатар болбоос хоёр хатантай байв. Есүхэй баатрын эхэлж буулгасан хатан бол Бэгтэр, Бэлгүтэй нарын эх Сочигэл, түүний дараа Чингис хааны эх Өэлүн Үжин Боржигин овогт иржээ. Өэлүн Үжин Есүхэйн гол хатан байжээ. Учир нь тухайн үед үе угсаа залгамжлах ёс заншлын дагуу тухайн язгууртны ганцхан(гол) эхнэрийн хүүхдүүд л ах захаа баримтлан үе залгамжилдаг байсан аж.³¹ Тиймээс Өэлүн эхээс төрсөн Тэмүжинд Есүхэй баатар эхнэр олж өгөхөөр эхнэрийн төрхөм олхануд аймагт очжээ. Энэ нь Есүхэй баатар Тэмүжинийг өөрийн хаан удмын угсаа залгамжлах хөвүүнээр сонгосон болох нь нэгэнт тодорхой байна. Сурвалжид: “Есүхэй эзэн хальсны хойно ёст хөвгүүн Чингис хаан залгамжилбай.”³² гэжээ. Харин Сочигэл эх Есүхэйн гол хатан байгаагүй бололтой байна. Тэр гэрт эзлэх эрх ямбаар Өэлүнээс доогуур байсныг нэгэнт сурвалжууд бидэнд хэлж өгч байна. Хаадын түүхийг өгүүлэх “Хөх түүх” зохиолд: “.... Их Өгэлэн хатнаас дөрвөн хөвгүүн, нэг авхай(охин.О.Д), **бага Данагш хатнаас** хоёр хөвгүүн буйгаас, их хөвгүүн нь

²⁶ Ишбалдан “Монголын оронд хааны угсаа хийгээд шашин дэлгэрсэн, шашныг баригчин үсэг урласан, хийд аймаг тэргүүтэн ямар мэт гарсны ёсыг номлосон эрдэнийн эрих оршвой”, (Төвд хэлээрхи сурвалжуудтай харгуулан, монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хэлхээс хийсэн Д.Бүрнээ), (Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал) УБ.,2006, т.15, 16.

²⁷ Ломи “Монгол боржигид овгийн түүх”, (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн М.Баярсайхан, Р.Төрдалай), (Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал), УБ.,2006, т.20.

²⁸ Б.Я.Валидимирцов “Чингис хаан”, /Олон улсын Монгол судлалын холбооноос эрхлэн гаргав/, “Дэлхийн Монгол судлалын дээжээс” 1996 цуврал (1), /цувралын эрхлэгч Академич Ш.Бира/, (Орос хэлнээс орчуулсан Б.Дашцэрэн), УБ.,1996, т.12.

²⁹ Райнхолд Нойман-Ходиц “Чингис хаан” (Болгар хэлнээс орчуулсан Д.Батсайхан), Монгол найруулгыг хянан тохиолдуулсан Б.Даш-Ёндон, УБ.,2002, т.23.

³⁰ П.Поуха “Монголын нууц товчоо бол түүх ба уран зохиолын дурсгалт бичиг мөн” Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн хэвлэл, Улаанбаатар, 1957, т.3.

³¹ Рене Груссе “Орчлонг эзэгнэгч Чингис хаан” (орчуулагч Чойнзонгийн Баатар, ред:Сандуйжавын Одхүү), УБ.,2001, т.64.

³² Гомбожав “Гангын урсгал”, (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн Б.Баяртуяа, Ц.Батдорж, Б.Пүрэвбаатар), (Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал), УБ.,2006, т.12.

тэнгэрээс заяат Тэмүжин хаан хөвгүүн /бөгөөд/ тэр нь магад Очирваанийн хувилгаан буюу.”³³ гэжээ. Мөн Ишбалданы “Эрдэнийн эрих” зохиолд: “... тэр цагт Есүхэй баатар түүнд хатан Өэлин хийгээд Танагши хэмээх байжээ. **Их хатанд** хөвгүүн дөрөв, охин нэг, **бага хатанд** хөвгүүн хоёр байсан буй. Түүнээс их хатны их хөвгүүн нь Тэмүжин хэмээх алдартай Очирваанийн хувилгаанд алдаршсан] ...”³⁴ гэжээ. Галданы “Эрдэнийн эрих” зохиолд ...Есүхэй баатар, түүний их хатан Өгэлэн, **бага хатан** Танагши хоёр. Их хатнаас Хасар, Хачигин, Өчигин гурван хөвгүүн, **бага хатнаас** Бэгтэр, Бэлгэтэй хоёр хөвгүүн төрөв.”³⁵ гэжээ. Түүхийн бусад сурвалжуудад Сочигэл эхийн талаар сонирхолтой мэдээ занги үлдээсэн байна. Тухайлбал, “Юань улсын түүх” зохиолд: “Лецзу”-гийн таван хөвгүүдээс Тэмүгэ Отчигин дөрөвдүгээрт, Бэлгүдэй тавдугаарт буй, энэ нь хатан хийгээд татвар эмээс гарснаар нь эш болгосон тул насны их багаар нь дараалаагүй юм.”³⁶ гэжээ. Дээрх зохиолд Сочигэл эхийг Есүхэйн татвар эм гэж үзсэн нь ихэнхи судлаачдын Сочигэл эх бол Есүхэй баатрын нөгөө гэргий (хатан) байсан гэдэг үзэлтэй харшилдаж байна. Дээрх түүхийн сурвалж дахь мэдээнд үндэслэвэл, Сочигэл эх Есүхэйн албан ёсны гэргий хараахан биш агаад тэрээр /Сочигэл/татвар эм, сул хатан байжээ. Есүхэй баатар бусад аймагтай хямралдан тэмцэлдэж байх цагт /магадгүй Сочигэлийг дайнаас олзлон авсан байх/Сочигэлтэй танилцаж тэдний дундаас Бэгтэр, Бэлгүтэй хоёр хөвүүн төржээ. Гэвч Сочигэл эх бол Есүхэйн татвар эм /сул хатан/ байсан уу гэдэг асуулт дахин урган гарч ирж байна. Түүхийн ганц сурвалжийн мэдээнд үндэслэж Сочигэлийг Есүхэйн татвар сул эм байсан гэж үзэх нь түүхэн үнэнд үл нийцэх ажгуу. “Юань улсын судар”-ыг бичихдээ зохиогч ямар ямар сурвалжууд дээр тулгуурлаж бичиж вэ? гэдэг нь чухал ба нөгөөтэйгүүр зохиогч Чингисийн алтан ургийн цагаан ястаны байр суурийг өндөрт өргөж харуулахдаа чухамхүү Сочигэлийг Есүхэй баатрын сул эм байсан ба түүнээс гарсан хөвүүд бол алтан ургийн залгамжлагч байж чадаагүй юм гэдгийг тодотгож өгөх гэсэн санаа ч байж болох юм. Энэ үүднээс үзвэл Бэгтэр, Бэлгүтэй нарт Тэмүжиний адилаар хаан эрх заяагдсангүй гэсэн санааг “Юань улсын түүх”-ийн зохиогч тэмдэглэжээ. Дээрх түүхийн сурвалж дахь мэдээ нь түүхч, судлаачдыг өөрсдийн баримталж ирсэн үзэл бодол, онолоо өөр өнцгөөс, өөр байдлаас харахыг шаардаж буй авч бидний үзэж буйгаар Сочигэл эх бол Есүхэйн татвар (сул) эм хараахан биш агаад харин түүний (Есүхэйн) нөгөө гэргий /байсан/ юм. Энэ талаар Лу “Алтан товч”-д өгүүлэхдээ: “Есүхэй баатрын нөгөө гэргий Сучигэл /Сүчигэл.хөр./ эхээс төрсөн Бэгтэр, Бэлгэтэй хоёр бүлгээ.” /Лу.Алтан товч/³⁷ гэжээ. Эндээс харвал Сочигэл эх бол Есүхэйн татвар(сул) эм бус харин түүний гэргий болох нь маргаангүй юм. Харин Сочигэл эх Боржигин овгийн энэ айлд их хатан өөрөөр хэлбэл Есүхэйн гол хатан байж чадсангүй гэдэг нь дээрх сурвалжуудаас тодорхой харагдаж байна. Өөрөөр хэлбэл, Сочигэл эх Өэлүнийг Есүхэйн гэргий болж ирэхээс өмнө энэ айлд ирж Бэгтэр, Бэлгүтэй хоёр хөвүүнийг төрүүлжээ. Гэвч Сочигэлээс урьтаж Өэлүн алтан ургийн язгууртан энэ айлд хатан өргөмжлөгджээ. Залуу Өэлүний хэрсүү ухаан, ертөнцийг үзэх үзэл нь нэлээд задарсан байсан ба тэр хэдийгээр боржигин овгийн бэр болж ирэхдээ хайрт эр нөхөрөөсөө булаагдаж энэ ургийн хүн болсон боловч түүний бодол сэтгэл зүй, сэтгэлгээний хандлага нь Монголын алтан ургийн боржигин овгийн ирээдүйн хөгжлийн төлөө ихээхэн санаа тавьж зовниж байсан явдал нь алтан ургийнханд хатан болж сэтгэгджээ.

³³ “Чингис хааны үе улирлыг тэмдэглэсэн хаадын үндэсний шастир ХӨХ ТҮҮХ” (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн О.Дэмчигмаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.46.

³⁴ Ишбалдан “Монголын оронд хааны угсаа хийгээд шашин дэлгэрсэн, шашныг баригчин үсэг урласан, хийд аймаг тэргүүтэн ямар мэт гарсны ёсыг номлосон эрдэнийн эрих оршвой” (Төвд хэлээрхи сурвалжуудтай харгуулан, монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хэлхээс хийсэн Д.Бүрнээ), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.15,16.

³⁵ Галдан “Эрдэнийн эрих хэмээх түүх болой” (Монгол бичгээс хөрвүүлж, эхүүдийг харьцуулан тулгаж, оршил бичин, тайлбар хийсэн доктор Ж.Гэрэлбадрах, Д.Бүдсүрэн, П.Бямбахорол), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.99.

³⁶ Ж.Баясах “Их Монгол Улсын түүхэнд холбогдох хоёр сурвалж бичиг”, УБ.,2005, т.164.

³⁷ Лувсанданзан “Эртний Хаадын Үндэслэсэн Төр Ёсны Зохиолыг Товчлон Хураасан Алтан Товч Хэмээх Оршвой” (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.46.

Сочигэл эх гэрийн дотор байр суурь, эрх мэдэлээр доогуур байсан ба өөрийн эхийн энэхүү байдлыг Бэгтэр харж мэдээд Өэлүний хөвүүдтэй тэрсэлдэж эхэлсэн нь гарцаагүй юм.

Тэмүжин, Бэгтэр нарын хэн нь эцэг Есүхэйн байр суурийг залгамжлах асуудал Өэлүний гэр бүлийнхний уур амьсгал, байдлыг улам хурцатгасан нь лавтай. Уг нь том хатны хөвүүн хаан ширээнд залрах ёстой талын нүүдэлчдийн заншил ёсоор Бэгтэр монгол боржигин овгийн хаан сууринд залрах ёстой байлаа. Гэвч түүний эх Сочигэл их хатан, гол хатны байр сууриа Өэлүнд алджээ. Дээр өгүүлсэнчлэн энэ үед үе угсаа залгамжлах ёс заншлын дагуу тухайн язгууртны ганцхан(гол) эхнэрийн хүүхдүүд л ах захаа баримтлан үе залгамжилдаг байсан аж.³⁸ Иймд Есүхэй баатрын суурийг Бэгтэр бус Өэлүн эхээс төрсөн Тэмүжин залгамжлах нь нэгэнт тодорхой болжээ. Гэвч Сочигэл эхээс төрсөн Бэгтэр хаан эцгийн суурийг залгамжлах ёстой гэсэн яриа алтан ургийн зарим язгууртнуудын дунд яригдах болсон биз ээ. Тиймээс Тэмүжин эцэг Есүхэйн суурийг залгамжлахад юу ч саад болж чадахгүй гэдэг асуудал бэрхтэй болжээ.

Тэмүжин Бэгтэрийг улс төрийн эрх мэдэл, язгууртан байдалтай эн зэрэгцэх дайснаа гэж үзээд хороожээ. Түүний дүү Бэлгүтэйг яагаад Бэгтэрийн адил үгүй хийхийг урьтал болгосонгүй вэ? Харин дүү Бэлгүтэй ахаасаа арай өөр зан араншинтай хөвүүн байсан учир Тэмүжин түүнийг хороолгүй үлдээсэн нь илт. Нэг эхийн хэвлийгээс төрж, нэг модноос салаалсан ахыгаа хөнөөлгөчихөөд Бэлгүтэй зүгээр хараад эс өнгөрөх гэдгийг Тэмүжин хүү ухаараагүй гэж үү. Ингэж үзвэл Бэлгүтэйг Тэмүжин Бэгтэрийн адил мөн л хөнөөж орхих байсан биз ээ. Харин Бэлгүтэй бол биерхүү хүчтэй учир тэр гэр бүлд загас барих, ан агнах зэрэг ажилд дуулгавартайгаар хүчээ өгч байхыг Тэмүжин мэдэж байв. Саган Сэцэний “Эрдэний товч”-д өгүүлснээр: “... Бэгтэр өгүүлрүүн, намайг албаас алагтун, Бэлгүтэйг минь бүү ал. Нэгэн цагт танд хүчээ өгөх хүн буй хэмээн өгүүлтэл ...”³⁹ гэжээ. В.Инжаннашийн “Хөх судар” түүхэн романы тэргүүн дэвтэрт “...Есүхэй баатарт таван хөвгүүн буй, ахмад нь Тайцзу Тэмүжин Чингис Богд мөн, хоёрдугаар нь Бөх Бэлгүтэй, зэв чулуунд оногдовч өчүүхэн ч алддаггүй тул Бөх Бэлгүтэй хэмээжүхүй.”⁴⁰ гэжээ. “Монголын нууц товчоо”-нд өгүүлснээр, “Нэгэн өдөр шарга агттан найман морьд гэрийн дэргэд байж бүхүйг дээрэм ирж, үзтэл дээрэмдэж зорчив. Явган үзэж хоцров. Бэлгүдэй оготор дарги хонгорыг унаж, тарвагачилахаар одож бүлгээ. Үдэш нар шингэсний хойно Бэлгүдэй дарги оготор хонгорт тарвага ачиж, нягсалзуултал явган хөтөлж ирэв. “Шарга агттаныг дээрэм авч одов.” хэмээвээс Бэлгүдэй өгүүлрүүн: “Би нэхсү” хэмээв.”⁴¹ гэжээ. Хятадын эрдэмтэн Жү Яотины зохиолд өгүүлэхдээ: “Арван хэдэн настай Бэлгүтэй чадал тэнхээ чамгүй их болсон учир тэр даруй мод цавчин хамгаалалт бэхлэлтийн шивээ барив.”⁴² гэжээ. Германы эрдэмтэн Райнхолд Нойман-ходиц “Чингис хаан” хэмээх номондоо: “...Бэлгүтэй Чингис хаанд үргэлж үнэнчээр үлдсэн байна.”⁴³ гэж өгүүлжээ. Энэ бүгдээс харвал Бэлгүтэйд (энэ гэр бүлд өөрийн хүчийг гаргаж чадах)

³⁸ Рене Груссе “Орчлонг эзэгнэгч Чингис хаан” (орчуулагч Чойнзонгийн Баатар, ред:Сандуйжавын Одхүү), УБ.,2001, т.64.

³⁹ Саган Сэцэн “Эрдэний товч”, (Сонгомол эх бэлтгэж, хөрвүүлэг, тайлбар зүүлт хийсэн М.Баярсайхан), УБ.,2006, т.59.

⁴⁰ Ванчинбалын Инжаннаши “Хөх судар”, (Тэргүүн дэвтэр), (Монгол бичгээс хөрвүүлэн оршил бичиж, тайлбар зүүлт хийсэн Ш.Чоймаа, М.Баярсайхан), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.128.

⁴¹ “Монголын Нууц Товчоо”, (Монголын Нууц Товчооны эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, (90 дүгээр зүйл), УБ.,2006, т.44, 45. (Мөн энэ тухай өөр нэг сурвалжид өгүүлснээр “Түүнээсээ Бурхан халдуны өвөр Сэнгүрийн горхин нутаглаж суутал нэгэн өдөр найман шарга морийг дээрэм булааж одвой. Тэр өдрийн үдэш Бэлгүтэй дарги хонгорт тарвага ачиж, явган хөтөлж ирээд: -Би нэхсү (=нэхье) гэв.” гэжээ. (Жамба “Асрагч нэртнийн түүх” (Хөрвүүлж, тайлбар зүүлт, нэрийн хэлхээ хийсэн доктор (Ph.D) Д.Заяабаатар), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006, т.20.)

⁴² Жү Яотин “Чингис хааны түүх шастир” (Хятад хэлнээс орчуулсан Оцолын Адъяа), УБ.,2002, т.46. /профессор Ш.Чоймаагийн хөрвүүлсэн Монголын Нууц Товчоонд өгүүлснээр: “... Бэлгүдэй мод хуга таталж, шивээ барьж, ...” гэжээ. /Тайчуудын Таргудай Хирилтуг шадар нөхдөө дагуулж, <<Хурганы үс гуужив, төлөгний бие төлжив>>(Өэлүний хөвүүд тэнхрэв) гэж доглохоор ирэхэд, тэднээс айж Өэлүн үжин хөвүүдийн хамт ой шугуйд дутаахад Бэлгүтэй мод хугалж шивээ барьжээ. / (“Монголын Нууц Товчоо”, (Монголын Нууц Товчооны эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, (79 дүгээр зүйл), УБ.,2006, т.40.)

⁴³ Райнхолд Нойман-Ходиц “Чингис хаан” (Болгар хэлнээс орчуулсан Д.Батсайхан), Монгол найруулгыг хянан тохиолдуулсан Б.Даш-Ёндон, УБ.,2002, т.23.

хүч чадал, зориг тэвчээр /аль хэдийн/ суусан байжээ. Гэсэн ч Бэлгүтэй гэрийн эзэн Тэмүжиний өөдөөс хараахан хөдөлж чадах зүрх зориг түүнд дутаж /дутагдаж/ байсан биз ээ. Нөгөөтэйгүүр нэг удам угсааны ах дүү хоёрыг хөнөөвөл өстөн дайснууддаа эв эегүй харагдаж бусдын шүдний чигчлүүр болно гэдгийг Тэмүжин хүү ойлгож ухаарсан байжээ. Эцэг нэг, эх өөр ах дүү нараа хөнөөвөл Өөлүн эхийн царайг яаж харах билээ. Басхүү хөвүүдийг нь хөнөөчихөөд эх Сочигэлийн өөдөөс яахан инээмсэглэж харж чадах билээ. Ингэж үзвэл Бэгтэр, Бэлгүтэй хоёрын эх Сочигэлтэй тэд нэг гэрт яахин багталцах билээ. Гэсэн ч Тэмүжинд язгууртан хүний эрдэм ухаан аль хэдийн суусан байсан болохоор тэр дайсан болгоноо үгүй хийж хороох тухай санаа түүнд байгаагүй юм. Академич Б.Я.Владимирцов "Чингис хаан" хэмээх номондоо: "Тэрээр зүй ёсны эрх дархаас салж ангижирахыг тэвчидэггүй байсан бөгөөд тэр зан араншин нь ах дүү, ард иргэдээ алж талахаас буцахгүй болгосон байж ч магадгүй юм. Гэхдээ тийм ч цус урсгахыг хичээдэг харгис хэрцгий зан авир залуу Тэмүжинд огт байгаагүй ажээ."⁴⁴ гэжээ. Мөн энэ тухай Чжао Хун "Монгол-Татарын бүрэн тэмдэглэл"-д: "Тэр хүмүн /Тэмүжинийг хэлж байна. Л.Б./ баатарлаг бөгөөд эрс шуурхай, цээж уудам, олныг багтааж чадна. Тэнгэр газарт сүсэгтэй, бат журмыг хүндэтгэмой"⁴⁵ гэж дурджээ. Эндээс харахад Тэмүжиний Бэгтэрийг хөнөөсөн нь шударга үнэний төлөө гэсэн Чингис хааны зарчим явагдаж байжээ.

"МНТ"-ны 140-р зүйлд "...Бүри бөх улсын бөх бөгөөтөл, Бэлгүдэйд нуруугаан хугачуулж үхэв"⁴⁶ гэжээ. Мөн зохиолд өгүүлснээр: "Тэнд Бэлгүдэй, Бүри бөх хоёрыг барилдуулахад Бүри бөх үл ялагдах хүн атал унаж өгөв. Бэлгүдэй даран ядан мөрлөж саарь /зоон/ дээр нь гарч, Бэлгүдэй гилжис хийж Чингис хаан руу харвал хаан хөмхийгөө зуув. Бэлгүдэй санаа авч, дээр нь агтлан [дарж] хоёр захы нь солибон мэхийлгэж"⁴⁷ татаж нуруугий нь өвдөглөж хугалж орхив. Бүри бөх нуруугаа хугалуулж өгүүлрүүн: "Бэлгүдэйд үл ялагдах бөлгөө би. Хаанаас айж

Аргадан унаж

Алмайран байж

Аминдаа хүрэв би" хэмээгээд үхэж үлдэв."⁴⁸ гэжээ. Улсын бөх бөгөөтөл Бэлгүдэйд унаж амиа алдсан нь ямар учиртай вэ?⁴⁹ Энд ах дүүгийн хоорондын тэмцлийг Бүри бөх Бэлгүдэйд унаж амиа алдаж ялагдаж буйгаар дүрсэлжээ. Тэмүжин бол Есүхэй баатрын хүү, харин Бүри бол Есүхэй баатрын эцэг Бартан баатарын дүү Хутагт Мөнгүрийн хөвүүн билээ. Иймд тэд ойр төрөл

⁴⁴ Б.Я.Владимирцов "Чингис хаан", /Олон улсын Монгол судлалын холбооноос эрхлэн гаргав/, "Дэлхийн Монгол судлалын дээжээс" 1996 цуврал (1), /цувралын эрхлэгч Академич Ш.Бира/, (Орос хэлнээс орчуулсан Б.Дашцэрэн), УБ.,1996, т.14.

⁴⁵ "Богд баатар биеэр дайсан тэмдэглэл", (Хятад эхээс харгуулан орчуулсан Х.Асралт, Хөх-Өндөр), Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн Хороо, 1985, т.104.

⁴⁶ "Монголын Нууц Товчоо", (Монголын Нууц Товчооны эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, (140 дүгээр зүйл), УБ.,2006, т.82.

⁴⁷ "Ханз галигт mie-ke-chi-lien (тэмдэг үсэг 66-22-41-174) гэсэн үгийг латин галигч megejilen (мэгэжлэн?) гэж буулгажээ. Чухамдаан бол Бэлгүдэй, Бүри-бөхийн нурууг мэхээр мэт мэтийлгэн (=нумруулан) татаад нурууг өвдөглөн хугалж алсан ажээ." гэжээ. (Жүгдэрийн Лувсандорж, "МНТ-ны уг эхийн зөв уншилгын зарим жишээ", // Оюуны хэлхээ, Антоон Мостаэрт-Монгол Судлалын төв, Эрдэм шинжилгээний бичиг, Боть II (12), Эрхэлсэн: Г.Цэцэгдарь, УБ.,2014, т.143.

⁴⁸ Д.Цэрэнсодном "Монголын Нууц Товчоо". Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, редактор, проф Д.Төмөртоого, УБ.,2000, т.77, 78.

⁴⁹ Бүри бөх Бэлгүдэйд унаж амиа алдсан нь ямар учиртай талаар "МНТ"-нд тодорхой тэмдэглэжээ. "МНТ" дахь "Бүри бөх улсын бөх бөгөөтөл, Бэлгүдэйд нуруугаан хугачуулж үхэв" гэсэн өгүүлбэрээс харвал, Бүри улсын бөх хүн, тэр Бэлгүдэйд унаж амиа алдах ёсгүй, Бүри бол бөх хүнд байх ёстой бие, ухаан задарсан байсан гэдгийг уншиж болохоор байна. Тэрчлэн Бэлгүтэй Бүрийг өөрийн хүчээр дийлээгүй нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, Бэлгүтэй Чингис хааны дэмжлэгтэйгээр Бүрийг хороожээ. Энэ тухай НТ-нд өгүүлснээс ил байна. Тухайлбал, Бүри бөх нуруугаа хугалуулж өгүүлрүүн: "Бэлгүдэйд үл ялагдах бөлгөө би. Хаанаас айж

Аргадан унаж

Алмайран байж

Аминдаа хүрэв би" хэмээгээд үхэж үлдэв." гэжээ. Эндээс харвал Бүри бөх Чингис хаанаас айж Бэлгүдэйд унаж, алмайран цаг алдаж байх завсар Бэлгүтэй түүний нурууг хугалж орхив. Чингис хааны Бэлгүдэйд хөмхийгөө зууж дохио өгснийг Бүри бөх аль хэдийн анзаарч эд өөрийг нь алахаар шийдсэнийг тэрээр аль хэдийн мэджээ. Энэ талаар Ж.Баясах өгүүлэхдээ: "... энд өгүүлж буй барилдаан нь наадам хийх үеэр болсон барилдаан бус харин хувийн өшөөрхлөөс болж нэг нь чадлаар дутуу ч хааны дүү гэдгээрээ түрээ барин хүчтэй бөхийн нурууг хугалж алсан тухай өгүүлэмж бөлгөө" гэжээ. (Ж.Баясах "Их Монголын Улсын түүхэнд холбогдох хоёр сурвалж бичиг", УБ.,2005, т.140.)

атал яахин нэг нэгнээ хороов? Учир нь Бүри бөх улсын бөх хүн атал Бархагийн талынханд дулуйдах болсон учир Чингис хаан түүнийг Бэлгүтэйгүүр хороолгов. Бархагийн омгийнхон Бүри бөхтэй нийлж өөрийнх нь эсрэг тэмцэх санаархлыг эзэн Чингис хаан аль эрт гадарласан байсан учир Бүри бөхийг хороов. Энэ нь Чингис хааны эсрэг тэмцэх санаархалтай бүхний сэтгэлийг мохоож орхив. Нөгөөтэйгүүр Жүрхин нарын Чингис хаантай тэрсэлдэх болсон байдал, Бүри бөхийн Сача Бэхи нартай нийлж Эзэн Чингис хааны эсрэг бодол тээх болсон зэргээс үүдэж Чингис хаан түүнийг (Бүри бөхийг) цаазалжээ. А.Амарын “Монголын товч түүх”-д өгүүлснээр: “...Түүнээс Тэмүжин нэгэн өдөр Бэлгүтэй, Бүрибөх хоёрыг барилдуулж, Бэлгүтэй, Бүрибөхийн нурууг хугалж, үхүүлэв. Бүрибөх нь Тэмүжинд хортой санаа санаж явсны учир болой.”⁵⁰ гэжээ. “МНТ”-нд өгүүлсэнчлэн Чингис хаан Бэлгүтэйд хөмхийгөө зууж дохио өгдөг. Бэлгүтэй Чингис хааны бодлыг ойлгоод Бүри бөхийн нурууг хугалж алдаг. Эндээс харвал Эзэн Чингис хаан Бүри бөхийг өөрөөс нь урвасны төлөө түүнийг цаазлах тухай зарлиг (Бүри бөхийг алах)-ыг Бэлгүтэйд өгсөн нь гарцаагүй байна. Ингэж үзвэл Чингис хаан Бүрийг цаазалсан, цаазлах зарлиг буулгасан нь тодорхой байна. Учир нь тухайн үед хааны цааз, зарлиг ганцхан бичгээр гардаггүй байв. Энэ нь тухайн үеийн дайн байлдааны нөхцөл байдлаас шалтгаалж хаан цэргүүддээ хурдан зарлиг буулгах, цэрэг дайны арга тактикаа түргэн шийдэх зэрэгтэй холбоотой байв.

Чингис хаан Бэлгүтэйгээр Бүри бөхийн нурууг хугалуулж түүнийг хороосон нь ганц дан Чингис хаан, Бүри бөх, Бэлгүтэй нарын хооронд өрнөсөн үйл явдал биш харин нэлээд учир шалтгаантай байна. Тэмүжин цэргээ арван гурван хэсэг болгоод “Даланбалжуд” гэдэг газар Жамухатай тулалдав. Энэ тулалдаанд “Чингис хаан Жамухад хөтлөгдөж Ононы Жэрэнэ хавцгайд хоргодов.”⁵¹ “Жамухаа тэндээс хариулаад Уруудын Жүрчидэйг Уруудаа удирдаад Мангудын Хуйлдар Мангуудаа удирдаад Жамухаас хагацаж Чингис хаанд ирэв. Хонхотаны Мүнлиг эцэг тэнд Жамухад байжээ. Мүнлиг эцэг долоон хөвүүнтэйгээ Жамухаас салж, тэнд Чингис хаанд нийлэн ирэв.”⁵² Жамухын хүмүүс түүнээс хагацаж Тэмүжинд ирэхэд “Тэмүжин олон садан төрлийн

⁵⁰ А.Амар “Монголын товч түүх”, /ред:А.Очир/, УБ.,1990, т.113.

⁵¹ Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоого/, УБ.,2000, т.72.

⁵² Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоого/, УБ.,2000, т.73. “Сацэ Бэхи эхэн үедээ Жамухыг дагалдаж явсан боловч Жамуха өөрийн хамсаатан аймгийг дээрэмдэх харгислах зэргээр ёс бусчилсан учир тэд санал алдагдаж Жамухаас хөндийрөн салахад Жүрхэн нар мөн салан Тэмүжинтэй ирж нийлсэн ажээ. Чухамхүү ийм учраас Тэмүжин Сацэ Бэхи нарт талархан Ононгийн шугуйд хурим хийжээ.” (Ш.Нацагдорж “Чингис хааны цадиг”, УБ.,1990, т.68) Юань Улсын судар”-т тэмдэглэсэн нь: “... Тэр цагт Хааны гавъяа, эрдэм улмаар мандах тул Тайчууд олон аймаг олонхи нь түүний эзний хууль бусд зовох бөгөөд Хааны агуу өршөөлөөр хүнд дээл ба морь хүртээхийг үзэж сэтгэлд хүсэж Чулуун (齊拉袞 qí la gun) ба Зэв (哲伯 zhe bo) ба Силгэ өвгөн (錫六格額布根 xī lu ge e bu gen) ба олон хүн, Долонгис (多隆吉斯 duo long ji si) ба Жалар (扎拉爾 zha la er) ба Мангу (莽果 mang guo) олон аймаг цөм журмыг хүсэж дагахаар иржээ. Хаан олон төрлийг цуглуулахад Сэцэн Тайчу (色辰岱酬 se chen dai chou) жич Сэцэн [17] Бухи (色辰伯奇 se chen bo qi) нар тус тус тугаан авч тэргэнд чигээ зүйлийг агуулж Ону (鄂諾 e nuo) голын дээр хуримлахад Хаан ба олон төрөл жич Сэцэн Бухын эх Хурц (呼爾察 hu er cha)-ын (МНТ:Хуурчин) өмнө бүгдэд нэгэн тулам чигээ тавиад Сэцэн бухын дараа эх Ибгэл (伊伯格勒 yí bog ge le)-ийн (МНТ:Эбэхэйд) өмнө гагцаарт нэг тулам тавьсан тулд Хурц уурлаж өгүүллүүн: -“Өдгөө намайг хүндлэхгүй бөгөөд Ибгэлийг эрхэмлэмүй юү” хэмээгээд Хааны зоогийг эрхлэгч Шихир (實奇爾 shí qí er)-ийг явсан нь хэмээн сэжиглэж туйвандсан тулд даруй өс бололцов.” (Юань Улсын судар 元史 (Хятад хэлнээс орчуулсан Ч.Дэмчигдорж (Дандаа), (Монгол бичгээс хөрвүүлж, тайлбар сэлт үйлдсэн: А.Алимаа, Д.Боролзой, С.Мөнхсайхан, Б.Төвшинтөгс), УБ.,2002, т.28, 29). “Юань Улсын судар”-т Сача бэхийн эх Хурц болон бусад хүмүүсийн өмнө нэгэн тулам чигээг тавиад, эх Ибгэл хатанд гагцаар нэг тулам чигээ тавьсанд Хурц хатан хуримын зоогийн эрхлэгч Шихирийг загнасанд үүнээс үүдэж хуримлаж байсан хүмүүс хоорондоо өс бололцож зодоон гарах шалтгаан бий болжээ. “Юань Улсын судар”-т өгүүлснээс харвал Хуурчин хатан Сача бэхийн төрсөн эх байжээ. Энэ талаар судлаач Антоон Мостаэрт тайлбар гаргалгаа хийжээ. Антоон Мостаэртын “Монголын Нууц Товчооны зарим хэсгийн тухай” номонд өгүүлснээр: (XIX. -(53) Уругуд, Мангуд, Хонхотан нарыг Чингистэй нэгдэхээр ирэхэд баяртай хүлээн авчээ. Тэр бээр Өэлүн үжин, Хасар, Жүрхиный хоёр ханхүү Сача бэхи, Тайчу нарыг дагуулан Онон мөрний эрэг дээр найрлажээ. Сайхи найр, найрын үед гарсан маргааны тухай түүхч МНТ-ны § 130-131-д дүрсэлжээ. Удалгүй тулалдаан болж хувирсан уг хэрүүл үүссэн тухай дор өгүүлжээ: ...Энэ хэсгийг гурван орчуулагч дараахи байдлаар орчуулжээ. Козин (т.112): “На пиру первую чару наливали, по порядку, Чингис-хану, Оэлун-учжине, Хасару, Сача-беки с его родными. Затем кравчий стал наливать чару по очереди, начиная с молодой жены Сача-беки по имени Ебегай. Тогда ханши Хорочжин-хатун и Хуурчин-Хатун нанесли оскорбление

хамтаар Онон голын шугуйд хуримлан баяр найр хийсэн бөлгөө.⁵³ Гэтэл энэ үед Хабул хааны ахмад хөвгүүн Охинбархагийн хөвгүүн Хутугту жүрхэ, түүний хөвгүүн Сэчэ-бэхи, түүний дүү

действием кравчему Шикиуру со словами: ‘Как ты смел начинать не с нас, а с Ебегай?’-Найрын үеэр Чингис хаан, Өүлэн үжин, Хасар, Сача бэхи болон төрөл төрөгсдөд ээлж дараалан эхний хундагыг барилаа. Дараа нь сөнч Сача бэхийн Эбэхэй хэмээх залуу хатанд дараагийн хундагыг барив. Тэгтэл Хорожин хатан, Хуурчин хатан хоёр ‘Чи бидэнд бус харин Эбэхэйд эхлэн барьж хэрхэн зүрхлэв? хэмээн хэлээд Шихигүр сөнчийг доромжилов.] Хэниш (т.37): ‘Als sie beim Mahle sassen, schenkte man Tschinggis Chan, Ho‘elun udschin, Chasar, Satscha beki und Genossen zuerst einen Krug ein. Da man dann auch Satscha bekis Nebenfrau Ebegai vor den andern einen Krug einschenken wollte, schlugen Frau Choridschin und Frau Chu‘urtschin beide mit den Worten: ‘Warum schenkt man nicht uns zuerst ein, sondern zuerst der Ebegai? auf den Koch Schiki‘ur los.’ ...н.Пелло Хорижин Хуурчин хоёр хатныг Сача бэхийн их хатад гэж үзсэн боловч үнэн хэрэгтээ тэд түүний эцгийн их хатад байснаас гадна Хуурчин хатан Сача бэхийн эх байжээ. *Богд баатар биеэр дайлан тэмдэглэл* болон *Юань улсын судар* (мөн бүтээл)-аас харна уу. Хоёр бэлбэсэн хатан өөрсдөөс нь дор зиндааны бага хатан Эбэхэйд тэднээс илүү хүндэтгэл үзүүлж байна гэж үзээд дургүйцэж уурласан байна. Энэ хэсгийг би ингэж орчууллаа: Найрлах үеэр домбоноос [ундааг] хамгийн түрүүнд Чингис хаан, Өүлэн үжин, Хасар, Сача бэхи болон бусад хүнд сөгнөөд, мөн [эмэгтэйчүүдэд үйлчилэхдээ] домбоноос-сөнгөөс [ундааг] аягалахдаа Сача бэхийн “өчүүхэн эх” Эбэхэйгээс эхлэхэд Хорижин хатан, Хуурчин хатан хоёр хоёул: “Юунд надаас биш харин Эбэхэйгээс эхлэн аягалав?” хэмээн өгүүлээд тогооч Шихигүрийг занчив.” (Антоон Мостаэрт “Монголын Нууц Товчооны зарим хэсгийн тухай”, УБ.,2010, т.47-49.) “Юань Улсын судар”-т: Сэцэн бухийн эх Хурцын өмнө бүгдэд нэгэн тулам чигээ тавиад харин эх Ибгэлийн өмнө ганцаар нэгэн тулам чигээ тавьсанд Хурц хатан хааны зоогийг эрхлэгч Шихирийг загнажээ. Энд өөрсдөд нь эхэлж чигээ барьсангүй харин Эбэхэйд түрүүлж аягалав гэж Хуурчин, Хорижин хатан хоёр уурлав уу, аль эсвэл Хуурчин хатан, Хорижин хатан хоёрын өмнө нэгэн тулам чигээ тавиад харин эх Эбэхэйн өмнө гагцаар нэгэн тулам чигээ тавьсанд хоёр хатан тогооч Шихигүрийг загнав уу гэсэн асуулт урган гарч байна. Нууц товчоонд: “...хуримлахад Чингис хаан, Өүлэн Үжин, Хасар, Сача Бэхи нарт эхлэн нэгэн сөн сөгнөжээ. Бас Сача бэхийн бага эх Эбэхэй тэргүүлэн нэгэн сөн сөгнөсний учир Хорижин хатан, Хуурчин хатан хоёр “Намайг үл тэргүүлэн юунд Эбэхэйд эхлэн сөгнөв?” хэмээн буурч (тогооч) Шихигүрийг занчив.” гэжээ. (Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоого/, УБ.,2000, т.73). Ц.Дамдинсүрэнгийн орчуулсан “МНТ”-нд өгүүлснээр: “...Чингис хаан, Өүлэн үжин, Хасар, Сача бэхи нарт тэргүүлэн нийжээд хундага барив. Дараа нь Сача бэхи бага эхнэр Эбэхэйд тэргүүлэн хундагалахад, Хорижин хатан, Хуурчин хатан хоёр уурлаж, “Бидэнд тэргүүлэн барихгүй, яагаад Эбэхэйд эхлэн хундагалав” гэж тогооч Шихигүрийг занчив” гэжээ. (“Монголын Нууц Товчоо” Орчин цагийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав.УБ.,2003, т.64.) Лу “Алтан товч”-д: “Чингис хаанаа, Өгүлэн үжинээ, Хасар гурванаа Сэцэн бэхи нэгэн түсэргэ түсэрчүхүй. Бас Сэцэн бэхийн өчүүхэн эх Эбэхэйд тэргүүлэн нэгэн түсэргэ түсэрчүхүй тул Хоричан (МНТ:Хорижин) хатан, Хугугчин (МНТ:Хуурчин) хатан хоёр манаа /бидэнд, хөр/ үл тэргүүлэн хэр түсэрьюү хэмээн буурч Шихигүрийг ашигжухуй /зодчухуй, хөр/. (Лувсанданзаны зохиосон “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч”, (Эх бичгийн цогц судалгаа хийсэн доктор (Sc.D), профессор Шаравын Чоймаа), (XVII зууны Монгол түүхэн сурвалжийн тулгуур эхүүд), УБ.,2011, т.53). Эндээс харвал хурим болоход хоёр талаас (Чингис хааны талаас болон Жүрханий Сача бэхи нарын талаас) хөхүүртэй айраг, чигээг авчирч хуримлажээ. Ингэхдээ Чингис хаан, Өүлэн Үжин, Хасар, Сача бэхи нарт эхэлж барьжээ. Дараа нь мөн л хөхүүртэй айргийн дээжийг аль хүндтэй хүнд эхэлж барьдаг монгол ёсоор хатадын аль их хүмүнд нь барих ёстой байлаа. Уг нь нэгэн тулам чигээг Хуурчин хатан, Хорижин хатан бүгдийн өмнө өөрөөр хэлбэл, олон хүний дунд задалж тавьжээ. Харин хатан Эбэхэйд дангаар нэгэн тулам чигээг задлаад түүний өмнө тавьжээ. Өөрөөр хэлбэл, Хуурчин, Хорижин хоёр хатанд нэг нэг тулам чигээг задалж хундагалаагүй атал Сача бэхийн эхнэр Эбэхэйд нэгэн тулам чигээг дээжээс хундагалаад түүний өмнө тавьсанд хоёр хатан өөрсдийг нь хүндэтгэсэнгүй гэж үзээд Шихигүрийг загнажээ. Угтаа тухайн үеийн монгол ёсоор аль нэр хүндтэй хүнд тулам чигээг дээжээс нь хундагалаж түүний өмнө тэрхүү задалсан чигээг тавих ёстой байжээ. Антоон Мостаэртийн үзэж буйгаар Хуурчин хатан, Хорижин хатан хоёр болбоос Сача бэхийн эцгийн хатад байжээ. Үүнээс Хуурчин хатан болбоос Сача бэхийн төрсөн эх байжээ. (Антоон Мостаэрт “Монголын Нууц Товчооны зарим хэсгийн тухай”, УБ.,2010, т.47-48.). Иймд Сорхату жүрхийн бэр, өөрөөр хэлбэл насаар болоод гэрт эзлэх эрх ямба, байр сууриар доогуур Эбэхэйд нэгэн тулам чигээг гагцаар өмнө нь тавьсанд хоёр хатан тогооч Шихигүрийг загнажээ. Д.Цэрэнсодном, Ц.Дамдинсүрэн нарын орчуулсан “МНТ”-нд өгүүлснээс харахад эхний удаа Чингис хаан, Өүлэн үжин, Хасар, Сача бэхи нарт тэргүүлэн нийжээд хундага барьжээ. Үүний дараа хатдад архи барих ээлж иржээ. Ингээд эхний хундагыг Сача бэхийн эхнэр (хатан) Эбэхэйд тэргүүлэн барьсанд Хуурчин хатан, Хорижин хатан хоёр тогооч Шихигүрийг занчжээ.

⁵³ “Жамухаас өдий улс иргэн салж, Чингис өөртөө ирэв гэж баясч, Чингис хаан, Өүлэн үжин, Хасар, Жүрханий Сача бэхи, Тайчу нар Ононы шугуйд нийлж хуримлав.” (“МНТ” Орчин цагийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав, УБ.,2003, т.62.) “Чингис хаан өөртөө улс ирэв хэмээн баясч Чингис хаан Өгүлэн үжин, Хасар Жүрханий Сача бэхи, Тайчутан болон Ононы түнд хуримлая хэмээлдэж хуримларуун Чингис хаан, Өгүлэн үжинэ, Хасара Сача бэхитэ хийгээд тэргүүлэн нэгэн түсүргэ түсүрчүхүй” гэжээ. (“МНТ” Шанжментавын Гаадамбын сэргээсэн сийрүүлэг эх, Улсын Хэвлэлийн газар, УБ.,1990, т. 66.), “...Чингис хаан өөртөө улс ирэв хэмээн баясаж, Чингис хаан, Өүлэн Үжин, Хасар, Жүрханий Сача бэхи, Тайчу нар хамтаар Ононы шугуйд хуримлая хэмээлдэж, хуримлахад Чингис хаан, Өүлэн Үжин, Хасар, Сача Бэхи нарт эхлэн нэгэн сөн сөгнөжээ. (Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоого/, УБ.,2000, т.73)

Тайчу тан, бас Хабул хааны гуравдугаар хөвгүүн Хутугту монхорын хөвгүүн Бүри бөх нар Тэмүжинд муу сэтгэн явах тул хорлохоор зөвлөлдөж, Тэмүжинг гэртээ урьж, хуримлахад,⁵⁴

⁵⁴ “МНТ”-нд өгүүлснээр “... Жамухаас эдгээр хүмүүсийг ирэв гэж Чингис хаан өөртөө улс ирэв хэмээн баясаж, Чингис хаан, Өэлүн Үжин, Хасар, Жүрханий Сача Бэхи, Тайчу нар хамтаар Ононы шугуйд хуримлая хэмээлдэж, хуримлахад Чингис хаан, Өэлүн Үжин, Хасар, Сача Бэхи нарт эхлэн нэгэн сөн сөгнөжээ. ... Тэр хуримыг манайхаас Бэлгүдэй засаад Чингис хааны морийг барьж байсан бөлгөө. Жүрхэнээс Бүри бөх тэр хуримыг засаж байв.” гэжээ. (Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоогоо/, УБ.,2000, т.73). Эндээс Чингис хаан Ононы шугуйд хуримласан ба мөн Сача бэхи нарын гэрт уригдаж хуримлаж, тэрхүү хурим дээр Бүри бөх Бэлгүдэйн мөрийг цавчсан уу, аль эсвэл Чингис хаан Сача бэхи нар нийлж хуримлаад, хурим дээр Бүри бөх Бэлгүдэйн мөрийг цавчсан уу гэдэг асуулт урган гарч ирж байна. “МНТ”-нд өгүүлснээс харвал Чингис хаан Ононы шугуйд хуримлаж, тэрхүү хурим дээр Бүри бөх Бэлгүдэйн мөрийг цавчжээ. Харин Тэмүжин Сача бэхи нарын гэрт хүрэлцэн очоогүй ба Жамухаас Чингис хаанд улс /хүмүүс/ ирж нэгдэж ирэхэд (Сача бэхи нартай нийлж) тэрээр баясаж хуримласан гэдэг нь тодорхой байна. Гэвч А.Амарын зохиолд Тэмүжин, Өэлүн эх, Хасар, Сача бэхи нар хамтран хурим хийж, дараа нь Жүрханий Сача бэхи нар өөрсдөө гэртээ дахин хуримлаж, тэр хуримдаа Чингис хааныг урьсан гэсэн мэдээ, ойлголтууд байна. “МНТ” зохиолд Чингис хааны талаас Бэлгүдэй хурим засаж, Бэлгүдэйгүүр Чингис хаан морио бариулж байв гэж тэмдэглэсэн нь Жүрханий талынхан Чингис хааныг хорлохоор дахин хуримласан гэдэгт эргэлзээ төрүүлж байна. /Гэвч Жүрханий Сача бэхи нар Чингис хааныг хорлох тухай санаа өвөртөлж байсныг үгүйсгэсэнгүй./ Нягталж үзвэл, Сача бэхи нар Чингис хаан, Өэлүн, Хасар нартай хамтаар хуримласан ба харин тухайн үеийн ихэс дээдэс, хаад язгууртнуудын заншил ёсоор тэд нэг дор Ононы шугуйд хуримласан авч өөр өөрийн өргөө бариулж хуримласан биз ээ. Угтаа Чингис хаан өөрт улс ирэв хэмээн баясаж Өэлүн Үжин, Хасар, Бэлгүдэй, Жүрханий Сача бэхи, Тайчу нарын хамт Ононы шугуйд хуримласан болой. Ингэж үзвэл Сача бэхи нар Чингис хааныг хорлох гэж ярилцаад тэрхүү хуримлаж буй өөрийн гэр, өргөө, майханд Чингис хааныг урьсан гэдэг нь харагдаж байна. Энэ нь Бэлгүдэй Чингис хааны морины цулбуурыг бариад зогсож байсан гэдгээс тодорхой байна. (*Лу Алтан товчид өгүүлснээр: “... Тэр хуримыг биднээс Бэлгүдэй засаад, Жүрхэнээс Бүри бөх тэр хуримыг засан бөлгөө. Чингис хааны агт Хачигун барьж байн бүлгээ. (Лувсанданзаны зохиосон “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч”, (Эх бичгийн цогц судалгаа хийсэн доктор (Sc.D), профессор Шаравын Чоймаа), (XVII зууны Монгол түүхэн сурвалжийн тулгуур эхүүд), УБ.,2011, т.53).* Учир нь Бэлгүдэй Чингис хааныг Сача бэхи нарын өргөөнд уригдаж ороход гадаа морины цулбуур бариад зогсож хаан эзний амийг өмөөрөн харгалзаж байжээ. Нөгөөтэйгүүр Бэлгүдэй Чингис хааны морины цулбуурыг барьж зогсохдоо гадаах байдлыг сэрэмжлэн харж, хараандаа хянаж байсан биз ээ. Энд Бэлгүдэйн хурим зассан гэдэг нь хурим найр хийж буй үед алтан ургийнхны ялангуяа Чингис хааны амь насыг хамгаалж, ах дүү нар /хуримд оролцож буй хүмүүс/ хоорондоо эв түнжин хагарах байдал гарч зодоон, алалдаан болвол Чингис хааны унаж явах морийг Бэлгүдэй бэлэн байлгаж их эзэн хаанаа хамгаалж байсан нь тодорхой байна. Ингэж үзвэл хурим засах хүн гэдэг нь найр хурим хийж үед орд, өргөө, хурим болж буй орчныг, гаднах байдлыг амгалан байлгаж харж хянаж, хэрүүл маргаан гарвал тэрнийг таслан зогсоох үүрэг хүлээсэн хүнийг хэлж байна. Тэрчлэн хуримлах гэдэг нь өнөө цагийн бидний ойлгож буй эхнэр нөхөр бололцох ёс бус харин баяр тэмдэглэх, найрлах гэсэн утгыг илтгэнэ. Тухайн үеийн монголын ихэс дээдэс, хаад ноёдын баяр ёслолоо тэмдэглэх, алжаалаа тайлдаг газар нь Ононы шугуй байсан бололтой байна. “МНТ”-нд “... **хатгин хүн цулбуур** хулгайсны хулгай баригдав. Бүри бөх тэр хүнээ өмөөрчээ Бэлгүдэй үргэлж барилдах учир баруун ханцуйгаа мулталж [гар] нүцгэн явах бөлгөө. Тийн мулталсан (сугалдаргалсан) нүцгэн мөрий нь Бүри бөх илдээр ангас [хийтэл] цавчжээ.” гэжээ. (Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоогоо/, УБ.,2000, т.73.). Ц.Дамдинсүрэнгийн орчуулсан “МНТ”-нд өгүүлснээр: “...Гэтэл **хатагин овгийн нэгэн хүн бидний морины уяанаас цулбуур хулгайлж** аваад баригдав.”(“Монголын Нууц Товчоо”, Орчин цагийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав., УБ.,2003, т.64.). “Чингис хааны Алтан нэртний цэди”-т: “Түүний хойно, Тайчидын (Тайчуудын, хөр.) Чилгэр бөх муу сэтгээ гэж гэртэн нүх ухаж, дээр нь эсгий дэвсээд, эзэнд эчиж (одож, хөр.) төрөл төрсөн бидний өөр биш нэг билээ муу муугаар явахуу буй юу гэж [13.b] Богд эзнийг залав. Залахуйд Өгэлэн хатан эх нь зарлиг болов.

Хорт дайсныг цөөн гэж

Хорт могойг нарийн гэж бүү сана

Итгэл үгүй, сэрэлтэй (сэрэмжлэлтэй, хөр.) буй за

тэр үгэнд Богд эзэн зарлиг болов.

Хавт Хасар чи саадгийг минь хадгал

Бөх Бэлгэтэй чи засуул бай

Хачуга чи морь хадгал

Ойт Очугу чи дэргэд минь суу[14.a], ямарваа үйл мэдээ буюу гэж эзэн зарлиг болов. Эзэн гэрт орж эсгийн дунд суухуйд Очугу эзний биеийг татаад дэвсгэрийн захад суулгав. Төдий нэгэн эм дуулж (угтаан доголж хэмээн үг байсан болов уу, хөр.) ирээд эзний зөвтөөх (зөв талд байгаа, хөр.) дөрөөг огтолж авч одохуйг Бэлгэтэй үзээд, тэр эмийн хөлийг нь хуга ташиж орхив.” гэжээ. (“Чингис хааны алтан товч нэртний цэди”, (монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн С.Дашдэжид), (Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал), УБ.,2006, т.25.). Лу “Алтан товч”-д “Чингис хаан өөртөө улс ирэв хэмээн баясч, Өгэлэн үжин, Хасар, Жүрхэний Сэцэн бэхи, Тайчутан бүгд элэлдэн зөвшөөлдөж, Ононы түнд хуримлая хэмээлдэж хуримлахуйд, урьд Жүрхэний Сэцэн бэхи, Тайчутан, Өгэлэн эх тэргүүлэн, Чингис хааныг залав. Төрөл төрсөн бидний өөр биш нэгэн билээ. Муу муугаар явах буюу гэж залахад, Өгэлэн эх зарлиг болов.

“Хортон дайсныг цөөн, хорт могойг нарийн гэж бүү сана. Итгэл үгүй сэрэлтэй буй” хэмээвээс, Богд эзэн зарлиг болов. “Хавт Хасар чи саадаг хадгал, бөх бэлгэтэй чи засуул бай. Хачугу чи морь хадгал, ойт Очигин чи миний дэргэд суу. Ямарваа үйл мэдээгүй буюу” гэж зарлиг болов. Жүрхэн муу сэтгэж, нүх ухаж дээр нь эсгий дэвссэн ажгуу. Эзэн, эсгийн дунд суухуйяа завдсанд, Очигин эзний биеэс татаад дэвсгэрийн захад суулгав.” (Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршвой”, УБ.,1990, [35. b].) Хураангуй Алтан товчид, “... Эм хүн доголж ирээд **зөв тээх** (зөв тал дахь. хөр) **дөрөөг** огтолож авч одохуйг, Бэлгэтэй үзээд, тэр эмийн хөлийг нь хуга ташиж орхив.” гэжээ. (“Хаадын Үндсэн Хураангуй Алтан Товч”, (Эх бичгийн цогц судалгаа хийсэн доктор (Sc.D), профессор Шаравын Чоймаа), (XVII зууны Монгол түүхэн сурвалжийн тулгуур эхүүд), УБ.,2011, т.43.). Энэ тухай Лувсанданзаны “Алтан товч”-д “... **Жүрхэнээс нэгэн эм хүн** доголж ирээд, **зөвтөх** /зөв талын. хөр/ **дөрөөг** огтолож авахыг Бэлгүтэй үзээд, тэр эмийн хөлийг нь хуга ташиж орхив.” гэжээ. (Лувсанданзаны зохиосон “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч”, (Эх бичгийн цогц судалгаа хийсэн доктор (Sc.D), профессор Шаравын Чоймаа), (XVII зууны Монгол түүхэн сурвалжийн тулгуур эхүүд), УБ.,2011, т.53). “МНТ”-д хатгин хүн цулбуур хулгайлж байгаад баригдаж байгаа тухай гарч байхад бусад сурвалжид Жүрхений нэг эм хүн доголж ирээд морины зөв төө дөрөөг хулгайлах гэж байгаад баригдсан тухай өгүүлж байна. Энд чухам эхний унаж явсан морины дөрөө, цулбуурыг хулгайлсан нь тодорхойгүй боловч Чингис Эзний морины дөрөөг Жүрхений талынхан хулгай хийлгэх гэж нэгэн эм хүнийг явуулсан нь харагдаж байна. Эндээс харахад Жүрхений Сача бэхи нар Чингис хаантай тэрсэлдэж түүнийг ямар нэгэн байдлаар өдөөн хатгасан нь (Чингис хааныг хорлох санаа агуулж байсан нь) Жүрхений талын хүн Чингис хааны морины эд хэрэглэлийг хулгайлах гэж оролдоод Бэлгүдэйд баригдаж, Бэлгүдэй, Бүри бөх нарын хооронд маргаан үүссэн тухай тэмдэглэгдэж үлдсэнээс тодорхой байна. Гэвч Саган Сэцэний “Эрдэний товч”-д өгүүлснээс харвал Жүрхэнээс нэгэн эм хүн хүрч ирээд Чингис хааны морины дөрөө эсхүл цулбуурыг хулгайлж аван одохуйяа Бэлгүтэйд баригдсан нь ил байна. Энэхүү Жүрхэний эм хүн Чингис хааны морины цулбуурыг (МНТ:цулбуур) хулгайлж авч байгаа нь цулбуургүй морь ижил олон сүрэг рүүгээ давхин одох ба Эзэн Чингис хаан унаж явах хүлэггүй үлдэх аюул тулгарчээ. Энэ тухай сурвалжид: “Тэндээс эзэн хүрч гэрт ороод, эсгийн дунд суун атал, оюут Очигин биеэс нь татаж, эсгий захад суулгавай. Төдий **нэгэн эм хүн эзний зөв дөрөөг нитулж** (огтолож, хөр.) аван одохуйяа, бөх Бэлгүтэй үзэн хөөж одоод, эмийн хөлийг хуга ташсанд, Бүри бөх Бэлгүтэйн мөрийг нь илдээр цавчин бүхийсэ, Тайчуудын нуусан цэрэг нь гарч байлдахуйд, хавт Хасар сум тоолон харваж унаган, есөн өрлөгүүд биеийг нь халхлан байж, **Бэлгүтэй Хорчины Тогтунга тайжийн эрмэг цагаагчинаа солгой гараараа эзнийг мордуулаад**, мөн төдий байн аж, цавчин дарж бүрүүн, эрхэндээ оруулан барвай.” гэжээ. (Sagang Secen “Erdeni-yin tobci”, (Precious Summary), The Urga text transcribed and edited by, M.Go, I. de.Rachewiltz, J.R.Krueger and B.Ulaan, Faculty of Asian studies, The Anstralian National University, 1990, 62-63.) (“Чингис хааны Алтан товч нэргийн цэди”-т “ Бэлгэтэй намаат (борив хөхүүртэй, хөр) айргаар цохилцоод **Хорчины Тогтонгуйн эрмэг цагаагчинд эзнийг солгой гараар моринд унуулбай**” “Чингис хааны алтан товч нэргийн цэди”, (монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн С.Дашдэжид), (Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал), УБ.,2006, т.25.). Гэвч Мэргэн гэгээний “Алтан товч”-д өгүүлснээс харвал, Сача Бэхийн дагалт Булай (Бүри бөхийг хэлж байна. Л.Б) Очигэний мориний цулбуурыг хулгайлж байгаад Бэлгүтэйд баригдсан талаар өгүүлж байна. (Сэцэн бөхийн дагалт Булай нэрт хүн Очигэний морин дахи цулбуурыг хулгайлж (хулгайлж) өвөрлөв (өөвөртөө хийв). Бэлгэтэй үзэн одож, Булайг нэгэн нудрагадаад цулбуураа авав. Булай очин уурлаж, илдээ гарган, Бэлгэтэйн мөрийг хаа цавчив. (Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан “Их Монгол Улсын Үндсэн Алтан Товч Тууж Оривой”, (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсрал хийсэн Д.Бүрнээ), УБ.,2006, т.66.) Рашпунцаг “Болор эрих”-д өгүүлсэн нь: “Сэцэн бөх бээр Тэмүжинийг хоймор суу хэмээн дахин дахин шаардавч, Тэмүжин сэжиглэж эс суувай. Төдий айраг ба архи уулгаж хуримлан байсаар, Сэцэн бөхийн түшмэл Болай нэрт хүний хөтөч нь Тэмүжинийг дагасан хүний мориноос цулбуурыг хулган (хулгайлан) авахуйг Бэлгэдэй үзээд барьсанд, Болай уурлаж, илдээр Бэлгэдэйн баруун мөрийг цавчвай.” гэжээ. (Рашпунцаг “Болор эрих”, Тэргүүн дэвтэр, (Харгуулан хөрвүүлсэн М.Баярсайхан, Ч.Нэргүй, Д.Бүдсүрэн), (Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал), УБ.,2006, т.32.). “Юань Улсын судар”-т тэмдэглэсэн нь: “Тэр цагт Хааны дүү Билигт (伯勒格太 bo le ge tai) (Бэлгүтэй. Л.Б) Хааны хээр адууны хэргийг мэднэ. Бүрин (布琳 bu lin) (Бүри бөх. Л.Б) Сэцэн бухийн хээр адууны хэргийг мэднэ. Бүриний дагах хүн морины цулбуур хулгусанд (хулгайлсанд. Л.Б) Билигт барьжээ. (Юань Улсын судар 元史, (Хятад хэлнээс орчуулсан Ч.Дэмчигдорж (Дандаа), (Монгол бичгээс хөрвүүлж, тайлбар сэлт үйлдсэн: А.Алимаа, Д.Боролзой, С.Мөнхсайхан, Б.Төвшинтөгс), УБ.,2002, т.29). Энэ нь “МНТ” болоод бусад сурвалж дахь Хатгин хүн эсхүл Жүрхэний нэгэн доголон эм хүн ирээд морины цулбуур хулгайлсан талаар өгүүлсэн байдгаас нэлээд өөрөөр бичжээ. Өөрөөр хэлбэл, Бүри бөх Чингис хааны, эсхүл Очигэний морины цулбуурыг авч тэдний аль нэгнийх нь мөрийг сул тавьж явуулах гэж байгаад Бэлгүдэйд баригдаж, үүнээс үүдэж Бүри бөх Бэлгүдэйн мөрийг цавчсан байна. Сурвалжуудад өгүүлж байгаачлан Бүри бөх Очигэний морины цулбуурыг хулгайлсан уу, аль эсвэл Чингис хааны унаж явсан морины цулбуурыг хулгайлсан уу гэдэг асуулт урган гарч байна. Саган Сэцэний “Эрдэнийн товч”, “Чингис хааны алтан товчийн нэргийн цэди” зэрэг сурвалжуудад өгүүлснээс харвал, Жүрхений талын хүн Чингис хааны морины цулбуурыг эсхүл дөрөөг хулгайлж аваад Чингис хаан унаж явах морьгүй хоцорсон байна. Гэвч зарим сурвалжуудад тухайлбал, Мэргэн гэгээний “Алтан товч” зэрэг сурвалжид өгүүлж байгаачлан Очигэний морины цулбуурыг Жүрхений талынхан хулгайлсан гэдгээс задлан шинжилбэл, Жүрхений Сача бэхи Чингис эзний морины цулбуурыг хулгайлуулсан ба хулгайлсан хүн нь Бэлгүтэйд баригджээ. Бас Чингис хааны мөрийг хараандаа байлгаж байсан хүний морины цулбуурыг бас хамтад нь хулгайлсан байх магадлалтай байна. Нөгөөтэйгүүр Лу Алтан товчид Чингис хааны мөрийг Хачигун барьж байсан тухай өгүүлж байхад Мэргэн гэгээний Алтан Товчид Очигэний морины цулбуурыг Булай хулгайлж аваад Бэлгүдэйд баригдсан тухай өгүүлж байна. Эндээс харвал Чингис хааны мөрийг Бэлгүтэй, Хачигун, Очигэн нар ээлжлэн харж байсан байна. Харин морины цулбуур хулгайд алдагдахад Чингис хааны

Тэмүжин мэдээд, ихэд сэргийлэн байсан тул Тэмүжин Бэлгүтэйг гадна морь бариулж байсан ба жүрхэний Бүрибөх тэр хуримыг засан бөлгөө. Харин Чингис хааны талаас Бэлгүтэй хуримыг засаж байв. Жүрхэний нэг эм хүн ирж зөвтөө дөрөөг огтолож авахыг Бэлгүтэй үзээд, түүний хөлийг хуга ташиж орхив. Бүрибөх өмөөрөн Бэлгүтэйн баруун мөрийг цавчив. Тэмүжин үзээд хилэгнэхүйд Бэлгүтэйн өгүүлсэн нь: Миний биед төдий л гэм болсонгүй тул ах, дүү лүгээ миний төлөө эвдэрсний хэрэггүй хэмээн хоригловч Тэмүжин хилэгнэж, тэд нарыг жанчихүйд Сэчэ-бэхи нар гуйж найрамдав”⁵⁵. “Чингис хаан, Бэлгүтэйн ятгасан үгийг үл хайхарч, хоёр этгээд (хоёр тал)-ээс модны гишүүдийг хуга татаж, айргийн бүлүүрийг сугачиж аваад зодолдож, жүрхин нарыг ялж Хорижин хатан Хуурчин хатан хоёрыг булааж авав. [Хасар харвах тутам нэг хүнийг унагаж байв. Бэлгүтэй хөхүүртэй айргаар цохилцож явав. Тайчууд нар Бэлгүтэйг барьж аваад хасаг тэрэгнээс хүлж тавив. Унтсан хойно Бэлгүтэй, хасгийг үүрсээр хүрч ирэв. А.то] Жүрхин нар найрамдан зохилдъ гэснийг бид зөвшөөрч, Хорижин хатан, Хуурчин хатан хоёрыг буцааж өгөв.”⁵⁶ Тэмүжиний олон монгол овгийг нэгтгэж заналт дайснуудаас өш хонзонг авч байх энэ мөчид түүнд (Тэмүжинд) атаархаж хорссон хорсол мөн л тасраагүй байна. “... янз бүрийн ураг омгийн язгууртнууд бүхэл бүтэн айл өрх байтугай “хот хүрээгээрээ” нүүж ирж Тэмүжинтэй нийлж эхэлжээ.”⁵⁷ Энэхүү Тэмүжиний амжилтанд атаархсан атаархал нь түүний ах дүүгээс бас илэрч байв. Жүрхин овгийн Сача бэхи нар Бүри бөхтэй нийлж Тэмүжинийг хорлож үгүй хийхийг урьтал болгож байгаа нь тухайн үед монголын алтан ургийн дунд ч хаан ширээ, боржигин овгийн байр суурийн төлөө зөрчил явагдаж байсан нь харагдаж байна. Жүрхиний нэг эм хүн ирж Тэмүжиний унаж явсан морины зөв талын дөрөөг хулгайлах гэж байгаад Бэлгүтэйд баригджээ. Энэ нь Сача-бэхи нарын явуулсан өдөөн хатгалга байсан ба нөгөөтэйгүүр морины зөв талын дөрөөг/цулбуур.МНТ/ авах гэсэн оролдлого нь Тэмүжиний сүр сүлдийг үгүй хийж хорлох гэсэн санаа ч байсан байж мэднэ. Нөгөөтэйгүүр тулалдаан болоход өрөөсөн дөрөөтэй морь унасан хүн нэг тал руугаа илүү их дийлдэх муу талтай юм. Нөгөөтэйгүүр цулбуургүй морь хүнд хөтлөгдөхгүй ба хүн цулбуургүй морийг унаж үл болохыг Сача бэхи нар бодолхийлсон байсан биз ээ.

Жүрхиний Сача бэхи нар Чингис хааныг хорлохоор сэм хэлэлцэж, нэгэн эм хүнийг Их Эзэн хааны морины цулбуурыг хулгай хийлгэх явуулсан тухайд Чилгэр бөх нэгэнтээ оролцсон болох нь “Хаадын үндсэн хураангуй алтан товч”⁵⁸, “Чингис хааны алтан товч нэртийн цэдиг”⁵⁹, Лу “Алтан

морийг хэн харж байв? гэдэг асуулт урган гарч ирж байна. Мэргэн гэгээний Алтан товчид өгүүлснээр Чингис хааны морийг Очигэний (ээлжинд) ээлж ирж харж байсан ба энэ үед Булай нэрт хүн морины цулбуур хулгайлж байгаад Бэлгүдэйд баригдсан болж таарч байна. Дээр сурвалжуудад Бэлгүтэй солгой гараараа, өөрөөр хэлбэл Бүри бөхөд цавчигдаагүй гараараа Чингис хааныг Тогтунга тайжийн эрмэг цагаагчинд мордуулсан тухай өгүүлж байгаа нь Жүрхэний Бүри бөх Чингис хааны унаж явсан морины цулбуурыг авч морийг сул тавьсан ба Чингис хаан унах морьгүй үлдээд Тогтунга тайжийн мориор хөл залгуулжээ гэдэг нь харагдаж байна. Мэргэн гэгээний “Алтан товч” дахь Бүри Очигэний морины цулбуурыг хулгайлж байгаад Бэлгүдэйд баригдсан тухай мэдээ нь “Нууц Товчоон”-д байхгүй зарим зүйлийг ил болгож өгч байна. *Жич, Лу Алтан товчид “МНТ”-д байгаа зарим үг, мэдээллүүд ялгаатай байна. Тухайлбал, “МНТ” Хатгин хүн цулбуур хулгайлж байгаад Бэлгүдэйд баригдаж байхад Лу Алтан товчид Жүрхэний нэг эм хүн доголж ирээд зөв талын дөрөөг хулгайлах гэж байгаад Бэлгүдэйд баригдсан тухай өгүүлж байна. Гэвч Лувсанданзан “МНТ”-г мөрдлөг болгож “МНТ”-ны ихэнхи зүйлийг зохиолдоо оруулж бичсэн нь нэгэнт тодорхой билээ. Лувсанданзан гүүш бээр “Алтан товч”-ийг зохиохдоо “МНТ” зохиолоос иш үндэс болгож өөрийн зохиолоо бичсэн ба нөгөөтэйгүүр “МНТ”-г товчлон хурааж, “МНТ” дахь үйл явдлаас хойших түүхэн хэргийг нэмэж бичсэн нь түүний зохиолын нэрнээс тодорхой харагдаж байна. Учир нь Лувсанданзан өөрийн зохиолоо нэрлэхдээ “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч” гэж өгүүлсэн нь уг “Алтан товч” зохиол нь эртний монголын хаад Чингис, Өгэдэй, Хубилай нарын үндэслэсэн төр ёсны зохиол болох “МНТ”-г товчлон хурааж бичсэнийг харуулж байна.*

⁵⁵ А.Амар “Монголын товч түүх”, /ред:А.Очир/, УБ.,1990, т.112.

⁵⁶ “Монголын Нууц Товчоо” (хуучин монгол хэлнээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав.), ред:Ш.Гаадамба, (МНТ дөрөв дэх удаагийн хэвлэл), (132 дүгээр зүйл) УБ.,1990. Т.83.

⁵⁷ Б.Я.Валидимирцов “Чингис хаан”, /Олон улсын Монгол судлалын холбооноос эрхлэн гаргав/, “Дэлхийн Монгол судлалын дээжээс” 1996 цуврал (1), /цувралын эрхлэгч Академич Ш.Бира/, (Орос хэлнээс орчуулсан Б.Дашцэрэн), УБ.,1996, т.23.

⁵⁸ Ш.Чоймаа “Хаадын үндсэн хураангуй алтан товч”, (Эх бичгийн судалгаа), тэргүүн дэвтэр, УБ.,2002, т.287-288.

⁵⁹ “Чингис хааны Алтан товч нэртийн цэдиг”, (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн С.Дашдэжид), (Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал), УБ.,2006, т.25.

товч”⁶⁰, Саган Сэцэн “Эрдэнийн товч”⁶¹, “Хөх түүх”⁶², Галдан “Эрдэнийн эрих”⁶³, В.Инжиннаши “Хөх судар”⁶⁴ зэрэг сурвалжуудад хадгалагдаж үлджээ. Гэвч Тайчуудын Чилгэр бөх Чингис хааныг хорлохоор Жүрханий Сача бэхи нартай сэм хэлэлцэж, гэрийн дотор нүх ухаад дээр нь эсгий дэвсэж бэлдсэн тухай “МНТ”-д байхгүй билээ. Энэхүү гэр дотор нүх ухаж, дээр нь эсгий дэвсээд дайснаа хорлож алах үзэгдэл нь 13 дугаар зуунд тун ховор үзэгдэл бөгөөд харин феодалын бутралын үед төрийн их хуралдай, ноёдын чуулган чуулахад ноёдууд өөрсөдтэй нь үзэл бодол, санаа сэтгэл таархгүй зарим хошуудын захирагч, ноёдыг тусгай ухаж бэлтгэсэн нүх рүү унагаж амийг нь хорлох үзэгдэл түгээмэл байв. Бидний бодохоор дээрх сурвалжуудын ихэнх нь Манжийн ноёрхолын үед бичигдсэн тул феодалын бутралын болоод манжийн үеийн монгол ноёд нэг нь нэгнийгээ үгүй хийж хорлон алж байсан аргыг зохиолдоо илүү их тусгаж бичсэн нь харагдана.

Чингис хаан Жүрханий Сача бэхи нартай нийлж хуримласан хурим дээр Бүри бөх Бэлгүтэйн мөрийг цавчсан тухайд Чингис хаан сүүлд Бэлгүтэйгээр Бүри бөхийн нурууг хугалуулж амь насыг нь хохироож өш хорсолоо авчээ. Басхүү Бүри бөх Сача бэхи нартай нийлж өөрийнх нь эсрэг хорон санаа агуулж байсныг Тэмүжин аль хэдийн мэдсэн байсан учир Бүрийг бөхийг хороов. Тэмүжиний их зорилгын өмнө тэрсэлсэн дайсантай тэмцэх тэмцэл Бүри бөхийг цаазлах мөчид ч илэрч байна.

Чингис хаан олон монгол овог, аймгийг нэгтгэж нэгэн захиргаан дор оруулахын тулд ихээхэн хүч, ухаан, сэтгэл зүйн асар их бэлтгэл, зориг тэвчээр зарцуулсан нь тодорхой. Тэмүжин Их Монгол Улсыг үндэслэн байгуулахын тулд урьдаар монгол олон овог аймгуудыг нэгтгэн, тэдний хүчийг зөв зүйтэй зангидаж атгах нь чухалтай байлаа. Иймд Тэмүжиний эхний зорилт бол юуны урьд овог аймгуудыг өөрийн харъяанд оруулах, өөртэй нь тэмцэлдсэн дотоод хүчийг дарж авах нь туйлаас зүйтэйг тэр мэдэж байв. Гэтэл Чингис хааны ойр төрөл Жүрхин нар эзэн хаантай тэрсэлдэх болов. “Чингис хааны арууг (ар гэр) Харилту нуурт [байсан] болой. Аруугт хоцорсон [хүмүүсийг] Жүрхин, тавин хүний хувцас тонож, арван хүнийг алжээ.”⁶⁵ “Чингис хаан Тоорил хан хоёр Жүрханий Сача бэхи, Тайчу тэргүүтэн Жүрхинээ хэлүүлж илгээрүүн:

“Эрт өдрөөс бидний

Эцэг өвгөдийг барсан татаарыг

Эдүгээ энэ ханалга дор хамсан

Хамт морильё” хэмээн илгээв. Жүрхинээс [цэрэг] хүрч ирэхийг зургаан өдөр хүлээж ядаад”⁶⁶ (Жүрхин нар эс ирэв). Энэ тухай “Юань Улсын судар”-т тэмдэглэсэн нь: “Тэр учирт Татар аймгийн дарга Могужин сорьт (摩古津掃里圖 mo gu jin sao li tu) Алтан (金 jin) улсын холбоог тасарсанд Алтан улсын эзэн чэнсъян (丞相 cheng xiang) Ван Ян Съян (完颜~囊 wan yan xiang)-ыг илгээж цэрэг авч хөөсөнд хойш буруулахыг Хаан сонсоод ойр цэргийг мордуулан [19] Ону голоос угтаж цохиход басхүү Сэцэн Бухуд ухуулан, аймгийн хүнээн авч туслахаар ирэгтүн хэмээж зургаан өдөр хүлээвээс хүрч ирсэнгүй. Хаан өөрөөн байлдаж Могужин сорьтыг алаад түүний цэргийн хүнсийг дуусган олзлов. Хааны харъяат Найман (奈曼~乃蛮 nai man) аймгийн хүнд уулгагдсан тулд Хаан дайлсугай хэмээн басхүү жаран хүнийг илгээж Сэцэн бухигээс цэрэг авахаар одвоос Сэцэн Бухигээс хуучин өсийн учирт түүний арван хүнийг алаад, тавин хүний дээлийг тайлж эгүүлсэнд Хаан хилэгнэж өгүүллүүн: “Сэцэн Бухи хэзээний Шихирийг туйвандаж, миний Билигтийг шархдуулаад эдүгээ бас аймшиггүй дайсны байдлыг

⁶⁰ “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршвой”, УБ.,1990, [35.b]-[36.b].

⁶¹ Sagang Secen “Erdeni-yin tobci”, (Precious Summary), The Urga text transcribed and edited by, M.Go, I. de.Rachewiltz, J.R.Krueger and B.Ulaan, Faculty of Asian studies, The Australian National University, 1990, 62-63.

⁶² “Хөх түүх”, ӨМСХХ, 1996, т.49.

⁶³ Галдан туслагч “Эрдэнийн эрих”, ӨМАХХ, 1999, 134.

⁶⁴ В.Инжиннаши “Хөх судар”, Тэргүүн дэвтэр, (Кирилл үсэгт хөрвүүлсэн Ш.Чоймаа, М.Баярсайхан), УБ.,2005, т.534-536, 539-542.

⁶⁵ Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоого/, УБ.,2000, т.75.

⁶⁶ Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоого/, УБ.,2000, т.74.

нэхэж намайг [20] дарлах ажгуу”⁶⁷ хэмээгээд түүнээс цэрэг авч алс давж байлдаад түүний аймаг олныг алж олзлов.”⁶⁸ гэжээ. Бас тэд (Жүрхин нар) олон монгол овог аймгийг нэгэн захиргаан дор нэгтгэж байсан Чингис хааны харъяанд оролгүй Хэрэйдийн Ван ханы мэдэлд орсон зэрэг нь ⁶⁹ Чингисийн уур хилэнг ихээр хүргэв. Түүнчлэн Тэмүжиний өвөг эцгийн дүүгийн хөвүүн Бүри бөх Жүрхиный талд орж Чингис хааны эсрэг тэмцэх болсон нь түүний уур хилэнг улам ихээр бадраасан нь мэдээж. Уг нь Бүри бол улсын бөх хүн байжээ. Тэр нэр хүндтэй улсын бөх атал Чингис хааны эсрэг хуйвалдаанд оролцож “Улсын бөх хүн”-нд байж боломгүй авир гаргав. Үүнийг мэдсэн Чингис хаан Бүри бөхийн нурууг Бэлгүтэйгээр санаатайгаар хугалуулж амь насыг үгүй хийв. Ийнхүү Бүри бөх Жүрхиный Сача бэхи нартай нийлж Чингис хааны эсрэг тэмцэх болсон нь нэлээд учир шалтгаантай биз ээ. Жүрхиный Сача бэхи Чингис хааны ойр “Улсын бөх” Бүрийг ашиглаж Тэмүжиний эсрэг тэмцэж, түүнийг хороохоор шийдэж арга мэх зохиож байсныг Тэмүжин аль хэдийн мэдсэн байв. Уг нь Жүрхин нар бол Чингис хааны ойр төрөл билээ. “Эд Жүрхин иргэнийг “Жүрхин” [гэсэн] ёсон болбоос Хабул ханы долоон хөвүүдийн их ах Охин-барахаг бөлгөө. Хөвүүн нь Сорхату-Жүрхи бөлгөө. [Тэр] Жүрхин [овогтон] болов.”⁷⁰ Гэтэл Чингис хаанд олон монгол овог цөм түүний мэдэлд бүрмөсөн хараахан ороогүй байсан энэ мөчид Чингис хааны ойр төрөл жүрхин нар Эзэн Чингис хааны захиргаанд орох ёстой атал хаантай тэрсэлдэв. Уг нь Жүрхиный Сача бэхи Жамухаас салж Тэмүжинтэй ирж нэгджээ.⁷¹ Гэвч Сача бэхи тэргүүтэй Жүрхин овгийнхон Чингис хааны эсрэг бодол тээжээ. Ийм нөхцөл байдал үүссэн үед Чингис хаан тэднийг (Жүрхин нарыг) дарж өөрийн эрхшээлдээ оруулах нь чухалтай болж ирэв. Энэхүү Чингис хааны Жүрхин нарыг байлдан дарсан явдал нь бусад монгол олон овог аймгийнхан өөрт нь нэгдэж, тэд (бусад овог аймгууд) Эзэн Чингис хааны эрхшээлд өөрийн эрхгүй багтан орох нөхцөл байдлыг бий болгоход тустай гэдгийг тэрээр(Чингис хаан) сайн ойлгож байв. Нөгөө талаар Тэмүжинийг Монголын их хаан болоход Сача бэхи өөртэй нь өрсөлдөх хүчин гэдгийг тэрээр мэдэж байв. Сача бэхи бол алтан ургийн хүн байсан ба нөгөө талаар тэр тухайн үед улс төрийн ноён нуруу, үзэл бодлын хувьд нэлээд чадвартай нэгэн байсан бололтой юм. Учир нь Тэмүжинийг хаан өргөмжилөхөд Сача бэхи голлох үүрэг гүйцэтгэснээс тодорхой байна.⁷² Ингэж үзвэл тэр (Сача бэхи) 13 зууны Монголын улс төрийн амьдралд зонхилох (үүрэгтэй) байсан нь харагдаж байна. Сача бэхи Тэмүжинээс өрсөж Монголын хаанд өргөмжлөгдөх өндөр магадлалтай хүн байжээ. Энэ

⁶⁷ “МНТ”-нд өгүүлсэн нь: “...Жүрхинээ тийн хөнөөгдөв хэмээн манай аурагт хоцрогсод Чингис хаанд мэдүүлбээс энэ хэлийг сонсоод Чингис хаан маш хилэгнэж өгүүллүүн: Жүрхинээ бид яагаад ийн хөнөөгдөх болов? Ононы шугуйд хуримлахад тогооч Шихихүрийг мөн занчив. Бэлгүдэйн мөрийг бас цавчив. Зохилдоё хэмээж Хорижин хатан Хуурчин хоёрыг буцааж өгөв бид. Түүний хойно эртний өшөөтэй болсон, бидний эцэг өвгөдийг барагсад татаарыг хамсан морильё хэмээн Жүрхиныйг зургаан өдөр хүлээж эс ирцгээв. Эдүгээ бас дайсантай хамжиж мөн дайсан болов” хэмээгээд Чингис хаан Жүрхинд морилов.” гэжээ. (Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоогоо/, УБ.,2000, т.75.)

⁶⁸ Юань Улсын судар 元史 (Хятад хэлнээс орчуулсан Ч.Дэмчигдорж (Дандаа), (Монгол бичгээс хөрвүүлж, тайлбар сэлт үйлдсэн: А.Алимаа, Д.Боролзой, С.Мөнхсайхан, Б.Төвшинтөгс), УБ.,2002, т.29.

⁶⁹ Жүрхин нар Тэмүжинийг хаан ширээнд өргөмжлөгдөх эхэн үед түүний талд орж Тэмүжинийг дэмжиж, харин явц дунд тэд (жүрхин нар) бусад аймгийн харъяанд орсон байна. Сүүлд Чингис хаан Хэрэйдийн Ван ханы мэдэлд орсон Сача Тайчу хоёрт хандаж: Одоо та нар хан эцэгт минь үнэнчээр нөхөрлөж явтугай, та нарыг буцамтгай гэдэг билээ. Битгий дахин урваж одогтун гэж хэлжээ. Энэ нь Жүрхин нар Чингис хааны харъяанаас гарч Хэрэйдийн Ван ханы мэдэлд орсныг харуулж байна.

⁷⁰ Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоогоо/, УБ.,2000, т.77. Ц.Дамдинсүрэнгийн орчуулсан “МНТ”-нд өгүүлснээр: “Тэд Хабул хааны долоон хөвүүний ахмад Охинбархагийн хөвүүн Хутугту Жүрхи, түүний хөвүүн Сэчэ бэхи, Тайчу хоёр бүлгээ. Тэд жүрхи овогтон болов.” (“Монголын Нууц Товчоо” (Хуучин монгол хэлнээс орчин цагийн бичгийн хэлээр Ц.Дамдинсүрэн орчуулав. Ред: Ш.Гаадамба) /Дөрөв дэх удаагийн хэвлэл/, (139 дүгээр зүйл), УБ.,1990, т.88)

⁷¹ Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоогоо/, УБ.,2000, т.67. Асрагч нэртний түүх” зохиолд өгүүлснээр: “Жүрхэнээс Сэцэн бэхи нэгэн хүрээ, Нэгүн тайшийн хөвгүүн Хучир бэхи нэгэн хүрээ, Хотула ханы хөвгүүн Алтан очигин нэгэн хүрээ, Жамухаас хагацан ирээд Чингист өгүүллүүн: - Чамайг хаан болгоё. Чингисийг хаан болговой. (“Асрагч нэртний түүх” (Эх бичгийн цогц судалгаа хийсэн доктор (Ph.D) Далайн Заяабаатар)(XVII зууны монгол түүхэн сурвалжийн тулгуур эхүүд), УБ.,2011, т.19.)

⁷² Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоогоо/, (123 дугаар зүйл), УБ.,2000, т.67

үүднээс үзвэл Чингис хааны улс төрийн үйл ажиллагаанд тэрсэлдэх хүн Сача бэхи байсан учир Тэмүжин түүнийг хороосон ч байж болох. “Сорхан хэмээгч мэргэн өвгөн хаан суух хүндтэй нэр бүхий хэдэн хүнийг тоочихдоо хамгийн тэргүүнд Сацэ бэхийг нэрлэсэн нь санамсаргүй хэрэг биш ээ. Ийнхүү Жүрхэн нар Тэмүжиний эсрэг ямагт дайсагнаж байсан учраас Жүрхэн нарыг довтолж Сацэ Бэхи түүний дүү нарыг барьж аваад хэлсэн үгэндээ эзэн болсонгүй гэж хоёуланг алжээ.”⁷³ Нөгөө талаар Нууц Товчоонд өгүүлсэнчлэн Хабул хааны хөвүүн Охинбархаг өөрийн иргэдийн дотроос **Эрхийдээ эрчимтэй Элгэндээ шүүстэй Уушгиндаа ууртай Урулдаа хилэнтэй Хүчит бөх ба Эрдэмт эрсийг** ялгаж хөвүүндээ өгчээ. Ийнхүү уур омогтой, чанга зүрхтэй хүмүүс нийлсэн тул Жүрхин гэж нэрлэжээ.⁷⁴ Жүрхин овийнхон уур омогтой, эрдэмт эрсээр дүүрэн байсан тул тэд Чингис хаантай эн зэрэгцэх ухаан, хүч тэдэнд мөн ноёрхож байсан нь лавтай. Иймд Чингис хаантай хүч тэнцүү дайсан ах дүү бий болж өөртэй нь тэрсэлдэхийг тэр тэвчиж сууж үл чадах учир Жүрхин овгийн толгойлогчийг цаазалж, энэ овгийг эзэлж авч жанжин нөхөддөө хувааж өгч⁷⁵, ард иргэнийг нь Чингис хаан өөрийн өмч иргэн болгов.⁷⁶ Юань Улсын судар”-т тэмдэглэсэн нь: “...Гагцхүү Сэцэн Тайчу арайхан эм хөвгүүнээн авч хэлтэрч хэдэн сар өнгөрөв. Хаан басхүү Сэцэн Тайчуг дайлахад нэхэж Толът (圖烈圖 tu lie tu) хавцалд хүрч сөнөөжээ.”⁷⁷ гэжээ. Энэ нь Жүрхин овгийнхныг хэзээ ч дахин нэгдэхгүй болгож, өөртэй нь тэрсэлдэх хүч чадалтай, эрдэмт эрс өөр өөр хүний харьяанд хүчинд автан орсон тул Чингис хаантай тэрсэлдэх хүн үгүй болж түүний сэтгэл амрав.

Дүгнэлт

Эртний түүхтэй Монголыг өөрийн гарт оруулах гэсэн олон овог аймаг хоорондоо тэмцэлдэж, энэ үед алтан ургийн залгамж Бартан баатрын хөвүүн Есүхэй баатар хорлогдож, түүний мэдэлд байсан олон овог аймгууд Өэлүн эхийг хөвүүдийн хамт буурин дээр нь орхин нүүж, түүнийг ганцаардуулжээ. Энэ бүхнийг нүдээрээ харсан Тэмүжин, Бэгтэр нарын сэтгэхүйд айдас түгшүүр, үзэн ядалт дүүрч нөгөөтэйгүүр тэд эндээс өмнөө маш том (томоохон) зорилт тавьжээ. Энэ бол Өэлүн эхийг хэдэн хөвүүдийнх нь хамтаар орхин нүүсэн олон монгол овгийг буцаан авчирах гэж зовон зүдэн байсан эхийгээ Тэмүжин харж, эндээс олон овог аймгийг нэгтгэх санаа Тэмүжинд сая төрсөн ажгуу. Ийнхүү Тэмүжиний их хүсэл зоригийн тууштай бөгөөд мятрашгүй тэмцэл эхэлсэн байхыг ч үгүйсгэхгүй юм. Их хүсэл зоригийг өмнөө пайз болгосон Тэмүжиний оюун санаанд сая зөрчилдсөн (явдал) хэрэг бол Бэгтэр түүний дүү Бэлгүтэй нараас гарах араншин байжээ. Бэгтэр бол өөрийн гэсэн биеэ даасан үзэл бодолтой, аливаа зүйлийг хийхдээ өөрийн зорилгыг түрүүнд тавьдаг, өөрийн эрх мэдлийг шууд гаргадаг бөгөөд энэ үүднээс үзвэл тэрээр бага зэрэг дээрэлхүү байсан байх. Тэмүжиний хувьд мөн л өөрийн гэсэн биеэ даасан бодолтой, шийдвэр гаргахдаа зоримог, шударга үнэнч байдлыг түрүүнд тавьдаг хөвүүн байжээ. Тэмүжин, Бэгтэр нарын зан байдал, ёс суртахуун тэдний хооронд үүсэх зөрчилт байдалд нилээд шийдтэй үүрэг гүйцэтгэсэн нь тодорхой юм. Тэдний тэмцэл оюун санааны хүрээнд явагдсан юм. Тэмүжин, Бэгтэр нарын хоорондын зөрчил нь Монгол олон овог аймгийг нэгтгэж нэгэн захиргаанд оруулах тухай бодол бүхнийг агуулж байснаараа онцлогтой юм Бэгтэр, Бэлгүтэй нарын түрэмгий байдал нь олон

⁷³ Ш.Нацагдорж “Чингис хааны цадиг”, УБ.,1991, т.70.

⁷⁴ “Монголын Нууц Товчоо” (хуучин монгол хэлнээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав.), ред:Ш.Гаадамба, (МНТ дөрөв дэх удаагийн хэвлэл), (139 дүгээр зүйл) УБ.,1990. Т.88.

⁷⁵ “Монголын Нууц Товчоо” (хуучин монгол хэлнээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав.), ред:Ш.Гаадамба, (МНТ дөрөв дэх удаагийн хэвлэл), (186 дүгээр зүйл) УБ.,1990. т.147.

⁷⁶ Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоого/, УБ.,2000, т.77.

⁷⁷ Юань Улсын судар 元史, (Хятад хэлнээс орчуулсан Ч.Дэмчигдорж (Дандаа), (Монгол бичгээс хөрвүүлж, тайлбар сэлт үйлдсэн: А.Алимаа, Д.Боролзой, С.Мөнхсайхан, Б.Төвшинтөгс), УБ.,2002, т.29.

Монгол овог аймгийг буцаан авчирч нэгтгэх гэсэн байдалд ямар нэгэн байдлаар сөргөөр нөлөөлнө гэдгийг Тэмүжин ойлгож байжээ. Мөн Бэгтэрийн зан авир ч ирээдүйн их үйл хэрэгт тусыг үл өгнө гэдгийг Тэмүжин мэдсэн байв. Мөнхүү Бэгтэр ч Есүхэйн хүү учир тэрээр олон овог аймгийг нэгтгэх их санаа түүнд байсан биз ээ. Ийнхүү Тэмүжин, Бэгтэр нарын зөрчил бол улс төрийн эрхийг авах гэсэн оюун ухааны томоохон зөрчил болж орхижээ. Энэ бол тухайн нийгмийнхээ хувьд маш том тэмцэл, нийгмийн оюун санааны хувьд томоохон дэвшил болж өгснийг ч орхиж болохгүй билээ. Аливаа зөрчилт байдлын дундаас дэвшил гарах боломж нь нээлттэй болдог учир тэдний зөрчилт тэмцэл бол нийгмийн хүрээг улам сонирхолтой болгож, Тэмүжин болон түүний гэр бүлийнхнийг анзаарч харах, тэдэн рүү анхаарлаа чиглүүлэхэд нөлөөлж чаджээ.

Бэлгүтэй Бүри бөхийн нурууг хугалж түүнийг хороосон нь эзэн Чингис хаан өөрөөс урвасан нөхрөө цаазалж байгаа нь харагдаж байна. Нөгөөтэйгүүр Чингис хаантай Жүрхин овгийнхон тэрсэлдэх болсон хийгээд энэхүү Тэмүжиний эсрэг түүний ах дүү нар түүнтэй шөргөөцөлдөх байдалд Бүри бөх нэгэнтээ оролцсон байв. Энэ нь Чингис хааны эсрэг алтан ургийнхан дотроос ч тэмцэл өрнүүлж байсныг Нууц Товчооны зохиогч нуулгүй бичжээ. Эндээс харвал Тэмүжиний их үйл хэрэгт алтан ургийнхан ч бүгд таатай хүлээж авсангүйг харуулна. Чингис хааныг Их Монгол Улсыг байгуулж, дэлхий дахиныг тохинуулж их гавъяа зүтгэл байгуулахад түүний өмнө олон олон саад бэрхшээл байв. Харин Чингис хаан тэр бүгдийг өөрийн ухаанаар сөрөн гарч чаджээ. Жүрхиний Сача бэхи нар Чингис хаантай эн зэрэгцэх хүч, ухаан ноёрхож байсан учир тэд Тэмүжинтэй тэрсэлджээ. Энэ нь 13 дугаар зууны монголын нийгэмд дан ганц хүний ноёрхол байсангүй харин олон үзэл санаа өөр хоорондоо тэмцэлдэж байсныг харуулна. Иймд Чингис хаан өөртэй нь өрсөлдөх хүчин гарч ирж буйг хараад Жүрхиний Сача бэхи түүний дүү Тайчу нарыг язгууртны ёсоор битүүлж алжээ. Сүүлд Бүри бөхийг ч Бэлгүтэйгээр нурууг нь хугалуулж хороож байгаа нь Чингис хаан өөрийнх нь эсрэг хорон санаа өвөртлөгчдийг /тэмцэх хүчийг/ ямагт өөрийн ухаан, цэргийн хүчээр дарсныг харуулна. Жүрхэний нэгэн эм хүн морины цулбуур хулгайлах гэж байгаад Бэлгүдэйд баригдсан тухайд зарим түүхэн сурвалж дахь мэдээг нягталж үзвэл Жүрхэний Бүри бөх Чингис хааны унаж явсан морины цулбуурыг авч морийг сул тавьсан ба Чингис хаан унах морьгүй үлдээд Тогтунга тайжийн мориор хөл залгуулжээ гэдэг нь тодорхой байна. Ингэж үзвэл, нэгэн эм хүн морины цулбуур хулгайлсан бус харин Бүри бөх Чингис эзний морины цулбуурыг хулгайлж яваад Бэлгүдэйд баригдаж, Бүри бөх Бэлгүдэйн мөрийг цавчжээ. Нэгэн эм хүн морины цулбуур хулгайлсан гэдэг нь магадгүй Бүри бөхийг эм хүнээс дор авирлаж, Чингис эзний морины цулбуурыг хулгайлсан болохоор нь түүнийг басамжлан егөөдөж бичихдээ нэгэн эм хүн болгож бичсэн байх магадлалтай юм.

Жүрхиний Сача бэхи, Тайчу нар Бүри бөхтэй нийлж Чингис хааныг хорлож алахыг завджээ. Иймд Чингис хаан Жүрхиний Сача бэхи, Тайчу нарыг битүүлж алж, Бүри бөхийг Бэлгүтэйгээр нурууг нь хугалуулж алжээ.

Чингис хаан, Жүрхиний Сача бэхи нарын хооронд өс бололцож зодоон гарах шалтгаан юунаас үүдэж би болов? Зоогийн эрхлэгч -(Юань Улсын сударт тэмдэглэсэнээр) Шихигүрийг Хуурчин хатан загнаж *(занчих-Д.Цэрэнсодном “Монголын Нууц Товчоо”*. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоого/, УБ.,2000, т.73)., *(зодчухуй.хөр Лувсанданзаны зохиосон “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч”, (Эх бичгийн цогц судалгаа хийсэн доктор (Sc.D), профессор Шаравын Чоймаа), (XVII зууны Монгол түүхэн сурвалжийн тулгуур эхүүд), УБ.,2011, т.53), (туйвандах-Юань Улсын судар) (Хорожсин хатан, Хуурчин хоёр Шихигүр сөнчийг доромжилов. С.А.Козин 1941-Антоон Мостаэртын мөн зохиол, тал.48.)-аас үүдэж төрөл төрөгсдийн хооронд өс бололцжээ.*

Түлхүүр үг: Монголын Нууц Товчоо, Тэмүжин, Бэгтэр, Бэлгүтэй, Бүри бөх, Жүрхин нар

Abstract: This study aimed to conduct analysis on some events of the “Mongolian Secret History” and provide with some explanations. In order to do this, historic data included in the Mongolian Secret History were compared with other information sources, and studied from historic point of view. As seen from this study, it is clear that conflict between Belgutei and Buri wrestler was caused by serious reason. This explanations and interpretations were resulted from careful study of historic events, including contradiction between Chinggis khan and the Jurkhin family, Jurkhin Sacha Bekhi, Taichu and Buri wrestler’s joint attempt to kill Chinggis Khan.

Товчлол. Тус өгүүлэлд “Монголын Нууц Товчоон” дахь зарим үйл явдлыг задлан шинжилж, тайлбар гаргалгаа хийхийг оролдов. Ингэхдээ Монголын Нууц Товчоон дахь түүхэн мэдээг бусад сурвалжуудтай харьцуулж, түүхийн судалгааны үүднээс асуудлыг авч үзэв. Бэлгүтэй, Бүри бөх нарын хооронд үүссэн зөрчилдөөн нь нэлээд гүн учир шалтгаантай байна. Энэ нь Чингис хаантай Жүрхин нарын тэрсэлдсэн байдал, Эзэн Чингис хааныг Жүрхиний Сача бэхи, Тайчу нар Бүри бөхтэй нийлж хорлохыг завдсан зэрэг түүхэн үйл явдлыг сурвалж бичгийн мэдээнд үндэслэж тайлбар гаргалгаа хийв.

Ном зүй

1. “Асрагч нэртийн түүх” (Эх бичгийн цогц судалгаа хийсэн доктор (Ph.D) Далайн Заяабаатар), (XVII зууны монгол түүхэн сурвалжийн тулгуур эхүүд), УБ.,2011.
2. Антоон Мостаэрт “Монголын Нууц Товчооны зарим хэсгийн тухай”, Антоон Мостаэрт Монгол Судлалын төв, ISBN 978-99929-78-71-6, УБ.,2010.
3. Амар А. “Монголын товч түүх”, /ред:А.Очир/, УБ.,1990.
4. Баясах Ж. “Их Монгол Улсын түүхэнд холбогдох хоёр сурвалж бичиг”, УБ.,2005.
5. “Богд баатар биеэр дайлсан тэмдэглэл”, (Х.Асралт, Хөх-Өндөр нар харгуулан орчуулав), Монгол тулгар бичгийн цуврал, Өвөр Монголын Соёлын Хэвлэлийн Хороо, 1985.
6. Валидимирцов Б.Я. “Чингис хаан”, /Олон улсын Монгол судлалын холбооноос эрхлэн гаргав/, “Дэлхийн Монгол судлалын дээжээс” 1996 цуврал (1), /цувралын эрхлэгч Академич Ш.Бира/, (Орос хэлнээс орчуулсан Б.Дашцэрэн), УБ.,1996.
7. Гаадамба Шанжмятавын “МНТ”-ныг нягталж сэргээсэн сийрүүлэг, УБ.,1990.
8. Ната Гомбованжил “Алтан эрих”(Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн доктор(Ph.D), проф Д.Бүрнээ), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006.
9. Рене Груссе “Орчлонг эзэгнэгч Чингис хаан” (орчуулсан Чойнзонгийн Баатар), ред:Сандуйжавын Одхүү, УБ.,2001.
10. Гончигжав “Дай Юань Улсын суут Богд Чингисийн сувд эрих хэмээх шастир оршвой”(Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн С.Амарбаяр), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006.
11. Дарма гүүш “Алтан хүрдэн мянган хигээст” (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн Т.Жамъянсүрэн, Л.Халиун), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006.
12. Галдан туслагч “Эрдэнийн эрих”, ӨМАХХ, 1999.
13. Галдан “Эрдэнийн эрих хэмээх түүх болой” (Монгол бичгээс хөрвүүлж, эхүүдийг харьцуулан тулгаж, оршил бичин, тайлбар хийсэн доктор Ж.Гэрэлбадрах, Д.Бүдсүрэн, П.Бямбахорол), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006.
14. Ишбалдан “Монголын оронд хааны угсаа хийгээд шашин дэлгэрсэн, шашныг баригчин үсэг урласан, хийд аймаг тэргүүтэн ямар мэт гарсны ёсыг номлосон эрдэнийн эрих оршвой” (Төвд хэлээрхи сурвалжуудтай харгуулан, монгол бичгээс хөрвүүлж, оршил

- бичиж, тайлбар, хэлхээс хийсэн Д.Бүрнээ), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006.
15. В.Инжиннаши “Хөх судар”, Тэргүүн дэвтэр, (Кирилл үсэгт хөрвүүлсэн Ш.Чоймаа, М.Баярсайхан), УБ.,2005.
 16. Инжаннаши Ванчинбалын “Хөх судар”, (Тэргүүн дэвтэр), (Монгол бичгээс хөрвүүлэн оршил бичиж, тайлбар зүүлт хийсэн Ш.Чоймаа, М.Баярсайхан), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006.
 17. Курчки А.И, Гумилев Л.Н. “Хар домог”, УБ.,1992.
 18. Лувсанданзан “Эртний Хаадын Үндэслэсэн Төр Ёсны Зохиолыг Товчлон Хураасан Алтан Товч Хэмээх Оршвой” (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш.Чоймаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006.
 19. Лувсанданзаны зохиосон “Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч”, (Эх бичгийн цогц судалгаа хийсэн доктор (Sc.D), профессор Шаравын Чоймаа), (XVII зууны Монгол түүхэн сурвалжийн тулгуур эхүүд), УБ.,2011.
 20. “Монголын Нууц Товчоо”, (Монголын Нууц Товчооны эхийг шинээр хөрвүүлж буулгаж, тайлбар хийсэн Ш.Чоймаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006.
 21. “Монголын Нууц Товчоо” (хуучин монгол хэлнээс одоогийн монгол бичгийн хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав.), ред:Ш.Гаадамба, (МНТ дөрөв дэх удаагийн хэвлэл), УБ.,1990.
 22. Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан “Алтан товч” (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн Д.Бүрнээ), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006.
 23. Нацагдорж Ш. “Чингис хааны цадиг”, УБ.,1991.
 24. Рашпунцаг “Болор эрих”, Тэргүүн дэвтэр, (Харгуулан хөрвүүлсэн М.Баярсайхан, Ч.Нэргүй, Д.Бүдсүрэн), (Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал), УБ.,2006
 25. Райнхолд Нойман-Ходиц “Чингис хаан” (Болгар хэлнээс орчуулсан Д.Батсайхан), Монгол найруулгыг хянан тохиолдуулсан Б.Даш-Ёндон, УБ.,2002.
 26. Рачневский П. “Чингис хаан, түүний амьдрал үйлс”, УБ.,1983.
 27. Sagang Secen “Erdeni-yin tobci”, (Precious Summary), The Urga text transcribed and edited by, M.Go, I. de.Rachewiltz, J.R.Krueger and B.Ulaan, Faculty of Asian studies, The Anstralian National University, 1990.
 28. Саган Сэцэн “Эрдэнийн товч”(Сонгомол эх бэлтгэж, хөрвүүлэг, тайлбар зүүлт хийсэн М.Баярсайхан), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006.
 29. Б.Сумъяабаатар “Монголын Нууц Товчоон Үсгийн галиг”, редактор:Л.Манлажав, Ц.Шагдарсүрэн, УБ.,1990.
 30. “Хаадын Үндсэн Хураангуй Алтан Товч”, (Эх бичгийн цогц судалгаа хийсэн доктор (Sc.D), профессор Шаравын Чоймаа), (XVII зууны Монгол түүхэн сурвалжийн тулгуур эхүүд), УБ.,2011.
 31. “Хөх түүх”, ӨМСХХ, 1996.
 32. “Чингис хааны алтан товч нэртийн цэдиг”, (монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн С.Дашдэжид), (Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал), УБ.,2006.
 33. Чоймаа Ш. “Хаадын үндсэн хураангуй алтан товч”, (Эх бичгийн судалгаа), тэргүүн дэвтэр, УБ.,2002.
 34. Цэрэнсодном Д. “Монголын Нууц Товчоо”. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, /редактор, проф Д.Төмөртоого/, УБ.,2000.
 35. “Чингис хааны үе улирлыг тэмдэглэсэн хаадын үндэсний шастир ХӨХ ТҮҮХ” (Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар, хавсралт хийсэн О.Дэмчигмаа), Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал, УБ.,2006.
 36. Лео Де Хартог “Дэлхийг эзэгнэгч Чингис хаан”, /Эх хэлнээ хөрвүүлсэн Ж.Насанжаргал, хянан тохиолдуулсан Академич Ч.Далай/, УБ.,2004.

37. Поуха П. “Монголын нууц товчоо бол түүх ба уран зохиолын дурсгалт бичиг мөн” Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн хэвлэл, Улаанбаатар, 1957.
38. Жү Яотин “Чингис хааны түүх шастир” (Хятад хэлнээс орчуулсан Оцолын Адъяа), УБ.,2002.
39. Эртний хаадын үндэслэсэн төр ёсны зохиолыг товчлон хураасан алтан товч хэмээх оршвой”, УБ.,1990.
40. Юань Улсын судар 元史 (Хятад хэлнээс орчуулсан Ч.Дэмчигдорж (Дандаа), (Монгол бичгээс хөрвүүлж, тайлбар сэлт үйлдсэн: А.Алимаа, Д.Боролзой, С.Мөнхсайхан, Б.Төвшинтөгс), УБ.,2002.

**The Metaphorical Conceptualization of Emotions
in the Secret History of the Mongols**

*Zolzaya Choijin**

Introduction

This study investigates the conceptual metaphors for the concepts of emotions including anger, happiness and sadness in the Secret History of the Mongols (1227), which is considered as a piece of classic literature as well as a fundamental historical source of Mongolia and the rest of the world. There are many studies done on the Secret History of the Mongols from different points of view. The Secret History of the Mongols has been published in translation in over 30 languages by researchers. Linguistically, it provides richest source of Middle Mongolian. This study focuses on the use of the emotion metaphors in the Secret History of the Mongols. Specifically, it examines the linguistic metaphorical expressions making the conceptual metaphors for emotions manifest in the classical source of the Mongols.

The article consists of the following parts: Part 1 is an introduction; Part 2 describes the historical changes of metaphors and presents a brief overview of the Conceptual Metaphor Theory, which provides a theoretical background for the current research, before reviewing briefly the studies on the Secret History of the Mongols by different scholars. Part 3 provides the methods and approaches selected and illustrates their application by examples. This paper is written within the framework of cognitive semantics. The study adopts the MIP (Steen 1999) for identifying metaphorical expressions in Mongolian. Part 4 presents the results of the study related to the emotion metaphors in the Secret History of the Mongols. It also provides a coherent explanation of the conceptual correspondences and metaphorical mappings for emotion metaphors in the source and target domains. In addition, it gives the fundamental accounts for culture-specific realizations of emotion metaphors in the pastoral nomadic cultures. Finally, the paper summarizes by stating that what the speakers have seen in reality causes the speakers to conceptualize their emotions based on the similarities of the two things in the given culture. The study shows that metaphors are stable over the times of history. There are many historical metaphorical expressions of anger, happiness and sadness that are still frequently used in everyday language of Modern Mongolian.

Literature review

Traditionally, metaphor has been defined as the most fundamental form of figurative language. Thus, metaphor has been primarily studied by literature and rhetoric specialists. Lakoff and Johnson (1980: 3) claim that “our ordinary conceptual system, in terms of which we both think and act, is fundamentally metaphorical in nature.” They first claim that metaphors are conceptual in nature, which is that they reside in the conceptual system and not just in language. Moreover, anthropologists have always thought of metaphor as a powerful conceptual device rather just a linguistics ornament. In cognitive linguistics, metaphor is a set of conceptual correspondences, or more technically, mappings, between two conceptual domains, a source and a target (Lakoff and Johnson 1980). The relationship between metaphorical thinking and speaking is often described by linguistic metaphors. According to Kövecses (2005), metaphor is a many sided phenomenon that involves not only language but also the conceptual system, as well as a social-cultural structure and neural and bodily activity. These studies point to the fact that emotion concepts have a complex conceptual structure and are also comprehended through a large number of conceptual metaphors. The concept of emotion has been described variously depending on the psychological, anthropological, and love, happiness and sadness, pride and so on are characterized as prototypically organized cognitive models based on the prototypical analysis. Some scholars combine the prototype approach with some other view of emotions. Wierzbicka (1990) points out that prototypical scripts composed of the semantic primitives do not support “the idea that boundaries between emotion concepts are “fuzzy”. Social constructionists argue that the conceptualization of emotions is social-cultural scripts/scenarios whose properties depend on particular aspects

*Doctoral student in the Department of English Language and Literature, Gyeongsang National University in Korea

of a given culture.

The conceptual metaphors for emotions in English were investigated in more details in the works by Lakoff and Johnson (1980), Lakoff and Kövecses (1987), Barcelona (1986), and Esenova (2011). For instance, the conceptual metaphor HAPPINESS IS LIGHT found by Kövecses (1991) shows positive evaluations of the concept of happiness as light (e.g. *She has a sunny smile*). In relation to the concept of anger, Lakoff and Kövecses (1987) found the ANGER IS A CAPTIVE ANIMAL metaphor. Moreover, Esenova (2011) investigated animal metaphors for anger and found a number of metaphorical entailments of the ANGER IS A CAPTIVE ANIMAL metaphor. His investigation contributes importantly to understanding the concept of anger in English. The basic-level metaphor ANGER IS A CAPTIVE ANIMAL entails the sub-metaphors ANGER IS A HORSE and ANGER IS A SNAKE in English (e.g. *unbridled anger*, “*You shall yet repent this*” *he hissed*). Barcelona (1986) first found the metaphor SADNESS IS AN ILLNESS in English (e.g. *Mary is heartsick*). In this metaphor, sadness is understood in terms of heartsick. This concept is more conventionalized in English.

There are many cross-cultural studies done on the conceptual metaphors for the emotion concepts including anger, love, happiness and sadness. For instance, Yu (1995, 1998) found the conceptual metaphor HAPPINESS IS LIGHT in Chinese (e.g. **Chinese:** *Tamen gege xing-gao cai-lie lit., they everyone spirit-high color-strong, They are all in high spirits and with a strong glow/They're all in great delight*). It is true that emotions such as anger, love, happiness and sadness are commonly expressed through person's body, heart, and eyes across cultures (e.g. **English:** *She is really heartsick*, **Mongolian:** *Zurh min hoyor huvaagdsan yum shig baina lit., My heart seems to be divided into two pieces, fig., I seem to be very sad*, **Japanese:** *mune-ga mukatsuku chest-nom. retch lit., Chest retches with anger*, **Turkish:** *Öfkest burnunda, anger in the nose lit., His anger is in the nose*). All of the examples cited from different languages display variations in the metaphorical linguistic expressions that are the basis of the conceptual metaphors in different languages.

There are many studies on the Secret History of the Mongols (SHM: 1227). However, there have not been any studies on the use of the emotion metaphors in the Secret History of the Mongols yet. Researchers mostly conduct their studies from the anthropological, historical, and cultural points of view. The Secret History of the Mongols is the oldest literary work written for the Mongol royal family sometime after Chingis Khan's death in 1227. The author of this classical work still remains unknown. The original texts of this work were written in the Uygur script which was adopted by the Mongols from the Turkic Uighurs in the 13th century. The copies of this classical work were translated into Chinese and found from the archives of the Ming government. First, Russian monk Palladij (1866) translated Chinese part of this work into Russian under the title “An old Mongolian tale about Gengis Khan”. After that, the full text of the “Secret History” was published by Kozin in Leningrad (1941), Haenisch in Berlin (1948), Pelliot in Paris (1949). It should be noted the importance of the works including the dictionary of the language of the Secret History of the Mongols (Haenisch 1962) and the index to the manuscript compiled by Igor de Rachewiltz (1972). Professor Igor de Rachewiltz showed his excellence in the translation of the Secret History of the Mongols which contains epic poetry and folklore of the Mongols in the 13th century. The Secret History of the Mongols is a very unique of its kind and it contains many different elements of folklore and epic poetry written so skillfully and indeed artistically blended with fictional and historical accounts. Mongolian researchers translated this historical source into Modern Mongolian language. Moreover, it is rich with metaphorical expressions manifesting the concept of emotions such as *anger*, *happiness* and *sadness*.

Data and methodology

This paper is written within the cognitive semantics framework. Conceptual Metaphor Theory proposed by Lakoff and Johnson (1987) rejects the idea that metaphor is a decorative device, instead, this theory explains that metaphor is central to thought, and therefore to language. In the conceptual metaphor literature, small capital letters are used to denote a conceptual metaphor which shows the existence of the concept in a culture. Conceptual metaphor is a connection between two semantic areas including source and target domains. For instance, HAPPINESS IS LIGHT is a conceptual metaphor, in which the source domain “light” applies to “happiness” in the target domain. The linguistic metaphorical expressions make conceptual metaphors manifest in any language (e.g. *English: She brightened up at the news*).

The purpose of this study is to explore the conceptual metaphors of emotion concepts including *anger*, *happiness* and *sadness* in the Secret History of the Mongols (SHM: 1227), which is regarded as the single significant native Mongolian account of Chingis Khan and his family history. It consists of 12 chapters. The data gathering methods were designed to focus on the observation of linguistic expressions from the Secret History of the Mongols written in Mongolian version. Therefore, this study also adopts the MIP (The Metaphor Identification Procedure, Steen 1999) for identifying metaphorical expressions in the historical source of Mongolian. In recent years, several proposals have been made in order to systematize the method for identifying metaphorically used words in discourse (e.g. Pragglejaz group 2007; Crisp et al., 2007; Steen 1999) The Metaphor Identification Procedure (Steen 1999) is a practical and systematic method for identifying metaphorically-used words in discourse.

Thus, the following steps were taken in identifying linguistic metaphors from the data. First, the author reads

the entire text from the Secret History of Mongols to establish a general understanding of the meaning. Second, the author checked the lexical units in the text whether any of the words in the discussion had been used metaphorically. Third, for each lexical unit, the author determined its basic meaning. The next step was to decide whether the basic meaning of the word was sufficiently distinct from the contextual meaning. Then the author analyzed whether the contextual meaning of the word was related to its basic meaning by some form of similarity. The final step was to mark the lexical unit as metaphorical.

The last two stages of Steen's procedure were applied in inferring conceptual metaphors from linguistic metaphors. Specifically, the step for identifying metaphorical analogy involves making more specific connections between elements in the source and target domains. The identification of such metaphorical analogies then became the basis for understanding of metaphorical mapping. Linguistic expressions that contained either actual words for target domains such as ANGER, HAPPINESS and SADNESS or references to them were selected from the data. After defining the source domains, elements in them were then identified and the metaphorical mapping for the conceptual metaphors was established in the study. Mongolian is rich with case systems and for this reason, the author uses several grammatical abbreviations¹ in this paper. In addition, we provide three levels of translation for Mongolian metaphorical expressions, namely, an interlinear glossing, a literal translation, and an English translation equivalent. The Romanization System was used to transcribe the metaphorical expressions in this study. Since the main focus is on the Mongolian examples not English. Thus, all the translations of the literal meanings represent explanations of the sense of Mongolian metaphorical expressions of the emotion concepts.

Results and Discussion

As a result of the study, we have found 22 linguistic metaphorical expressions manifesting the emotion concepts such as *anger*, *happiness* and *sadness* in the Secret History of the Mongols (SHM: 1227). Interestingly, there are 13 metaphorical expressions that realize the concept of anger, and five expressions of the total data express the concept of sadness. In this study, we have found only four metaphorical expressions that refer to the concept of happiness.

The study shows that the concept of anger has been rich with metaphorical expressions since ancient times in Mongolian. In the Secret History of the Mongols (SHM: 78) Temujin² and Khasar's³ angry behavior was described metaphorically as a dog, lion, tiger, wolf, monster, pike, falcon, camel. It shows that Mongolians have conceptualized anger as an animal since the 13th century and before that. The conceptual metaphors ANGER IS A LION AND TIGER, and ANGRY BEHAVIOR IS AGGRESSIVE DOG BEHAVIOR are highly conventionalized in Modern Mongolian. These concepts are common in our everyday language. In this metaphor, the source domain aggressive dog behavior applies to angry behavior in the target domain. Consider the examples found from the classical historical source as below:

ANGER IS A LION AND TIGER

- (1) Khadand dovtloh hablan⁴ met (SHM: 78)
 rock(ACC) to fight tiger(NOM) CONJ
 lit., Like a tiger attacking on the rocky mountains.
 fig., You were like a tiger attacking the others.
- (2) Aguuraa daran yadah arslan met
 anger(DAT)-REL to try to suppress lion(NOM) CONJ
 lit., Like a lion trying to suppress its anger.
 fig., You were like an angry lion that can not control its anger.
- (3) Barij ul saarah bars met
 to hold can not tigers(NOM) CONJ
 lit., Like tigers that can't be held.
 fig., You were like tigers that unable to control its anger.

¹ Grammatical abbreviations used in this study are as follows: Nominative case-NOM, Genitive case-GEN, Dative case-DAT, Accusative case-ACC, Ablative case-ABL, Instrumental case-INST, Comitative case-COM, Directional case-DIREC, Determiner-DET, Possessive relation-POSS-REL, Reflexive pronoun-REF, Possessive pronoun-POSS, Subject-SUB, Object-OBJ, Proper noun-PR.N, Infinitive-INF, Complement-COMPL, Present tense-PRES, Past tense-PAST, Future tense-FUT, Postposition-PP etc.

² Chingis Khan, born Temujin, was the founder and the Great Khan of the Mongol Empire.

³ Chingis Khan's younger brother was named "Khasar" who played a very important role in the unification of the Great Mongol Empire.

⁴ "Hablan" is an archaic use to refer to one kind of tigers. (SHM: 78)

In (1), the expression *khadand dovtloh hablan met* (lit., like a tiger attacking on the rocky mountains) means figuratively “You were like an angry tiger attacking the others”. As in (2), the expression *aguuraa daran yadah arslan met* (lit., like a lion trying to suppress its anger) shows that the angry person is viewed as an angry lion that can not control its anger. In (3), the expression *barij ul saarah bars met* (lit., like the tigers that can’t be held) means figuratively “You were like tigers that unable to control its anger and fury”. It also shows that an angry person is understood in terms of an angry animal that lost its control of anger.

Moreover, we have found that animal metaphors for anger elaborated with different usages in the Secret History of the Mongols (SHM: 78). Consider the culture-specific linguistic realizations of conceptual metaphor for anger as follows:

- (4) Boroond dovtloh chono met (SHM: 78)
rain(ACC) to attack wolf(NOM) CONJ
lit., Like a wolf attacking in the rainstorm.
fig., You were like a wolf stalking under the cover of a rainstorm..
- (5) Hevteshee höndöhuus ömööroḥ tsöövör chono met
cave(DAT)-REL to touch on to protect hyena(NOM) CONJ
lit., Like a hyena protecting his den when he is touched.
fig., You were like a hyena who fights with anyone who’s touched him.

As in (4), the linguistic expression *boroond dovtloh chono met* (lit., like a wolf attacking in the rainstorm) shows that an angry person is viewed as a wolf stalking under the cover of a rainstorm.

The speakers in the 13th century also conceptualized anger as a monster eating a person. Mongolian legends and folk tales are rich with descriptions of the monster causing some bad effects on the kind people. Consider the example below:

- (6) Amidaar zalgih mangas met (SHM: 78)
alive(INST) to eat monster(NOM) CONJ
lit., Like a monster eating with alive.
fig., You were like a monster swallowing its prey alive.

In (6), the expression *amidaar zalgih mangas met* (lit., like a monster eating with alive) describes angry person’s behavior. The linguistic elaborations below as in (7-11) also indicate that Mongolians conceptualize anger as a falcon, pike, camel and mandarin duck which are the most common animals in the country. It shows that the speakers create metaphorical concepts based on the physical environments around them. Consider the examples below:

- (7) Suudree dovtloh shonhor met (SHM: 78)
shadow(DAT)-REL to attack falcon CONJ
lit., Like a falcon attacking foolishly its shadow.
fig., You were like a falcon attacking foolishly its shadow.
- (8) Semeer zalgih tsurhai met
silently to gulp pike(NOM) CONJ
lit., Like a pike swallowing in silently.
fig., You were like a pike swallowing wildly.
- (9) Botgonihoo⁵ borvi hazah buur⁶ met
young camel(GEN)-REL heel(DAT) to bite camel (NOM) CONJ
lit., Like a camel biting the heel of its young.
fig., You are like an angry camel biting the heels of its young.
- (10) Hövuudee höön yadaj ideh angir met
boys(DAT)-REL to follow to eat mandarin duck (NOM) CONJ
lit., Like a mandarin duck trying to eat his own chicks when they fall behind.
fig., You were like a mandarin duck trying to eat his chicks.

As in (7), the expression *suudree dovtloh shonhor met* (lit., like a falcon attacking foolishly its shadow) means figuratively “You were like a falcon attacking its shadow”. In this metaphor, an angry person is understood in terms

⁵ The word “botgo” refers to a young camel in the first year.

⁶ The word “buur” refers to a camel(not gelding camel).

of an angry falcon. In (8), the expression *semeer zalgih tsurhai met* (like a pike swallowing in silently) shows that the angry person is understood as a pike gulping something wildly. In (9), the expression *botgonihoo borvi hazah buur met* (lit., like a camel biting the heel of its young) indicates that an angry person is viewed as an angry camel that is not gelding. The expression in (10) *hövuudee höön yadaj ideh angir met* (lit., like a mandarin duck trying to eat its own chicks) shows that an angry person is viewed as an angry mandarin duck.

The culture-specific metaphor ANGRY BEHAVIOR IS AGGRESSIVE DOG BEHAVIOR arises from the central metaphor ANGRY BEHAVIOR IS AGGRESSIVE ANIMAL BEHAVIOR metaphor. In this metaphor, an angry person is understood in terms of an aggressive dog. Consider the examples below:

ANGRY BEHAVIOR IS AGGRESSIVE DOG BEHAVIOR

- (11) Harvisaa hazah Khasar⁷ nohoi met (SHM: 78)
 placenta(NOM)-REL to bite Khasar(PR.N) dog CONJ
 lit., Like Khasar(dog) biting its own placenta.
 fig., You were like a dog named “Khasar” gnawing on its own after birth.
- (12) Hadran duu gargaj harvisaa hazagsad (SHM: 244)
 to slash(PRES) sound(NOM) to make(PRES) placenta(DAT)-REL to bite
 lit., Biters of its own placentas by making the sound of slashing.
 fig., You were as if dogs gnawing its own after birth.
- (13) Balmad dovtloh barug (nohoi) met barav. (SHM: 78)
 foolishly to attack dog(NOM) like to destroy(PAST)
 lit., Like a dog attacking foolishly and destroyed..
 fig., You were like a dog attacking wildly and caused him to die.

The metaphorical expression found from the classical historical source the Secret History of the Mongols (SHM: 78) in (11), *harvisaa hazah Khasar nohoi met* (lit., like Khasar dog biting its own placenta), implies that angry behavior is compared to aggressive dog behavior in Mongolian. Specifically, losing control because of anger and effects on the person are understood in terms of an aggressive dog gnawing on its own after birth. As in (13), the expression *balmad dovtloh nohoi met barav* (lit., like a dog attacking foolishly) means figuratively “You were like a dog attacking wildly and caused him to die”. Thus, the DOG domain has been used to express anger in Mongolian since the 13th century and long before that. The dog barks against something or somebody to protect its belongings and it is very dangerous to others, if it is untied. Anger is figuratively comparable to a dog, in that if the self loses his/her control, and it is harmful to others.

The study has found the metaphorical expressions realizing the concept of happiness in the historical source. The data show that Mongolians tend to conceptualize happiness as light. By providing clear evidence, we point out that the speakers in the 13th century viewed happiness in relation to their bodily experience. Consider the examples below:

HAPPINESS IS LIGHT

- (14) Nuurendee gereltei, nudendee galtai baisan tul oindoo oruulav. (SHM: 64)
 face(ACC)-REL light(COM) eye(ACC)-REL fire(COM) to be(PAST) to include(PAST) mind(ACC)
 lit., She was a girl with light in her face, and fire in her eyes, thus, he included in his mind.
 fig., When he met the girl, she was bright, and joyful, thus, he began to consider her father’s proposal.
- (15) Dai tsesen⁸ uguulruun: Ene huvuun chin nudendee galt nuurendee gerelt huvguun baina.
 Dai Wise to say(PAST) this boy(NOM)-REL eye(ACC)-REL fire(COM) face(ACC)-REL light(COM)
 boy(NOM) to be(PRES)
 lit., Dai Wise said: “This boy has fire in his eyes and light in his face.
 fig., Dai Wise said: “This boy looks bright and joyful.”

⁷ The meanings of the words “Khasar” and “Basar” are explained in more details in the Mongolian Advanced Explanatory Dictionary as follows: “Khasar” is an archaic use of the oldest name for Mongolian dog and wild animals. “Khasar and Basar” are described as the strongest dogs in old Mongolian folk tales. The word “Khasar” was originated from the word “arslan”(lion), but the word “Basar” was derived from the word “Bar”(tiger) resulting in vowel alternations in Mongolian.

⁸ Dai Tsetsen (Dai Wise) was Chingis Khan’s father-in-law, whose daughter was Borte, the first wife of Chingis Khan.

- (16) Khuchu⁹ nert nudendee galt hövuuniig bidnii tserguud nutagt hotsorsoniig olj avhcirch
 Ögelun¹⁰ ehed beleg hemeen ögöv. (SHM: 114)
 Khuchu(PR.N) name(COM) eye(ACC)-REL fire(COM) boy(DAT) we(GEN) soldier(NOM)-
 PL to find(PRES) to bring(PRES) Ögelun(PR.N) mother(ACC) gift(NOM) to give(PAST)
 lit., Our soldiers found a boy named Khuchu with fire in his eyes and gave to Ögelun mother as a gift.
 fig., Our soldiers found a boy named Khuchu who was bright and joyful and gave him to
 Ögelun mother to take care of him.
- (17) Uul arilj eh naran uzsen met, mös arilj mörön us olson met baysav.
 cloud(NOM) disappear(PRES) great sun(DAT) to look(PAST) (CONJ) ice(NOM) to
As seen above, livestock-related taboos are about dogs in Korea and horses in Mongolia. This is because these animals represent settlement culture and nomadic culture, respectively. Another difference is that whereas Mongolian taboos emphasize the direction of an animal, for instance, to the left (east) or the right (west), Korean taboos refer to being inside or outside of a house, that is, exiting and entering.

III. Conclusion: Comparison of the Consciousness Structures of the Housing-Related Taboos of the Two Countries

We have examined the similarities and differences between Mongolian and Korean superstitious idioms while referring to the sentence structure features of the Mongolian idioms. The basic and universal sentence structure of Mongolian taboos features the instructions, "Do not...or ...will happen." In contrast, the basic structure of Korean taboos is that, "If..., you will...."

The analysis of the consciousness structure of both countries' housing-related taboos are shown in the following table.

Housing-related taboo	Consciousness Structure			
	Korea	Mongolia	Similarities	Differences
Other people's homes	– mutual etiquette among neighbors – division of space between men and women – emphasis of confucian manners and norms	– clothing etiquette education – emphasis on etiquette among neighbors – emphasis on nomadic manners and norms	emphasis on mutual etiquette among neighbors	Korea: division of men's and women's spaces; emphasis on Confucian manners and norms Mongolia: emphasis on nomadic custom and norms
Thresholds	– etiquette education – prevention of carelessness – respect for shamanistic life	– residential life education – prevention of carelessness – emphasis on human dignity	– wish for blessings – prevention of carelessness – respect for life	Korea: Confucian respect for life Mongolia: shamanistic respect for life
Chimneys and pillars	– wishes for blessing – prevention of disasters	– etiquette education – prevention of disasters	– prevention of disasters	Korea: emphasis on health, wealth, gospel, and superstitions based on folk beliefs Mongolia: emphasis on superstitions based on shamanism
Doors	– wishes for blessing	– respect for common law	none	Korea: wishes for blessing Mongolia: respect for common laws and norms
Home and yard	– instillation of diligence – prevention of disasters – prevention of property loss	– etiquette education	none	Korea: prevention of disasters by emphasizing space Mongolia: respect for etiquette
Livestock	– respect for dwelling space – prevention of disasters	– prevention of disasters	– prevention of disaster	Korea: livestock is considered filthy and ominous Mongolia: farming is worshipped

In order to compare housing cultures between Korea and Mongolia, various detailed and regional approaches and comparisons detail are required. Among them, housing-related taboos, which are shared by individuals, families, and relatives, and which also constitute components of psychological culture, are essential areas for analysis when studying the two cultures.

Korea and Mongolia have different natural environments; they have developed the most suitable and refined taboos in the process of adjusting themselves to their environments through challenges and trial and error. Their folk cultures have been created in the process of understanding their natural environments, and the order of their respective nature and housing-related taboos constitute their cultures.

In terms of contents, Mongolian taboos reflect the Mongolian lifestyle and also provide a clue to identify what their lives are like. Therefore, this study meaningfully adopted a cognitive-linguistic approach to the analysis of

Korean and Mongolian taboos from the broader perspective of everyday rituals. This study will be the foundation for further discussion.

From this point of view, this study of Korean and Mongolian taboos, which show more diversity than any other country's taboos in their number and expressions, will enrich the study of Mongolian nomadic culture at a time when the concept of nomadic culture is being emphasized. This study is also expected to facilitate improvement-oriented exchanges between settlement culture and nomadic culture.

References

- Bae, YoungDong, "Residential space usage and Traditional home management." In *Folklore and Politics*, edited by Comparative Folklore Academy, Seoul: Minsokwon, 2004.
- Byambasu'ren, D, Lisa Reisch, trans. Kim, RiHab, *Tomorrow, Which Grassland We Sleep: A Summer Story of Arhangai Grassland*. Seoul: Woongjin, 2006.
- Choi, Raeok. *Dictionary of Korean Folk Religion*. Seoul: Jibmundang, 1995.
- Choi, UnSik. andal. *An Introduction to Korean Folklore*. Seoul, Minsokwon, 1998.
- Kim, Gwangeon. *House Carer of Korea*, Seoul: Darakbang, 2000.
- Maidar, D, and C'u'Item, N. trans. Kim, GuSan, *The Cultural History of Mongol*. Seoul: Dongmunseon, 1991.
- Lee, Anna. *Life and Customs of Mongolians*. Seoul: Cheotnnunae, 2005.
- Lim, DeHo. *Ancestral Memorial Services*. Seoul: Taewongsa, 1999.
- Namz'il, T. *Family's politeness and tradition of Mongol*. Ulaanbaatar: Ulaanbaatar Collage, 2005. [Намжил, Т. *Монгол гэр бүлийн ёс уламжлал*, УБ: Улаанбаатар дээд сургууль. 2005.]
- Nyambuu, H., and Nacagdorz', C. *The taboo concise dictionary of Mongolia race*. Ulaanbaatar: Ardincergi-inhevllel. 1993 [Нямбуу, Х, Нацагдорж, Ц. *Монголчуудын цээрлэх ёсны хураангуй толь*, УБ: Ардын цэргийн хэвлэл. 1993.]
- Park, HwanYoung. *Mongolian Traditions and Folk Beliefs*. Seoul: Bakijeong, 2008.
- Park, WonKil *The Culture and Physiography of Mongol*. Seoul: Dusol, 1996.
- Yun, JaeHeung. *The Personality Space of Our Old Home*. Seoul: Jibmundang, 2004.
- Zan, Znasik. *The Life and Folklore of Mongol Nomads*. Seoul: Minsokwon, 2005.

(Footnotes)

1 If a ceiling cover is closed in the middle of the day, it means that someone died. Thus only relatives who are there for the funeral may visit the house.

2 Bringing weapons may be considered threatening to other people, so you should leave them on the ger outside the door.

3 Mongolians have avoided stepping on the threshold throughout the ages. Travelers who visited Mongolia in the Middle Ages made it a taboo to step on the threshold of a ger, particularly a khan's or commander's threshold. A legend says that stepping on the threshold is the same as stepping on the neck of the owner of the house.

4 This means that a dying person is taking a last comfortable rest, so you should not disturb the person. The string in front of the threshold also means infectious disease (Byambasu'ren, 2006).

5 Mongolians have a custom of respecting and worshipping pillars. They believe, in particular, that ancestor spirits dwells in pillars to which horses are chained.

6 Thunder and lightning represent the authority or anger of the heavenly gods in Mongolian shamanism. In particular, the death of livestock from being struck by lightning is regarded as an evil omen and rituals are conducted to remove bad luck. Dagur tribe shamans in inner Mongolia in the east sometimes raise the souls of animals who died from lightning and transmit their messages (Park, 1996).

7 Entering through the left side of a door was interpreted as having severed or intending to sever relations with the owner of the ger.

ХӨӨМЭЙ ХАМ ШИНЖИТ УРЛАГ БОЛОХ НЬ

Л.Хэрлэн¹

Дэлхийд гайхагдсан монгол хөөмэй бол дуун ухааны ай сав дахь өгүүлэхүйн эрхтний бүхий л чадамжийг шаардах авиагаар илэрхийлэгдэж байгаа урлагийн бие даасан нэгэн төрөл мөн. Тодотговол монгол туургатны ухамсарт үйл ажиллагаагаар бүтээгдсэн гоц гайхамшигт үзэгдэл “хүн хөгжим” бол хөөмэй.

Ахуй амьдралын болон гоо сайхны зайлшгүй эрэлт хэрэгцээгээ хангах шаардлагын улмаас хөөмэй үүсч хөгжих явцдаа аман зохиол, урлагийн болон хөгжмийн тодорхой төрлүүдтэй тухайлбал тууль, магтаал, ерөөл, үлгэр болон цуур, хуучир, морин хуур, аман хуур зэрэгтэй хамт өнөөг хүртэл уламжлан хөгжиж ирсэн байдаг.

1. Хөөмэй ардын аман яруу найрагтай холбогдох нь

Монголчуудын магтаал магтан дуулах сэтгэлгээтэй хамт аялгууг хөгжмийн зэмсэгтэй хамсран шүлгийн шад бүрийн дараа хоолой шахан хөөмэйн ая эгшиглэгээг нэмэн баяжуулдагаараа хөөмэй аман зохиолтой холбогдох учиртай юм.

Монгол туульчид тууль хайлахынхаа өмнө уул ус, байгалийн гоо үзэмжээ магтан дуулдаг сайхан заншилтай. Тэрхүү тууль, магтаалын ая аялгуунд уулын оройн салхи шуурганы исгэрэн, өвс ургамалын найган шуугих чимээг санагдуулсан дүрслэл олонтаа бий.

Өнөөдөр хүртэл монголчууд тууль магтаалыг хайлахдаа шахмал буюу хөөмэйн хархираатай өгүүлэхдээ нутаг нутагт өөр өөр төрлийн товшуур, хуур хөгжмүүдтэй хамсран хөгжимдөж ирсэн байдаг. Монгол хөөмэй нь суурь хархираан төрөл түүн дээрээ исгэрэх, хуухирах, үлгэр, тууль хайлах, шашин номын уншлага гоншилгон унших, тоо бүртгэлийг сампингийн цохилттой нийлүүлэн уянгалан дуудах, хийгээд захиа захидлыг уянгалуулан дуудах зэрэг мөн цуур хөгжимтэй хамсрах зэргээр олон үйлдлээр баялаг байдаг бол бусад үндэстэн ястанд энэ нь тийм ч арвин баялаг биш байх жишээтэй. Энэ нь нутаг усаа магтан дуулах явцдаа эгшиг аялгууг арвижуулах аливаа байгалийн дуу чимээг хөгжмийн зэмсэг, өгүүлэхүйн эрхтэнээр үлгэрлэн дүрслэх явцдаа өгүүлж байгаа өгүүлэмжээ бодитоор илэрхийлэхдээ хөгжмийн зэмсэг мөн хоолойн янз бүрийн авиа эгшиглэгээгээр тодотгодог.

Хөөмэйн урлаг байгалийн авиа чимээг үлгэрлэн үүсч гарсан гэдэг утгаараа монгол ардын аман зохиолд ч байгалийн дуу чимээг илэрхийлэх байдлаар хадгалагдан үлдсэн нь бий. Тухайлбал тууль магтаалуудыг хайлахдаа хөөмэйн ая аялгуутай хамран гүйцэтгэж иржээ. Түүнийгээ “Уулын оройн хөөмэй” ч гэж нэрлэх ёс байдаг бөгөөд иймэрхүү дүрслэл бүхий аялгуунд “Цаст уул алаг Алтайн шил”, “Алтайн магтаал”, “Хангайн магтаал”-ын ая аялгуу зэргийг дурдаж болно. Энэхүү уул ус, нутаг орныг магтсан шүлэгтэй хирнээ хоолойгоо шахан тоочин дуудах явцдаа туульч нарын хүүрнэн хайлахтай төстэй хөөмэйлэх аялгуу нь богинохон байсан бол 1930-1940 оны үест олны хүртээл болж нийтэд сонирхогдож эхэлсэн бөгөөд 1938 онд Тогоочийн Чулуун хөөмэйг нутгийн залууст зааж дэлгэрүүлсэ² гэдэг. /Тогоочийн хөвгүүд ах дүүсээрээ Хар-ус савын хөөмэйчид гэж алдаршсан хүмүүс байжээ / Энэ үед хөөмэй сонирхогч залуучууд бий болсон бөгөөд тэдний дотроос малчин С.Цэдээ хөөмэйлэх авъяас билгээрээ тодорч Д.Лувсаншаравын найруулга “Алтайн магтаал” дан найралдуунд хамтран хөөмэйлж, анх тайзнаа хөөмэйн урлагийг олонд эгшиглүүлэн таниулснаар хөөмэйлэх урлагт өвөрмөц шинэчлэл гаргасан бөгөөд хөөмэйн аялгуу урт болсны дээр ардын дууны аялгууг дагнан хөөмэйлж хэмнэл, хөдөлгөөн, төрөл зүйл нь баяжиж бие даасан урлаг болоход их ахиц болсон юм.

2. Хөөмэйлэхэд түргэн хэллэг, жороо үгний үүрэг

Монгол аман зохиолын зөвхөн сонгодог хэлбэр туульд хөөмэйн эгшиг авиа хадгалагдан үлдсэн гэж бас хэлж болохгүй. Аман зохиолын богино хэлбэрүүд ч хөөмэйн урлагийг хөгжүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэж ирсэн нь бий. Тэдгээрийн нэг болох жороо үг, зугаа үг нь сургамжтай дууриалтай зүйлийг өгүүлсэн байх төдийгүй хэл яриа хөгжүүлэх ардын аман зохиолын олон төрөл зүйл байдгийн нэг нь билээ.

¹ МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын багш, доктор.

² “Монгол хөгжим судлалын дээж бичиг” УБ., 2008, 106

Монгол ардын түргэн хэллэг, жороо үгнүүдийг хөөмэйн сургуулилтын зайлшгүй хийгддэг дасгал бөгөөд энэ нь хэлийг уян хатан болгох эгшиг авиаг зөв эгшиглүүлэхэд чухал үүрэгтэй үндсэн дэг сургуулилт юм. Энэ утгаараа түргэн хэллэг, жороо үг нь хөөмэйн хэл хэллэгт чухал үүрэг гүйцэтгэнэ.

3. Хөөмэй исгэрээтэй холбогдох нь

Хөөмэйлэх нь дуулах үйл явц дээгүүр багалзуурын шахалтын зохистой үйл ажиллагаа бөгөөд тэр дундаа хүний өгүүлэхүйн эрхтэнээр үйлдэгдэх нэгэн хэлбэр болох исгэрээг оролцуулах нарийн үйлдэл оролцуулдагаараа онцлог юм.

Исгэрээ нь амьсгааны нарийн зохицуулалт шаардагддаггүй хэдий ч өгүүлэхүйн эрхтний нарийн зохицуулалтаар уруул, шүд, тагнайн оронд эгшиг авиаг үүсгэдгээрээ хөөмэйн исгэрээгээс ондоо юм. Өөрөөр хэлбэл төвөнхөд исгэрэг үүсгэдэггүй юм. Харин хөөмэй нь амьсгааны нарийн зохицуулалтаар төвөнхөд авиа, цуурай үүсгэн хөөмэйн эрхтэнд дуун хүрд үүсгэн өгүүлэхүйн эрхтнүүдийн оролцоогоор исгэрэг гаргаж зохицуулдагаараа онцлогтой.

Ийнхүү монголчуудын исгэрэх урлаг төдийгүй өгүүлэх эрхтний эрдэм урлагийн төгс чанар улам хөгжин дэвжсээр хөөмэйлэх урлагийг шинэ шатанд хөгжүүлжээ гэх бүрэн үндэстэй.

4. Хөөмэй дуулах урлагтай холбогдох нь

Монгол уртын дууг олон төрөл ангилалд хамруулан үздэг бөгөөд монголд айзам, бэсрэг, суман (жирийн) уртын дуу гэж ангилан хуваадаг бол өвөрмонголд айзам уртын дуу гэж байхгүй цуурын (цоорын) дуу (хөөмэй) хэмээн нэгэн ангилалд хамааруулан адил бус төрөл зүйлд хувааж задлан шинжилсэн нь бий. Үүнээс ажвал найрт дуулагдах уртын дуунд монголд цуурын дуу гэж байхгүй бол өвөрмонголд цуурын дуу гэж найрын ая эгшиглэгээнд хөөмэй төст эгшиг авиа, бахлуурын дууг нэмж дуулах ёс өвөрлөгчид дунд хадгалагдан үлдсэн нь сонирхолтой.

Энд уртын дууны аяыг хоолойн цуур буюу хөөмэйн хархираа төст эгшгээр баяжуулдаг нэгэн төрөл бий. Өвөрмонголд найрт уртын дуу дуулахдаа тунгалаг хоолойгоор ая барьж эхлэхэд хөөмэйн хархираа төст бахлуурын эгшиг аялгуугаар нэг өнгө дээр эгшиг нэмж түрж хавсарч дуулахуйд түүнийг цуурын дуу гэж нэрлэдэг байна. Өөрөөр хэлбэл цуурын дуу гэдэг нь хөөмэйн хархираа төст суурь өтгөн өнгөн дээр уртын дууны нэгдмэл дуулах ойлголтыг илтгэдэг. Гоцлон дуулагч нэг хүн үндсэн аялгууг цээл хоолойгоор аялахад цуурчин буюу хөөмэйч аргил буюу хархираагаар доор нүсэр бүдүүн хоолойгоор ая барьж хүнгэнүүлэн хамжихад дараа нь бусад түрлэгчид олон хоолойгоор түрж дуулдаг ёсон байна.

Уртын дууг ийнхүү хөөмэйн эгшиг авиагаар баяжуулан монголдуул ахуйн урлагийн нэг төрөл болгон хөгжүүлж төр ёсны дуу, найрын дууг агуулга хэлбэрийг нь нэг буюу хэдэн цуурчин, гол дуулаачыг даган олон хоолойгоор хавсран ая аялгууны харьцааг барин дуулах хэлбэр бөгөөд монгол үндэстний эртний дууг илтгэж буй уламжлалт найрын дууны хэлбэрийг хадгалж үлджээ.

5. Хөөмэй хөгжмийн зэмсэгтэй холбогдох нь

Хөөмэй хөгжих явцдаа тууль хайлахад нумт болон товшуур хөгжимтэй, бөө мөргөлд аман хууртай хамсран хэрэглэгдэж ирсэн хэдий ч цуур хөгжимтэй нарийн шүтэлцээтэй холбогддог.

Цуурыг исгэрүүлэн татахад гарч буй үндсэн эгшиг нь аялгууг бүтээх бөгөөд өгүүлэхийн эрхтний оролцоо ба хэвлийн булчингийн шахалтаар гарч буй хөөмэйн хархираа төст авиа буюу доод суурь эгшиг нь зайтай ойрын үсрэлтээр үндсэн эгшгээ даган татагдах замаар хөдлөн аялгууг бүтээдгээрээ онцлогтой. Суурь эгшиг нь аялгууг бүтээхэд төдийлөн холбогдолгүй мэт боловч тухайн ая, аялгууны дүрийг тодотгох хийгээд цуурын өвөрмөц тембрийг бүрдүүлэхэд онц ач холбогдолтой.

Тэгэхээр цуур татаж сурах гэдэг нь эхлээд тагнайн исгэрээ сайн исгэрдэг, дараа нь хөөмэйн хархираа сайн эзэмшсэн хүн сайн цуурчин болох бөгөөд энэ нь өгүүлэхүйн эрхтний өндөр чадвар шаардсан билиг авьяас хөдөлмөрийг бий болгодогоороо онцлог юм.

Монгол цуураар цуурдах өвөрмөц онцлог нь цуурч цуурыг эгшиглүүлэхдээ амгай буюу үлээх нарийн үзүүрийг шүдээр зууж үлээхийн сацуу хөөмэй төст дэвсгэр өнгөтэй хамтатган хос өнгө гаргадгаараа онцлог юм.

6. Хөөмэй шашны зан үйлтэй холбогдох нь

Бөөгийн тамлага дуудлагад Монголчуудын эртнээс уламжилж ирсэн уламжлалт аман зохиолын төрлүүдийг өөрөө багтаан домог, яруу хэл хэллэг харилцан шүтэлцээтэйгээр оршиж ирсэн төдийгүй хөгжмийн айзмийн хэм хэмнэл, ая аялага, бүжиглэлийн үйл хөдөлгөөн үлэмжхэн орж урлагийн хэд хэдэн төрлийг өөртөө багтаасан байдаг.

Мөн зан үйлдээ зориулалтын хуяг өмсгөлөөс гадна хэнгэрэг, хэнгэрэгийн цохиур, аман хуур зэрэг хөгжмийн зэмсэг тоног, элдэв амьтны авиа эгшгийг чимээлэн бөөлдөг ёстой. Ингэхдээ хөөмэйн шахалт, хархираа зэрэг эгшиг авиаг аялгуулан хийгалж, гийгэлж, хуугайлж, гуугалж, гүүгэлж онгоддоо хүч оруулан аялгуулдаг ажээ. Энэ нь нутаг нутагт бага зэрэг ялгаатай ч ерөнхий бөөгийн шашинд нийтлэг байдаг. Бөөгийн шашны тэнгэр, газар, галын тахилгуудад хоолойн шахалт, хархираа хөөмэйн элементүүд нийтлэг байх

бөгөөд зарим онгодоос хамааран дуу авиа, хэл ярианд өөрчлөлт орох явдал байдаг. Тухайлбал: Авгалдайн онгодыг оруулахдаа авгалдайн дуудлагын ерийн айзам хэмнэл ая дангаар дуудах бөгөөд онгодыг ирүүлэх үес далайн давалгаа долгион хүүгээний чимээ бүхий шахалттай хархираа хөөмэйн аяс оруулан бөөлдөг. Мөн маш эртний бөө, удгадтай харьцах явцад амьсгааг цааш татсан байдалтай баргил хоолойгоор (хархираатай шахалттай маягтай)³ аяархан хэлэгддэг ч зүйл бий.

Энэ мэтээр зөвхөн бөөд төдийгүй буддын шашны номын уншлагад ч “умзад” хоолойгоор гэх хөөмэйн хархирааны ая аялгуу уламжилж ирсэн байх бөгөөд сонирхолтой нь тэрхүү ая аялгууг нь тэмдэглэсэн тэмдэглэгээтэйгээ бидэнд уламжилж ирсэн нь нэн сонирхол татаж байна. Хөөмэйн авиа эгшиглэгээ сүм хийдийн ном уншлагад лам нар номоо нэг хэмнэлд оруулан дуудах, сүсэгтэн олонд номын утгыг тодотгох үүднээс тухайн хурлыг тэргүүлэн удирдагч шахмал бүдүүн хоолойгоор номыг аялгуулан зэдлүүлэхэд бусад нь дагалдах маягтай гоншилгон дууддаг уламжлал бий. Энэхүү бурхны шашны номыг аргил хоолойгоор гоцлон эгшиглүүлэхийг унзад гэх бөгөөд энэ нь хөөмэйтөст авиан нэгэн хэлбэр юм.

Дээрхи урлаг соёлын зарим зүйлстэй хөөмэй хам шинжит байдлаар үүсч хөгжих явцдаа өнөөдөр мэргэжлийн түвшинд гэх буюу бие даасан урлагийн нэгэн төрөл болж уламжлалт болон системчилсэн сургалтанд шилжин гүнзгийрч хамрах хүрээ нь ч өргөжиж байна. Тиймээс хөөмэйн сургалт, судлагаа, хөгжлийн бодлого чиг, хандлагыг цогц байдлаар авч үзэх нь өнөөдөрийн хөөмэйн урлагийн тулгамдсан асуудал болох байх гэж бодож байна.

1. Даяаршлын эринд Монголчуудынурлаг соёлыг хэрхэн авч үлдэх, язгуур шинж чанарыг нь хэвээр хадгалах асуудал чухал болсон өнөө үед хөөмэйн ардын язгуур шинж чанарыг хадгалах асуудал, мөн үүний зэрэгцээгээр түүнийг дэлхийн өнөөгийн соёл урлагийн хөгжилтэй хэрхэн хослуулах вэ гэдэг асуудал бидний өмнө тулгарч байна.

2. Орчин үед шинжлэх ухааны салбар өндөр хурдацтай хөгжиж, үндсэн суурь шинжлэх ухаанууд бусад салбар шинжлэх ухаануудтай хамсран харьцуулсан судлагаагаар хүрээгээ тэлж шинжлэх ухааны судлагааг өргөжүүлэн хөгжүүлж байна. Энэ нь тухайн салбар шинжлэх ухаануудад хөгжил дэвшлийг бий болгодог. Гэтэл хөөмэйн судлагааг аль ч шинжлэх ухааны салбартай холбон гүнзгийрүүлэн судлах асуудал хоцрогдонгуй байгаа нь ажиглагдаж байна. Хөөмэйн урлагийг хөгжмийн урлаг, түүхийн шинжлэх ухаан, хэлшинжлэлийн шинжлэх ухаан, биологийн шинжлэх ухаан, анагаахын шинжлэх ухаан төдийгүй газарзүй, хүн судлал, хүмүүнлэг, угсаатан судлал зэрэг олон салбаруудтай ч хамтатган судлах асуудал шаардагдсаар байна.

3. Хөөмэйлэх арга ажиллагаа, түүнийг нийтэд таниулах сургах үйл ажиллагаа зөвхөн мэргэжлийн түвшинд бус нийтэд зориулагдсан байх шаардлагатай байна. Тиймээс сурах бичиг, гарын авлага, баримтат өв, кино хийх, үүнд яамны бодлоготой уялдаад сургалт, судлагаа, сурталчилгааны байгууллагатай хамтран нэгдэж ажиллах нь хөөмэйн урлагаар дамжуулан залуу үед үндэсний бахархалыг төлөвшүүлэх, гадаадад монгол урлагийг сурталчлах, сургалтанд ашиглах зэрэг их үйлд их ахиц гарах боломжтой.

Хөөмэй монгол угсаатны язгуур их урлаг мөний хувьд, дэлхийн олон үндэстэн угсаатны анхаарал сонирхолыг татан сонгодог урлагийн түвшинд хүрэх ирээдүй бүхий, цаашид ч хүн төрөлхтөний урлагийн өвөрмөц урлагийн нэг хэлбэр хэвээр хадгалагдан, улам цэцэглэн хөгжих ёстой их урлаг билээ.

Resume

The Mongolian throat singing (höömei) is a separate genre of the Art which claims the high capacity of the vocal organ. That means it is the man-musical instrument, which is a wonderful phenomena or creation of the Mongol people.

The höömei is in association with not only the musical art and phonetics but also the religious rituals, apart from the traditional oral literature like epics and tongue twitters, etc. In this way, it has been developing as a special genre of the art.

³ Эрдэмтэн С. Дулам: “Говь-Алтайн уугуул Батгэрэл удганы бөөлж онгод орох явцад залуу эмэгтэй байж бүдэг аргил хоолойгоор хэлж байхыг нь үзсэн. Энэ нь эртний бөө зайрангууд орж ирэхдээ ийм хоолойгоор дуугардаг юм билээ. Тэр үед 800 гаруй жилийн өмнө байсан Гүр зайран орж ирсэн нь ийнхүү дуу авиа нь сонин янз бол юм билээ” гэсэн билээ. /2009 оны 3. 19, Л.Х/

Нүүдэлчид ба зах зээлийн эдийн засаг
Nomads and market economy

*Ж.Дэлгэрмаа**

Товч агуулга: Нүүдэлчин ард түмэн бид байгаль дэлхийн эрхшээл дор амьдарч түүнийгээ дээдлэн шүтэж, хайрлан хамгаалж, аргадан эелдэг зөөлнөөр харьцаж, үржил шим өгөөж буянаар нь мал сүргээ адгуулан амьдарсаар ирсэн уламжлалтай билээ. Монгол гэхээр гадныханд морь, мал, хээр тал, нүүдэлчин ард түмэн төсөөлөгддөг гэх. Үнэндээ ч мал гэдэг Монголын брэнд, баялаг. Байнга хувьсан өөрчлөгдөж байдаг тогтворгүй араншинтай цаг улирал, ган, зудын бэрхшээлийг даван туулах боломжийг нүүдлийн мал аж ахуй л олгож байна. Монгол үндэстний эдийн засгийн хөгжил, худалдаа наймаанд хандах нүүдэлч ард түмний сэтгэлгээний онцлогуудаас эхлээд дэлхийг хамарсан соёл, эдийн засгийн шинэчлэлүүд, зах зээлийн эдийн засагт эргэн орсоноор одоогийн эдийн засгийн хөгжил бидэнд хэрхэн нөлөөлж байна вэ? Монголчууд нүүсээр. Талаас илүү хувийнх нь амьдрал хотожсон хэв маягт шилжиж, уламжлалт нүүдлийн соёл иргэншилтэйгээ айлсав. Хоёр соёл хэрхэн тэнцвэржиж, аль нь давамгайлан өөриймшихүй дор бидний ирээдүйн чиг хандлага тодорхойлогдоно.

Түлхүүр үг: Монгол улс, нүүдэлчид, зах зээлийн эдийн засаг, эдийн засгийн хөгжил.

Нэг. Нүүдэлчид

Монгол нутаг дахь нүүдэлчдийн амьжиргаа, аж төрлийн хэлбэр нь тэдний хүсэл зориг санаачлагаас бага хамаарч, цаг уур газар нутгийнх нь онцлогтой уялдан үүсч хөгжиж иржээ. Эрс тэс, хуурай уур амьсгалтай, далайгаас алслагдсан энэ нутаг тивийг тивтэй, нэг иргэншилийг нөгөө иргэншилтэй холбосон их замаас зайдуу оршино. Ийм учраас чухал замыг дагасан боомт баригдах боломж хомс, дээр нь газар тариаланд төдий л тохиромжгүй цаг ууртай. Ийм орчинд эрс тэс цаг уурт тэсвэртэй, хагас зэрлэг, бэлчээрийн мал аж ахуй л тал нутгийн амьжиргаанд хамгийн тохиромжтой байлаа. Гантай газраас зунтай газар руу, зудтай нутгаас өвөлжөө тийш, хангайн шилээс уулын өвөр рүү, нөмөр нөөлөгтэй бууцнаас сэрүүн дэнж рүү амархан шилжин **хөдөлж чадна. Эрт цагийн нүүдэлчид гэрийн мал адгуулахаас гадна ан гөрөө хийж өрх гэрийнхээ аж ахуйд нэмэрлэдэг байв.**

Нүүдэлчдийн бүхий л эд хогшил, сав суулга нь түргэн ачаалахад зохицсон авсаархан агаад замын ая даахуйц борог бааз. Нүүж суухад хөнгөн, барихад амархан гэр орон, тайлахад хялбар хувцас хунараас эхлээд цасан доороос өвсөө өөрөө малтаж идэх ба мөс цоо цавчин ус гарган ууж амиа өөрөө аргалаад явдаг мал сүрэг чухам энэхүү онцог дээр бий болжээ. Нүүдэлчин амьдрал нь аж төрөх амь зуух арга төдийгүй дайснаас биеэ хамгаалах, оршин тогтнох арга нь байв. Хүний тоо, зэр зэвсгийн хүчээр хавьгүй илүү гүрнүүдийн хажууд, дунд оршиж ирсэн Монголчууд чухамхүү хурдан нүүдэллэх чадварын хүчээр оршин тогтнож байв. Тэд өөрсдөөс нь хүчирхэг арми түрэмгийлэн ирэхийн цагт нүд алдам тал, ой хөвчийнхөө аль нэг булан руу ачаагаа хөтөлж, адуу малаа туусаар уусан шингэнэ. Эзэлж аваад суучих хот энэ тэр (нүүдэлчин биш ард амьдрах орд, харш, цайз) үгүй тул өнөө “эзлэн түрэмгийлэгчид” аяганы хийц, аяны зуушаа барахын цагт нутаг буцна. Тэд өөрсдөө нүүдэлчин ард болохгүйгээс хойш яалтай билээ.

“Монголчууд гар урлал, эдлэл хэрэглэлээ чимэглэх дуртай ард түмэн. Шинэ зүйлд басхүү хоройтой, тиймээс ч аливааг амархан сурдаг. Монголчууд хүчирхэг боловч шалихгүй, ялагдашгүй мөртөө хэврэг, цөөхүүлээ байтлаа дуусахгүй, жижигхэн хэрнээ дуусашгүй үндэстэн байсны нууц нь чухам энэ нүүдэлчин амьдралд л байгаа. Нүүдэлчин амьдралын уг сурвалж нь хээр тал нутагтаа буй. Иймээс бидний зуун зууны туршид нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн нь тэдний сонголт гэхээсээ илүү хувь заяаны тулгалт байсан гэж хэлж болно. Нүүдэлчид бүхнийг гаднаас авдаг байсангүй. Өөрснөө с бас технологитой, арьс нэхий элдэж боловсруулахаас эхлээд уран дархчуул гар урлал үйлдэж тэр бүү хэл хүдрээс металл гаргах хүртэл үйлдвэртэй байжээ. **Сайн өөриймшүүлэгч /монголчлох/ малчин монголчууд аж төрлөө даган цаг үргэлжид**

*БНХАУ-ын Өвөр монголын Их Сургуулийн докторант.

зэрлэгшин, нийтлэг хөгжлийн эсрэг чиглэл рүү нүүж явсан юм биш. Зах зээл, үйлдвэрлэлээс хол, цаг үргэлж нүүдэллэн явдаг амьдралаасаа болоод бүхнийг өөрөө хийх, хэрэгцээт зүйлсээ малын ашиг шим болон байгалийн гаралтай зүйлсээр хангахаас өөр замгүй байсан. **Гэхдээ тэдэнд суурин иргэншилээс зугтаах, эргэн түүнд татагдах хандлага аль алин бий.** Нөгөө талаас нүүдэлчин монголчууд гайхамшигтай сайн сурагч, бусдын технологи, бүтээлийг өөриймшүүлэгч байлаа” (1.17).

Монгол гэр нь нүүдэлчин ард түмний уламжлалт гэр сууц юм. Байгалийнхаа зүйлээр бүтэж, эцэс сүүлд нь байгальдаа уусан шингэдэг. Ямар ч хор хохиролгүйгээр. Барихад, буулгахад хөнгөн авсаархан, зай багтаамж ихтэй, удаан эдлэгддэг. Нүүж, зөөхөд хялбар, ердөө 2-3 тэмээний л ачаа болно. Мөн гэр дэлхийтэй адил бөөрөнхий учраас элдэв муу энерги хорогдон үлдэхгүй. Хүний уур бухимдал, уцаарыг тайлдаг онцгой чадвартайн дээр, хана болох эсгий туурга нь цагт 500 удаа агаар солилцдог. Монгол гэрийг хэн ч, хаана ч, ямар ч төрлийн зориулалтаар ашиглаж болно. Одоо ч АНУ, Япон, Канад, БНСУ, Франц, гээд дэлхийн олон улсад ашиглаад эхэлчихсэн. Үүний араас гаалийн экспортын дүн мэдээг үндэслэн 35 орны нэрийг, дэлхий дахинаа түгсэн мянга мянган монгол гэрийн тоог дурайтал жагсааж болно. Энэ бол их нүүдлийн эхлэл. Тэгээд бас болоогүй архитекторын төгс шийдэлд тооцогдоод байгаа 3000 жилийн түүхтэй монгол гэрийг хэн ч өөрчилсөнгүй, угаас төгс бүтээгджээ. **(Монголчуудаас гэр бэлгэнд авсан гадаадын хэсэг хүн барих гэж долоо хоног ноцолдоод баралгүй “Монголчууд бүгдээрээ инженерүүд юм байна” гэж дуу алдсан удаатай)** Ийм онцгой шинжүүд цогцолсон монгол гэртээ нүүдэлчин ард түмэн тэнгэр газар, байгальтай нэгэн зэрэг холбогдож, нар сар, огторгуйгаас эрчим хүчээр тэтгэгдэн, мөнх тэнгэрт ивээгдэж байдаг учиртай.

Монголчуудад суурин соёл иргэншил, хотжилт, хэт хөгжил зохихгүй. Нүүдлийн соёл иргэншил бол монголчуудын өнө удаан оршин тогтнохын үндэс бас цорын ганц гарц нь ч байж мэднэ. Ер нь хүн төрөлхтөн эзэн Чингис хааны төвхнүүлсэн Эзэнт гүрний нүүдлийн соёл иргэншил, монгол ухаанаас иш татахыг байг гэхгүй. Энэ бол байгаль дэлхийтэй ойлголцох хамгийн оновчтой арга. Бас таатай сонголт. Ингэж байж л байгаль дэлхийн хүсэл биелж, хүрэх газраа мэдэхгүй хүн төрөлхтний хөгжил амсхийх боломжтой болно. Байгаль дэлхийн төлөө бидний хийж чадах цорын ганц зүйл бол түүнийг чин сэтгэлээсээ хайрлах. Чин сэтгэлээсээ хайрлана гэдэг өнгөц хэсгийн ногооноор бүрхэж, бусдын нүдийг хуурахыг хэлдэггүй. Бас “Яарвал даарна” гэдэг хоёрхон үгнээс бүтсэн монгол ардын зүйр үг бий. Хүн төрөлхтөн бид энэ хөгжилд дэндүү ихээр яарч хүрсэн. Явах замаа олохгүй, төөрч будилж, хөгжил хэмээн андууран, мөхлийн ирмэгт тулж ирсэн мэт.

Нүүдэлчин байх нь суурин ард түмнийг бодвол олон талаар дутагдалтай нь үнэн. Түүхийн үнэт эд өлгий зүйлс нь нүүдэл суудлын явцад хугарч эвдрэх, норж урагдах, гээгдэж хаягдах гэх түмэн шалтгаанаар үрэгдэж алга болох нь элбэг. Тийм ч учир **Монгол хүн** үл хөдлөх хөрөнгийг шүтэхээс илүү **хөдөлгөх, хувиргах, наймаалах эд хөрөнгийг ихээхэн эрхэмлэн үзнэ.** Үүнээс уламжлан нүүдэлчин ард түмний боловсрол мэдлэг нь компакт, цомхон аль ч үед юунд ч шилжүүлэн хэрэглэж болох хурдан шалмаг хувирамтгай шинж чанартай байдаг. Энэ нь тэдний тархи толгой, генд нь оршиж байдаг.

Манай өвөг дээдэс эртнээс олон улс түмнийг захиран нийгэм харьцаа, хүн төрөлхтний хоорондох мэдээллийн шинэ зарчмыг дэлхийн түүхэнд хэрэгжүүлж байсны хувьд бидний уураг тархинд ассир, перс, хятад, түвд, европын асар их нууцлаг мэдээллүүд удамшин оршиж ирсэн байдаг. Суурин ард түмэн консерватив сэтгэлгээтэй байдаг. Нэгэнт л тэгээд ойлгочихсон бол түүнээсээ сална гэж байхгүй. Ном, сонин, телевизээр хичнээн үзэж хараад ойлгохгүй. Жишээлэхэд, Монголыг элчилгүй цөл гээд ойлгочихсон бол манай нутаг ой модтой, загас жараахайтай гээд яриад байхад танайхан чинь хаана усанд ордог юм бэ? Танайх чинь гол, горхи байхгүй говь цөл шүү дээ гээд асуугаад байдаг. Газрын зураг дээр том гол, мөрний зураг үзүүлээд ч нэмэргүй. Гэтэл бид чинь бараг мэдээлэл авч чадахгүй байтлаа сургаар нь ойлгоод, мэдээд байдаг чадал увьдастай. Энэ бол монгол хүний боловсрол, мэдээлэл олж авах өвөрмөц онцлог юм. Гэхдээ **монголчууд суурьшиж эхэлж байна.**

Хоёр. Нүүдэлчид зах зээлийн эдийн засагт хэрхэх

Аливаа суурин газар, хот хүн амаа нэмэхийн төлөө ажилладаг. Дэлхийн аль ч хот ийм. Гэхдээ хэт замбараагүй биш. Хүн ам өснө гэдэг нь тухайн суурьшилд амьдрах бололцоо нэмэгдэнэ гэсэн үг. 1990 оны эхээр хотын хүн ам бага, бизнес хийхээр ашиггүй гэдэг байсан бол өнөөдөр сая гаруй хүнтэй, тодорхой хэмжээний ашиг олох чадамжтай болчихож. Хотынхоо зохион байгуулалтыг зөв хийх хэрэгтэй. Бид их хүнтэй болчихлоо, орон нутаг руу нь шилжүүлбэ гэж ярьж болохгүй. ДНБ-ий 60 гаруй хувийг үйлдвэрлэж байгаа энэ хоттой өрсөлдөх ямар ч төв өнөөдөр Монголд алга. Ойрын хугацаанд төвүүд байгуулах бололцоо ч байхгүй. Өнөөдөр томоохон хотын хэмжээтэй нь Дархан, Эрдэнэт л байна. Сайхан амьдарч, ажлын байртай болохоор хөдөө орон нутгийн иргэд хотыг зорьж ирсээр. Тиймээс орон сууц их баригдахын сацуу

түүнийгээ дагаад бизнес ч хөгжиж байна. Өөрөөр хэлбэл Дархан, Эрдэнэт эдийн засгийн тулгуур байсан бол хүмүүс тэнд орон сууц бариад амьдарч болно. Үнэндээ эдийн засгийн хувьд соронз хэлбэртэй болчихсон Улаанбаатар хотод Монгол Улсын 50 гаруй хувь нь амьдарч байгаа. Тиймээс хөдөө орон нутгийн иргэдээр тэлээд буй гэр хорооллыг барилгажуулах хэрэгтэй. Улаанбаатар хотод барилга барих газар байхгүй юм шиг ярьдаг. Хангалттай бий. Хотын захаасаа эхлээд байна. Манай улс 1990 оноос зах зээлийн шилжилтэнд эргэлт буцалтгүй шилжин орсноос хойш өнөөдрийг хүртэл хөгжлийн тодорхой шатанд хүрч дэлхийн хөгжилтэй хөл зэрэгцэн хөгжиж, ихээхэн ололт амжилтанд хүрч байгаа хэдий ч шилжилтийн өнөө үед нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдлын улмаас нийт хүн амын дунд ажилгүйдэл, ядуурал, бухимдал, нийгмийн сөрөг үзэгдлүүд улам бүр ихсэж байна.

Ийм нөхцөл байдалд манай улсын баримтлах **боловсролын бодлого** ямар байх ёстой вэ?

Нэгт, хямд төсөр байх ёстой.

Хоёрт, амьдралын зорилго шаардлагад яв цав нийцсэн оновчтой байх ёстой.

Гуравт, дэлхийн шинжлэх ухаан соёлоос хоцрохгүй байх ёстой.

Дөрөвт, нэгдсэн систем шаардлагатай байх ёстой.

Тэгвэл бид ирээдүйнхээ иргэдэд юу мэдүүлэх хэрэгтэй вэ? Энэ бол зайлшгүй соёлт хүн мэдэж байвал зохих хүн төрөлхтний соёлын өв уламжлал түүний үндэс юм. Сургуулийн хүүхдэд хүн төрөлхтний соёлын өвийг системтэй мэдүүлэх хэрэгтэй. Яагаад соёл гээд байгаа юм гэхлээр хүн болгон чадаж байх албагүй ч мэдэж байх ёстой онолын мэдэгдэхүүн хүнийг бүх насанд нь дагаж түүний амьдралыг залж тодорхойлж явдаг тэр зүйл нь соёл байдаг.

Нүүдэлчин Монголчууд өвөг дээдэс нь үхэж үрэгдэвч тэнгэрт хальсан тэднийхээ сүнсийг үр сад нь дээдлэн хүндэлдэг, зааж сургасан сургаалыг нь ягштал биелүүлдэг, байгуулсан алдар гавъяаг нь ам дамжуулан ярьж шүтдэг байлаа. Тэд үе үеийнхний оюун санаагаар тасралтгүй баяжин, хөгжиж ирсэн соёлын гайхамшигт түүхтэй.

Жишээлбэл, Математикийн шинжлэх ухаан гэхэд л натурал тоо, бүхэл тоо, рационал тоо, иррационал тоог ямар шинжээр нь ангилдаг, бодит тоо хуурмаг тоо гэж юу юм бэ? Тэгшитгэл, тэнцэтгэл биш гэж юу юм бэ? Функциэс юугаараа ялгаатай юм бэ гэдгийг ойлгосон байх ёстой. Түүнээс хүн бүр математикийн мэргэжилтэн болох албагүй. Математик бол дүрсэлж, харж, загварчилж байх ёстой шинжлэх ухаан юм. Хэдүйгээр физик, хими математик загварчлалыг сайн харуулж чаддаг боловч зориуд томъёо, тэгшитгэл бүрийн загварыг геометр загвараар зураглан харуулж байж математикийг ойлгуулах болно. Аливаа шинжлэх ухаанд үйлчилж байгаа ерөнхий хууль, чанарыг нарийн цэгцтэй ойлгуулахыг соёл гээд байгаа юм. Ерөнхий боловсролын асуудалд онолын чиглэлтэй ийм соёлын үндсэн мэдлэгийг өгөхөөс гадна практикум гэдэг хичээлийн төрөл маш чухал байр суурь эзэлнэ. Хүн юмыг гараар хийж амьдрал дээр туршиж байж мэдлэг нь жинхэнэ бүтээлч болдог. Жинхэнэ практикумын хичээл дээр дуулж хуурдаж, биеийн тамир хөөж, гар урлалын бүтээл туурвидаг байх хэрэгтэй. Тэгэхдээ энэ нь хүүхэд бүрийн дур сонирхол, авьяас чадвараас шалтгаалсан сонголт байвал зүгээр. Анги өгсөх тутам бүхэл бүтэн сэдвээр бүрэн дүүрэн практикумын ажил хийлгэж байвал их үр дүнтэй байхсан. Мэдлэгээ хэрэглээд, дасгалжуулаад байхаар хүн аяндаа ухаан цоорч ирдэг. Хэрэгцээтэй мэдээллээ эрж олж авч чаддаг болно. Одоо хүн хангалттай мэдээлэл авч байна. Харин түүнийг ойлгож, тусгаж авах чадвартай болгох хэрэгтэй.

Хүнээ хөгжүүлэхгүйгээр урагш давшингүй хөгжих тухай ярих нь чөдөртэй морь унаад өртөө газар явах гэж адгаж буйгаас өөрцгүй. Хүндээ анхаарал хандуулж, бид өнөөдөр хэдэн хүнтэй, ирэх жилд хэд болох, өнгөрсөн жил хэдэн хүнтэй байсан гэдгээ яг мэдэж байж нийгэмдээ тохирсон зохистой хөтөлбөр, ядуурал, ажилгүйдэлийн төвшинг барих, түүнийгээ улс орныхоо хөгжил ирээдүйтэй холбох боломжтой болно.

Гурав. Бэлчээрийн хомсдолоос барааны хомсдол

“Долоон хямрал : Үл хямрах эдийн засагтай нүүдэлчид манжийн эрхшээлээс гаруутаа дэлхийтэй хөл нийлэх учиртай болов. Хэрэглээний хувьд өөрөө өөрийгөө хангадаг учраас бусдаас хамаарал багатай, тэр хирээрээ нийтийг хамарсан эдийн засгийн хямралаас зайдуу. Гэвч аж төрөл нь малаасаа хамраалтай, мал нь бэлчээрээсээ хамааралтай, бэлчээр гарц нь цаг улирлаас хамааралтай. Тэгэхээр эдийн засаг үргэлж риск дээр байдаг гэж болно.

Анхны хямрал : (1911-1912)

Монголчууд цөөн нэрийн барааны импорт, экспорт дээр тогтдог эдийн засаг нь нөгөө талаасаа үргэлж гадаадаас үргэлж хамааралтай ирсэн. Тэр нь өөрийг нь эзэрхийлэгч орны хүсэл зоригоос хамааралтай байв. Үндэсний эрх чөлөөний хувьсгалаар Манжийн амбан төлөөлөгчийн газруудыг хөөхдөө Хятадын худалдааны сүлжээ, пүүсүүдийг хамтад нь хөөж, ялангуяа баруун хязгаарт дээрэмдэн тоножээ. Үүнээс үүдэн

Ж.Дэлгэрмаа

монголчуудын цай, тамхи, даалимбаар хангадаг сүлжээ тасалдаж, импортын гол нэрийн бараа хомсдож хямрал үүсэв.

Хоёрдугаар хямрал : (1922-1928)

1920-иод онд гадаадын хөрөнгө оруулагчдыг хөөн гаргаж, тэдэнд төлөх өр зээлийг хүчингүй болгож, улмаар үүнээс үүдэлтэй мөн л цай, тамхи, даалимбын хомсдол. Энэ орон зайг зөвлөлтүүд нөхөхөөр гүрж цай, казах дүнс, орос даалимба үйлдвэрлэн нийлүүлж эхэлсэн боловч дассан бирэндээс шинэ бирэндэд шилжих нь амаргүй байлаа. Зөвлөлтүүд шинэ бараандаа дасгахын тулд дотроо ээмэг, бөгж зэрэг хонжвортой “азын” цай, тамхи хүртэл гаргаж байв.

Эдийн засгийн гуравдугаар хямрал : (1928-1932)

Гадаадын хөрөнгө оруулагчдыг хөөн гаргасны дараа Феодалын хөрөнгө хураах нэрийн дор өмч хураах ажил эхэлсэн. Сүм хийд жас жавын хөрөнгийг хураан түүн дээрээ коммун байгуулж, иргэдийг албан хүчээр хамруулсан. Ямарч бүтээлгүй, зорилгогүй ерөөсөө л коммунизм байгуулах зорилгын дор цуглуулсан хүмүүс асар их хөрөнгийг агшин зуур идэж, үрэн таран болгож дууссан. Үүнийг даган үнэгүйдэл бий болсон. (1939-1945) Энэ нь Дэлхийн II дайнд Зөвлөлт гүрэн татагдан орсонтой холбоотой. Зөвлөлтөөс хангадаг байсан цай, тамхи, даалимба хомсдсон төдийгүй, Монгол орон дайны байдалд орж “бүхнийг фронтод” хөдөлгөөн өрнүүлэн ажиллаж эхэлсэн. Дайн дууссаны дараа аж ахуйн байдал эргэн хэвэндээ орсон.

Эдийн засгийн дөрөвдүгээр хямрал : (1959-1990-ээд он)

Эхний ээлжинд чинээлэг ардын хөрөнгийг “Феодалын хөрөнгө хураах” нэрийн дор булаан авсан. Дараагийн ээлжинд коммунд нэгтгэсэн. Ингээд иргэдийн гар дээр үлдсэн малыг 1959-1962 онуудад нэгдэлжих болон дахин нийгэмчлэх компаниар хураан дуусгав. Нэг талаас мал хөрөнгийн үнэгүйдэл бий болсон. Иргэд малаа нийгэмчлэхээс өрсөн, зарж борлуулахыг хязгаарлах зорилгоор суурин газрыг сүү цагаан идээ, махаар хангадаг сүлжээг тасалсан. Малын захыг татан буулгав. Үр дүнд нь орон нутагт малын үнэгүйдэл, суурин газар махан хүнсний хомсдол бий болсон. Мах сүүний хангамжийг зөвхөн улсын худалдаагаар дамжуулан хийх шийд гарсан. Энэ бүтэц хомсдолыг бүрэн шийдэж чадаагүй. Суурин газарт мах сүү олох нь хамгийн том асуудал хэвээр үлдсэн төдийгүй хомсдол 1990-ээд оныг хүртэл үргэлжилжээ.

Эдийн засгийн тавдугаар хямрал : (1990-1995)

Энэ нь мөн л гол ивээн тэтгэгчээсээ салсантай холбоотой. 1990 онд социалист систем түүний дотор Зөвлөлт гүрэн задран унаж, Монголын үргэлжийн алдагдалтай, “коммунизм байгуулж байгаа” гэдэг зөвтгөлийн дор тэднээс тэжээгдэж байсан монголын эдийн засаг хямарсан. Дэлгүүрийн лангуу хоосорч, үлдсэн цөөн нэрийн бараагаа картаар хувиарлаж эхлэв. Эдийн засгийн эрх чөлөөний үрээр бий болсон чөлөөт худалдаа, Монголын өмнө нээгдсэн Хятадын эдийн засгийн өсөлт, мөн хувьчлал, ялангуяа малыг хувьчилсан нь элбэг мах хүнсээр нийгмийг хангаж эхэлснээр энэ хямрал намжсан юм.

Эдийн засгийн зургадугаар хямрал : (2008-2010)

Монгол орон ертөнцөөс тусгаарлагдахаа больж, дэлхийн зах зээлийн нэгэн хэсэг болсонтой холбоотой. Дэлхийг хамарсан эдийн засгийн хямрал нь Монголыг нэргэв. Энэ үеэр манайд анх удаа диффилаци ажиглагдсан. Дэлхийг хамарсан хямрал харьцангуй намжиж, Монголд уул уурхайн шинэ ирээдүй харагдаж гаднаас хөрөнгө орж ирсэнтэй холбоотой эргэн сэргэсэн.

Эдийн засгийн долдугаар хямрал : (2013-...)

Монголчууд гадаадын хөрөнгө оруулагчдын эсрэг шинэ дайн эхлүүлж, байгаль хамгаалах нэрийн дор орон нутгийн дарамтлагч бүлгүүд үүссэн. Төрөөс хоёр нүүртэй бодлого явуулж нэг талаасаа гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих мэт боловч нөгөө талаасаа 68 хувийн татвар гэхчлэнгээр хөрөнгө оруулалтыг боомилсон бодлого явуулсанаар гадаадынхан хөрөнгөө эргүүлэн татаж, гарч эхэлсэн. Үүнтэй холбоотойгоор валютын нөөц хомсдож, эдийн засгийн хямрал эхлэв”(1.230).

Дөрөв. Гадаадын хөрөнгө оруулалт

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлаас жил бүр гаргадаг “Дэлхийн хөрөнгө оруулалтын илтгэл”-д улс орнуудыг гадаадын шууд хөрөнгө оруулалтын үр дүнгийн болон чадавхийн индексээр нь байр эзлүүлэн ангилахад Монгол улс 1993-1995 онуудад хоцрогсдын ангилалд байсан бол 1999 оноос “чадавхиасаа илүү гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шингээсэн улс орнууд”-ын тоонд орох болжээ. Харин “Дэлхийн хөрөнгө оруулалтын тухай-2008” илтгэлд “хошуучлагч” улс орнуудын эгнээнд тэмдэглэсэн нь Монгол улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлт болон хөрөнгө оруулалтын орчин жил ирэх тутам сайжирч байгааг харуулсан явдал болсон.

“2011 оны эхний есөн сарын байдлаар 11.380 гадаадын хөрөнгө оруулалт бүхий аж ахуй нэгж Монгол улсад бүртгэлтэй болжээ. Энэ хугацаанд дээрх аж ахуйн нэгжээс нийт 5,8 тэрбум ам.долларын шууд хөрөнгө

оруулалт хийж, тэр хэмжээгээр Монгол улсын эдийн засаг өсч иржээ. 2008 онд гадаадын 1.551 компаний нийт 708 сая ам.долларын хөрөнгө оруулалт бүртгэгдсэн нь 1996 оныхтой харьцуулбал даруй 13 дахин нэмэгдсэн явдал бий.

2009 он гэхэд л Канад улс Монголд 500 сая ам.долларын шууд хөрөнгө оруулсан гэсэн тооцоо байдаг. Оюу Толгой төсөл хэрэгжиж эхлээд зөвхөн Оюу Толгойд хоёр тэрбум ам.долларын хөрөнгө оруулсан нь манай улсыг чиглэсэн хөрөнгө оруулалтын дүнгээр Канад улс анх удаа БНХАУ, БНСУ, Канад, ОХУ, Их Британийн Виржини арлууд, АНУ, Япон зэрэг улсууд оруулсан хөрөнгө болон компанийхаа тоогоор тэргүүлэх хөрөнгө оруулагчид болж байна. 2008 оны судалгаанаас үзвэл гадаадын шууд хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтөд шууд нөлөө үзүүлж, Монгол улсын ДНБ-ний 10 орчим хувь, нийт хөрөнгө оруулалтын 30 орчим хувийг бүрдүүлж, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд төсөвт жилд дундажаар 200 орчим тэрбум төгрөгийн орлогын албан татварыг төвлөрүүлж, давхардсан тоогоор **100 гаруй мянган ажлын байрыг** бий болгосон. 2012 он гэхэд энэ дүн бүр ч нэмэгдсэн”(1.233). Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт нь шилжилтийн эдийн засагтай бусад орнуудтай ижил түвшинд байна.

Монгол Улсад хангалттай хөрөнгө оруулалт хийж байна уу үгүй юу гэдэг нь нээлттэй асуудал хэвээр байна. Хэрэв Монгол Улс бусад орнуудаас эдийн засгаа илүү хурдан хөгжүүлэхийг хүсч байвал тодорхой шалтгаанаар хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх шаардлагатай юм. Гэхдээ хадгаламжтай болж, хөрөнгө оруулалт хийхийн тулд хэрэглээгээ зүгээр орхино гэсэн үг биш юм. Ийм тохиолдолд Монгол улс эдийн засгийн хөгжлөө хурдасгахын тулд улам их хөрөнгө буюу капиталыг гадаадаас оруулж ирэх хэрэгтэй. Мэргэжлийн ур чадвар болон оюун ухаан шингээсэн үйлдвэрлэл ба борлуулалтыг шаарддаг технологи, чанар, загвар, дизайн, барааны тэмдэгттэй болох замаар Монголын бүтээгдэхүүнийг гадаадын зах зээлд гаргах арга хэрэгсэлд хөрөнгө оруулах нөхцлийг хангах нь гол асуудал болж байна.

Abstract: We have traditional custom which we as Mongolian nomads live under natural power, worship it, and keep to safe, and live to herd their own livestock by grassland fertility and pasturage. The foreigners imagine Mongolia such as horse, steppe and nomadic life. In fact, the five kinds of livestock are Mongolian brand and their wealth. The unique nomadic livestock always overcome hard climate which is getting evolution. The nomadic economic development and characteristics of approach for the people's businesses were moved to market economy. How would they been influencing into the world culture and reform of economic development? Mongols are moving. Most of Mongolian people getting urbanized and live by traditional nomadic custom. How to equivalent the two culture and we would be determined approach of the future development by better culture.

Keywords: Mongolia, nomads, a market economy and economic development.

Ашигласан ном зүй

1. Ч.Болдбаатар нар “Монголын эдийн засгийн түүхийн альманах” УБ 2014он
2. Х.Дондог “Монголоо эрсэн монгол” УБ 2011он
3. Улаанбаатарын бүсийн зөвлөл “Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөр 2006-2015он” УБ 2006он
4. И Ү Гуан “Япон орныг ахин дэлгэхэд” УБ 2014он

**ХАРЬЦАА ЗААСАН НЭГЖ ӨГҮҮЛБЭРИЙН ГИШҮҮДИЙГ
ХУРААХ ХЭРЭГЛҮҮР БОЛОХ НЬ**
(Англи-Монгол хэлний жишээн дээр)

Ц. Отгонсүрэн*

Академич Ш. Лувсанвандан “Монгол хэлний үгэлбэрийн доторх үгсийн харьцааг тал бүрээс нь нягтлан судлах явдал бол монгол хэлний үгэлбэрзүйг нарийвчлан судлахад онолын чухал ач холбогдолтойгоос гадна зохиох, найруулах, ялангуяа урт үгэлбэрийн бүтцэд багтсан үгсийн хоорондын харьцааг зөв тогтооход бас практикийн чухал холбогдол учиртай”¹ гэж өгүүллээ эхлүүлсэн нь ихээхэн учир холбогдолтой юм.

Тиймээс өгүүлбэрийг судлахдаа түүнийг бүрдүүлж буй гишүүд болон нэн ялангуяа тэдгээрийг хооронд нь холбож, орон байр, цаг хугацаа, учир шалтгааны зэрэг харьцаа заасан нэгжийг онцлох нь хэлний тогтолцоог судлахад нэн чухал алхам болно.

Бид энэхүү өгүүлэлдээ англи хэлний угтвар үг (Preposition), монгол хэлний дагавар үг болон тийн ялгалын нөхцөл (Postposition)-ийг «**харьцаа заасан нэгж**» гэсэн нэр томъёонд багтаасан агаад үүний учир нь хоёр хэлэнд ижил үүрэг гүйцэтгэдэг ч хэлний бүтцээс хамааран англи хэлний хувьд «бие даасан үг», харин монгол хэлнээ дагавар үгийг эс тооцвол «залгавар бүтээвэр» гэсэн хэлний хоёр өөр түвшний нэгжид тооцогддогтой холбоотой.


Өмнөх судалгаандаа бид англи хэлний угтвар үг дараах 5 үүргийг гүйцэтгэдэг гэж үзсэн билээ. Үүнд: 1. Угтвар үгийн үндсэн үүрэг болох өгүүлбэрийн гишүүдийг холбох буюу харьцаа заах; 2. Өгүүлбэрийн гишүүдийг хураах; 3. Өгүүлбэрийн холбоос болох; 4. Хэлц үйл үгийн нэмэлт болох; 5. Тоо хэмжээг баримжаалан заах². Харин энэ удаад дээрх үүргүүдээс **өгүүлбэрийн гишүүдийг хураах** үүргийг онцлон, гүнзгийрүүлэн судалж, англи-монгол хоёр хэлэнд ижил төсөөтэй хийгээд ялгаатай шинжийг тодруулахыг зорьлоо.

Гэхдээ бид судалгааны ажлаа ахиулан нягталснаар энэхүү үүрэг нь гишүүн өгүүлбэрийг бус өгүүлбэр (clause)-ийн гишүүдийг хураадаг гэж үзэхэд хүргэж байна.

Өгүүлбэр дэх харьцаа заасан нэгж гэдэг нь «НЭР+НЭР», «НЭР+ҮЙЛ»-ийн харьцааг заадаг бөгөөд үндсэндээ хоёр дахь харьцаан дээр тулгуурлан бид тухайн харьцаа заасан нэгжээр гишүүн өгүүлбэрийн гишүүдийг хураах боломжтой хэмээн үзэж байна. Аль ч хэлэнд өгүүлбэрийг хураах нь хэлний хэмнэх зарчмын үүднээс авч үзвэл байвал зохих үзэгдлийн нэг. Гагцхүү ямар өгүүлбэрийг, бас аль гишүүнийг хураах вэ гэдэг асуудал л хэл хэлэнд бага сага зөрүүтэй байдаг.

Нэг. Англи хэл

Англи хэлний хувьд тодотгол гишүүн өгүүлбэр (Adjective/Relative Clause), байц гишүүн өгүүлбэр (Adverbial Clause) болон өгүүлбэрзүйн онцлогоос хамааран гишүүн өгүүлбэрт тооцогдохгүй ч тусгай асуултын хариулт (Answer of Wh-question)-ыг хураах бүрэн боломжтой гэж үзэж болно.



Тодотгол гишүүн өгүүлбэр:

Англи хэлний тодотгол гишүүн өгүүлбэр гэдэг нь тухайн тодотгуулж буй нэрийн ард буюу дагуулын байранд байрлаж, тэрхүү нэр үгээ тодотгох үүрэг бүхий идэвхитэй (Active Voice) хийгээд

*МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын багш, докторант


¹ -Лувсанвандан. Ш. *Монгол хэлний үгэлбэрийн доторх үгсийн харьцаа*. Бүтээлийн чуулган. VII боть. Монгол хэлний бүтээвэр, үг, үгүүлбэрийн судлал. Улаанбаатар. 2010. 216-227-р тал

² -Отгонсүрэн.Ц. *Англи хэлний угтвар үгийн бүтэц-үүргийн тогтолцоо*. МУИС. ШУС. ХУС-ын “Монгол Судлал” ЭШБичиг. Vol XXXVIII (412). Улаанбаатар. 2014. 57-66-р тал

идэвхигүй хэв (Passive Voice)-ийн өгүүлбэрүүд юм. Эдгээр тодотгол гишүүн өгүүлбэрийн гишүүдийг ялангуяа бичгийн хэлэнд хураан товчлох үзэгдэл элбэг.³

- Тодотгол гишүүн өгүүлбэрийн үйл үгийн нэмэлт (Verb Complement) нь тодотгуулж буй нэр үгийг шууд зааж байвал тодотгол гишүүн өгүүлбэрийн холбох төлөөний нэр (Relative Pronoun) болон үйл үг (Verb/Predicate)-ийг бүхэлд нь хурааж болно. Жишээ1: *In Japanese, the country's name is Dai Nihon, (that means/is) **Land of Rising Sun*** [13:56]; Жишээ2: *The original religion-(which is) **shamanism** had been originated 5000-7000 years ago.* [13:122]
- Хэрвээ тухайн тодотгол гишүүн өгүүлбэр идэвхигүй хэвд байвал холбох төлөөний нэр болон гишүүн өгүүлбэрт идэвхигүй хэвийг үүсгэж буй туслах үйл үг (Auxiliary Verb) болох «TO BE»-ийг хурааж, үндсэн үйл үг (Main Verb)-ийг үлдээдэг онцлогтой. Жишээ3: *I was born in a place (which is) **called Khankhar*** [13:41]; Жишээ4: *"The Twelve Deeds of Buddha" is the translation of a Tibetan original (which was) **compiled by Ć'os-kyi 'Od-zer*** [13:178].

Дээр дурдсан аргуудаас гадна англи хэлний тодотгол гишүүн өгүүлбэрийн гишүүдийг хураах бас нэгэн өвөрмөц арга байна хэмээн бид судалгааны явцад үзлээ. Англи хэлэнд нэрийн хэлхэц (Noun Phrase)-ийн ард угтварын хэлхэц (Prepositional Phrase) байрласан өгүүлбэр нэлээд тохиолддог. Жишээ5: *Nomadic people **from Siberia** began crossing the Bering Strait during the Ice Age* [13:86]. Англи хэлийг судалсан өмнөх судлаачдын бүтээлээс үзвэл дээрх өгүүлбэрийн *Nomadic people* гэх нэрийн хэлхэцийн ард байрлах **from Siberia** хэмээх угтварын хэлхэцийг бүхэлд нь арын тодотгогч (post-modifier) гэж үзсээр ирсэн. Тухайлбал Керсти Бөржарс болон Кейт Бурриж нар нэрийн хэлхэцийн арын тодотгогчийн хэдэн жишээ гаргаж, дараах загвараар задалжээ. Жишээ6: *A man on the moon*⁴.




Энэ мэтчилэн угтварын хэлхэц нэрийн хэлхэцийг тодотгож буй нь гарцаагүй боловч эл үзэгдлийг хэлний тогтолцооны үүднээс дэлгэрүүлэн үзэх чухалтай мэт санагдана.


Бидний үзэхээр дээр дурдсан жишээ5: *"Nomadic people **from Siberia** began crossing the Bering Strait during the Ice Age"* өгүүлбэрийн *"Nomadic people"* нэрийн хэлхэцийн ард байрлах **"from Siberia"** угтварын хэлхэцийг өнгөн бүтэц (Surface Structure)-ийн үүднээс «НЭР+НЭР»-ийн харьцаа мэт харагдавч хэлний тогтолцоо буюу гүн бүтэц (Deep Structure)-ийн үүднээс бол дээрхи нэрийн хэлхэцийг тодотгосон тодотгол гишүүн өгүүлбэрийн гол гишүүдийг бүхэлд нь хураагаад үлдсэн хэсэг гэж үзэж болохоор байна. Учир нь англи хэлэнд "OF"-оос бусад бүх угтвар үг «НЭР+ҮЙЛ»-ийн харьцаа заадаг. Үйлийн харьцааг заана гэдэг нь угтаа бол үйл үг, цаашилбал өгүүлбэр далд хэлбэртэй байна гэж үзэж болно.

³-Гэхдээ тодотгол гишүүн өгүүлбэр бүрийн гишүүдийг хураан товчилдоггүйг дараах хэдэн тохиолдлууд харуулж байна. Үүнд: 1. Тодотгол гишүүн өгүүлбэрийн үйл үг нь динамик (Dynamic) хийгээд байц гишүүн нь харьцаа заасан нэгж бүрдүүлбэртэй хэлхэц (PP)-ээр илрээгүй бол гол гишүүдийг бүхэлд нь хураах боломжгүй. Жишээ: *He telephoned the local doctor, **who arrived shortly afterwards*** [22:74]; 2. Тодотгуулж буй нэр болон тодотгол гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн нэг зүйлийг заагаагүй бол тодотгол гишүүн өгүүлбэрийн аль нэг гишүүнийг хураах боломжгүй. Жишээ: *The first thing **which you have to decide** is what to buy.* [22:73]

⁴-Kersti Börjars and Kate Burridge. *Introducing English Grammar*. II ed. Hodder Education. An Hachette UK company. 2010. 181-185-р тал



Ийм үзэгдэл идэвхигүй хэв дэх тодотгол гишүүн өгүүлбэрт бас ажиглагддаг. Жишээ7: *The success of this operation **in the area** will be determined in the minds of the Afghan people* [19:19].




Байц гишүүн өгүүлбэр:


Байц гишүүн өгүүлбэр гэдэг нь гишүүн болон гол өгүүлбэр хоёрын харьцаа буюу «ӨГҮҮЛБЭР+ӨГҮҮЛБЭР»-ийн харьцаа юм. Англи хэлний хувьд хоёр өгүүлбэрийг хооронд нь холбож байвал холбоос (Conjunction), тухайн гишүүн өгүүлбэрээс үүссэн нэрийн хэлхэцийг гол өгүүлбэртэй холбож байвал угтвар үг (Preposition) болдог. Бидний энд онцлох нэгэн зүйл гэвэл тухайн гишүүн өгүүлбэрийг хэрхэн яаж нэрийн хэлхэц болгох вэ гэдэг нь тухайн байц гишүүн өгүүлбэрийг хэрхэн яаж хураах тухай асуудал юм.

- Тухайн байц гишүүн өгүүлбэрийн үйл үгийг «-ING» залгаж нэршүүлэх аргаар хурааж болно. Жишээ8: *We'll never restore children's right to play **until the legal system protects the freedom*** [19:13] гэсэн өгүүлбэрийн байц гишүүн өгүүлбэрийг дараах байдалтай хурааж болно. ***Until protecting freedom through the legal system ...***
- Тухайн байц гишүүн өгүүлбэрийн үйл үгийг нэр үг болгон хувиргаж хураах боломжтой. Жишээ9: ***Until the protection of the legal system for the freedom...***

Дээрхи хоёр хувиргалаас үзвэл *Until* гэх холбоос нь үндсэн холбоосын бус угтвар үгийн үүргээр орж байна. Угтвар үг нь нэр үг (Noun) болон нэрийн хэлхэц (Noun Phrase)-ийн өмнө байрлан, бүхэлдээ үйлийн хэлхэцтэй холбогдож, «НЭР+ҮЙЛ»-ийн харьцааг заадаг бол байц гишүүн өгүүлбэрт гишүүдийг хооронд нь холбохоос гадна, нэр болон нэрийн хэлхэцийг гол өгүүлбэртэй холбодгоороо бусад өгүүлбэрээс өвөрмөц гэж хэлж болно. Үүнийг С. Гранатын бүтээлээс мэдэж болно. Тэрээр “Данийн хэлшинжээч Жэсперсен (Otto Jespersen) “Англи хэлний угтвар үг хөгжлийнхөө эхэн үед гишүүн өгүүлбэрийн өмнө байрладаг байжээ” гэж үзсэн тухай дурдаад, тэндээс үүдэн *after, before, till, since* гэх мэт үгс нь анх *THAT*-тай хамт нэг холбоос мэтээр хэрэглэгддэг байснаа *THAT* нь сугарч, өдгөө өгүүлбэрт хоёр үүрэгтэй болжээ. Өөрөөр хэлбэл гишүүн өгүүлбэрийн өмнө **холбоос** харин нэр үг болон нэрийн хэлхэцийн өмнө **угтвар үг** үгийн үүрэг гүйцэтгэх болсон”⁵ тухай тэмдэглэсэн байна. Мөн тэрээр Жэсперсений дээрхи үзэл болон “угтвар үг (Preposition), нэмэлт (Adverbial Compelement) болон холбоос (Conjunction) гурвыг нэг ангилалд багтаан үзвэл зохилтой” гэсэн санал дээр үндэслэн “холбоос” хэмээх нэгжийг “**өгүүлбэрийн угтвар үг юм.**”⁶ гэж томъёолсныг бас үгүйсгэхийн аргагүй юм. *Жишээ10: After the Pictogram Age finished, the writing evolved to the Ideogram Age.* [13:159]



Харин дараах жишээнээс гишүүн өгүүлбэрийн үйл үгийг хураан зөвхөн үйлийн эзнийг үлдээснээр холбоос нь угтвар үгийн үүрэг гүйцэтгэх болсныг харж болно. *Жишээ11: After the Pictogram Age, the writing evolved to the Ideogram Age.* [13:159]




⁵ -Solveig Granath. *Verb complementation in English. Omission of Prepositions before THAT-clauses and TO-infinitives.* Acta Universitatis Gothoburgensis. Gothenburg. Sweden. 1997. 9-р тал


⁶ -Мөн тэнд. 55-р тал

Тусгай асуултын хариулт:

Дээрх хоёр төрлийн гишүүн өгүүлбэрээс гадна тусгай асуулт (Wh-question)-ын хариултыг хураан боломжтой. Учир нь тухайн өгүүлбэр дэх аль нэг гишүүнийг онцгойлон асуух тохиолдолд давтан нуршихгүйн тулд ийнхүү хураадаг. Гэхдээ бид энд байц гишүүнийг онцлон дурдах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл аль нэг байц гишүүнийг асуух тохиолдолд тухайн угтварын хэлхэцийг үлдээн бусад гишүүдийг хураана гэж үзэж болно. Жишээлээ: -**Where** are you going (**to**)? -**To school**.

**Хоёр. Монгол хэл**


Монгол хэл залгамал бүтэцтэй хэл учраас гишүүн өгүүлбэрээс гадна үгийг хураах боломжтой.

**Тодотгол гишүүн өгүүлбэр:**


Монгол хэлний тодотгол гишүүн өгүүлбэр нь тодотгуулж буй нэрийн өмнө байрлаж, бүхэлдээ тодотгол гишүүний үүргийг гүйцэтгэдэг. Эдгээр тодотгол гишүүн өгүүлбэрийг хураан товчлох үзэгдэл монгол хэлэнд ч бас ажиглагддаг. Гэхдээ ийм хэв шинжийн өгүүлбэрийн үйл үгийг хурааж, утга, үүргийг нь ихэнхи тохиолдолд тухайн үйл үгтэй шууд холбогдсон нэр үгийг хэлбэржүүлсэн харьяалахын тийн ялгалын нөхцөл «-ЫН/-ИЙН» рүү шилжүүлдэг гэж үзэж болно. Гэхдээ тухайн нэр үг тодотгол гишүүн өгүүлбэрт ямар байранд, ямар гишүүн болохоос хамааран өөр хоорондоо ялгаа зөрүүтэй байдал бас байгааг энд тэмдэглүүштэй.

- Тодотгол гишүүн өгүүлбэр нь орон байр заасан байц гишүүн бүхий өгүүлбэр байвал тухайн гишүүн өгүүлбэрийн гол үйл үгийг хурааж, тэрхүү үндсэн үйл үгийн утга, үүргийг харьяалахын тийн ялгалын нөхцөл болох «-ЫН/-ИЙН» болон өгөх оршихын тийн ялгалын нөхцөлийн дараа «-ХИ» бүтээвэр залгаж орсон хувилбар болох «-ДАХЬ/-ДЭХ» нөхцлүүдэд шилжүүлдэг.

Жишээ 13: Улаанбаатарын (-т байдаг) ихэнхи их дээд сургуулиуд хотын төвдөө байрладаг.




Жишээ 14: Голомт банкны Эрдэнэт дэх (-т байдаг) салбар зээлийн хүүгээ буурууллаа.




Дээр дурдсан хоёр зүйл нөхцлөөс гадна харьяалахын тийн ялгалын нөхцөл «-ЫН/-ИЙН» нь бусад динамик үйл үгийн утга, үүргийг өөр дээрээ авдагийг дараах жишээ харуулж байна. Үүнийг зөвхөн өгүүлбэрийн доторхи бусад гишүүдийн байр, утгаас нь гаргах бүрэн боломжтой.

Жишээ15: Сайншандын (чиглэлд явах) галт тэрэг 9:15-д хөдөлнө.



Жишээ16: Монголчууд Нацагдоржийн (зохиосон) “Миний нутаг”-ийг цээжээр мэддэг.




Дээрхи 2 жишээнээс үзвэл “галт тэрэг”-ийг “Сайншанд”-д, бас “Миний нутаг”-ийг “Нацагдорж”-д хамааруулж, харьяалуулсан «НЭР+НЭР»-ийн харьцаа бус, харин «НЭР+ҮЙЛ»-ийн харьцааг зааж, ялангуяа Жишээ16-ийн “Нацагдоржийн” нь “Тодотгол гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүн нь харьяалахын тийн ялгалын тэг буюу тэг бус хувилбараар хэлбэржсэн байна”⁷ хэмээснийг бэлхнээ нотлож байна.

Байц гишүүн өгүүлбэр:


Монгол хэлний байц гишүүн өгүүлбэрт «ҮГ+ҮГ»-ийн хоорондын харьцаа гэхээсээ илүүтэйгээр «ӨГҮҮЛБЭР (гишүүн)+ӨГҮҮЛБЭР (гол)» болон «ҮГ+ӨГҮҮЛБЭР»-ийн харьцааг заадаг талаар өмнө нь дурдсан билээ. Эндээс «ҮГ+ӨГҮҮЛБЭР»-ийн харьцаа гэдэг нь «ӨГҮҮЛБЭР (гишүүн)+ӨГҮҮЛБЭР (гол)» гэсэн харьцааны гишүүн өгүүлбэрийн үйлт нэрээр хэлбэржсэн үйл үгийг хураасан нь.

⁷ -Лувсанвандан.Ш. Хавсарсан нийлмэл өгүүлбэр. Бүтээлийн чуулган. VII боть. Монгол хэлний бүтээвэр, үг, үгүүлбэрийн судлал. Улаанбаатар. 2010. 259-р тал

Жишээ17: Борооны өмнө шороо. (Бороо орохын өмнө шороо босдог)




Жишээ18: Цагийн урт (О), нарны галтайд бид цааш хөдлөв. (Цаг урт байхад, нар галтай байхад...)




Тусагдахуун гишүүн өгүүлбэр:

Тусагдахуун гишүүн өгүүлбэр нь бүхэлдээ тусагдахуун гишүүний үүргийг гүйцэтгэдэг. “Тусагдахуун гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь үйлт нэр, ерийн нэр үгээр бүтсэн байна. ... заахын тийн ялгалаар хэлбэржсэн байна”⁸ хэмээн тодорхойлжээ. Монгол хэлний тусагдахуун гишүүн өгүүлбэрт бас нэр үгийг нь хураах үзэгдэл арвин. Жишээ19: Би түүний ирснийг харсан.



⁸ -Лувсанвандан.Ш. Хавсарсан нийлмэл өгүүлбэр. Бүтээлийн чуулган. VII боть. Монгол хэлний бүтээвэр, үг, үгүүлбэрийн судлал. Улаанбаатар. 2010. 261-р тал


Гэхдээ энэ жишээнээс үзэхэд тусагдахуун гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь үйлт нэрийн нөхцөл болон заахын тийн ялгалын нөхцөлөөр хэлбэржсэн нь тухайн өгүүлэхүүн нь нэрийн үүргийг гүйцэтгэж буй мэт боловч нэр үгийг хураасан гэж үзэх бүрэн боломжтой. Үүнээс гадна тусагдахуун гишүүн өгүүлбэрийн бас нэг онцлог гэвэл өгүүлэхүүн гишүүн буюу үйл үгийг хурааж болно. *Жишээ20: Чиний багшийг сая мэдэв.* [10:261]



Энэ тохиолдолд тусагдахуун гишүүн өгүүлбэрийн үйл үгийн үүрэг тусагдахуун болон түүнийг хэлбэржүүлсэн заахын тийн ялгалын нөхцөл рүү шилжиж байна гэсэн үг.

Тусгай асуултын хариулт:

Энэ бол аль ч хэлэнд байдаг нийтлэг үзэгдэл. Тиймээс өмнө дурдсанчилан тусгай асуултын хариултад дахин давтан нуршихгүйн тулд хурааж, асуусан гишүүнийг үлдээдэг. Ийм өгүүлбэрийг «төгс бус өгүүлбэр»⁹ гэж үздэг. *Жишээ 21: -Та дээлээ хэнээр оёулсан бэ? -Ээжээрээ.*



Үг:

Монгол хэлний залгамал бүтцээс ихээхэн шалтгаан, дээр дурдсанчилан өгүүлбэр хураахаас гадна бас үгийг хурааж болно. Үг дотроо нэр үгийг хураах нь илүү түлхүү аж. Өөрөөр хэлбэл бүхий л тийн ялгалын нөхцөл нэр үгийг хурааж байна. Энэ нь нэр үгийн үүргийг өмнөх үгэнд нь шилжүүлэн, тийн ялгалын нөхцлийг залгадаг.

Жишээ22: Та нарын хэн сайн (тоглогч/тоглодог гишүүн) О нь энэ багт тоглоно.

Жишээ23: Ажил сайт (-тай хүн)-ын амьдрал сайн.

Жишээ24: Сайн (мэдээ)-ыг нь эхлээд дуулгаарай.

Жишээ25: Танай ангийн хамгийн сайн (оюутан)-д нь хуралд оролцох урилга өгье.

Жишээ26: Аль сайн (жимс)-аас нь шилж авах хэрэгтэй.

Жишээ27: Хэн сайн (хүн/сурсан хүн/оюутан)-аар нь хичээл заалгая.

Жишээ28: Сайн (хүн)-тай нөхөрлөвөл сарны гэрэл.

Жишээ29: Сайн (хүн/газар) руу нь очлоо.

⁹ -Лувсанвандан.Ш. Өгүүлбэр зүйн тухай. Бүтээлийн чуулган. VII боть. Монгол хэлний бүтээвэр, үг, үгүүлбэрийн судлал. Улаанбаатар. 2010. 235-р тал

Ц.Отгонсүрэн

Харин үйл үгийг хураах тухай асуудал ганц тохиолдолд буюу гишүүдийн харьцааг зааж буй тийн ялгалын өөрийн үндсэн утгаас ихээхэн хамааралтай мэт. Өөрөөр хэлбэл Монгол хэлний «ТАЙ»-г хамтрахын тийн ялгал гэж үзсээр ирсэн ч «ХАМТ» гэсэн утгаас гадна «БАЙГАА, БУЙ» гэсэн эзэмшлийн утгыг илэрхийлдэг. Эл утгаар нь авч үзвэл яг таг хамтрахын тийн ялгал гэж үзэхэд ихээхэн учир дутагдалтай ч зөвхөн энэ тохиолдолд л үйл үгийг нь хураах боломжтой юм. *Жишээ30: Би маргааш хичээлтэй (юм/билээ г.м.).*

Дүгнэлт

- Хэдийгээр дээр дурдсанчилан бид харьцаа заасан нэгж нь гишүүн өгүүлбэрийг хураах хэрэглээр хэмээн үзэх боловч утга бол энэхүү харьцаа заасан нэгж дээр тулгуурлан тухайн харьцаа заасан нэгж бүрдүүлбэр бүхий өгүүлбэрийн гол гишүүдийг ил гаргаснаар хэлний тогтолцоог зөв тодорхойлох боломжтой гэж ойлгож болно.
- Англи хэлэнд тодотгол гишүүн өгүүлбэр бүрийг хураах боломжгүй. Гагцхүү харьцаа заасан нэгж бүхий хэлхэц бүрдүүлбэртэй өгүүлбэр байвал тэрхүү өгүүлбэрийн гол гишүүдийг бүхэлд нь хураах боломжтой. Харин тухайн тодотгол гишүүн өгүүлбэр идэвхигүй хэвд байвал холбох төлөөний нэр болон туслах үйл үгийг хурааж, үндсэн үйл үгийг үлдээдэг. Жишээлбэл: *I was born in a place (which is) called Khankhar.*
- Англи хэлний байц гишүүн өгүүлбэр нь үгийг буюу хэлцийг гол өгүүлбэртэй холбодог учраас гишүүн өгүүлбэрийн үйл үгийг нэршүүлэх аргаар гол гишүүдийг хэсэгчлэн хураадаг. Харин тодотгол гишүүн өгүүлбэр болон тусгай асуултын хариулт дахь гол гишүүдийг бүхэлд нь хурааж болно.
- Монгол хэлний тодотгол гишүүн өгүүлбэрийн үйл үгийг хураах боломжтой бөгөөд тухайн үйл үгийг утга үүргийг гагцхүү тийн ялгалын нөхцөлүүд (харьяалахын болон өгөх оршихын тийн ялгалын нөхцөлийн дараа –ХИ орсон хувилбар) л гүйцэтгэх чадамжтай.
- Монгол хэлний байц гишүүн өгүүлбэрийн үйл үгийг хурааснаар, түүний утга, үүрэг нь гол төлөв дагавар үгэнд, цөөн тохиолдолд тийн ялгалын нөхцөл рүү шилждэг.
- Англи, монгол хоёр хэлэнд байц, тодотгол гишүүн өгүүлбэр болон тусгай асуултын хариултыг хурааж болдогоороо нийтлэг боловч хоёр хэлний бүтцээсээ хамааран англи хэлэнд тусгагдахуун гишүүн өгүүлбэр болон үгийг, харин монгол хэлэнд идэвхигүй хэв бүхий өгүүлбэрийг хураах боломжгүйгээрээ өөр хоорондоо ялгаатай байна.
- Хоёр хэлэнд өгүүлбэр болон үг хураах аргыг зэргэцүүлэн хүснэгтээр үзүүлбэл:

	АНГЛИ ХЭЛ	МОНГОЛ ХЭЛ
ТОДОТГОЛ ГИШҮҮН ӨГҮҮЛБЭР	Гол гишүүдийг бүхэлд нь хураах	-Үйл үгийг хураах -Гол төлөв тийн ялгалын нөхцөл энэ үүргийг гүйцэтгэдэг
БАЙЦ ГИШҮҮН ӨГҮҮЛБЭР	Үйл үгийг нэршүүлэх эсвэл үйл үгийг дангаар нь хураах	-Үйл үгийг нэршүүлэх эсвэл үйл үгийг дангаар нь хураах -Гол төлөв дагавар үг энэ үүргийг гүйцэтгэдэг
ТУСАГДАХУУН ГИШҮҮН ӨГҮҮЛБЭР	–	-Үйл үгийг хураах -Тусгагдахуун гишүүний үүрэг бүхий нэр үгийг хураах -Заахын тийн ялгал энэ үүргийг гүйцэтгэдэг
ХАРИУЛТ	Гол гишүүдийг бүхэлд нь хураах	Гол гишүүдийг бүхэлд нь хураах
ИДЭВХИГҮЙ ХЭВ	Гол гишүүдийг бүхэлд нь хураах	–
ҮГ	–	Тийн ялгалын нөхцлөөр хэлбэржсэнээр үндсэн нэр үгийн үүрэг өмнөх үг рүү шилждэг

Abstract: (*The relative elements-the means of truncating members in clause*)

In this article, we are using the term «RELATIVE ELEMENT» instead of the PREPOSITION in English and the POSTPOSITION in Mongolian, as their cross-linguistic meaning depending on their different positions and structures (described as a single word in English and as a morpheme in Mongolian) in both languages.

Of their some alternative functions, the most common one is to indicate the relations between separate words or members in a sentence. The above mentioned relation is said to be «NOUN +NOUN» or «NOUN+VERB». Based on the second, there is another function that is to truncate members in clause which we are stressing, here, in the article.

It is appeared in the syntactic relation, that is to say, in the deep structure in the languages. Like being able to reveal any relative elements in a sentence, it is possible to find out any full sentences or clauses (relative clause, adverbial clause, object clause and answer of WH-questions etc.) through the relative elements.

Номзүй

1. Buck.F.H. *Comparative study of postpositions in Mongolian dialect and the written language*. Cambridge, Harvard University Press. 1955
2. Бямбасан.Ж. *Монгол хэлний залгавар морфемийн ангиллын асуудалд*. Монгол хэлний онол, бүтцийн асуудалд. Хэл Зохиолын Хүрээлэн. Монголын Алтай Судлаачдын холбоо. Улаанбаатар. 2006
3. Бямбасан.Ж. *Монгол хэлний нэр үгийн нэгэн онцлог*. Монгол хэлний онол, бүтцийн асуудалд. Хэл Зохиолын Хүрээлэн. Монголын Алтай Судлаачдын холбоо. Улаанбаатар. 2006
4. Бямбасан.Ж. *Орчин цагийн монгол хэлний нөхцөлүүдийг харьцааных нь шинжээр ангилах боломж*. Монгол хэлний онол, бүтцийн асуудалд. Хэл Зохиолын Хүрээлэн. Монголын Алтай Судлаачдын холбоо. Улаанбаатар. 2006
5. Granath.S. *Verb complementation in English: Omission of preposition before THAT clauses and TO infinitives*. Sweden. 1997
6. John Street. *Khalkha Structure*. Indiana University. Bloomington. 1963
7. Kersti Börjars and Kate Burridge. *Introducing English Grammar*. II ed. Hodder Education. An Hachette UK company. 2010
8. Лувсанвандан.Ш. *Монгол хэлний үгэлбэрийн доторх үгсийн харьцаа*. Бүтээлийн чуулган. VII боть. Монгол хэлний бүтээвэр, үг, үгүүлбэрийн судлал. Улаанбаатар. 2010
9. Лувсанвандан.Ш. *Өгүүлбэр зүйн тухай*. Бүтээлийн чуулган. VII боть. Монгол хэлний бүтээвэр, үг, үгүүлбэрийн судлал. Улаанбаатар. 2010
10. Лувсанвандан.Ш. *Хавсарсан нийлмэл өгүүлбэр*. Бүтээлийн чуулган. VII боть. Монгол хэлний бүтээвэр, үг, үгүүлбэрийн судлал. Улаанбаатар. 2010
11. *Орчин цагийн монгол хэлиинжлэл*. МУБИС. МСС. МХШ-ийн тэнхим. Улаанбаатар. 2008
12. Отгонсүрэн.Ц. *Англи хэлний угтвар үгийн бүтэц-үүргийн тогтолцоо*. МУИС. ШУС. ХУС-ын Монгол судлал. Боть. XXXVIII (412). ЭШБичиг. Улаанбаатар. 2014
13. Отгонсүрэн.Ц. *Орчуулахад суралцах бичиг-I*. Здахь хэвлэл. Улаанбаатар. 2014
14. *Oxford Advanced Learner's Dictionary*. 8th edition. Oxford University Press. 2010
15. Равдан. Э. *Бүтэц хэлиинжлэл*. Улаанбаатар. 1998
16. Равдан.Э. *Орчин цагийн хэлиинжлэл*. Улаанбаатар. 2006
17. Пүрэв-Очир.Б. *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй*. Улаанбаатар. 2001
18. Пүрэв-Очир.Б. *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүйн холбох тогтолцоо*. Улаанбаатар. 1988
19. *TIME*. Journal. December 14. 2009
20. Төмөртоого.Д. *Хэлиинжлэлийн нэр томъёоны хураангуй толь*. Улаанбаатар. 2004
21. Цэрэнпил.Д. *Монгол хэлний нэгэн өвөрмөц залгавар бүтээвэр*. МУИС ЭШ-ний бичиг. 4/102/ Улаанбаатар. 1990
22. Virginia Evans. *FCE Use of English*. Express Publishing. 2000

Товчилсон үгийн жагсаалт

- AP (Adjective Phrase)-Тэмдгийн хэлхэц
- MC (Main Clause)-Гол өгүүлбэр
- NP (Noun Phrase)-Нэрийн хэлхэц
- PP (Pre/Postpositional Phrase)-Харьцаа заасан нэгж бүрдүүлбэртэй хэлхэц
- SC (Subordinate Clause)-Гишүүн өгүүлбэр
- SL (Second Language)-Гадаад хэл/Хоёрдогч хэл
- VP (Verb Phrase)-Үйлийн хэлхэц

МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭЛЦЭД “ТЭНЭГ” ХЭМЭЭХ УТГЫГ ИЛЭРХИЙЛЭХ НЬ
Expressing the meaning of “stupid” in phrases in Mongolian Language

Б.Мөнгөнцэцэг*

Хэлц нэгж нь тухайн улс үндэстний сэтгэлгээний хэв шинж, ертөнцийг таньсан байдлынх нь илэрхийлэл болж байдаг тул яагаад ингэж нэрлэж хэвших болсон шалтгаан, үүсгэл санааг ухаарч таних нь чухал юм. Хэл шинжлэлч эрдэмтдийн үзэж буйгаар, хэлц нэгжийг үндэсний сэтгэлгээний онцлогийг тайлбарлах гол судлагдахуун болгохдоо тухайн үндэстний нийгэмшсэн ухамсар төлөвшихөд байгалийн юм үзэгдлийг тусган ухаарсан сэтгэхүй хийгээд сэтгэлгээний хэв шинж (stereotype)¹ болон түүнийг илэрхийлэх тогтсон жишиг хэмжүүр (эталон)²-ийг илрүүлэн тайлбарлах хэрэгтэй хэмээн үздэг.

Бид энэхүү өгүүлэлд “тэнэг” гэсэн ойлголтыг илэрхийлэх хэлцийн жишиг хэмжүүрийг тогтоон, яагаад ингэж хэвших болсныг тайлбарлахаар зорьсон болно. Утга санаа, референт хоёрын харьцаа хамаарлыг илэрхийлдэг мөн чанар нь уламжлалт ойлголтоор, танин мэдэхүйн дүр буюу ухагдахуун, харилцааны тодорхой нөхцөл байдлын дүр буюу утга санааны аль аль нь биш, харин тэмдэглэгдэхүүний тухай хэв шинжит мэдлэг буюу түүний үүсгэмэл хэв шинж байх ёстой³ гэж үзсэнийг бид аргазүйн чухал баримжаа болгон авч үзсэн болно.

Монгол хэлнээ “тэнэг” хэмээх утгын хүрээнд

- тархи (толгой) нь эргэсэн;
- хатиу/чүдэнз толгойлох;
- хүүдэг нь битүү;
- эргүү төлөг (эргүү мал);
- төөрсөн гөлөг/төөрүүлсэн нохой;
- дон хөдлөх;
- чангаагаад сунахгүй, чанаад шалчийхгүй;
- хойшоо харсан нүх;
- богино жолоотой;
- доодохоосоо долоон доор;
- ухаан сэхээ муутай;
- ухааныг уяаж болохгүй, санааг савлаж болохгүй;
- малгай, толгой хоёр нь адилхан;
- усан /махан мануухай/ хөндий/хоосон/хөлдүү/гэсдэггүй/махан толгойт, усан тархи;
- чих нь цоорхой;
- арилсан дотортой;
- гавал нь гашилах, тархи нь гашилсан
- үхэр хэдгэнийг дээсээр бугуйлдах;
- мэдрэл дээр нь мэлхий шээх;
- ухаанд нь ухна үхсэн, санаанд нь сарлаг үхсэн;
- ухаанд нь ус орж, санаанд нь шавар орох;
- ухаан нь уландаа орох;
- ухаан нь ууцандаа, санаа нь сүүжиндээ;
- амьтан болох;
- ягшгалдай болох⁴;

* МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын багш, доктор (Ph.D)

¹ Ж.Баянсан. Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ, Уб., 2002, 2;

В.А.Маслова. Лингвокультурология. М., 2002, 108-110 зэрэг номоос үзэж болно.

² Мөн тэнд

³ В.Н.Телия. Русская фразеология. Семантический, прагматический и лингвокультурологические аспекты. М., 1996, 94

⁴ “тэнэг ажил хийх” гэсэн санаатай хэлц. Урьд нэгэн хүн тулгаа тэмээний үдээрээр дангинатал үдчихээд “За одоо ягшгалдай болсон шүү” гэж хэлсэн гэдэг. Тэр цагаас хойш “ягшгалдай болох” гэсэн нэгэн аман хэлц монголчуудын дунд дэлгэрчээ. (Д.Баттогтох. Үлгэрийн хэлц үгийн толь. Уб., 2013, 91)

- *хоёр үгний утга мэдэхгүй, хоймсон дээсний эрч эрхээхгүй;*
(*гурван үгний утга мэдэхгүй, гурамсан дээсний эрч эрхээхгүй*)
- *азаргаа унаад адуугаа эрсэн*


гэхчлэн ёжилж егөөдсөн, доромжлон доршоож үзсэн, харааж зүхсэн, өрөвдөж харамссан зэрэг утгын олон өнгө аяс бүхий хэлцүүдийг жишээлэн авч үзэж болохоор байна.

Монгол хүний хувьд мал бол хэд хэдэн онцгой учир холбогдолтой зүйл болно. Тухайлбал, эртнээс нааш амьдарлынх нь үндэс болсоор ирсний хувьд хамгийн сайн таньж мэдсэн, хамгийн олон янзаар, хамгийн гарамгай эрхшээж чаддаг болсон амьтан нь даруй таван хошуу мал бололтой. Тэгээд ч тэдний зарим нь “их ухаантай” (морь гэх мэт) бол зарим нь “нэлээд тэнэг” (үхэр гэх мэт) гэсэн танилт үзэл ч бий. Хэдий тийм боловч хүн өөрийгөө ямар ч “ухаантай” мал амьтантай үлгэрлэшгүй, дээд эрэмбэ, дээд “ертөнцийн” бодгаль гэж үздэг учраас “тэнэг”-ийн монгол эталон буюу жишиг хэмжүүр нь “мал” ажээ. Тиймээс мал шиг тэнэг гэх буюу заримдаа бие биенээ шууд л “мал” гэлцдэг.

А. Хүний ухааныг цээжинд байна гэж үзэх нь:

Юмыг ухаарч ойлгохгүй хүнийг “Ухаан нь ууцандаа, санаа нь сүүжиндээ” гэж хэлэх бөгөөд уг хэлцийн санааг бүтээх хэмжүүр (эталон)-ээр ууц, сүүжийг сонгосон байна. Энэ нь нэг талаас, хүн төрөлхтөн хүний биеийг цээж, бөгс гэсэн хоёр зүйлд хуваан үзэж байсан бөгөөд нэгийг нь дээр байрладаг, цэвэр юмыг агуулдаг, нөгөөг нь доор байрладаг, бохир юм (шээс баас)-ыг агуулдаг гэж үзсэнээс үүдэн, эерэг, сөрөг үнэлэмжтэй болгосон байна. Тэгэхээр аливаа юм орших орон, байрлах байртай, тэдгээр нь бүгд зүй тогтол, эрэмбээрээ л байна. Харин тэрхүү орших газрын эрэмбэ нь алдагдахаар, тодруулбал, ухаан нь ууцандаа, санаа нь сүүжиндээ орохоор “тэнэг” болох мэтээр төсөөлөн ойлгосон хэмээн хэлж болмоор байна. Энэ нь хүний ухаан цээжиндээ байна гэж үзсээр ирсэнтэй холбоотой.

Ташрамд тэмдэглэхэд бидний одоо хэлэлцдэг “цээжлэх”, “цээж сайтай хүн” (цээж муутай хүн),



“цээжний бангаар ярих” зэрэг үг хэллэгийн анхдагч утга нь юмыг тогтоох, хадгалах ой ухааны “орон” нь даруй цээжний хөндийд байдаг гэсэн гэнэн (naïve) ойлголт байсантай холбон үзэх боломжтой юм. Иймэрхүү төсөөлөл ойлголт нь Монголоос өөр соёл- хэлтэнд ч гэсэн түгээмэл байдаг гэсэн баримт бий.

“Монголын нууц товчоо”-ны 96-р зүйлийн төгсгөлд:

“Бөхэрэ-ийн бөксө-түр

Чэжэрэ-ийн чэгэжи-түр атухай” гэсэн маш сонин зүйр үг бий бөгөөд үүнийг академич Ц.Дамдинсүрэн “Бөөр нь бөгсөнд байг, цэр нь цээжинд байг”; Ш.Гаадамба цээр мэт бохир зүйл цээжинд байх нь зохисгүй, харин бөгс бол бохир зүйл орших орон байх учиртай гэж үзсэн бололтой “Бохирын (муугийн) бөгсөнд, цэврийн (сайны) цээжинд атугай” хэмээн сэргээн сийрүүлээд үүнийхээ тайлбар өгүүлэлд: “Бидний бодлоор бол энэ өвөрмөц хэллэг бохир (муу) ину бөксэ дүр, (сүүлд) цэвэр (сайн) ину чэгэжи дүр (эхэнд) атугай (байтугай) гэсэн үг байсныг хятад галиглагч ба хадмал орчуулга үйлдэгч нар ойлголгүй “бокир” гэдгийг “бөгэрэ” гэж буруу уншиж, буруу галигласан ба ташаа орчуулжээ” гэж бичсэн байна. Энэ тухайд академич Д.Цэрэнсодном “Монгол хэлд бөөр хэмээх нь хүний биеийн усны тунгалгийг боловсруулах үйлдэл бүхий таван цулын нэгийг нэрлэхээс гадна эр бэлгийн засаа, төмсийг бас “бөөр” гэдэг байна. ...“Бөөрөө бөгсөнд, цээрээ цээжинд атугай” хэмээн сурган хэлсэн эл үг нь нууцлах далдлах зохистой зүйлээ нууцалж хадгалж явтугай гэсэн гүн гүнзгий утга санаатай сургаал ажээ”⁵ гэсэн байна.

Бас нэг зүйлийг үүнд холбогдуулан тэмдэглэвэл, J.Лакофф⁶ англи соёл- хэлтний хувьд “UP” (дээшээ) нь “GOOD” (сайн), “DOWN” (доошоо) нь “BAD” (муу) гэсэн утгатай байдаг хэмээн “conceptual metaphor”-ын нэг зүйлийг жишээлэн өгүүлсэн нь бидний дээр үзүүлсэн хүний биеийн дээд бие буюу цээжин бие, доод бие буюу бөгсөн бие, тэдгээрийн тухай үнэлэмжийн онцлогийг гаргах гэсэн санаатай бас холбоо хамааралтай гэж үзэж байна.

“Монгол хэлэнд К.Юнгийн анима анимус гэсэн анхдагч дүр (археотип) хадгалагдсаар байна. ...эртний

⁵ Д.Цэрэнсодном. Монголын нууц товчооны утгазүй, уран сайхны шинжилгээ, Уб., 2008, 104-105

⁶ Lacoff J. & Johnson M. Metaphors we live by. Chicago, 1980

анхдагч дүр нь ухамсраас гадуур бий болох ба төрөлх шинжтэй, учир шалтгааны холбогдолтой ба бие даасан шинжтэй ажээ. Анхдагч шинж нь үеэс үед үлгэр домог, утга зохиол урлагийн зүйлд уламжлагдан давтагдахдаа бэлгэдлийн шинжтэй байдаг”⁷ Үүнийг дээрх хэлцийг бүтээх жишиг хэмжүүрээр яагаад заавал сүүжийг сонгох болсонтой холбон тайлбарлаж болно. Монголчууд малын махыг хүнсэнд хэрэглэхдээ өдрийн өл залгах хоол хүнс төдийгөөр хязгаарлалгүй заншил ёс, шүтлэг бишрэлийн онцгой учир холбогдолтой хэмээн ханддаг байсан. Тухайлбал, махан зоог барих ёсонд сүүж, богтос, богино хавирга, далны мөгөөрс, өвчүүний бүдэрхийг хүндэтгэлийн маханд оруулдаггүй бөгөөд эмэгтэй хүнд сүүж, дунд чөмөг, өвчүү зэргийг тавьдаг байжээ. Тэр ч байтугай нүдийг нь авсан толгой, нүхий нь ухсан сүүж, нүнжгий нь хуулсан далны ясыг зочинд үзүүлэхгүйг хичээдгээс гадна гэртээ хонуулахыг одоо ч төвддөггүй. Учир нь, тэдгээрт чөтгөр орогнодог, хэрэв сүүжний нүхийг сэтэлж хаяхгүй бол үхээрийн сүнс хоргодон, сүр сүлд нь буурна гэж үздэгээс үүдэн сахиж байгаа дом. Ийм ч учраас баатарлагийн туульд харвасан сум нь сүүжний нүхээр гаран, алтан мөнгөн тэвнийг онож байгаагаар гардаг нь сүүжний ясан дахь чөтгөрийг дарж байгаа хэрэг хэмээн битүү егөөдсөн санаа байж магадгүй юм. “Ялангуяа сүүжний ясыг хамгийн муу муухайн бэлгэдэл болгох... урьд гэмт хэрэг хийсэн хүний аман хайланг авахын тулд доогуур нь мөлхүүлдэг шахааны хэцэнд өлгөдөг элдэв бузар муухай юмсын нэгэнд оруулдаг байв”⁸

Нөгөөтэйгүүр, монгол хүний ухаарлаар ухаан нь хөндий, уудам талбай бүхий цээжин дотор үргэлж чөлөөтэй хөдөлж, гүйлгээ ухаан суух ёстой атал үүнийг биеийн хэсэгтэй харьцуулахад бүхэл цул биеийн хэсэг болох “ууц (нурууны сээрээс хойш ахар сүүл хүртэлх хэсэг, харцага), сүүж (хүн, амьтны гуяны дунд чөмөгний дээд этгээдэд ууцтай холболдон байдаг нүхтэй яс)”-нд ухаан орох юм бол мулгуу тэнэг болох мэтээр сэтгэхүйн ертөнцдөө төсөөлөн дүрсэлсэн онцлог харагдаж байна. Хүн, амьтны бэлхүүс, хүзүү хоёрын хоорондох хэсгийг цээж гэх бөгөөд *цээжний хөндий* (өрцнөөс дээших хөндий, хэнхдэг), *цээжний хэнгэрцэг* (өвчүү, хавирга, сээрний яснаас бүрдсэн шоовон хэлбэртэй ясан хайрцаг) гэх нь бий. Монгол хүн цээжийг “багтаамжтай” гэсэн утгаар ойлгодог, аливаа зүйлийн учрыг олсондоо баярлахын сацуу уужирч тайвширдаг. Ийм ч учраас “*цээж уужрах* (а.цээж дүүрэхээ болих, б.сэтгэл санаа тайвшрах), *цээж онгойх* (ухаан санаа уужрах), *цээж тэнийх* (сэтгэлийн зовлон дарамт арилах), *цээж уудлах* (санасан бодсоноо нуулгүй, бүгдийг ярих, хэлэх), *цээж сайтай* (хүний оюун ухаан хурц, сэргэлэн, юмыг мартдаггүй), *цээж ихтэй* (үзсэн сонссоноо мартдаггүй хүн; цээжтэй), *цээж саруул* (ухаан санаа, ухаан бодол уужуу), *цээж дүүрэн* (сэтгэл санаа баясгалантай), *цээжээр бичих* (бодсон санасан, тогтоосон зүйлээ бичих), *цээжээ хавтаслах* (ном эрдэмтэй болох, ном зохиол их уншиж мэдлэгтэй болох), *цээжийн бөх* (ухаантай, мэргэн цэцэн), *эр хүний цээжинд, эмээлтэй хазаартай морь багтана* (эр хүний ухаан бодол уужуу) гэхээс гадна *цээж муутай* (юм тогтоохдоо муу), *хөндий цээж* (юу ч мэдэхгүй мөртлөө мэдэмхийрдэг, бардам сагсуу), *цээж түрэх* ~ *цээж тэлэх* (а.цээжээ урагш болгох, б.омгорхог зан ааш гаргах, ханхалзах), *цээжнийхээ махыг барж идэх* (сэтгэл туйлын их зовох), *аавын цээж* (хаахгар, их зантай, давилуун хөвгүүн), *аавын цээж гаргах* (нас бага хүүхэд, хаахгар, давилуун зан гаргах)” гэж сөргөөр хэлэх нь ч бий.

Монгол хүний үзлээр ухааныг хөндий, уужим зай бүхий цээжин дотор үргэлж бясалгаж хөдөлгөж байх ёстой атал тэрхүү хөдөлгөөнийг хязгаарлах юм бол мулгуу тэнэг болох мэтээр сэтгэхүйн ертөнцдөө төсөөлөн дүрсэлдэг онцлог нь “*Ухааныг уяж болохгүй, санааг савлаж болохгүй*” гэсэн хэллэгээр илэрч байна.

Монголчууд “*Ухаанд нь ухна үхсэн, санаанд нь сарлаг үхсэн*” гэж хэлдэг. Гэтэл хамгийн сайн мэдэх малаасаа тэмээг биш, ямааг биш яагаад заавал ухна (хөнгөлж засаагүй эр ямаа), сарлаг (хүзүү, дөрвөн мөч охор, сээр өндөр, урт үстэй нэг зүйл үхэр)-ийг сонгов? Учир нь монгол хүн ухныг дараах байдлаар ойлгодог ажээ. Үүнд:

- *ухна царайлах* (уруу царайлах, унхиагүй байх)
- *халтар ухна* (бохир заваан)
- *халтар ухна болох* (бохиртох, заваан болох)
- *Ухна шиг эс аашилах аашигүй*
Улиг хүн эс загнах зангүй
- *Ухна шиг бүү бавтна*
Буур шиг бүү галзуур
- *Ухнын бие нь үзэгдэхгүй заар нь ханхлах*
Уршигтын бие нь харагдахгүй зар нь хангинах
- *Баруун зүгийн бам хар тангад*
Загал хошуутай, зааран хормойтой
Зай завсаргүй тарнидна (Ухна)
- *Дээрээ хоёр жадтай, доороо хоёр домботой*
Аймаар хурц нүдтэй, анхил ханхил үнэртэй (Ухна)
- *Урт шар илдтэй, уранхай навтас дээлтэй*
Унжуу цагаан сахалтай, үглүүр бавтнуур заарт (Ухна)

зэргээс үзвэл, ухнын дүр зураг нь үзэх нүднээ сүр их, навсайж нэвсийсэн, заар зангаг ханхалсан,

⁷ М.Базаррагчаа. Монгол хэлний сүгээр ба найруулбарын тухай. УБ., 2003, 8-9

⁸ Г.Ловор. Учир мэдэхгүй хүнд ууц битгий тавь. УБ., 2002, 6

тодруулбал, хөгшрөх тусмаа заар нь ихэсч, чадал нь багасдаг амьтан ажээ. Ийнхүү хөндий, уужим зай бүхий цээж буюу ухаанд нь хэжим (гэдэсний дагуу ургасан урт үс), саваг үс (сарлагийн хэжлүүрийг дагаж ургасан болон биеийн бусад хэсгийн үс) ихтэй, газартай үргэлжлэн ороолдсон, нэвсгэр том амьтан (ухна, сарлаг) ороод үхсэнтэй адилтгаж хэтрүүлсэн нь уг хэлцийн санааг бүтээх хэмжүүр (эталон) болсон ухна, сарлагийн гадаад дүрийн төстэй шинжид тулгуурлажээ. Энэ нь монголчуудын сэтгэхүйн өвөрмөц дүр зураг болжээ.

“Ухаанд нь ус орж, санаанд нь шавар орох” гэсэн хэлцийн тухайд, уг хэлцийн санааг бүтээх хэмжүүр (эталон)-ээр ус, шаврыг сонгосон нь малыг амьжиргааныхаа эх үндэс болгож ирсэн монголчууд хамгийн сайн мэдэх цагаан идээтэйгээ холбож, усыг шимгүй, сүүг шимтэй хэмээн эсрэгцүүлэн үздэгтэй холбоотой аж. Энэ мэтээс үүдэж *усан тэнэг* (юу ч мэдэхгүй, туйлын мангуу), *усан толгой* (мангуу), *усан нүдлэх* (уйлах), *усан нүдэт* (уйланхай), *усан гүзээ болох* (шалба норох, нэвт норох), *усан чөдөр* (цай нь болохгүй хүлээлгэх), *усан амтай* (дандаа бүтэлгүй юм ярьж явдаг), *ус болох* (хор болох, саад болох), *ус балгасан юм шиг* (үг дуугарч чадахгүй гөлөлзөх, яахаа мэдэхээ болих), *гал ус хоёр шиг* (хоорондоо харшилдсан, огт таарч тохирохгүй), *олгойтой ус шиг* (эв хавгүй, хэлбэр галбир муутай) гэх мэтчилэн сөргөөр хэлэх нь олонтоо байна. Харин сүүг шимтэй хэмээн эрхэмлэдгийн илрэл нь *сүү шиг дотортой* (цагаан санаатай, сайхан сэтгэлтэй), *сүүний хариу цус* (ачийг өшөөгөөр, сайныг муугаар хариулах), *сүүтэй л бол эх* (биед нь ашигтай л бол сайн), *сүү мэт цагаан сэтгэлтэй, түлхүүр мэт уран гартай* (сэтгэл сайхан, ажилд чадамгай), *сүүн мөртэй* (сайн, бэлгэшээлтэй), *сүүгүй цай хар, сүсэггүй сэтгэл хар* (хүн итгэх бишрэх юмгүй, айж ичих зүйлгүй байх нь муу), *сүү хийсэн савнаас үнэр нь гарахгүй, сур иддэг нохойны ховдог нь гарахгүй* (сурсан занг болиход хэцүү), *сүү гашилбал язмаг, мэргэд ганцаардвал өнчин* (хань нөхөр, ах дүүгүй ганцаардах хэцүү) зэрэг хэллэгээс тодорхой харагдаж байна. “Гэхдээ энэ нь монгол хүн усыг хэрэггүй, тусгүй зүйл гэж үздэг гэсэн үг биш, харин ч “Амьдралыг тэтгэгч гурван чандмань эрдэнийн нэг нь ус мөн” гэж ардын үлгэр домогт гардаг. Гагцхүү сүүтэй харьцуулсан үнэлэмжээс л харшууллын энэ утга санаа үүсэх болсныг тэмдэглэх хэрэгтэй болсон юмаа”⁹ Иймд ус, сүү хоёр бол шимтэй- шимгүй эсрэгцлийн жишиг хэмжүүр болж тогтжээ. Түүнчлэн “сүү гашлах”-ийг “гавал нь гашлах, тархи нь гашилсан” гэсэн нь “сүү”-г “гавал/тархи”-аар сольсон тойруулал болно.

Б. Хүний ухааныг гэрлээр хэмжих нь:

Тэнэг хүнийг “хүүдэг нь битүү”, “хойшоо харсан нүх” гэдэг нь ухааныг гэрлээр хэмжихээс үүдсэн гэж хэлж болно. Энэ тухайд эрдэмтэн М.Базаррагчаа “Ухаантай хүнийг гэгээн (гэ-гэ-(гэ)-н) гэдэг нь ухаантай хүнээс гэгээ цацардаг гэж үзэж байсантай холбоотой бөгөөд энэ нь К.Юнгийн анхдагч төгслөг шинж юм. Энэ шинж нь 35-40 наснаа тохиох бөгөөд үлгэр домогт мэргэн өвгөн, бөө удган, эрэлхэг баатрын дүрээр илэрдэг ажээ. Үүний эсрэг тэнэг хаан, тэнэг хүү, хулчгар эр зэрэг дүрүүд байдаг нь сүүдэр гэдэг эртний анхдагч дүр юм”¹⁰ гэжээ. “хойшоо харсан нүх” гэсэн хэлцийн тухайд харааж зүхсэн аясыг илэрхийлэх бөгөөд Монголын салхи баруун хойноос голдуу гардаг учир хойшоо харсан нүхэнд нарны гэрэл тусахгүйн зэрэгцээ амьтан орогнох магадлал бага байдагтай холбоотой гэж хэлж болно.

Энэ мэтээс үзэхэд, юуны урьд малыг таньсан танилт, ухаарал ойлголтыг адилтгагдахуун буюу зүйрлэгдэхүүн болгож байгааг үндэслэл болговол, монгол сэтгэлгээний “тэнэг” хэмээх багцалмал мэдлэг (concept)-ийн нэг гол эталон нь мал болох нь бидний сонгон жишээлсэн олонх хэлцээс харагдаж байна. Ингэхлээр “тэнэг” хэмээх утгыг илэрхийлэх хэлцүүд нь дотроо ёжилж егөөдсөн, доромжлон доршоож үзсэн, харааж зүхсэн, өрөвдөж харамссан зэрэг олон өнгө аястай байгааг тус бүр олон жишээгээр задлан нарийвчлах боломжтой. Цухас төдийг дурдвал, “үхэр хэдгэнийг дээсээр бугуйлдах” нь егөөдлөөр бүтсэн бөгөөд бага- том хоёрыг эсрэгцэлдүүлэн, өнгөц харахад сайнаар буюу жирийн хэлсэн мэт ч утгаа муугаар егөж, шүүмжлэх санаа илтгэн, зүй тогтлыг урвуу аргаар эвдсэн байна.

Хүний ухаан цээжинд байдаг гэж үзэхийн зэрэгцээ үргэлж чөлөөтэй хөдөлж байдаг мэтээр сэтгэхүйн ертөнцдөө төсөөлөн дүрсэлдэг онцлог нь бидний жишээлэн авсан ихэнх хэлцээр илэрч байна. Үүнээс үүдэн “Хүний цээж бол гүйлгээ ухаан суух ОРОН юм” хэмээн тодорхойлж болно гэж үзвэл энэ нь Ж.Лакоффын “conceptual metaphor” гэдэгтэй хавьтах дүгнэлт болж болох юм гэж үзэж байна. Түүнчлэн ухааныг гэрлээр хэмжих буюу гэрэл сүүдрийн тухай ухагдахууныг К.Юнгийн төгслөг ба сүүдэр гэсэн анхдагч хэв шинжтэй холбон тайлбарлаж болох нь хэлний баримтаас харагдаж байна.

SUMMARY

We aimed to determine the standard to express the meaning of “stupid”, and also tried to explain it’s reason of habit. Hence phrases have been as expression of thinking style and recognition the earth of nations it is important to recognize the reason why it’s named so and to reveal it’s basic idea which formed it.

Mongolian says “bucks dead in conception”, “yak dead in mind”. But why it is not the most well - known animal camel and goats, why are bucks, (male goat which is not castrated), Yak (neck and four legs are short, spine is tall,

⁹ Ж.Баянсан. Хэл, соёл, сэтгэлгээ. УБ., 2002, 7

¹⁰ М.Базаррагчаа. Монгол хэлний сүгээр ба найруулбарын тухай. УБ., 2003, 8

long hair, one kind of cow) are selected? Mongolian people pictures bucks like more powerful, shaggy and ragged, musk- strong odour smelled animal. Thus, valleys and wide chest with a space or in conception (intestinal grown under long hair), steal hair (rest of the body hair) with always the entangled crinite the shaggy big animals (goats, yaks), and the dead, excessive compared created the idea of the phrases (in reference) bucks and yak overseas role, based on similar factors. This the unique Mongolian mental picture.

To sum up, when people comparing himself with people and animals, and the animals and their species - related measures with the word “stupid” in the meaning observed in the language documentation. The “dumb” mean value of phrases as fine seed is usually considered in relation to identity, exaggerated. For example: “catch the humblebee with ropes” by opposing small and large things, and trying to show with physical forms, so broke the a parallel pattern identification method.

Ашигласан ном

- Базаррагчаа М. Монгол хэлний сүегэр ба найруулбарын тухай. Уб., 2003
Баттогтох Д. Үлгэрийн хэлц үгийн толь. Уб., 2013
Баянсан Ж. Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ, Уб., 2002
Lacoff J. & Johnson M. Metaphors we live by. Chicago, 1980
Ловор Г. Учир мэдэхгүй хүнд ууц битгий тавь. Уб., 2002
Маслова В.А. Лингвокультурология. М., 2002
Телия В.Н. Русская фразеология. Семантический, прагматический и лингвокультурологические аспекты. М., 1996
Цэрэнсодном Д. Монголын нууц товчооны утгазүй, уран сайхны шинжилгээ, Уб., 2008

ЭГШИГ АВИАГ ТУРШИЛТ АВИАЗҮЙН АРГААР СУДЛАХ НЬ

С. Булгантамир*

Энэхүү илтгэлийн эхний хэсэгт бид туршилт авиазүйн үүсэл, хөгжил, өнөөгийн байдлыг товч өгүүлнэ. Удаах хэсэгт МУИС-ийн гадаад хэлний судалгааны багийн хийсэн монгол хэлний халх аялгууны эгшиг авианы туршилт авиазүйн судалгааны зарим үр дүнгээс танилцуулах болно.

Оршил

Зөвлөлтийн нэрт эрдэмтэн Л. В. Щерба “Хичнээн нарийн соргог сонсголтой хэн ч байсан жинхэнэ хэлж байгаа зүйлийг сонсохоосоо чихэндээ өртөж, дадсан сэтгэхүйтэйгээ холбоотой дуу авиаг урьдал болгон сонсчихоод байдаг юм.” гэжээ. /4. т.37/ Туршилт авиазүйн судалгаа нь уламжлалт авиазүйн ололт амжилтыг туршилтын аргаар батлах, эдүгээ ч нарийвчлах шаардлагатай үзэгдлийг нягтлах, утга зохиолын хэлний зөв бичих, зөв дуудахзүйн хэм хэмжээг тогтоох, гадаад хэл заах, сурахад онол практикийн чухал ач холбогдолтой.

Нөгөөтэйгүүр шинжлэх ухаан, техник технологийн хөгжлийг даган хэлний үзэгдэл, түүний мөн чанарыг судлах хэрэгцээ нэмэгдэж, судалгааны үр дүнг цахим хэл шинжлэл, нийгмийн хэлшинжлэл зэрэг салбарт ашиглаж байна. Учир нь хэл зөвхөн хүмүүсийн хоорондын харилцааны хэрэгсэл, мэдээлэл дамжуулах хэрэгсэл төдийгүй хүн-машин, машин-машин, машин-хүний харилцаанд хэрэглэгдэх болжээ. Эдгээр шинэ харилцаанд дан уламжлалт авиазүйн чанар илтгэсэн (qualitatif) үр дүнгээс гадна, тоо (quantitatif), туршилтад тулгуурласан чанар ба хэмжээг илтгэсэн үр дүн хэрэгтэй болжээ. Энэ үүднээс орчин цагийн авиазүйг туршилтаас салгах аргагүй юм. Өөрөөр хэлбэл уламжлалт чанарын авиазүй болон туршилт тоон авиазүй хоёрыг зөв хослуулах нь чухал ач холбогдолтой төдийгүй энэ цаг үеийн хэрэгцээ шаардлага болоод байна.

Түүнчлэн туршилт авиазүйн талаас монгол хэлний авиаг судалсан нь 1990-ээд оноос хойш цаг үеийн шаардлагаар хэсэг зуур зогсонги байдалд орсон тул энэ салбарын судалгааг дахин эхлүүлэх, гүнзгийрүүлэн хийх шаардлага зүй ёсоор тулгарч байна. Мөн монгол хэлний эгшиг авианы дуун ухааны онцлог шинжүүдийг нарийвчлан тооцоолж гаргаснаар бусад хэлтэй харьцуулж, гарсан үр дүнг гадаад хэл заах арга зүй, түүнчлэн цахим хэлшинжлэл, анагаах ухаанд ашиглах боломж нээгдэх учиртай.

Туршилт авиазүйн үүсэл хөгжил

Физиологийн авиа зүйд аливаа авианы эсрэгцэх шинжийг нь зөвхөн бүтэх арга байдлаар нь тайлбарлахаар хязгаарлагдаж байсан. Энэ бэрхшээлийг давах туулахын тулд 19-р зууны сүүлчээр авиаг тэмдэглэж задлан шинжилдэг багаж хэрэгсэл бүхий туршилт авиазүй үүсчээ. 1867 онд физикч Германн вон Гелмолц дуу авианы дохиог задлах шинжлэх ухааны үндэслэлийг тогтоож, Жозеф Фурие үүнийг тооцоолох математик загварчлалд оруулсан билээ.

Хэлшинжээч Фердинанд де Соссюр хэл, хэлэхүй хоёрыг анх зааглаж хэл бол дохио, хэлэхүй нь түүний хэрэглээ гэж тодорхойлсон. Түүний дараа Прагийн хэлшинжлэлийн дэгийн эрдэмтэн Роман Якобсон болон эрдэмтэн Николай Сергеевич Трубецкой нар авиазүй, авиалбарзүйн хоёрын судлагдахууныг зааглах нь зүйтэй гэж үзсэн байна. Ийнхүү хоёр салбарыг заагласны ачаар салбар бүр илүү нарийсч, авиазүйн салбар физик, физиологи, анагаах ухаан зэрэг байгалийн шинжлэх ухаантай холбогдож туршилт авиазүйн хөгжих нөхцөл бүрджээ. Р. Якобсон, Ф. Гуннар, М. Халле нарын *Preliminaries to Speech Analysis* (1951) бүтээлдээ дуун ухаан-сонсолзүйн (acoustic-perceptif) шинж чанарт үндэслэн фонемын эсрэгцэх шинжийг тодорхойлж авиазүйн шинжлэх ухаанд эргэлт хийсэн.

1941 онд спектрограммыг нээсэн бол 1952 онд Петерсон, Барней нар англи хэлний эгшгийг задалсан судалгаандаа эгшиг авианы онцлог шинж болон формантын бүрэлдэхүүний холбоо хамаарлыг анх тогтоож, эрэгтэй, эмэгтэй, хүүхдийн дуу хоолойны онцлог ялгааг тодорхойлжээ. 1960 онд Гуннар Фант *Acoustic Theory of Speech Production* бүтээлдээ мөн Шиба, Кузияама нар судалгаандаа (1941) амны хөндийн зайн өөрчлөлт, цуурайллын бүрэлдэхүүн хоёрын хоорондын харилцан хамаарлыг дэлгэрүүлэн тайлбарласан байна. 1970 оноос Кен Стивинс фонемын үл хувирах чанарын онолыг (invariance theory) дэвшүүлж, хэлний ба хэлний бус олон хүчин зүйлийн нөлөөгөөр авианы үнэмлэхүй чанар нь ялгаатай байх боловч авиа нь маш

*МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын багш

нарийн зохион байгуулалттай, тогтвортой үл хувирах шинж чанартай дохио тул нэг фонемыг нөгөөгөөс ялгах боломжтой байдаг гэж үзжээ.

Өнөөдөр туршилт авиазүйн болон лабораторийн авиалбарзүйн хооронд зааг ялгаа бараг байхгүй болжээ. Туршилт авиазүйн онолын загвар нь авиалбарзүйн загварын нэг адил хүлээн зөвшөөрөгдөж, хэрэглээний хэлшинжлэл болон байгалийн салбар ухаануудын уулзварт чухал үүрэг гүйцэтгэх болжээ. Лабораторид өгөгдлийн сан бүрдүүлэх, мөн тэдгээрийг сүүлийн үеийн боловсронгуй техник технологи ашиглан дуун ухаан, өгүүлүүрзүй, харааны болон физиологийн олон хэмжигдэхүүнийг нэгэн зэрэг гарган авч задлан шинжлэх, өгүүлэх эрхтэний ажиллагааны талаар илүү нарийвчлалтай мэдээлэл авч авиазүйн үзэгдлийг тодорхойлоход ашиглаж байна. Мөн сүүлийн үеийн авч явах боломжтой авсаархан багаж хэрэгслийн ачаар заавал лабораторид бичлэг хийх шаардлагагүй, газар дээр нь очиж баримт мэдээлэл цуглуулах, хэлний баримтын бичлэгийн чанарт ахиц гарснаар авиазүй, тэр дундаа нутгийн аялгуу судлалд үнэтэй хувь нэмэр оруулж байна.

Өндөр чадвартай компьютер, программ, дуу бичлэгийн төхөөрөмж, хэрэгсэл, тархины бичлэг, рентген зураг, тагнайн зураг, тагнайн бичлэг, багалзуурын зураг, хэлний зураг, видео зураг, хэт авиан зураг, солонгон бичлэг, мяралзан бичлэг зэргийг ашиглан судалгааг явуулах болсноор гарах үр дүн илүү нарийвчлалтай бодитой гарах болжээ. Авиазүйн нарийн задлал хийдэг Praat, WinPitch, Wavesurfer, Winsnorri, GoldWave, Audacity, хэлэхүйн синтезийн судалгаа хийдэг Klatt, MBrola зэрэг программ, Systat, PASW Statistics, JMP зэрэг статистик тооцооллын программуудыг дурдаж болно. Авианы системийг товчоолох эдгээр нарийн багаж, техникийн тусламжтайгаар амьсгал, дууны хөвчийн ажиллагаа, нармайн байдал, чичрэх, хамжих, шүргэх байдал, хэлбэлзлэл, давтамж, хүчдэлийн нарийн чухал мэдээллийг авч, туршилтын үр дүнг ажиглах аргатай хослуулан хэрэглэж байна.

Монгол хэлний эгшиг авианы туршилт авиазүйн судалгааны тухайд

Илтгэлийнхээ дараагийн хэсэгт орчин цагийн монгол хэлний халх аялгууны эгшиг авиаг сонсолзүйн үүднээс задлан, өнө, өндөр нам, хүчдэл, давтамжийн бүрэлдэхүүн буюу формант (1, 2, 3)-ын хэмжигдэхүүнийг тооцоолон гаргаж эгшиг авианы онцлог шинжийг тодорхойлох туршилтын зарим үр дүнг танилцуулъя.

2007 оноос ӨМИС-ийн МСС-тай хэрэгжүүлсэн хамтарсан төслийн хүрээнд МУИС-ийн ГХСС-ийн багш Г. Буяннэмэх, Ё. Жанчив нар МСС-ийн авиазүйн лабораторид очиж ажилласнаар энэ судалгааны эхлэл тавигдсан билээ. Судалгаа хоёр үе шаттай. Эхний шатанд монгол хэлний эгшиг авианы тогтолцоог судлахад суурь болох дата хөмрөгийг бүрдүүлэх ажил байв. Судалгаа шинжилгээн дээр тулгуурлаж хөмрөгийг бүрдүүлэх шаардлагатай байсан тул 2008-2011 он хүртэл хөмрөг байгуулахад нилээн хугацаа, хүч хөдөлмөр зарцуулсан билээ. Я. Цэвэл гуайн Монгол хэлний товч тайлбар толиос 1-4 үет 826 үгийн дата хөмрөг 2008-2009 онд бүрдүүлсэн. 2012-2013 ӨМИС-ийн судалгааны багтай хамтран уг хөмрөгийг баяжуулж 1122 дан үгс, 163 холбоо үг, нэг үлгэр бүхий дата хөмрөгийг байгуулж, ӨМИС, МУИС-ийн дуу бичлэгийн студид 2 эмэгтэй, 4 эрэгтэй авиалагчаар уншуулж бичсэн. 2014 оноос нийтлэг 2 авиалагчийг сонгон авч авианы задлал хийж байна. Бичлэгийг Японы EMC-44В микрофон, Германы Terratec DMX 6 fire USB бичлэг шингээлтийн аппаратаар хийж, авиаг praat5361_win64.zip софт программаар задлаж байна.

Бид эхний ээлжинд монгол хэлний эгшиг авиаг задлахыг зорьсон нь эгшиг авианы тогтолцоог судлахад праат програм хангалттай бол гийгүүлэгч фонемийн тухайд тагнайн бичлэгийн аргатай хослуулан судалбал илүү үр дүнтэй байдагтай холбоотой.

Солонгон бичлэг - Спектрограмма Spectrogramme

Praat

Туршилт авиан зүйн олон төрлийн арга, электрон аппарат, багаж дотроос солонгон бичлэг буюу спектрограммын шинжилгээ ихэд өргөн дэлгэр болж байгаа бөгөөд судалгаа шинжилгээний үр дүн, тооцоолол, нийтэд хүртээлтэй байдал зэргээрээ Praat программ хангамж олон давуу талтай байна. Голланд улсын Амстердамын их сургуулийн эрдэмтэн Пол Боэрсма, Давид Вийник (Paul Boersma, David Weenik) нарын бүтээл бөгөөд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн программ юм.


Praat гэдэг нь аливаа авиаг задлан шинжлэх боломжтой нээлттэй программ хангамж бөгөөд [Macintosh](#), [Windows](#) (98, 2000, XP, Vista...), [Linux](#), [FreeBSD](#), [SGI](#), [Solaris](#), [HPUX](#) зэрэг систем дээр татан авч ажиллах боломжтой.

Уг програм хангамжийн гүйцэтгэх үйлдлээс дурдвал:

- Бичлэг хийж авиаг задлах, шинжлэх: 2Gb буюу 3 цагийн стерео бичлэг эсвэл 22 герцийн моно бичлэг 16 цаг хийх боломжтой. Мөн ямар нэг бичлэгийг уг программд суулган задлан шинжилнэ.
- Хэл яриа, авианы солонгон бичлэгийг задлан шинжилж авианы өндөр нам, формант, хүчлэл зэргийг хэмжинэ.
- Үгүүлүүрийн эрхтэний оролцоог тодорхойлно.
- Авиалбарын нэмэлт өнгө /прозоидия/-ийг задлан шинжилж формант, урт богино, хүчлэлийг хэмжинэ.

- Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулна.
- Хэл ярианы дохиог өөрчлөх боломжтой. Анализ-синтез: филтр
- Ном, мэдээг үсгээр буулгах ажлыг хөнгөвчлөнө.

Praat программаар авианы солонгон бичлэг харуулбал:



Энэ хугацаанд хийсэн зарим судалгааны үр дүнг танилцуулбал

1. Нэг ба хоёр үет нийт 32 үгийн **тэргүүн ба дэд үед** 6 авиа орсон V (8), VC (4), VCC (3), CV (3), CVC (29) бүхий 47 үеийг /хавсралт 1/ (задгай 11, битүү 36) дуун ухааны аргаар задлал хийж 6 авианы зарим онцлог шинжийг тодорхойлов. Үр дүн:

- Хоёр үет үгийн хоёрдугаар үед тохиож буй 6 авианы хүч сулран саармагжсан шинжтэй ажээ.
- Араас нь орж буй гийгүүлэгчийн бүтэх байраас /дуутай, дуугүй, хамжих, шүргэх гм./ хамааран балархай эгшгийн хэмжигдэхүүн харилцан адилгүй байна.

2. Орчин цагийн монгол хэлний халхын аман аялгууны дан үет үгийн тагнайшсан [ā, ō, ū] эгшиг авиаг туршилт авиазүйн аргаар судалж үр дүнг Шанхайн Авиазүйн олон улсын хуралд хэлэлцүүлсэн. Үр дүн:

- Ижил орчинд тохиож байгаа тагнайшсан эгшиг авианы өнө түүнтэй холбогдох ерийн эгшиг авианы өнөөс богино байна.
- [a] нь хагас уужим \дэд агуу\, хэлний хойгуур байхад [ā] авиа дунд буюу агуу дунд, хэлний дундуур болж урагшилсан байна. [o] авиа нь дунд, хэлний хойгуур, харин [ō] нь уйтан дунд, хэлний дундуур дуудагдаж байгаа нь ажиглагдлаа.
- Тагнайшсан гийгүүлэгчийн урд орсон [ā, ō, ū] эгшиг авианы дуудлага өөрчлөгдөхийн зэрэгцээ эгшгийн төгсгөл хэсэг илүү хувирч *i*-ших хандлага ажиглагдаж байна.

3. Одоо монгол хэлний а авиаг 227 үгийн жишээн дээр задалж, тооцоолон гаргасан үзүүлэлтээ харьцуулах, дүгнэх шатандаа явж байна.

Дүгнэлт

Сүүлийн үед зогсонги байсан туршилт авиазүйн судалгааг сэргээхийн зэрэгцээ монгол хэлний халх аялгууны эгшиг авианы сонсол зүйн онцлог шинжийг тооцоолон гаргаснаар нутгийн аялгууны харьцуулсан судалгаа, мөн бусад олон хэлтэй зэрэгцүүлэн судлах, гадаад хэл заах аргазүйн онолын нэг үндэслэл болох талтай.

Туршилт авиазүй судлагдахуун нь маш олон хүчин зүйлийн нөлөөнд байдаг олон талт үзэгдэл тул туршилтын үр дүнгээс харьцангуй таамаглал дэвшүүлэх боломжтой. Туршилтанд өгөгдлийн сангийн төрөл, авиалагчийн хүчин зүйл, бичлэг хийсэн нөхцөл чухал үүрэг гүйцэтгэдгийг анхаарах нь зүйтэй.

Туршилт авиазүйг хэл шинжлэлийн нэг биеэ даасан салбар гэж батлахдаа гол бус, нөгөөтэйгүүр зөвхөн ажиглалт эсвэл тооцоолол, тоонд шүтэн нэг тал руу хэлбийх бус, харин уламжлалт арга, туршилтын аргыг зөв хослуулан судалгаа шинжилгээнд хэрэглэх нь чухал юм.

Номзүй

Монгол хэлээр

Боржигон Баярмэнд, Баарин аман аялгууны судлал, ӨМАХХ, 1997.

Г. Буяннэмэх, Ё. Жанчив, Орчин цагийн монгол хэлний халхын аман аялгууны [i, e] авиаг туршилт авиазүйн аргаар судласан дүнгээс, “Гадаад хэл, соёл судлал” сэтгүүл № 295 (12), 2008.

С. Булгантамир, Acoustic analysis on the short palatalized vowels of Mongolian, the Khalkh dialect, International Conference of Phonetics et Phonology of Shanghai, 2012.

Ш. Лувсанванданы төрийн соёрхол хүртсэн Орчин цагийн монгол хэлний бүтэц. Тэргүүн дэвтэр. Авиа авиалбар хоёр нь, УБ., 1967.

Ш. Лувсанванданы төрийн соёрхол хүртсэн “Орчин цагийн монгол хэлний бүтэц. Тэргүүн дэвтэр. Авиа авиалбар хоёр нь”, УБ., 1967.

Ж. Цолоо, “Орчин үеийн монгол хэлний авиазүй”, УБ., 1976.

С. Мөөмөө, “Монгол хэлний авиан зүй”, УБ., 1979.

Ж. Надмид, Ж. Санжаа, “Орчин цагийн монгол хэлний авиан зүй”, УБ., 1992.

Ж. Санжаа, Ж. Надмид, “Монгол хэлний авиазүй ба авиалбарзүй”, УБ., 2008.

Р. Туяа, Ойрд аялгууны эгшиг авианы туршилт авиазүйн судалгаа, 2009, ӨМИС, Хөх хот.

Гадаад хэлээр

Gunnar Fant., *Acoustic Theory of Speech Production*, The Hague, Mouton, 1960.

Jakobson R., Fant G et Halle M., *Preliminaries to Speech Analysis*, Cambridge, MA, The MIT Press, 1952.

Delattre, Pierre, *Studies in French and Comparative Phonetics*, Londres, La Haye, Paris, Mouton & Co, 1966.

C. Meunier, *Phonétique acoustique*, Université de Provence, 2004.

J.-P. Tubach, *La parole et son traitement automatique*, Calliope, Paris, 1989

Хавсарлт

19-р зууны төгсгөлд Пьерр-Жан Русло (1846-1924) хэмээх францын нэгэн гэгээнтэн лабораторийн аргаар авиазүйн судалгааны анхны туршилтыг хийж авиан хувьсал өөрчлөлтийг судалснаар туршилт авиазүйн эхлэл тавигдаж, улмаар энэ арга нь 20-р зууны 2-р хагаст хурдацтай хөгжиж, өдгөө хэл шинжлэл болон олон хавсарга шинжлэх ухаанд өргөн хэрэглэгдэх болжээ.


Түүний *Principes de Phonétique Expérimentale* бүтээл нь 1897, 1901 онд хэвлэгдснээр хэл шинжлэх ухаанд шинэ эргэлт болж, авиазүй нь анагаах ухаан, сэтгэл судлалын дараагаар хүнд чиглэсэн хүн төвтэй шинжлэх ухааны аргыг нэвтрүүлж, туршилтын бодит аргыг хэрэглэх болсон байна. Тэрээр туршилт авиазүйн аргын тухай : “Авиазүй нь үхмэл эх бичвэр бус, харин амьд хүний бодит яриаг суурь болгох ёстой” гэж өгүүлжээ. Туршилт авиазүйн судалгааны үр дүнг гадаад хэл заах аргазүй, зөв дуудахзүйн алдааг засах, сонсголын бэрхшээлтэй иргэдэд туслах, эмчлэх зэргээр заах аргазүй болон эмчилгээнд бүрэн хэрэглэж болно гэж үзсэн байна.

Хүмүүсийн харилцааны гол хэрэгсэл болох хэлний нэгж үгүүлбэр нь үгээс, үг нь авианаас бүтэх тул хэлний шинжлэх ухааны үүднээс ч, хэрэглээнд тулгуурласан ч аливаа хэлийг суралцаж судлахад юуны өмнө авиазүйгээс эхэлдэг билээ.

Туршилт авиазүйн судалгаа нь нэг талаас төрөл хэлний гарал үүсэл, хөгжлийн асуудал, үгийн гарал үүсэл, хэлний түүхийн асуудлыг нягтлан боловсруулахад, нөгөө талаас утга зохиолын хэлний зөв бичих, зөв дуудахзүйн хэм хэмжээг тогтооход, гадаад хэлийг зааж сургахад онол практикийн чухал ач холбогдолтой.

Олон улсын авиазүйн цагаан толгойг 1886 онд Отто Жесперсен зохиож гадаад улмаар хэсэг багш нар гадаад хэлний сургалтанд зориулж авиа галиглах тогтолцоог бий болгосон билээ.

Үндсэн эгшиг



1956 онд Даниел Жонсын үндсэн эгшгийн судалгаа

ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ҮГҮЙСГЭХ ӨГҮҮЛБЭР
ТӨЛӨӨЛӨХ ХЭЛБЭР БУЮУ “PRO-FORM”-ООР ИЛРЭХ НЬ
Pro-forms of negative sentences in modern Mongolian

Д.Энхжаргал*

Товч агуулга: Олон хэлний хэв шинжийн судалгаанд үндэслэн орчин цагийн монгол хэлний үггүйсгэх өгүүлбэрийг төлөөлөх хэлбэрийг авч үзсэн болно.

Түлхүүр үг: үггүйсгэгч, үйлийн төлөөлөл, өгүүлбэрийн төлөөлөл

1. Олон хэлний хэв шинжийн судлал дахь “Pro-form” -ийн ойлголт

Төлөөлөх хэлбэр (pro-form) нь тухайн хам бичвэрт үг, хэлц, гишүүн өгүүлбэр эсвэл бүтэн өгүүлбэрийн утгыг нөхөж тэдгээрийг орлодог үг болон илэрхийллийн нэг төрөл юм. Тэдгээр нь тухайн илэрхийллийг давтахаас зайлсхийх зорилгоор хэрэглэгддэг. Төлөөлөх хэлбэрийг олон хэлний хэв шинжийн судлалд Paul Schachter (1978), Giuliano Bernini, Paolo Ramat (1996, 89-90), Hadumod Bussman (2006:950), Paul Schachter, Timothy Shopen (2007: 22-60), Jack C. Richards & Richard Schmidt (2002: 426) нарын зэрэг судлаачид судалсан байна.

Төлөөлөх хэлбэр (pro-form) бидний судалгаанд өгүүлбэр дэх үйл үгийг, эсвэл тухайн хам бичвэрт бүтэн өгүүлбэрийг орлож буйгаараа холбоотой. Хамгийн нийтлэг хэрэглэгддэг төлөөлөх хэлбэрийн төрөл нь төлөөний үг буюу *pronoun* бөгөөд өгүүлбэрт нэр болон нэрийн нийлэмжийг орлодог байна. Schachter (1978) дараах жишээнд буй налуу үгсийг төлөөлөх өгүүлэхүүн (pro-predicate) хэмээн тодорхойлсон байна. Тухайлбал,

Англи. Jack fell down, but Jill *didn't*

‘Жэк сэтгэлээр унасан байна, харин Жил үгүй байна.’

Jill isn't crying, but Jack *is*

‘Жил уйлаагүй байна, харин Жэк уйлж байна.’

Гэвч үгийн аймгийн хүрээнд л тодорхойлох нь хангалттай биш хэмээн Paul Schachter, Timothy Shopen (2007: 22-60) нар үзжээ. *Pronoun, pro-verbs, pro-adjectives, pro-adverbs, interrogative pro-forms* (Paul Schachter, Timothy Shopen, 2007:31) зэрэг өгүүлбэрийн гишүүдийг төлөөлөх төдийгүй тэдгээрээс илүү том нэгж, тухайлбал, гишүүн өгүүлбэр *pro-clause*, өгүүлбэрийг төлөөлөх *pro-sentence* (Giuliano Bernini, Paolo Ramat 1996:89, Paul Schachter, Timothy Shopen, 2007:31) хэлбэр байж болохыг судалгаандаа авч үзсэн байна.

Pro-verb буюу үйл үгийг төлөөлөх хэлбэр нь үйл үг эсвэл үйлийн нийлцийг орлодог байна. Тухайлбал, англи хэлний *do*. Мандарин хятад хэл аялгуунд *lai* ‘do it’ (түүнийг хий), *zemme* ‘do this’ (үүнийг), *nemme* ‘do that’ (тэрийг хий) зэрэг *pro-verb* байдаг ба нийтлэг хэрэглэгддэг нь *lai* юм. Тухайлбал,

Ni buhui xiu zhe jigu, rang wo lai

you know.how.neg repair this machine let I do. It

‘Та энэ машиныг яаж засахыг мэдэхгүй, надаар хийлгэ.’ (Timothy Shopen, Vol I, 2007:33)

Pro-adjective буюу хүртээл нэрийг төлөөлөх үг нь тэмдэг нэр эсвэл тэмдэг нэрийн үүргээр орж буй илэрхийллийг орлодог. Франц хэлэнд *le* нь тэмдэг нэрийг орлоно. Тухайлбал,

Jean est grand, mais je ne *le* suis pas

Jean is tall but I neg pro.adj am not

‘Жонн өндөр, харин би тийм биш.’

Pro-adverb буюу дайвар үгийг төлөөлөх үг нь дайвар үгийг эсвэл дайвар үгийн үүргээр орж буй илэрхийллийг орлоно. Англи хэлний *thus* эсвэл *akan*¹ хэлний *see* (үүнчлэн), *saa* (ийм маягаар) зэрэг үг дайвар үгийг төлөөлдөг. Тухайлбал,

Menoa no see, na ono nso noa no saa

I cook it this. way, and he too cooks it that. way

‘Би үүнийг ингэж чанадаг, тэр ч бас ийм маягаар чанадаг.’

Interrogative pro-forms буюу асуух үгийн төлөөлөх хэлбэрүүд мөн байна. Англи хэлний *who*, *what*, *where*, *when* гэх мэт асуух үгс асуух өгүүлбэрийн эхэнд хэрэглэгддэг ба асуух үгийн хэлбэрүүд үгийн бүх аймагт хамаатай. Тухайлбал, англи хэлэнд *who*, *what* гэх мэт асуух төлөөний үгс (interrogative pronouns), асуух

* МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын багш, докторант

¹ Акан (Akan) Нигер Конгийн хэлний бүлгийн хэл, Ква хэл аялгуунд хамаардаг.

дайвар үг (interrogative adverbs): *where, when*, асуух ялгац (interrogative articles) *which in which book* гэх мэт байна.

Pro-clause буюу гишүүн өгүүлбэрийг төлөөлөх хэлбэр. “Pro-clause”-ийн нийтлэг төрөл нь лавлах асуулт. Тухайлбал, *Англи хэлний ор бүхий асуултууд (Is it raining or not?)*

Хауса² хэлний

Ana ruwa, ko?

one. is rain or

‘Бороо орж байна уу, үгүй юу?’

Гишүүн өгүүлбэрийг төлөөлөх (pro-clause) өөр нэг төрөл нь англи хэлний *so, not* хэлбэр. Жишээлбэл,

John says that it will rain, but I don't think so

‘Бороо орно хэмээн Жонн хэлсэн, харин би тэгж бодохгүй байна.’

John says that it will rain, but I think not

‘Бороо орно хэмээн Жонн хэлсэн, харин би үгүй гэж бодож байна.’

So болон *not* нь энэ тохиолдолд *I don't think that it will rain, I think that it won't rain* гэсэн өгүүлбэрүүдийг төлөөлж байна.

Pro-sentence буюу өгүүлбэрийг төлөөлөх хэлбэр гэж тухайн хам бичвэрээс бүтэн өгүүлбэрийн агуулгыг нөхөж, бүтэн өгүүлбэрийг орлодог үг эсвэл илэрхийллийг хэлнэ.

Өмнөх хам бичвэрт буй илэрхийллийн нэгэн адил илтгэх бүрдүүлбэр бүхий бүтэн өгүүлбэрийг төлөөлж чадах **yes, no** хэлбэрийн илэрхийллүүдийг (Giuliano Bernini, Paolo Ramat 1996, Paul Schachter, Timothy Shopen, 2007) *pro-sentence* хэмээн үздэг. Англи хэлний *yes, no, okay, amen* зэрэг нь нийтлэг төлөөлөх өгүүлбэр (common pro-sentences) хэмээн тооцогддог байна. “Does Mars have two moons?”, өгүүлбэрийн хариулт “Yes” нь “Mars has two moons.” хэмээн ойлгогдоно. Заримдаа аялга үгс өгүүлбэрийг төлөөлөх нь байна. -Is it raining?, асуултад -Yes хэмээн хариулах нь *It's raining гэсэн өгүүлбэр*, -No нь *“It isn't raining” гэсэн өгүүлбэртэй тэнцэнэ.*

2. Орчин цагийн монгол хэлний үгүйсгэх өгүүлбэр төлөөлөх хэлбэрээр илрэх нь

Өгүүлбэрийг үг болон бусад илэрхийллүүд төлөөлөх хэв шинж нь өгүүлбэрээс дээш түвшинд буюу өгүүлэмжийн (discourse) түвшинд илэрнэ. Энэ нь тухайн хам бичвэр, ярианы хам орчноос хамааралтай. Орчин цагийн монгол хэлэнд төлөөлөх өгүүлбэрийг (pro-sentence) судлаачид үгүүлбэр үг (Ш. Лувсанвандан 2000), жинхэнэ бус аялга үг-өгүүлбэр (М. Базаррагчаа, 1987, Б. Пүрэв-Очир, 2001, Д. Төмөртоогоо ба бусад 2004) зэргээр нэрлэдэг байна. Эрдэмтэн Ш. Лувсанвандан (2000:82-83) “Тийм, тэгнэ, үгүй, биш” гэсэн үг дан дангаараа үгүүлбэрийн үүрэг гүйцэтгэж хэрэглэгдсэнийг үгүүлбэр үг гэнэ” хэмээн үзээд дараах жишээнүүдийг татжээ.

- | | |
|----------------------------------|-------------------------------------|
| 1. -Та өнөө орой манайд очих уу? | -Тэгнээ (өнөө орой танайд би очно) |
| -Энэ танай ном уу? | -Тийм (энэ миний ном) |
| -Энэ танай морь мөн үү? | -Мөн (энэ манай морь) |
| 2. -Та өнөө орой манайд очих уу? | -Үгүй (би өнөө орой танайд очихгүй) |
| -Энэ таны морь биш биз? | -Биш (энэ миний морь биш) |
| 3. -Та өнөө орой манайд очоорой. | -Заа. Би өнөө орой танайд очъё. |

Эрдэмтэн М. Базаррагчаа (1987:278) “Монгол хэлний аялга үг-өгүүлбэрийг дараах байдлаар ангилжээ. Үүнд:

А. *Жинхэнэ аялга үг-өгүүлбэр*: 1. Сэтгэлийн хөдөлгөөн илтгэсэн (-аа-ээ-өө-оо-ий, ай-эй-ой, тий тий-тай тай). 2. Уриалж дуудсан: а) хүнд: хүүш, чиш, уухай, ухай б) мал адгуусанд: хааяд, хаа, хөж, гуруй, чаа, мяу

Б. *Жинхэнэ бус аялга үг-өгүүлбэр*:

1. *Сэтгэлийн хөдөлгөөн илтгэсэн* (хөөрхий, зайлуул, чааваас, ашгүй, гялай, Сайхан аа, халаг, хайран, золгүй еэ, азтай яа, аргагүй, бүү үзэгд, баяртай, гялайлаа)

2. *Уриалан дуудсан* (Галлаад! Марш! Алхаад! Давшаад! Май, бүүвэй, ээжээ! Чимээгүй! Дуугай! Ац, аль! харав уу! та минь! барууншаа!)

3. *Зөвшөөрсөн буюу баталсан* (Мөн, тийм, тэгнэ, болно, за, зүгээр, нээрээ /н/, тэр дээ, энэ дээ! яахав, цод, мад)

4. *Эс зөвшөөрсөн буюу үгүйсгэсэн* (Биш, үгүй, тийм биш, болохгүй, тэгэхгүй, дуу! байз! аяд! горьгүй, хай, хаанаас даа, худал аа! хэрэггүй, дэмий гэх мэт) хэмээн ангилсан байна.

Эрдэмтэн судлаач Б. Пүрэв-Очир (2001:207) монгол хэлний өгүүлбэрийг бүтэц, бүтэц бус хэмээн ангилаад бүтэц өгүүлбэрт нэрийн ба үйлийн бүрдүүлбэртэй өгүүлбэрийг багтааж, бүтэц бус өгүүлбэрт нэрийн ба үйлийн бүрдүүлбэргүй өгүүлбэрийг оруулсан байдаг. Бүтэц бус өгүүлбэрийг дотор нь жинхэнэ аялга үг-өгүүлбэр (Бүүвэй бүүвэй, Халхай халхай), жинхэнэ бус аялга-үг өгүүлбэр (Тийм тийм. Үгүй, Биш, За)³ хэмээн ангилжээ. Б. Пүрэв-Очир (2001:215): “Нэг талаар “гишүүлбэргүй өгүүлбэр” гэж болмоор, нөгөө талаар хэлэхүйн өгүүлбэрийн энэ хэв шинжийг бүтэц бүрдүүлбэрээс нь үзвэл хэлбэр-бүтцийн хувьд өгүүлбэрийн тийм ийм гишүүнээс бүтсэн гэх аргагүй, харилцах төвшинд тухайн өгүүлбэрийн хэлзүйн цөм бүрдүүлэгч болоод дэлгэрүүлсэн дагуул бүрдүүлэгчийг хоёуланг нь задлах аргагүй болтол нь “хураасан”, “төлөөлж хэлсэн”, “нэгтгэн ерөнхийлсөн” мэт маш өвөрмөц бүтэцтэй юм” хэмээн дүгнэжээ.

² Хауса (Hausa), Афрозийн хэлний бүлгийн хэл


³ Б. Пүрэв-Очир (2001) Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй 1, УБ, 207-р тал

Бид орчин цагийн монгол хэлний жинхэнэ аялга үг-өгүүлбэр, жинхэнэ бус аялга-үг өгүүлбэрийг нь өгүүлбэрийг төлөөлж буй шинжээр нь төлөөлөх өгүүлбэр (pro-sentence) хэмээн үзэж байна. “алга”, “биш”, “үгүй” зэрэг үгүйсгэгчүүд үгүйсгэх өгүүлбэрт үйлийн бүлгийг орлож, үйл үгийн үүргээр хэрэглэгдэхийн зэрэгцээ бүтэн өгүүлбэрийг төлөөлөх чадвартай хэмээн үзэж байна.

2. 1. Үгүйсгэгч өгүүлбэрт үйлийн бүлгийг төлөөлөх (pro-verb)

2.1.1. “Алга” үгүйсгэгч өгүүлбэрт үйлийн бүлгийг төлөөлөх

“АЛГА” үгүйсгэгч “байхгүй, оршихгүй” гэх мэт үйл үгсийг өгүүлбэрт орлоно. Цаашилбал, харагдахгүй, үзэгдэхгүй, бараагүй, сураггүй зэрэг үгсийг өгүүлбэрт орлох боломжтой хэмээн үзэж байна. Х-штрихийн онолын (Noam Chomsky 1988, Jackendoff R.S. 1972) үүднээс авч үзвэл “алга” нь c-command-д үйл үгийн бүлгийг орлоно гэсэн үг.




Төлөөлөх хэлбэрийн онол ёсоор “алга” нь үйлийн төлөөлөл (pro-verb) болж чадна. Өгүүлбэрийн хэв шинжийн хувьд **SO+Neg=SO+ALGA** хэв шинжид хамаарна. Уран зохиолын жишээ баримтаар харуулъя. Нарийн бичгийн дарга бүсгүй харилцуурыг авсан боловч хэсэг хугацаанд чимээ алга. (Г. Батаа, Бундангийн ноён), Өнөөх дууч хүү алгаа. (З. Баттулга Уяхан замбуутив), Ер нь чамтай ярих хэрэг алга! (Ц. Дамдинсүрэн, Бух Гомбо), Гэтэл чамд янаг хайрын сэтгэл алга! (Ц. Дамдинсүрэн, Чемодантай юм), Одоо цагт чинь хатуужихаас дээр юм алга. (Д. Намдаг, Шинэ зам), Дуртай хүнд эдлүүлж байдаг бие надад алга. (Ч. Лодойдамба, Тунгалаг тамир) гэх мэт олон жишээг дурдаж болно.

Энэ хэв шинжид SOV-ын/-ийн NP+Neg V=SO+V-ын/-ийн NP+ALGA хэлбэртэй өгүүлбэр мөн хамаарна. C-command-д үйлийн бүлэг “үйл үг+харьяалахын тийн ялгалын нөхцөл+алга” гэсэн нийлмэл бүтэцтэй байх боломжтой. Тухайлбал, Ажил хийж ачит ээж, амраг хань, бор гэдсээ тэжээнэ гэхэд итгэхийн арга алга. (Г.Дүйнхэржав, Амин дэнс), Тэглээ гээд эцгийнх нь үгийн нууцыг хэлчихийн зориг алгаа. (З. Баттулга Уяхан замбуутив) гэх мэт болно.

2. 1.2. “ҮГҮЙ” үгүйсгэгч өгүүлбэрт үйлийн бүлгийг төлөөлөх (pro-verb)

“Үгүй” нь үгүйсгэгчийн үүргээр орж өгүүлбэрийг үгүйсгэхийн зэрэгцээ, дангаараа үйлийн бүлгийг орлож чадна. “Үгүй” нь “алга”-ын адил өгүүлбэрт байхгүй, оршихгүй гэх мэт үгсийг орлоно. Өгүүлбэрт үйлийн бүлгийг төлөөлж буй “үгүй” бүхий өгүүлбэр дараах бүтэцтэй.



Уран зохиолын жишээгээр: Хумка үг олон үгүй. Чонос үг Хумка үгэнд үгүй. Жад гэж Хумка үгэнд үгүй. Нум гэж Хумка үгэнд үгүй. Сал гэж Хумка үгэнд үгүй. Олон үг үгүй. (Б. Ринчен, Заан Залуудай), Хөнөөл хяхал чамд хүргэх хэн ч үгүй. (Д. Нацагдорж, Сараа), Ойдов:-Тэднээс тийм үг ер нь хэлсэн зааварласан зүйл огт үгүй. (Ши. Аюуш, Яг арван найм) гэх мэт болно.

2. 1.3. “Биш” үгүйсгэгч үйлийн бүлгийг төлөөлөх (pro-verb)

Үүнийг SO+pro-verb= SO + БИШ хэмээн томъёолж болно. Энэ тохиолдолд биш нь үйлийн бүлгийг орлох ба *pro-verb* болж байна. Судлаач Б. Пүрэв-Очир “Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй 2” (УБ, 2000) бүтээлдээ:

“Энэ нь биш, тэр нь таарч байна.

Чинийх биш, Батын ном юм.

Чамайг биш, намайг явуулна.

Доржид биш, Батад өгөв.

Батаас биш, Доржоос асуув.

Доржтой биш, Баттай тоглов.

Доржоор биш, Батаар яриулав.

Дорж руу биш, Бат руу харав.г.м-ээр хэлхэцийн нэг тал нь үгүйсгэсэн харьцаа зааж, нөгөө тал нь түүнтэй ерөнхийдөө эсрэгцсэн байдалтай, нотлол хэлбэртэй байгаа, нөгөө талаар бус, биш нь үйл үгийн утга үүргээр орж, өмнөх нэр үгээ нэрлэх, харьяалах, заах, өгөх орших, гарах, үйлдэх гэх мэт бүх тийн ялгалаар захирч байгаа юм шиг хэв шинж харагдаж байна” хэмээн тайлбарласан байна. Бид судлаачийн “бус, биш нь үйл үгийн утга үүргээр” орж байна гэсэнтэй санал нийлж байна. Бид дээрх жишээнд буй “биш”-ийг үйлийн бүлгийг орлож буй үйлийн төлөөлөл үг (pro-verb) хэмээн үзээд дээрх өгүүлбэрүүдийг

Энэ нь таарахгүй, тэр нь таарч байна.

Чиний ном биш, Батын ном юм.

Чамайг явуулахгүй, намайг явуулна.

Доржид өгөхгүй, Батад өгөв.

Батаас асуусангүй, Доржоос асуув.

Доржтой тоглосонгүй, Баттай тоглов.

Доржоор яриулсангүй, Батаар яриулав.

Дорж руу харсангүй, Бат руу харав.” гэсэн зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрүүдийг хураангуйлсан хэлбэрүүд байна гэж үзэж байна. Эдгээр зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрүүдийн эхний өгүүлбэрийн үйл үгийн бүлгийг “биш” нь дангаараа орлож, өгүүлбэрийг үгүйсгэх утгатай болгож байна хэмээн тооцож байна. Бид үүнийг уран зохиолын жишээгээр нотлон харуулъя. Чиний тайван нойрсдог цаг биш. (Г. Батаа, Бундангийн ноён), Үхэр холдоогүй цагт ус санах хэрэг биш. (Б. Ринчен, Заан Залуудай), Энэ бол амьтан биш шавар мөн. (Ц. Дамдинсүрэн, Хэнз хурга), Сандаг: -Сэмжид гэдэг чинь, учиргүй хүн бүрийн төлөө чихээ тавьж явдаг ч хүн биш шүү. (Л. Ванган, Эмч нар), Энэ хоёр Заяын хүрээний унаган шавь биш. (Ч. Лодойдамба, Тунгалаг тамир) гэх мэт болно.

2.2. Орчин цагийн монгол хэлнээ үгүйсгэх өгүүлбэрийг төлөөлөх хэлбэрүүд (pro-sentence)

Өгүүлбэрийг ганц үг биш, хэлц үгс болон бусад илэрхийллүүд төлөөлөх чадвартай. Бид энд зөвхөн үгүйсгэх утга бүхий өгүүлбэрийг үгүйсгэх үүрэгтэй үгүйсгэгчүүд төлөөлөх хэв шинжийг авч үзлээ. Бидний судалгаагаар орчин цагийн монгол хэлнээ үг үгүйсгэх өгүүлбэрийг төлөөлөх дараах хэлбэрүүд байна. Үүнд:

1. Үгүйсгэгчүүд: алга, биш, үгүй, битгий
2. Үгүйсгэх утгат үйл үгс эсвэл үгүйсгэгч бүхий үйл үгс
3. Үгүйсгэх утгатай хэлц үгс: үхсэн хойноо, гонж, яалаа гэж, хаанаас
4. Үгүйсгэн захирахууд хэрэглэгддэг зарим үгс, хэлц үгс: дуу!, чиш! гэх мэт болно.

2.2.1. Үгүйсгэгчүүд үгүйсгэх өгүүлбэрийг төлөөлөх нь

2.2.1.1. “алга” үгүйсгэгч өгүүлбэрийг төлөөлөх нь

“Алга” үгүйсгэгч өгүүлэмжийн түвшинд бүтэн өгүүлбэрийг төлөөлж, тухайн хам бичвэрт үгүйсгэх утгатай өгүүлбэрийг төлөөлнө. Тухайлбал,

Асуулт: Та нарын дунд монгол хүн байна уу?

Хариулт: **Алга**.

2.2.1.2. “БИШ” үгүйсгэгч өгүүлбэрийг төлөөлөх нь (pro-sentence)

Орчин цагийн монгол хэл (Д. Төмөртоогоо ба бусад, 2004:264) хамтын бүтээлд: “Монгол хэлний жинхэнэ бус аялга үг-өгүүлбэр нь **Тийм, Тийм дэг, Үгүй шүү, Мөн дөө** гэх мэтээр холбосон зэргэлдээх өгүүлбэрийн агуулга хэлбэрийг бүхэлд нь төлөөлж баталсан эсвэл төлөөлж үгүйсгэсэн харьцаатай байх бөгөөд хүүрнэх, асуух, анхааруулах өгүүлбэрийн аялгатайгаар бүтсэн байж болно. Жишээ нь:

-Та ямар үндэстэн бэ?

-Таа л даа.

-Араб гэж тэр хүүхний хэлэхэд Дармаев толгой сэгсрэв.

-Тэгвэл турк.

-**Биш**.

-Казак.

-**Биш**.

-Энэтхэг.

-Биш гэж хэлэв” хэмээн үзжээ.

Бид энд буй “биш”-ийг бүхэл бүтэн үгүйсгэх өгүүлбэрийг төлөөлж чадах төлөөлөх өгүүлбэр (pro-sentence) хэмээн үзэж байна. Төлөөлөх өгүүлбэр (pro-sentence) нь зөвхөн үгүйсгэх утга бүхий нэг үг биш бас өгүүлбэрийг төлөөлсөн үгүйсгэгч бүхий үйл үг болон бусад илэрхийллүүд байх боломжтой. Тухайлбал,

Сэмжид:- ...Тэр өвгөн чинь уг нь эмч хүн үү?

Сандаг:- Биш ээ галч, үгүй яагаав дээ, нөгөө найзтай өвгөн. (Л. Ванган, Эмч нар)

- Орой болтол хэдий хэр мөд харуулдах вэ гэж Лавай тэнсэх маягаар асуулаа.

-Их бишээ гэж Жү овогт гараа алдлаад ... (Б.Мандир, Нөмгөн эр)

2. 2.1.3 “ҮГҮЙ” үгүйсгэгч өгүүлбэрийг төлөөлөх (pro-sentence)

2. 2.1.3.1. “ҮГҮЙ” үгүйсгэгч гишүүн өгүүлбэрийг төлөөлөх нь

“Үгүй” үгүйсгэгч гишүүн өгүүлбэрийг мөн төлөөлж, төлөөлөх гишүүн өгүүлбэр (pro- clause)-ийн үүргийг гүйцэтгэж болно. Тухайлбал, Хуагчин эмгэн өгүүллүүн: <<Гэр нь ойр байна. Тэмүжиний бий үгүйг би мэдэхгүй, би хойд гэрээс гарч ирэв>> гэв. (МНТ, 100-р зүйл) Эл тохиолдолд “үгүй” нь гишүүн өгүүлбэрийг төлөөлж, <<Тэмүжиний бий үгүйг би мэдэхгүй, би хойд гэрээс гарч ирэв>> өгүүлбэр “Тэмүжиний байгаа болон Тэмүжиний байхгүйг би мэдэхгүй, би хойд гэрээс гарч ирэв” гэсэн өгүүлбэр байна.

2. 2.1.3.2. “ҮГҮЙ” үгүйсгэгч өгүүлбэрийг төлөөлөх нь

Орчин цагийн монгол хэлнээ “үгүй” хэмээх үг өгүүлэмжийн хүрээнд бүтэн өгүүлбэрийг орлож буйг харж болно. Тухайлбал, Чулуугаар тоо бодож байсан өвгөн гараа өргөж олны шуугиан намдаагаад, хоёр Дүлхижегээс -Та нар отгоосоо гарахдаа манайхны Цахиурчин отгийнхон дайрна гэж зорин гарсануу?- Үгүй. (Б. Ринчен, Заан Залуудай). Эл өгүүлэмжийн “үгүй” хариулт нь “Та нар отгоосоо гарахдаа манайхны Цахиурчин отгийнхон дайрна гэж зорин гарсануу?” гэсэн өгүүлбэрээс нөхөгдөн ойлгогдох “Бид нар отгоосоо гарахдаа манайхны Цахиурчин отгийнхон дайрна гэж зорин гараагүй” гэсэн бүтэн өгүүлбэрийг орлож байна хэмээн бид үзэж байна.

Хүүхдүүдийнхээ юу болох хувь заяатай төрснийг үзүүлсэн үү?

-Үгүй. (Д. Цэвэгмид, Соёлын зул бадарсан нь)

Энд буй “Үгүй” хариулт “Хүүхдүүдийнхээ юу болох хувь заяатай төрснийг үзүүлээгүй” гэсэн өгүүлбэрийг орлож байна.

-Хаалгандaa монгол цоож хийх гэж байгаа юм байх даа. -Үгүй дэгээ. (Д. Батбаяр, Мэлмий) “Үгүй дэгээ” хариулт “Хаалгандaa монгол цоож хийх гэж байгаа биш байна.” гэсэн бүтэн өгүүлбэрийг төлөөлнө.

Сүхбаатар: -Сүрхий холоос яваа юм байна. Бидэнтэй нийлэхээр ирээ үү?

Дандар:- (цочин) Үгүй чинь ! (Д. Намдаг, Шинэ зам)

Таньд зовлонгоо ярьж таны амрахад чинь саад болж байна уу даа гэж Дорж гуай хэлэхэд, -Үгүй, үгүй Дорж гуай гэж би хариулав. (Ч. Лодойдамба, Хугараагүй ноён нуруу)

Цээсүрэн:-Гал зууханд нэг сандал бий. Эгч нь аваад ирье.

Отгон: Үгүй, үгүй. Би суух гээгүй. (Д. Батбаяр, Цөөрөм) гэх мэт олон жишээг

дурдаж болно.

2. 2.1.4. “Битгий” үгүйсгэгч өгүүлбэрийг төлөөлөх нь

Судлаач Ю. Мөнх-Амгалан, Кан Шин (2014:225) нар “Бүү хэмээх чимэх үг нь биеэ дааж харьцангуй утга төгсгөж чаддаггүй бол битгий нь хойноо үг дагуулалгүй дангаараа хориглох утга илтгэж чадна. Жишээлбэл: Битгий! Одоо болно.” хэмээн үзжээ. Бид ч үүнтэй санал нэг байна. Бид үүнийг өгүүлбэр төлөөлөх нэг хэлбэр байж болно гэж үзэж байна.

2.2.2. Үгүйсгэх утгатай үгс өгүүлбэрийг төлөөлөх (pro-sentence)

Бид үгүйсгэх утгын тухай өгүүлж буй тул үгүйсгэгч болон үгүйсгэх үгс өгүүлбэрийг төлөөлөх хэлбэрийг л авч үзэж байна. Үгүйсгэгчүүд өгүүлбэрийг төлөөлөхөөс гадна үгүйсгэх утгатай, үгүйсгэгч бүхий үйл үгс өгүүлбэрийг төлөөлж болно. Тухайлбал, “-Танайд шинээр гарсан толь бичиг байна уу? –Байхгүй” гэсэн өгүүлэмжийн хүрээнд “байхгүй” нь “Манайд шинээр гарсан толь бичиг байхгүй” гэсэн өгүүлбэрийг төлөөлнө.

2.2.3.Хэлц нь өгүүлбэрийг төлөөлөх (phrase as a pro-sentence)

Хэлц үгс өгүүлбэрийн утгыг үгүйсгэх хэлбэрийг монгол хэл шинжлэлд судлаач Ж. Бат-Ирээдүй (2009) авч үзсэн байдаг. Үгүйсгэх утгатай хэлц үгс өгүүлбэрийг төлөөлж болохыг бидний судалгаа харуулж байна. Тухайлбал:

Цээсүрэн: -Ганзоригийг гараагүй бол чи өдийд намайг хаячихсан.

Гунгаа: -За яалаа гэж. (Д. Батбаяр, Цөөрөм)

“За яалаа гэж” хариулт “Ганзоригийг гараагүй байсан ч би чамайг хаяхгүй байсан” гэсэн өгүүлбэртэй дүйх тул бүтэн өгүүлбэрийг төлөөлж чадна.

Түшиг: -Ийм сайхан ус гарч байна. Чи уух уу. (Чоймболд өгнө.)

Чоймбол:- (зэвүүцэн) Үхсэн хойноо. (Д. Намдаг,Тэмцэл)

“Үхсэн хойноо” хэлц тухайн хам бичвэрт “-Ийм сайхан ус гарч байна. Чи уух уу” өгүүлбэрээс утга нөхөгдөн “Би тэр тэр сайхан усыг чинь уухгүй” гэсэн бүтэн өгүүлбэрийг төлөөлж байна хэмээн бид үзэж байна.

Цэрмаа: -Би яваад ирэх үү, танай мориор явах уу?

Нямжав: -Дэмий, дэмий. (Д. Намдаг,Тэмцэл)

Д.Энхжаргал

“Дэмий, дэмий” хариулт “Чи яваад хэрэггүй” гэсэн утгатай өгүүлбэрийг төлөөлнө.

-Хүүе хоол идээд яваач. **-Зүгээр. Зүгээр.** (Д. Батбаяр, Мэлмий)

Думаа:-Суу, суу, дайптайгаа зэрэгцэж сууж, цай ууж сайхан ярилц л даа.

Гавармаа:-За яришиг, юугаа ярих юм. (Д. Намдаг, Амь ба амьдралын үнэ)

Дээрх жишээ өгүүлбэрүүдэд буй “*үхсэн хойноо, дэмий, зүгээр, хаанаас, яришиг* зэрэг нь тухайн хам бичвэрт бүтэн өгүүлбэрийг төлөөлж үгүйсгэх утга бүхий pro-sentence болж байна.

2.2.4. Үгүйсгэн захирахуйд хэрэглэгддэг зарим үгс, хэлц үгс өгүүлбэрийг төлөөлөх нь

Үгүйсгэн захирахуйн хэв шинжид бүтэн өгүүлбэрийг төлөөлсөн зарим үгс, хэлц үгс өгүүлбэрийг төлөөлнө. Тухайлбал,

Гавармаа:-Би түүгээр чинь эмчлүүлэхгүй ээ, та өөрөө эмчлүүл.

Думаа:-**Хош!** Юу гэсэн үг вэ? (Д. Намдаг, Амь ба амьдралын үнэ)

“хош!” нь тухайн хам бичвэрт “Чи битгий тэгж ярь” гэсэн утгатай өгүүлбэрийг төлөөлнө.

Дариймаа: Тайвшир, битгий хөдөл! Бүү амьсгал!гэхээс өөр юу хэлж чадах юм.

Жав:-**Чиш!** Маргаан уу? ! (Д. Батбаяр, Хайрыг хайрла)

Дээрх өгүүлэмжийн хүрээнд илэрсэн “Чиш!” нь “Та нар чимээгүй бай” гэсэн утгатай өгүүлбэрийг төлөөлнө.

ДҮГНЭЛТ

Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрийн утгыг үгүйсгэх хэв шинжүүдийг судлах хүрээнд олон хэлний хэв шинжийн судлал дахь төлөөлөх хэлбэр буюу **pro-form** ойлголтыг авч үзээд дараах дүгнэлтэд хүрэв.

- Өгүүлбэр, өгүүлэмжийн (discourse) түвшинд илэрдэг төлөөлөх хэлбэр (pro-form) нь орчин цагийн монгол хэлнээ хангалттай судлагдаагүй байна. Иймд энэ чиглэлээр судалгаа хийх зайлшгүй шаардлага байна.

- Төлөөлөх хэлбэрийн олон төрлийг бид онолын хэсэгт өгүүлсэн ба эл судалгааны зорилго зөвхөн үгүйсгэх утгатай өгүүлбэрт хандсан тул батлах, асуух зэрэг бусад өгүүлбэрийн төрлийг авч үзсэнгүй. Бид монгол хэлэнд үгүйсгэх өгүүлбэрийн үндсэн хоёр төлөөлөх хэлбэр байна хэмээн үзэж байна.

- 1) Үгүйсгэгч үгүйсгэх өгүүлбэрийн үйлийн бүлгийг төлөөлөх хэлбэр (pro-verb)

- 2) Үгүйсгэгч болон үгүйсгэх утга бүхий бусад илэрхийллүүд үгүйсгэх өгүүлбэрийг төлөөлөх хэлбэр (pro-clause, pro-sentence)

- Эрдэмтэн судлаач Б. Пүрэв-Очирын жинхэнэ бус аялга үг өгүүлбэрийг хоёр ба нэг бүрэлдэхүүнт өгүүлбэрийн аль алинд нь оруулалгүй бүтцийн тусгай хэв маяг болгон үзэх гэсэнтэй санал нийлж байна.

- Бид орчин цагийн монгол хэлний үгүүлбэр үг (Ш. Лувсанвандан, 2000), *жинхэнэ ба жинхэнэ бус аялга үг-өгүүлбэр* (М. Базаррагчаа 1987, Б. Пүрэв-Очир 2001) нь өгүүлбэрийг төлөөлөх хэлбэр буюу pro-sentence мөн хэмээн үзэж байна. Үүнээс үүдэн бид үүнийг олон хэлний хэв шинжийн судлалд хүлээн зөвшөөрөгдсөн төлөөлөх өгүүлбэр (pro-sentence) хэмээх нэр томъёогоор нь нэрлэх санал дэвшүүлж байна.

Resume. Pro-sentences are words like English *yes* and *no*, which are used in answering questions, and which are understood as equivalent to affirmative and negative sentences respectively. In the article were considered pro-forms of negative sentences in modern Mongolian.

Номзүй

Базаррагчаа М (1987) Монгол хэлний өгүүлбэр, УБ

Бат-Ирээдүй Ж (2009) Монгол хэлний үгүйсгэх харьцаа ба түүний илрэх

хэлбэрүүд. “Area and Culture Studies”, Tokyo University of Foreign Studies, №78, 2-13

Бямбасан П. (2006) Монгол хэлний онол, бүтцийн асуудалд, УБ

Гантогтох Г (1987) Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулал, ШУА, ХЗХ, УБ

Лувсанвандан Ш (2000) Монгол хэлний үгүүлбэрзүйн асуудлууд, гутгаар дэвтэр, УБ

Төмөртоого Д. ба бусад (2004) Орчин цагийн монгол хэл, ред Ү. Ариунболд, УБ

Пүрэв-Очир Б (2001) Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй I, УБ

Пүрэв-Очир Б. (1998) Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй II, УБ

Giuliano Bernini, Paolo Ramat (1996) *Negative Sentences in the Languages of Europe: A Typological Approach*. Mouton de Gruyter, Berlin/New York, 89-90

Hadumod Bussmann (1998), *Routledge Dictionary of Language and Linguistics*, London&New York

Jack C. Richards, Richard Schmidt (2002) *Longman dictionary of language teaching and applied linguistics*

Jackendoff R.S. (1972) *Semantic interpretation in Generative Grammar*, Cambridge

Noam Chomsky (1988) *The lectures on Government and binding*, Foris Publications Holland

Paul Schachter (1978) English proprecates. *Linguistic Analysis* 4, 187–224.

Timothy Shopen (2007) *Language typology and Syntactic description*, Volume I: Clause structure, second edition, Cambridge University press

Wonsoo Yu (1991) *A study of Mongolian Negation*, Indiana University

Pitch patterns of Mongolian compound place names

Naoki UETA*

1. Introduction

Mongolian accent is not distinctive in relation to meaning. With respect to Mongolian accent, not a few researches have been carried out, including studies which claim that Mongolian has stress accent (Hangin 1968), pitch accent (Kakudo 1982) and both of them (Ozawa 1994). In recent research Karlsson (2005) clarified the pitch patterns of Khalkha Mongolian, taking the position that Mongolian has no lexical stress.

However, the accent of compound words in Mongolian has not been clarified well so far. In this study, pitch patterns of Mongolian compound place names which consist of two words, such as *ulaan-baatar* and *bör-nür*, are analyzed, and it is clarified that 1) most compound place names are pronounced not as two words but as a single phonological word, 2) in general the word accent of the first element is preserved and that of the second element disappears, and 3) in some words, the number of syllables, vowel length and syllable structure are related to the pitch pattern.

2. Previous researches

2.1. Kakudo (1982)

Kakudo (1982) describes Khalkha Mongolian accent with 'pitch units', which are defined as (C)V (V is a short vowel; long vowels and diphthongs are analyzed as VV).

- (1) PP = HL, PPP = LHL, PPPP = LHHL, PPPPP = LHHHL ...
(P = pitch unit, L = low pitch, H = high pitch)

With respect to the accent of compound words, he pointed out that the accent of compound words is not straightforward as can be seen below.

- (2) a. *ulaanbaatar* ('Ulaanbaatar' < *ulaan* 'red' + *baatar* 'hero')
u|laanbaa|ta|r, u|laan|baatar, u|laan|ba|ta|r. (there are 3 patterns)
(2) b. *uls tör* 'government' (< *uls* 'state' + *tör* 'administration')
u|l s t ö |r (pronounced with only one pitch peak, that is to say, as one word)
c. *tsagaan tölgoi* 'alphabet' (< *tsagaan* 'white' + *tölgoi* 'head')
tsa|ga|an töl|go|i or tsa|ga|an töl|go|i (not pronounced as one word)

Kakudo (1982) shows that whether a compound word has two pitch peaks or only one peak seems to be related to the length of the first element of the compound word.

2.2. Ichinose (1992)

Ichinose (1992) deals with the accent of compound words in the Chakhar dialect. According to Ichinose (1992), in general the accent of the first element is preserved in compound words, but in compound words which consist of a monosyllable word and a word with a long vowel, the accent of the second element can be preserved and the accent pattern is different from that of non-compound noun phrase.

- (3) *göx* 'blue' + *nür* 'lake'
a. ,göx "nür (place name)...compound word
b. "göx ,nür 'blue lake'...noun phrase (Ichinose 1992: 110 (5) (5'))

2.3. Karlsson (2005)

In Karlsson (2005), word accent and intonation in Khalkha Mongolian are analyzed in the framework of Autosegmental Theory. The word accent is a rising (LH) tone aligned with the first two morae of the word. The

*Kyoto University /JSPS/ National University of Mongolia

first L tone often disappears in monosyllabic words and polysyllabic words with a long vowel in the initial syllable. Word accent is downstepped.

However, Karlsson (2005) shows, by referring to the following examples, that the accent of compound words is controversial and further research is needed on it.

- (4) a. *galt tereg* ‘train’ (< *galt* ‘fire’ + *tereg* ‘car’)
 ...one LH contour = single phonological word
 b. *ulaanbaatar* ‘Ulaanbaatar’ (< *ulaan* ‘red’ + *baatar* ‘hero’)
 ...two LH contours = two phonological words
 c. *enx taiwanii* ‘peaceful’ (< *enx* ‘peaceful’ + *taiwan* ‘peace’ + *ii* <genitive>)
 ...different from speaker to speaker

3. Pitch patterns of compound place names

3.1. Why place names?

Whether a sequence of words form a compound word or not should be determined synthetically from morphological, syntactic, semantic and phonological viewpoints. Syntactically, for example, another word is never inserted between two elements of a compound word. Since the purpose of this study is to clarify the pitch pattern of compound words, the words used in this study should be absolute compound words from all viewpoints. Place names can be regarded as compound words from all points of view

3.2. The place names used in the survey

The compound place names used in this survey were selected by focusing on the number of syllables of each element (monosyllable or bisyllable), and on whether each element has a long vowel or a diphthong (henceforth “long vowel” includes diphthongs) or not. The structures of the compound place names in this study and their respective numbers are shown in Table 1.

Table 1: The structures of the compound place names in this study and their respective numbers

			the second element			
		no. of syll	monosyllable		bisyllable	
	no. of syll	long vowel	with	without	with	without
the first element	monosyllable	with	0※	2	3	3
		without	3	3	6	3
	bisyllable	with	4	3	9	3
		without	3	3	6	3

(※There are no place names with this structure.)

Total: 57 words

3.3. The methodology of the survey and the informants

The survey was carried out by having informants read compound place names inserted into the following carrier sentence.

- (5) Ter ____ gedeg sUmaas irsen. ‘He came from the town of ____.’

The sentences were recorded and the pitch patterns were analyzed with *praat* (Boersma and Weenik 2012). In this study, only the pitch contour was focused on and the absolute value of F0 was not paid attention to.

The data was provided by two speakers of Khalkha Mongolian (T and P).

T...female, 29 years old, birth place: Ulaanbaatar

P...female, 21 years old, birth place: Rashaant (about 200 km from Ulaanbaatar)

4. Results

4.1. [monosyllable word - monosyllable word]

The compound place names composed of two monosyllable words can be further classified into 3 types in relation to vowel length, as below.

- (6) (a word with a long vowel) + (a word with a short vowel) = L-S structure
 (a word with a short vowel) + (a word with a long vowel) = S-L structure
 (a word with a short vowel) + (a word with a short vowel) = S-S structure

The pitch patterns of each structure are shown in (7).

- (7) L-S structure (e.g. sain-shand, zuun-mod): H-L
 S-L structure: two patterns were seen
 bör-nᠥᠭᠦᠷ, ix-ᠥᠭᠤᠯ: L-H / mönx-xaan: H-L
 S-S structure (e.g. xan-bogd, shine-jinst): H-L

The compound place names with an S-L structure are problematic. Figure 1 and Figure 2 show the pitch patterns of bör-nᠥᠭᠦᠷ and mönx-xaan, respectively, spoken by informant P.

Figure 1: pitch contour of bör-nᠥᠭᠦᠷ (written as bor-nuur in the figure)





Figure 2: pitch contour of mönx-xaan



The difference in phonological structure between mönx-xaan, which is pronounced with H-L pitch, and bör-nᠥᠭᠦᠷ and ix-ᠥᠭᠤᠯ, which have L-H pitch, is that the former has a super-heavy syllable (CVCC) in the first element but the latter do not. It may be said that super-heavy syllables can attract H pitch.


4.2. [monosyllable word - bisyllable word]

4.2.1. When the first element has a long vowel

In this case, the first element is consistently pronounced with higher pitch than the second element.

It is important to note that no second pitch peak appears in the second element in most compound place names. In other words, the second element has usually lost its own accent and the sequence of two words is pronounced with a single pitch peak, that is, as a single phonological word.

Figure 3: pitch contour of sain-tsagaan (informant T)



4.2.2. When the first element has a short vowel

In this case, the results are different depending on whether the second element has a long vowel or not. When the second element has no long vowel, the word sequences are always pronounced with a H-LL pitch contour. On the other hand, when the second element has a long vowel, there are several pitch patterns.

(8) no long vowel: H-LL (e.g. böx-mörön, xan-xəngəl)

with a long vowel: mönx-xairxan, xar-airag, tsəgt-owoo = H-LL /

sux-baatar = L-HL / bat-ölzii = L-HH (or gradually upstepped)

Figure 4: pitch contour of tsəgt-owoo (written as tsogt-owoo in the figure)





Figure 5: pitch contour of sux-baatar



If there is a long vowel in the second element, the second element can be pronounced with higher pitch than the first one. It seems that the long vowel can attract H pitch.

However, there are also compound words with the opposite pitch contour, i.e. the first element is pronounced with higher pitch than the second one. As far as this investigation is concerned, it can be said that when the first word consists of a super-heavy syllable (CVCC), it always attracts a high pitch, which is parallel to the result of *mōnx-xaan* (H-L) as shown in 4.1, although the reverse is not true.

The discussion so far can be summarized as follows:

- (9) When the first element is a monosyllable word,
- a. in general, the first element has high pitch and the second element has low pitch,
 - b. the second element can attract high pitch if the second element has a long vowel,
 - c. (but) a super-heavy syllable, or CVCC in the first element gets high pitch, even if the second element has a long vowel.

(9a) and (9b) constitute the same result as that of Ichinose (1992). (9c) suggests the possibility that the location of accent is related to syllable structure.

4.3. [bisyllable word - monosyllable word]

These compound place names are consistently pronounced with a LH-L pitch contour without regard to whether a long vowel is present or not, except for two examples. This means that most of them are pronounced as a single phonological word and the pronunciation is the same as that of a simplex word, in which LH is aligned with the first two morae. The two exceptions are as follows:

- (10) *ider-meg*: pronounced with overall rising pitch

orxon-tuul: LH-H in informant T, which is not one but two phonological words

4.4. [bisyllable word - bisyllable word]

These compound place names are consistently pronounced with a LH-LL pitch contour regardless of whether a long vowel is present or not. This is also the pitch pattern of a single phonological word. When the first syllable of the first element has a long vowel, it is pronounced with H pitch. This corresponds to the claim in Karlsson (2005) that the first L tone often disappears in polysyllabic words with a long vowel in the initial syllable.

5. Summary

The conclusions of this study are as follows:

- 1) In most compound place names, the pitch peak in the second element usually disappears and as a result they are pronounced as a single phonological word.
- 2) The basic pitch patterns of compound place names are as follows:
 - i) If the first element is a bisyllable word, a rising pitch (LH) appears in the first element and the pitch peak is on the second vowel of the first element. The second element has lower pitch as a whole than the first element.
 - ii) If the first element is a monosyllable word, the pitch peak is on the vowel of the first element and the second element has lower pitch as a whole than the first element unless the second element has a long vowel.
 - iii) If the first element is a monosyllable word and the second element has a long vowel, the pitch peak tends to be on the long vowel in the second element, probably because the long vowel can attract H pitch.
 - iv) Even if the second element has a long vowel, a super-heavy syllable (CVCC) in the first element can attract H pitch instead of the long vowel.
- 3) (As can be concluded from 2,) the number of syllables, vowel length and syllable structure are related to the pitch pattern of compound place names.

Reference

- Boersma, Paul and David Weenink (2012) *Praat: Doing phonetics by computer* (Version 5.3.23). Online: <http://www.praat.org/>.
- Hangin, John G. (1968) *Basic Course in Mongolian*, Indiana University Press.
- Ichinose, Megumi (1992) 'Mongorugo no fukugougo no on-inteki tokuchou' [Phonemic characteristics of compound words in Mongolian], *Hoppou bunka kenkyuu (Bulletin of the Institute for the study of North Eurasian cultures)* 21, pp. 105-119.
- Kakudo, Masayoshi (1982) 'Haruha Mongorugo no pitchi akusento' [Pitch Accent in Khalkha Mongolian], *Osaka gaikokugo daigaku gakuhou (Journal of Osaka University of foreign studies)* 56, pp. 31-49.
- Karlsson, Anastasia Muhanova (2005) *Rhythm and Intonation in Halh Mongolian*, Lund University.
- Ozawa, shigeo (1994) *Zouho Mongorugo yonshuukan [4-week Mongolian, enlargement]*, Daigaku shorin.

Key words: Khalkha Mongolian, compound place names, pitch pattern, phonological word, word structure

**МОНГОЛ ХЭЛНИЙ -Ч ДЭД БҮТЭЭВРИЙН ОНЦЛОГ,
НАЙРУУЛГЫН ҮҮРЭГ**

*М.Энхжаргал**

1. Оршил

Үг нь тогтсон нэг утгатай байхаас гадна нийгмийн хөгжлийн өөрчлөлтийг даган хувирч өөрчлөгдсөөр иржээ. Ийнхүү хэлний хөгжил, хэрэглээний явцад салбар салаа утгатай болдог байна. Тухайн үгийн утгын өөр нэгэн зүйлийн шинж чанартай харьцуулан зүйрлэх журмаар утгыг шилжүүлж, үгийн олон хувилбарыг үүсгэж, үгийн утгыг салбарлуулан хөгжүүлж болно. Үг олон салаа утгатай болсон ч үндсэн утгатайгаа дам холбоотой байдаг. Энэ утгын холбоо холдож, үндсэн утгаасаа өөр утгатай болбол үгийн сангийн нэгэн шинэ нэгж болдог билээ.

Орчин цагийн монгол хэлэнд үг бүтэх олон арга байдаг бөгөөд үндсэн аргын нэг нь “Дагаврын аргаар үг бүтэх ёс” юм. Энэ нь үгийн язгуур үндсэнд үг бүтээх дагавар залгаж шинэ үг бүтэх аргыг хэлдэг. Гэтэл хэлний энэ зүй тогтлыг зөрчиж, тухайн язгуур үндсэнд дагавар нэмэн залгавч шинэ утга бүхий үг бүтээхгүй байгаа сонирхолтой үзэгдэл ажиглагдаж байна.

Үг зүй буюу бүтээврийн түвшинд үүнийг “Субморф” буюу “Дэд бүтээвэр” (дийлэнх олны нэрлэснээр) хэмээн нэрлэдэг. Жишээ нь: дамнуур/га, хэмжүүр/гэ, горьдол/го, шив/г/нэх, ноор/н/хой, цоор/н/хой, гудам/ж, инээд/м, зээл/лэг, татаа/с/тай, хүлээ/с, дараа/с, ялгамж/аа, нис/гэ/гч, дуус/га/вар, эрмэлз/л/эл зэргээр эдгээр үгсэд дагавар, оруулбар бүтээвэр нэмэвч утга үл ялгах нь ажиглагдаж байна.

Ер нь дэд нэгж гэдэг нь маш өргөн хүрээтэй ойлголт бөгөөд бүхий л салбар шинжлэх ухаанд хэрэглэгдэнэ. Тухайлбал: Дэд бүтэц, дэд хурандаа, УИХ-ийн дэд дарга, дэд профессор гэх мэт. Харин хэл шинжлэлд дэд аялгуу, дэд өргөлт, дэд утга гэх зэрэг олон ойлголт байдгийн нэг нь энэхүү бидний авч үзсэн “Дэд бүтээвэр” хэмээх ойлголт юм. Дэд бүтээврийн талаар Оросын эрдэмтдээс Н.М.Шанский, В.Г.Чурганова, Е.А.Земская, Д.С.Ворт, Е.С.Кубрякова, В.В.Лопатин, Г.О.Винокур, А.И.Моисеев зэрэг эрдэмтэд судлан, үг бүтэх ёсны тухай зохиол бүтээлүүддээ дурдсан байдаг. Монгол хэлний дэд бүтээврийг тусгайлан судалсан бүтээл ховор бөгөөд энэ тухай өөрсдийн санал дүгнэлтийг монголын судлаачдаас М.Базаррагчаа, Ш.Туяа, Б.Идэрбаяр, оросын монгол судлаачдаас Г.Ц.Пюрбеев нарын эрдэмтэд дэвшүүлсэн байдаг.

2. Хэлэн дэх дэд нэгжийн тухай

Хүн төрөлхтний хэл нь олон тооны нэгж хэсгүүдээс бүрдэх бөгөөд тэдгээр нь нарийн зүй тогтлоор холбогдож, бүхэл бүтэн дохионы тогтолцоо үүсгэдэг. Хэлний нэгжүүд нь нэг нь нөгөөтэйгөө эсрэгцэхийн зэрэгцээгээр бие биеэ нөхсөн, давхарласан, шаталсан тогтолцоотой. Хэлний тогтолцоог хэлний нэгжүүд, тэдгээрийн үүрэг, шинж дээр тулгуурлаж агуулгын түвшин, хэлбэрийн түвшин, үндсэн түвшин, завсрын түвшин гэх мэтээр ангилдаг.¹

Нэгжүүд нь хийсвэр ба бодитой шинжээр илрэх бөгөөд хийсвэр шинж нь хэл (язык), бодит шинж нь хэлэхүй (речи) болно. Түвшин бүр нэгжээр илрэх бөгөөд авиа судлалын үндсэн нэгж нь авиа, авиалбар; бүтээвэр судлалын түвшний үндсэн нэгж нь бүтээвэр, бүтээврийн хувилбар; үг судлалын үндсэн нэгж нь үг, үглэвэр; өгүүлбэр судлалын үндсэн нэгж нь өгүүлбэр, үглэбэр; эх судлалын түвшний үндсэн нэгж нь цогц, цогцолбор хоёр болно. Ийнхүү хэлний түвшин бүр үндсэн нэгжээр илрэхээс гадна “дэд нэгж”-ээр илэрдэг.

Чой.Лувсанжавын боловсруулсан “Хэл шинжлэлийн нэр томьёоны толь” (орос-монгол, монгол-орос)-ийн “Дэд” гэсэн толгойн монгол хэсэгт доорх нэр томьёог оруулжээ. Үүнд: Дэд- под, про, суб:

- дэд аялгуу, салбар аялгуу - (поддиалоги, подналичие)
- дэд байдал, салбар байдал- (подвид)
- дэд бүлэг, салбар бүлэг (подгруппа)
- дэд давхарга- прослойка

*МУБИС-ийн Багшийн сургуулийн багш, докторант

¹Ц.Өнөрбаян. “Орчин цагийн монгол хэлний үг зүй” УБ., 2004, 3 дахь тал

- дэд нийлц- субсинтагма
- дэд өргөлт- второстепенное, узарение
- дэд утга- побочное значение
- дэд хэлбэр- побочная форма
- дэд эс тухайлах төлөв (орлох эс тухайлах төлөв) –проинфинитив (Чой.Лувсанжав,

УБ.,1964, 205-206 дахь тал) гэсэн 11 толгой үг бүхий жишээ авчээ. Уг толийн орос хэсгийн “Суб” толгойн үгэнд сублатив –верхнеприблизительной падеж (дээшлэх тийн ялгал), субсинтагма –дэд нийлц, субстрат-түрэн цуцах хэл гэх мэтийн 12 толгой үг орсон байна (Чой.Лувсанжав, УБ, 1964.,146 дахь тал).

3. Дэд бүтээврийг судалсан нь

Дэд бүтээврийг судалсан байдлыг ажиглахад орос хэлний судалгаа нь монгол хэлийг бодвол илүү гүнзгий, ахисан шатанд байна. Орос хэлэнд дэд бүтээврийн талаар өгүүлсэн бүтээлүүдийн хэвлэгдсэн байдлыг ажиглахад 1967 оноос энэ талын судалгаа эхэлсэн байна. “Дэд бүтээвэр”-ийн тухай бие даасан ном бүтээл гараагүй боловч орос хэлний үг бүтэх ёс, утга зүйн ном зохиолд асуудал дэвшүүлэн дурдсан, илтгэл, өгүүлэл болгон оруулсан зүйл цөөнгүй байна.

Оросын эрдэмтэн В.Г.Чурганова² 1967 онд хэвлүүлсэн нэгэн өгүүлэлдээ дэд бүтээврийн шинжтэй хэлний үзэгдлийг “бүтээвэр-авиалбарзүйн ялгаварт хэсэг” гэж нэрлэжээ. Жишээ нь зубец, чепец гэх мэт үг нь –ец, -ц гэсэн багасгасан утгатай дэд бүтээврийг авч зубчик, чепчик (бяцхан шүд, бяцхан оройвч) гэсэн үгсийг бүтээж байна гэжээ.

Орос хэлний бүтээвэр судлаач Е.А.Земская³ “Авианы бүтцээр ба янз бүрийн сэлгэцээр тухайн бүтээврээс ялгарч байвч утгын ялгаа гаргахгүй байгаа тийм хэсгийг дэд бүтээвэр (субморф) гэнэ. Дэд бүтээврийг өгүүлбэрийн бүтцээс ялгах нь чухал. Учир нь дэд бүтээвэр нь үг бүтэх ёсонд (словообразовательное поведение) нөлөөлдөг” гээд ларь-ларец, сын-сынок, нож-ножик гэх мэт үгэнд орсон –ец, -ок, -ик гэсэн дагаврууд нь үндэс үүсгэхэд оролцож байна. Харин чепец-чепчик, чулок-чулочек, колпак-колпачок зэрэг үгсэд орсон –ик, -ок дагаврыг үндэс бүтээхэд оролцож байгаа дэд бүтээвэр хэмээн ялгажээ.

Д.С.Ворт⁴ Олон улсын хуралд тавьсан нэгэн илтгэлдээ: “Бидний бодоход одоогийн бүтээврийн бүтэх хэсэгт олон ойлголт багтдаг. Үүнд: бүтээврийн хэсгүүд, авиалбарзүйн хэлбэртэй байх, утгын агуулгагүй бүтээвэр гэх мэт” гэжээ. Эдгээрээс “Утгын агуулгагүй бүтээвэр” гэдэг нь дэд бүтээврийн тухай дурджээ.

Дэд бүтээврийн тухай Оросын эрдэмтэд судалгааны ном, бүтээлүүддээ дээрх маягаар үзсэн бол О.С.Ахмановгийн тайлбар толийн 460-р талд: “Субморфемный” (анг.submorphemic) гэсэн үгийг “Не дифференцированный на уровне морфем” буюу “бүтээврийн түвшинд утга үл ялгах бүтээвэр”⁵ хэмээн тайлбарласан байна.

Монгол хэлэн дэх дэд бүтээврийг тусгайлан судалсан судалгаа ховор бөгөөд М.Базаррагчаа монгол хэлний гарал судлалын нэгэн бүтээлийнхээ “Га...хэмээх үе-утгалбар” гэсэн өгүүлэлдээ га... үе-утгалбарын хийсвэр шинжийг тоочжээ.

Доктор Ш.Туяа⁶ “Хэлбэрээрээ бүтээвэртэй адил боловч бүтээвэр биш үүсмэл үгийн хэсгүүдийг хуурмаг бүтээвэр (квазиморфемы) буюу гол бус бүтээвэр (субморфемы) гэж нэрлэх нь бий гээд суб-аренда, нем-ец зэрэг жишээг дурджээ”

Б.Идэрбаяр⁷ “Төсөөт үгийг ойролцоо үг болон хувилбараас ялгах хэрэгтэй боловч энэ нь тийм ч хялбар зүйл биш юм. Жишээ нь: ая~уя, ховил~ говил, гүн~ гүнзгий, уудам~ уужуу гэхэд ихэвчлэн авиа болон бүтээврийн сэлгэцээр үүссэн боловч утга нь төдий л ялгараагүй тул нэрлэвэр (номема), илэрхийлбэр (сомема)-ийн хувилбар болно. Ийм хувилбарыг авианы болон утгын холбогдол бүхий сэлгэц хэмээн үзсэн байдаг. Ийм хувилбар нь зөвхөн утга салаалахаас үүсэх төдийгүй бүтээврээр илрэх нь буй. Жишээ нь: дурын бүтээвэр буюу дэд бүтээвэр (субморф) нь тухайн нэг үед нэмэлт бүтээвэр болж, найруулгын ялгаа бүтээх шинжтэй байдаг. Монгол хэлний дайта-дайла, эгүрид-абурид, бөгж- бөлжиг гэх мэтээр авиа-утгалбар, үе-утгалбар сэлгэн үглэврийн хувилбар үүсгэжээ. Мөн гөжүү-гөжүүд, гажуу-гажууд, зөрүү-зөрүүд, үхлүү-үхлүүт, хол-холхи гэх мэтээр аль нэг бүтээвэр нэмж орсон ч уул үгээсээ утгын хувьд төдий л үл ялгарах ажээ. Иймд эдгээрийг дэд бүтээврээр үүссэн хувилбар гэж болно” гэжээ.

Монгол судлаач, доктор Г.Ц.Пюрбеев монгол хэлэн дэх дэд бүтээвэр илрэх сонирхолтой үзэгдлийг ажиглан тайлбар, зүүлт хийсэн байна.⁸ Тэрээр дэд бүтээвэр бүхий үгсийг “нэг үндэст ойролцоо нэр” хэмээн

² В.Г.Чурганова “О предмете и понятиях фонемологии”, Известия АН СССР. Серия литературы и языка.4.1967. стр.366-367.

³ Е.А.Земская “Современный русский язык”, М.,стр.81-82.

⁴ Д.С.Ворт “Морфология славянского словообразования”, American contributions to the VII International congress of Slavists I.The Hague, 1973., p.387.

⁵ О.С.Ахманова “Словарь лингвистических терминов”, М., 1969, стр.460.

⁶ Ш.Туяа “Үг бүтэхүйн утга зүй”, УБ., 2005, 28 тал

⁷ Б.Идэрбаяр “Монгол хэлний төсөөт үг” .УБ, 2005. 14 тал

⁸ Г.Ц.Пюрбеев “Об одном типе синонимов в современной монгольской терминологии”, ШУА, ХЗХ “Нэр томьёо судлал”, УБ.,

нэрлэсэн юм. Үүнд: “Ойролцоо нэр нь утгын янз бүрийн бүтэцтэй, бүтээвэрзүйн хувьд өөр хоорондоо ямар нэгэн холбоогүй тохиолдохоос гадна (Жишээ нь: дэлхий, ертөнц, орчлон, бөмбөрцөг, хорвоо) утгын харьцааны нэг хэлбэрийн үр дүнд үүссэн, нэг үндэстэй, залгавар залгаж бүтсэн шинжтэйгээр тохиолдоно. Ийм нэгдмэл хэв шинжит ойролцоо нэрийг «Нэг үндэст үг» гэдэг бөгөөд монгол хэлэнд элбэг тохиолдоно гээд тэрээр хөшүүр-хөшүүрэг, хэмжүүр-хэмжүүргэ, холио-холиос, хольц-хольцоо, шахуур-шахуурга, дамжуур-дамжуурга, дамнуур-дамнуурга, хориглол-хориглолт, дэшил-дэвшилт, урвал-урвалт зэрэг дэд бүтээвэрээр дам үүссэн үгийг жишээ болгон тайлбарлажээ. Тухайлбал: Урвал-урвалт (1. Эргэх, өөрчлөгдөх эргэх буцах, 2. Урвах) дагаврын хослолоор үүссэн энэ хоёр үгс нь “Урвах гэсэн үйл үндсээс үүссэн бөгөөд урвал буюу 1-р хэлбэрт нь өөр байдалд шилжих гэсэн утгаас гадна химийн урвал гэж утга байгаа. Харин урвалт буюу 2-р хэлбэр нь эргэлт, гэсэн утгатайгаас гадна улс төрийн нэр томьёо” болон хэрэглэгдэнэ. Мөн -уур, -уурга гэсэн дагавар нь хоёулаа багаж зэвсэг болон үйлийн үр дүнгийн ерөнхий утга илтгэдгээрээ нэгддэг. Шахуур-шахуурга гэсэн үг нь дээр өгөгдсөн утгын дагуу утга илтгэх бөгөөд харьцуулахад шахуурга нь шахуураасаа хэрэглэгдэх хүрээ нь илүү өргөн. Шахуур нь шахуургынхаа анхдагч хэлбэр нь юм. Дамнуур-дамнуурга хоёрыг харьцуулахад дамнуур нь илүү өргөн утга зааж байхад дамнуургын илтгэх утга нь илүү нарийссан шинжтэй байна” гэх мэтээр өгүүлээд хэд хэдэн оновчтой, сонирхолтой дүгнэлтийг хийжээ.

4. Монгол хэлэнд дэд бүтээвэр илрэх нь

Монгол хэлэнд дэд бүтээвэр -га⁴, -с, -м, -ж, -ч, -р, -аа⁴, -ц, -н, -т, -д, -вч зэрэг дагавар болон оруулбаруудаар илэрч байна. Илрэх хэмжээний хувьд -га⁴, -с нь бусад дагавраа бодвол илүү их хэрэглэгдэж байна. Зөвхөн энэ хоёр дагаврын хувьд гэхэд 200 орчим үгийн жишээ байна.

Эдгээр дэд бүтээврийг авч чадахуйц үгс нь дараах утгын дор нэгдэж байна. Үүнд: Үйлийн үр дүн заасан бодит утга (тавил/га, олз/го, шаваа/с, эвхээ/с, зураа/с, нэхээ/с), уул үйлийн хэрэглэгдэхүүн (хулдаа/с, үдээ/с, нөхөө/с, хадаа/с, хүлээ/с), багаж зэвсгийн утга (таглаа/с, бөглөө/с, аргамжаа/с, нэмнээ/с тушаа/с), үйлийг байнга буюу түр эрхлэгч (засуул/ч, манаа/ч, туршуул/ч, тагнуул/ч, хэсүүл/ч, хулгай/ч) сэтгэл хөдлөл, сэтгэхүйн үйлдлийг заасан үйл үгийн үндсэнд зарим дэд бүтээврийг залгаж сэтгэхүйн үйлдэл, зан төлөвийн шинж тэмдэг заасан хийсвэр утгатай нэр (гэмшил/гэ, завдал/га, харгалзал/га, албадал/га, хүсэл/н), нийгмийн болон бусад үйл явцад гарч байгаа хувирал өөрчлөлтийн нэрийн дагуу тийм нэр бүтээнэ (хувьс/га/ал), үйлийн хэмжээ заасан утга (баглаа/с, ор/м, хэр/м, алд/м) гэх мэтийн утгууд үүсч байна.

5. Монгол хэлний -ч дэд бүтээврийн утга, үүрэг, найруулгын онцлог

Бид энэхүү өгүүллийн хүрээнд Монгол хэлний дэд -ч бүтээвэр бүхий үгсийн илрэх хэлбэр, онцлогийг хэрэглээ, найруулгын талаас нь тайлбарлахыг оролдсон бөгөөд уран зохиолын жишээгээр харьцуулан үзүүлсэн болно. Уг -ч бүтээврийн талаар эрдэмтэд дараах байдлаар үзжээ.

П.Бямбасан⁹ “-ч, -чин хоёр дагавар нь адил утга илэрхийлэх боловч -чин нь малчин, тариачин, үсчин, гуталчин, зурагчин гэх мэтээр жинхэнэ эрхэлсэн ажил мэргэжлийн нэр бүтээх ба хувилбар болох -ч дагавар залгахад уг ажилд дадал зүтгэлтэйг илэрхийлсэн нэр бүтнэ. Үүнд: дууч-н, сэтгүүлч-н, ажилч-н, төлөгч, залуурч, жолооч, эмч, номч” хэмээн -ч, -чин дагаврын илтгэх утгын бяцхан ялгааг тайлбарлажээ.

Энэхүү -ч дагаврыг залгавч утга үл нэмэх энэ сонирхолтой үзэгдлийг Ш.Туяа¹⁰ ажиглан “Уул үндсэнд -л, -уул, -үүл, -аа дагавар залгаж тухайн үйлийг байнга буюу түр эрхэлдэг хүнийг заасан утгатай нэр бүтээнэ. Жишээ нь: захирал, засуул, сахиул, тагнуул, хайгуул, манаач. Эдгээр үүсмэл үг нь -ч дагаврыг давхар авах тохиолдол байдаг, гэхдээ утга нь өөрчлөгддөггүй: засуулч, хайгуулч, манаач. Ингэхлээр -уулч, -үүлч гэсэн нийлмэл дагавар нь -аач⁴ дагавартай ойролцоо утгатай юм” гэж үзсэн нь бидний дэд бүтээврийн судалгаатай зайлшгүй холбогдож байгаа юм.

Утга судлаач Д.Бадамдорж¹¹ үүсгэх утгаар нь -ч дагаврыг 6, -чин дагаврыг 8 ангилжээ. Үүнд, бидний дэд бүтээвэр бүхий үгсийг ямар ангилалд хамаатуулсныг үзвэл

“манаач гэдэг нь ажил мэргэжилтэй хүнийг илтгэх утга, сүүлч гэсэн үг нь дараах, доод үеийн хэмээх утга, тэнүүлч, хулгайч гэсэн үг нь муу үйлд зуршсан хүнийг илтгэх утга илтгэнэ” гэжээ.

Л.Болд¹² “-уул² дагавар нь ажил мэргэжлийн нэр заасан нэр үг үүсгэнэ. Тэнүүл, эрчүүл, хайгуул, туршуул нь тухайн үйлийн явц, байдлыг харуулсан нэр үг үүсгэнэ. Ингэж үүссэн үгийн утгыг нягтлан үзвэл эхлээд тухайн үйл үйлдэгчийг заасан нэр үг байснаа утгын талаар баяжин өөрчлөгдөж тухайн үйлийн буюу тухайн үйлийг хийгч хүнээс өөр зүйлийг заасан нэр үг үүсгэсэн байна. Тухайлбал: “дагуул” гэхэд эхлээд дагах үйлийг гүйцэтгэгчийг заасан үг байснаа хожим дагадаг юм гэсэн утгатай болсон байх. Жишээ нь: “хиймэл дагуул” гэсэн саналыг дагавал доорх шатлалыг үүсгэж болно. -Уул/-үүл дагаврын “-ч”-тэй, “-ч” –

2006, 60-68 тал

⁹ П.Бямбасан “ОЦМХ-ний үгийн бүтэц, нэр үгийн аймаг”, Уб., 1975, 27 дахь тал.

¹⁰ Ш.Туяа “Үг бүтэхүйн утга зүй”, Уб, 2005, 44-45 дахь тал.

¹¹ Д.Бадамдорж “Монгол хэлний утга судлал”, I дэвтэр, Уб., 2001, 70 дахь тал.

¹² Л.Болд “ОЦМХ-ний дагавар”, Уб., 1986, 80-82 тал.

гүй хэлэгддэг тухай Ш.Сэцэнцогт¹³ тайлбарлахдаа эдгээр үгс нь үйлийг зааж байх үед “-ч” дагаврыг залгаж үйлийн эзэн ба үйлийн гүйцэтгэгчийг зааж байв. Дараа нь -уул/-үүл нь үйлийн эзэн ба гүйцэтгэгчийг заах болсны дараа “-ч”, “-чин”, “-су”, “-сун” дагаврууд нь үүргээ алдсан байна. Үүнд: харуул, цагдуул, мануул, хэвтүүл, эргүүл, тагнуул, засуул, бүгдүүл гэх мэт.

Монгол хэлэнд -ч бүтээврийг нэмэвч тухайн үгнээ шинээр утга нэмэхгүй, найруулгын өнгө аясын бага сага утга ялгаж байгаа зарим үг байна. Эдгээрийг -ч дэд бүтээвэр бүхий үгс гэж нэрлэлээ. Үүнд: засуул-засуулч, хэсүүл-хэсүүлч, манаа-манаач, сахиул-сахиулч, тагнуул-тагнуулч, сүүл-сүүлч, хулгай-хулгайч, тонуул-тонуулч гэх мэт. Эдгээр үгс нь аливаа үйлийг түр болон байнга эзэмшигчийн утгыг голдуу илэрхийлнэ. Жишээ нь: “Сүүлийн давааны хоёр бөх бараа бараагаа харсан ормол буур шиг дэвэн дэвж, дэгдэн дэвхэрч засуулаа тойрно” (С.Д.69) болон “Наадмын талбай буюу Яармагийн бөхийн талбар дүүрэн засуулчийн эр хонгор дуу хүнгэнэн цуурайтав” (С.Д.69) гэхэд С.Дашдооровын “Говийн өндөр” роман дахь нэг цогцолбор санааг илтгэхэд “засуул- засуулч” гэсэн үгс нь нэгэн адил утга буюу барилдааны арга мэхүүдийг сайн мэддэг, бөхийн зөвлөгч, цолыг нь дуудаж хариуцан барилдуулдаг хүн гэсэн утгаар (И.Дамбажав, 776 дахь тал) орсон байна.

“-Чин” дагавар нь хүмүүсийн байнга буюу түр эрхэлж буй ажил мэргэжлийн нэр, үйлийн эзнийг заасан утгатай нэр бүтээхэд оролцдог. Жишээ нь: ажил гэсэн нэр язгуур дээр “-чин” гэсэн дагаврыг залгахад уул нэрийн дагуу ажил үйлийг эрхлэгч хүн, этгээдийн нэр үүснэ. Гэтэл “-чин” дагаврын хувилбар болох “-ч”-г ийнхүү ажлын үйл явц, болон ажил мэргэжлийн нэр заасан нэр үндсэнд залгахад залгагдан орсон үг нь утга үл ялгах нь харагдаж байна.

Үгийн бүтцийн талаас нь үзвэл “засуул” гэсэн үгтэй адил үгийн бүтэцтэй “босуул” гэсэн үгэнд “босуулч” хэмээн хэлж болохгүй байгаа нь утга нь хэвшээгүйнх бөгөөд “-ч” дэд бүтээврийн илрэх онцлогийг улам тодотгож байна.

Эдгээр дэд бүтээвэртэй, бүтээвэргүй үгсийг монгол хэлний тайлбар толь бичигт дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

3. Тагнуул: а. Ямар нэг юмыг нууц аргаар мэдэх, мэдээлэх ажиллагаа, б. Цэргийн ба улсын нууцыг олж мэдэх үүрэг бүхий этгээд (И.Д.214),

Тагнуулч: Тагнах үүрэг бүхий этгээд, тагнуул (И.Д.214)

4. Сүүл: Аливаа юмын хойд, адаг, бөгс төгсгөл, шувтарга (И.Д.173),

Сүүлч: Эцэс төгсгөл. (И.Д.173)

5. Хэсүүл: Дэмий хэсч тэнэж явагч хүн (И.Д.925)

Хэсүүлч: (ярианд)

6. Хулгай: а. Бусдын эд юмыг хэлэлгүй авах жигшүүрт үйл ажиллагаа

б. Бусдын эд юмыг хулгайлан авдаг хүн

Хулгайч: Хулгай хийдэг этгээд. (И.Д.749)

7. Тонуул: а. Тонох үйлийн нэр, б. Тонож дээрэмдсэн эд юм, Тонуулчин (И.Д.285)

Тонуулч: Тонооч, тоногч этгээд. (И.Д.285)

8. Манаа: Манаач, юмыг харгалзан сахьдаг хүн. (И.Д.935)

Манаач: Юмыг харгалзан сахих манааны ажилтай хүн (И.Д.935)

Дээрх тайлбарыг үзвэл, -ч дэд бүтээврийг нэмэвч утгын ялгамжаа төдийлөн гаргахгүй, салаа боловч адил утгаар тайлбарласан байна.

Дүгнэлт:

Гадаад хэлбэрээрээ үгийн нэгэн утгат хэсэг буюу бүтээвэр болон харагдах боловч үнэндээ утга үл ялгах, эсвэл маш бага утга ялган найруулга, хэрэглээнд тодорхой үүрэг гүйцэтгэх, нэмэлт бүтээвэр шинжтэй, үгийн хувилбар үүсгэж байгаа тийм хэсгийг дэд бүтээвэр хэмээн тодорхойлж болно. Монгол хэлэнд дэд бүтээвэр -га⁴, -с, -м, -ж, -ч, -р, -аа⁴, -ц, -н, -т, -д, -вч зэрэг дагавар болон оруулбаруудаар илэрч байна. Бид энэ өгүүлэлдээ монгол хэлний -ч дэд бүтээврийн тухай авч үзлээ.

Abstract

现代蒙语中，“Цагаан”不仅是指白颜色，其象征意义更明确出。如指“цагаан идээ –奶食、乳制品”“цагаан сэтгэл-纯洁的心”、“цагаан сар - 春节”等。在蒙古春节时都亲手做奶品，例如“马奶- айраг 奶皮- өрөм 奶油-цөцгий、奶- сүү、酸奶-тараг、酸牛奶-элгэн тараг、酸凝乳干-ааруул”等。

蒙古人白色寄寓了美好的期望，形成了一种观念：白色是富裕、美好、吉祥、如意、高尚、纯洁的象征。1) 例如，Ертөнцийн гурван цагаан 在蒙古的世界上三白诗：

Өсөхөд шүд нэг цагаан 长大时牙一白

Өтлөхөд үс нэг цагаан 变老时头发一白

Үхэхэд яс нэг цагаан 死亡时骨头一白

笔者认为，白色是蒙古民族喜爱的颜色之一，尤其是跟蒙古民族生活接近的颜色。历史文化、民情风俗、生活方式和思维特点深刻的含义。

汉蒙语颜色词象征异同

本节进步对蒙汉两国中“黑、白”颜色词的象征进行比较，得出了相同和不同的之处，并对造成文化差异的原因进行了简单的比较。

黑色：在汉语中黑色与古代中国的“黥”这种模型有关系。因为在犯人的脸上画或写字，然后用黑墨涂之，因此黑色含义有不光彩的意义。还有给人的感觉死亡和酷。

在蒙语中的黑色表示丑陋恶劣、恶毒心、不幸、不吉利。“Хар санаа-恶的、坏心眼”、“ хар хүч хар дотортой-阴险”、“ хар элгийн -冷酷的”等。

在时尚人说黑色代表神秘、高贵、高雅和悲伤等。社会流行上的语词比较相同的，例如“黑户口、黑社会、黑市、黑车、黑钱”等。总的来说黑颜色词的词义比较多，但蒙汉语中黑色词义的意义只有上面两个例子比较相同。

²张秀华：《蒙古族生活掠影》2002 年，p278。

在汉语中人们常用黑色词象征“刚直、严正、无私、坚毅”等含义。因而它又象征“深沉和神秘肃穆”等含义。给人的感觉安静、稳定、严肃、庄重等。在蒙语中没有那些词义和象征。黑色来象征巨大的力量，一般年龄、身体、宫和物体。例如黑力量、云雾、大风、黄土风等，这些日常生活方式有关的。如果用“黑色”来形容事物的话，那一定是形容有毒的事物。在蒙古自古以来亲人死后家人穿黑色孝服。

白色：“白色”在汉语中词义消极方面比较多，如“唱白脸、白脸、白衣、百工、白身”等。所以在汉语中颜色词义指白色恐怖的意义。

消极方面只有本身色彩“白灾”，这指新下的雪、新鲜生奶及百合花的颜色。

“白色”在蒙语中词义是“纯洁的心、精神，高尚、幸运、吉利”等。这就是白色是蒙古人民喜爱的颜色之一。

结语

颜色词的象征意义在不同的民族文化里有很大的差异，从根本上讲，在中国文化中，颜色的象征是基于过去中国的封建统治、封建迷信及其原始、落后的科学、教育状况而形成的，所以颜色词象征意义有相当强烈的政治化和神秘化倾向。

不同文化之间颜色象征意义又都是在社会的发展、历史的沉淀中约定俗称的，是一种永久性的文化现象。它们能够语言更生动、有趣、幽默、亲切，所以我们应该予以足够的注意。每种颜色都有一定的情绪色彩。

颜色词的象征意义在不同的民族文化中有共性和也有异性，对它的使用不能仅限于词本身的意义，还要更深入地获取它们的隐含意义。就是需要了解汉蒙两国文化的异同，从本质上掌握这两颜色词在两国语言中的相同及不同语用，从而有效地进行语言交际，促进文化交流。

参考文献

- [1]初源莉, 论俄汉颜色词的引申意义[J], 黑龙江教育学院报, 2005 年. (1)
- [2]叶绍宁、吴敏, 试论中西文化中颜色词语的象征意义[J], 湖南教育学院学报, 1995. (6)
- [3]张洋, 英汉颜色词对比研究[J], 长春教育学院学报, 2013. (11)
- [4]张祝祥、杜凤兰, 英汉基本颜色词“黑”、“白”的认知语义分析[J], 辽宁工学院外语系, 2007. (5)
- [5]周梅, 汉语“红”色词族的句法功能[J], 昭通师范高等专科学校学报, 2010. (3)
- [6]韩振宇, 俄汉颜色词对比与翻译[J], 吉林师范大学人文社会科学版, 2011. (5)
- [7]黄行. 颜色词的语言认知研究[J]. 中国社会科学院民族学与人类学研究所, 2011. (3)
- [8]宛容, 颜色与心理[J], 六盘水师专学报, 2000. (2)
- [9]王华, 英汉颜色词文化透视与翻译对比[J], 西安工程大学人文学院, 2010.12 月号下旬刊
- [10]Д.Болдбаатар, Хятад Монгол толь бичиг[M], Гэгээ дээд сургууль, 2009
- [11]С.Дулам. Монгол бэлгэдэл зүй-Өнгийн бэлгэдэл зүй [M], 2011
- [12]Ц.Базаррагчаа. Хятад Монгол хэлний орчуулгын харьцуулсан судалгаа[M], МУИС, 1999
- [13]Ц.Өнөрбаян、А.Цог-Очир, Орчин цагийн монгол хэл[M], Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Монгол Судлалын Сургууль, 2008

**ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛ ДАХ
ГАЗАР УСНЫ НЭРИЙН СУДАЛГААНЫ АСУУДАЛД**

Ж.Бат-Ирээдүй*

Монгол газар усны нэрийн судалгааг гадаад дотоодын эрдэмтэд олон жилийн турш нарийн чамбай судласаар байгаа билээ. Харин Монголын эрдэмтдийн судалгаа харьцангуй сүүлийн үед идэвхижсэн гэж судлаачид үздэг. Монголын эрдэмтдээс Х.Пэрлээ, Ч.Догсүрэн, А.Лувсандэндэв, О.Сүхбаатар, Ж.Сэржээ, Э.Равдан нар олон талын судалгаа хийж эрдэм шинжилгээний өгүүлэлээс нэг сэдэвт зохиол хүртэл, мөн толь бичиг гарын авлага олныг бичиж туурвижээ.

Бид энэ өгүүлэлд орчин цагийн монгол уран зохиолд дурдагдаж байгаа монгол газар усны нэрийн тухай тусгайлан авч үзэх юм. Энэ чиглэлээр бид 2009 онд “Монгол газар усны нэрийн сан” хэмээх бэсрэг ном гаргасан бөгөөд энэ нь Монголын уран зохиолын төрөл бүрийн дотор байгаа монгол газар усны нэрийн тухай баримттай цуглуулсан хэрэглэгдэхүүн юм.

2009 онд хэвлүүлсэн “Монгол газар усны нэрийн сан” хэмээх бичил ном (ISBN 978-99929-0-959-5, Редактор Х.Фүтаки) нь нийт 100 гаруй газар усны нэрийн сантай бөгөөд голлон монголын орчин үеийн уран зохиол дах газар усны нэрээс бүрдсэн юм. Эл номын оршилд профессор Х.Фүтаки “... түүний бүтээлийн жагсаалтад нэмэгдсэн нэгэн сонин бүтээл нь газар, усны нэрийн сургалт, судалгааны материал юм. Үгнүүдийн дотор газрын нэр, хүний нэр нь гадаад хэлээр орчуулагддаггүй, дуудлагаар нь галиглах заншилтай бөгөөд хэлний энгийн тольд оруулдаггүй. Харин зарим газрын нэр, хүний нэр нь маш түгээмэл хэрэглэдэг тул үгсийн сангийн чухал бүрэлдэхүүн нь болж байна. ... Газрын нэр нь тухайн үндэстний түүх соёлыг тусгасан үнэтэй материал болдог. Жишээлбэл, Цамбагарав, Мааньтын толгой зэрэг төвд, самгарди гаралтай газрын нэр нь буддийн шашин Монголд нэвтэрснээс хойш бий болсон нь тодорхой.”¹ хэмээн дүгнэсэн байна.

Уран зохиолын газар усны нэрийг ярихад бид дэвсгэр буюу нэрийтгэл нэр болон оноосон нэрийг хамт ярих учиртай. Тэгвэл д-р Ж.Сэржээ, “Оноосон нэр нь нэрийтгэл нэрийн нэгэн адил үг буюу хэлний дохио билээ. Гэхдээ аль ч хэлний нэрийтгэл нэр бол ямар нэгэн ухагдахууныг илэрхийлсэн дохио бөгөөд нэрлүүлж байгаа зүйлтэйгээ зүй тогтлын ямар ч холбоогүй юм. Тэгвэл оноосон нэр нь хэдийгээр үгээс бүтсэн дохио мөн боловч хэлний дохио буюу үгээс чанарын ихээхэн ялгаатай гэж болно.” гэжээ.

Газар усны нэр бол тухайн улс үндэстний түүх, соёл, зан заншил, шүтлэг бишрэл, ус ургамал, эрдэнэс баялаг, ахуй соёл зэрэг олон зүйлийн тодруулах боломжийг өөртөө агуулж байдаг маш сонирхолтой судлагдахуун юм. “Монгол хүмүүний газар нутгаа нэрлэх чадамж шавхагдашгүй болох нь маргаангүй. Дэлхийн бусад орны газар нутгийн нэртэй жишин үзвэл тоо, чанарын хувьд ихээхэн өвөрмөц ялгаатай болохыг нүүдлийн мал аж ахуй эрхлэн газар орныхоо өчүүхэн ч атугай хэсгийг заавал нэрлэх монголчуудын амьдралын хэрэгцээ, шаардлагатай холбон тайлбарлахад хүргэнэ.” (ЭР:04:07) гэж профессор Э.Равдан бичжээ.

Уран зохиолын үйл явдал бол тодорхой нэр бүхий газар нутаг дээр болдог зүйл. Монголчууд хэдийгээр дов толгой, жалга судаг бүхэн нь нэртэй боловч тэр бүхэн дээр пайз зоож, хаяг хаддаггүй харин тэр нэр усаа цээжиндээ хадаж, энэ мэдлэгийг үе дамжуулан уламжилж явдаг өвөрмөц ёс заншилтай улс билээ.

Тэр тусмаа Монголын нүүдэлчин соёлын хүрээнд уран зохиолыг газар, усгүйгээр төсөөлөхөд бэрх юм. Монгол зохиолчид уран бүтээл туурвихдаа тухайн зохиолын үйл явдал болсон газрыг судлаж тухайн бодит нэр усыг голдуу хэрэглэдэг бөгөөд ихэнхи зохиолчид өөрийн сайн мэддэг газар орныг уран зохиолын талбар болгон ашигладаг байна. Энэ нь ялангуяа үргэлжилсэн үгийн бүтээл өгүүллэг, тууж, роман дээр их ажиглагдаж байна.

Орчин үеийн монгол уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлэг “Хэнтий, Хангай, Соёны өндөр сайхан нуруунууд, хойд зүгийн чимэг болсон ой хөвчийн уулнууд, Мэнэн, Шарга, Номины өргөн их говиуд, өмнө зүгийн манлай болсон өргөн их далайнууд...” гэж эхлэдэг бөгөөд энд Хэнтий, Хангай, Саян, Мэнэн, Шарга, Номин, Хэрлэн, Онон, Туул, Хөвсгөл, Увс, Буйр, Орхон, Сэлэнгэ, Хөхүй, Хангай, Говь, Халх, зэрэг газар усны нэр олноор багтсан байдаг билээ. Уран зохиолын газар усны нэрийн тухай профессор

* МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын багш, доктор

¹ Ж.Бат-Ирээдүй, “Монгол газар, усны нэрийн сан”, Уб., 2009, 4 дэх тал.

Д.Галбаатар, “Уран зохиолын үйл явдал өрнөж буй газар орны нэрийн учир утгыг тайлбарладаг нэр зүйн салбар ухааныг *toponymy* буюу газар орны нэр судлал хэмээн нэрлэдэг. Үүнд зохиолын баатрын нэр ч хамаарна. Дүрийн зан төрх, үйл зорилго, байр суурь, зан араншингаа илэрхийлхүйц байх нь олон бөгөөд уг хэрэг явдал хаана болж байгаагаас шалтгаалан газар орон, уул усны нэр, тогтоцын талаарх мэдээлэл зөв байх шаардлага гарч ирдэг. Ялангуяа түүхэн, баримтаг уран сайхны зохиолд илүү чухал судлагдахуун болдог.”² гэжээ.

Газар усны нэр нь хаана улиран үлддэг нь бас сонин асуудал байна. Газар усны нэр, газрын зураг, хүний намтар түүх, толь бичиг, тэргүүтэн болон амнаас амаар дамжиж үлддэг бол уран зохиолын төрөл бүрд бичигдэж үлддэг нэг сонин зүйл байна. Уран зохиолд ганц газар усны нэр биш хүний нэр, хоч нэр, элдэв төрлийн оноосон нэр мөн бичигдэж үлддэг ажээ.

Газрын нэр бол нэгэн төрлийн оноосон нэр байдаг. Проф. Э.Равдан “Оноосон нэр нь нэгэн цагийн нэрийтгэл нэр мөн. Гэхдээ нэрлэх явцад тэр нь тодорхой зүйлд оноосон нэр болохын сацуу уг юм үзэгдлээ ижил төстэй, үзэгдлээс ялгах, түүнийг хэрэглээнд орлох тусгай үүрэг хүлээж нэрийтгэл нэрийн шинж чанараа алддаг байна. Гэвч энэ нь аливаа оноосон нэр бол учир холбогдолгүй “шошго” хэмээх үзэхийн үндэслэл болохгүй. Оноосон нэр нь тодорхой үүрэг бүтэц бүхий өвөрмөц хэрэглээнд орсон хэлэхүйн нэгж бол нэрийтгэл нэр нь хэлний нэгж юм.” (ЭР:2008:9-10) гэжээ.

Газрын нэр байгаа уран зохиолын төрөл зүйлийг ажиглавал шүлэг, яруу найраг, найраглал, өгүүлэл, тууж, роман, дурсамж болон дуртатгал, зэрэгт байх бөгөөд үүнийг монголын уран зохиолын үе үеийн бүтээл туурвилуудаас чөлөөтэй олж болно.

Уран зохиол бол тодорхой нэр ус бүхий газар орон тодорхой орон зайд болж өнгөрдөг үйл явдал болох тухай дээр дурдсан билээ. Уран зохиолд гарч байгаа газар усны нэрийг ажиглавал тэр болгон зохиогоод байдаггүй бодит оноосон нэр байдаг байна. Тийм учраас уран зохиолын газар усны нэр нь түүхэн газар зүйн судалгаанд бас нэгэн бааз болж болох юм гэж үзэж байна.

Хамгийн нэгдүгээрт уран зохиолоос газрын нэрийн утга учрыг хэрхэн яагаад тухайн газрыг тийн нэрлэсэн болохыг мэдэж болно. Тухайлбал, Д.Маамын “Газар шороо” романд гарч буй Алтан овооны нэрийн гарал үүслийг хэрхэн тайлбарласныг авч үзье. Тус зохиолд “Талдан бошготын дайнаас өмнө эзгүй байсан Шилийн энэ нутгийн гол дах зүрхэн овоог Захын хар овоо гэдэг байсан хэмээн эдүгээ өвөгцүүл хөөрөлддөг билээ. Бүр урьд энэ овоог Дарь Овоо гэж нэрлэж байсан агаад манж нар Өвөр Монголыг дайлаар авсны дараахан өвөрлөгч хошудын хилийг халхын нутгийн гүн рүү Дарь Овоо хүртэл түрэх санаагаар тэр овоог Захын хар овоо хэмээн хэсэг зуур албадан нэршүүлсэн гэдэг яриа бас бий. Нутгийн сүсэгтэй хүмүүс Дарь Овоог онгон Чойжин болгон тахиглаж нэрийг нь цээрлэн Алтан Дарь, Алтан Овоо хэмээн нэрлэдэг ажээ.” гэсэн бол Дарьганга гэдэг нэрийг “Дарь хэмээх нь хэдэн толин цэнхэр нуурын хойт талд орших дарь мэт хар өнгийн жижигхэн зүрхэн шовх овоог хэлдэг агаад Ганга гэдэг нь тэр хэдэн нуурийн нэгийг нэрлэх тул нутгийн шинэ хүмүүс хошуугаа уул усаараа овоглож Дарьганга хэмээх нь тийн болой” хэмээн бичжээ.

Өөр нэг зохиол Д.Төрбатын “Адын совин” гэдэг өгүүлэлд “Буман хандын ам гэдэг газрын тухай “Цувраа Хайлаастын арван гурван амны нэг болох Буман Хандын ам эл хуль оргино. Хориод ханд цуглаж хурдаг бяцхан сүмтэй хэдий ч алстаа буман ханд буян үйлдэх ерөөл болгон ийн нэрлэсэн юм санж.” хэмээн тайлбарлажээ.

Мөн уран зохиолоос тухайн газар орны хэмжээ дамжааг бараглан мэдэж болох бололцоотой байна. Тухайлбал, Б.Догмидын “Нутаг” өгүүллэгт “Тэр хүртэл өдөрчийн газар тул нарны голтойд Ар гурван говийг туулахсан гэж яаран сульдсан морь урагш алхах урам зориг мохсон бололтой хөл дороосоо шувуу дэрхийн ниссэн ч үргэж цочих нь үгүй.” гэх буюу Б.Баастын “Ногтруу” өгүүлэлд “Өвөр шанд хүрэхийн наана чи Ар хоолойг гатална. Ар хоолой ядуухан морьтой ганц бие хүнд тийм ч амархан барагддаг газар биш.”, Б.Лхагвасүрэнгийн “Турван сэрвэн” өгүүллэгт, “Турван сэрвэн нь хоорондоо саахалтын зайтай эгнэж эргэн тойрныхоо мод, асган дундаас ганц ганцаар нь цойлон өндөрлөж, тэнгэрт хүрэх замдаа үүлтэй саатан үг хэлэлцэнэ үү гэлтэй үүлэнд шурган цэнхэртэж харагдана.” гэх мэтээр дүрсэлсэн байдаг.

Газар нутгийн орчин тойрон, тэдгээрийн нэрийг мэдэж болох боломжтой. Тухайлбал, Б.Догмидын “Санаж сарвайх нутаг ус мину...” өгүүлэлд “Өглөөний гал улаан нарнаар Бор цагаан элэгний зүүн мөрөн дээр давхин гарч ирээд зогсоход тэртээ урд Эрдэнэцогтын говь, Их бага газрын чулуу, Тойгын уул, Омгорын толгод, Дөрвөлжийн хөндий, Сүүл толгой, Холбоо цагаан, Хонин чулуут ... дагнаасан хээ шиг давхраатан цэнхэртэж харагдахад бид хоёрын зовхинд нулимс хурж, уснаас гарч ирсэн мэт уртаар санаа алдацгаав.”, гэсэн бол С.Эрдэнийн “Амьдралын тойрог” романд “Хилийн дагуу баруун зүүншээ хагас өртөө шахам хөндөлссөн Галтханы баруун сугаас Галттайн гол эх авч нэлээд уужим амаар урагшаа урсан ...” гэж хүнээс байгальд харьцах түүнийг ойлгож ухаарч бишрэх харилцааг өгүүлэх үед ийнхүү орчмын газар орныг зураглан дүрслэх арга уран зохиолд их буй.

Уран зохиолын газар усны нэрээс түүний хувьсал өөрчлөлт, түүний учир шалтгааныг мэдэж болох боломжтой гэж үзэж байна. Тухайлбал, П.Баярсайханы “Хоёр зуун дөчин хоёр” өгүүлэлд “Энэ нутгийг хоёр зуун дөчин хоёр гэх. Уг нь Баянтал гэдэг байлаа. Цэвэр цэнгэг гол горхи дүүрэн, ууландаа хустай бол хустай,

² Д.Галбаатар, (2012) “Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл” нэвтэрхий толь”, Уб., 101 дэх тал.

хуш, нарс ч бас ургадаг газар. Гэтэл одоо ердөө хоёр зуун дөчин хоёр гэж нэрлэх болжээ.” гэж чухам тэр газрын нэрийн хувьсал өөрчлөлтийг зохиолын баатраар тайлбарлуулах жишээтэй.

Тухайн газар орон уул хайрханы байдал, газар орныг баримжаалан мэдэх боломжтой. Жишээлбэл, Ц.Дамдинсүрэнгийн “Морь шинжээч Жомбоо хүү” өгүүллэгт “Талд дунд шовойсон бараан Матад гэдэг уулыг тайж тахихаар тэр хавийн малчин ардууд цуглажээ. Баруун Матад уул шовх өндөр учраас уулын орой дээр хүмүүс гарч тахиж тайгаад түүний өврийн тэгшхэн дэнж дээр бууж ирээд наадмаа хийдэг байжээ.” Д.Батбаярын “Тэр жилийн бороо ногоо” өгүүллэгт “Таван толгойн энгэрт буувал Булангийн нуур ууна. Хаашаа л бол ил, сайхан даа.” Д.Цэдэвийн “Улаан хамбан зодогт буюу тавын даваа” өгүүллэгт “Улаанбаатараас баруун урагш холгүй орших Буянт-Ухаагийн уужим талбайд өнгө өнгийн асар майхан хаяа хаяагаа дэрлэх шахам ярайжээ.” Д.Маамын “Газар шороо” романд “Шорвойн дөрөлжөөс баруун хойш Хурц вангийн хошуутай Даригангын нийлэх зааг Шилийн богд хэмээх нутгийн хайрханы урдхан дор орших Баяндэлгэр нэрт цагаан овоо бол яах аргагүй Даригангын нутгийн дээс билээ.” Б.Баастын “Хаш аяга” өгүүллэд “Яасан бэ гэвэл Жирэмийн хөндий гэдэг битүү улиас, бургас, хустай, хөндий гэтэлж айлд очоод шөнө буцаж явахад нь нөгөө Лутаа гайхал сүүдэр шиг дагаж байгаад харанхуй шөнөөр их модон дотор барьж хүслээ хангах гэсэн байхгүй юу.” гэх мэтээр тухайн газар нутгийн дүр байдал, хэмжээ талбай, тэргүүтнийг мэдэж болохоор дүрслэн бичжээ.

Мөн тухайн зохиолд өгүүлж байгаа газар усны нэрээс газар орны байгаль, ургамал, ус ногооны байдлыг танин мэдэж болно. Тухайлбал, Л.Түдэвийн “Хөмрөг” өгүүллэгт “Бөөрөгийн элс хавиар хармаг их ургадаг юм. Хармагны бутанд сууя. Тэр үхрийн нүд мүднээс чинь дутахгүй сайхан жимс байгаа юм.” гэх буюу С.Эрдэнийн “Амьдралын тойрог” романд “Баянхан бол Сэрүүн Галтайнханы тахидаг гол овоо бөгөөд энгэр оройгоор арсгар барсгар хадан цохиотой, араараа шинэс нарс холилдсон ойтой зүрхэн шовх уул.” Д.Батбаярын “Дундрашгүй” өгүүллэгт “Морин хуур харагдахтай зэрэг надад Дэлгэрэхийн аман ус хэмээх элбэг уст нэгэн худаг санаанд ордог юм.” Д.Намсрайн “Лусын охинтой зохиосон үлгэр” гэдэг өгүүллэгт “Бусдаас онцгойхон ургасан аварга том улиасны ёроолоор буяхан булаг буриглан Сэлэнгэ мөрөн рүү нийлснийг Ганц модны рашаан гэдэг. Лусын охин бид хоёр тэр рашаанаас зөндөө ууж үзсэн. Шүд хага ташим хүйтэн л болохоос өөр ямар нэг гойдын сонин амтгүй тэр усыг хүмүүс яахаараа тэгж их шүтдэгийн нарийн учрыг бид мэдэх биш дээ” гэх мэтээр дүрслэн өгүүлж байгаа нь тухайн газар орны орчмын байгаль, ус ургамлын байдал зэргийг мэдээлж байна.

Уран зохиолын зарим төрлөөс уул усны домог үлгэрийг мэдэх боломжтой байдаг. Жишээлбэл, П.Лувсанцэрэнгийн “Мөнгөн аяга” өгүүллэгт Далангийн нуруу гэдэг газрын нэрийн домгийг тайлбарлан бичихдээ, “Энэ нутаг Далангийн нуруу гэдэг уул бий. Энэ уулын ар оройг дагаад урьд ямар нэг аварга амьтан мөлхөж явсны ул мөр болов уу гэмээр урт ховил зам байдаг. Үүгээр аварга могой явсан гэж нутгийн ярилцана.” гэх мэтээр учир начрыг тайлбарлах жишээтэй.

Монголын орчин үеийн уран зохиолд орсон газар усны нэрийтгэл нэрийг ажиглавал (дээрх номд орсноор авч үзвэл) Буман хандын ам, Залаатын ам гэх мэт амууд, Долоон болдог, Дэлүүн болдог гэх мэт болдогууд, Сэнгүр, Тана, Түнхэлиг зэрэг горхиуд, Ганц, Жирэм, Нарийн, Улаан зэрэг даваанууд, Авай, Баян бараат, Баянзүрх, Баянжаргалан, Баян хан, Богд, Бурхан Халдун, Гурван хасна, Далан хар, Дарви, Дархан хан, Дэлгэр Хангай, Ерлөг, Их, Маажинсан, Матад, Өлгий, Тагна зэрэг уулс, Ариг, Буут, Дугана, Дэлгэрэх, Нэхүн, Сохог, Тахийн ус зэрэг уснууд, Ганжуур, Мааньт, Омгор зэрэг толгод, Гурван шээзгийт, Ор нугын хэлтгий, Улаан зэрэг хаднууд, Бумбат, Отгон тэнгэр, Өлзийт, Сонгино, Тал, Тарлан, Үзүүр зэрэг хайрханууд, Дэлгэр, Жирэм, Жирэлзэх, Зузаан, Хавцалын зэрэг хөндийнүүд, Алтай Таван, Атас цагаан, Ацат, Сутай, Сэгс цагаан зэрэг богдууд, Адуун чулуутын, Ханын зэрэг хэцүүд, Айдас, Арай, Бургастай, Минжийн хангайн даваанууд, Бага газар, Гишгэр, Их газар, Тайхар зэрэг чулуунууд, Алтан дарь, Баяндэлгэр, Дарь, Захын хар, Олон, Тасган, Ухаа зэрэг овоонууд, Алхуй, Их хэт, Их дөт, Өлгийн булагууд, Алтай, Дарви, Даян, Дөвөнт, Магнай, Тайшир, Төвшин буурын нуруунууд, Ар гурван, Бор хээр, Заг сүүж, Захуй зарман, Зээргэнэт, Ингэн ус, Лиг, Мандал, Мэнэн, Нарийн хөх, Өөш номгон, Өргөн хашаат, Саарь, Сүүж, Төгрөгийн говиуд, Ар сүүж, Дөшийн худагууд, Бааст, Баян, Боржигины бор, Ботгон төгрөг, Бөөрөлжүүт, Туулайн өргөн талууд, Годил шар, Өнгөнт ногоон, Сүүл зэрэг толгойнууд, Онон, Оршуун, Сэлэнгэ мөрнүүд, Байдраг, Бороо, Бөхөг, Булган, Гашуун, Дархинт, Ерөө, Заг, Зэл, Идэр, Нөмрөг, Онон, Өрөм, Суман, Сүх, Сэлбэ, Хад могойн голууд, Балжун, Буйр, Ганга, Жирмийн цагаан, Зангуут, Нүдэн, Олон, Тэрхийн цагаан, Уянгын цагаан, Хар зүрхний Хөх нуурууд, Балж, Талхуны арлууд, Буурь, Саарь, Сулин хээрүүд, Бөөрөг, Нарангийн элсүүд, зэрэг нэрийтгэл нэр арвин давтамжтай таарч байна.

Эдгээрийн дунд газар усны нэр судлаачид олж хараагүй, дурдаагүй нэрийтгэл нэр ч хэд хэд байхыг үгүйсгэхгүй ялангуяа чулуу, ус, худаг, гудамж, хясаа, хунхуй, эрэг, нуга, тохой зэрэг нэрийтгэл нэрийн хэрэглээг цаашид судалж үзүүштэй санагдана.

Эдгээрээс дүгнэн үзхүл, юуны түрүүнд Монголын орчин үеийн ямар ч төрлөөс газар усны нэрийг төдөлгүй олж болох бөгөөд эдгээр газар усны нэрийг шинжлэн судлах нь зайлшгүй зүйл болно гэж үзэж байна.

Хэдийгээр бидний авч үзэж байгаа талбар нь уран зохиол боловч лав монгол уран зохиолын газар орны

Ж.Бат-Ирээдүй

нэр нь тэр болгон зохиомол биш харин тухайн зохиолд гарч байгаа газар усны нэрийг газрын зураг, тэнд амьдарч байсан, одоо амьдарч байгаа олон хүний аман яриа зэргээс мөшгөн хөөвөл бодитой газар орны нэр байдаг нь баттай болж байна. Өөрөөр хэлбэл зохиогч тухайн үйл явдал болж байгаа газар усны нэрийг барагтай бол зохиодоггүй харин түүнийг судалж шинжилж аль болох түүхэн нэр усыг ашиглаж бичих уламжлалтай төдийгүй магадгүй тухайн зохиолчийн хувьд хамгийн сайн мэдэх газар усны нэр байдаг байна гэж дүгнэж болох юм. Тийм учраас зохиогч ямар газар оронд төрж өссөн байна тэр нутгийн газар усны нэрийг төдөлгүй сайн мэдэж байдаг нь уран зохиолын төрөл зүйлээс тодорхой байна.

Монголын орчин үеийн уран зохиол төдийгүй ерөөсөө аливаа уран зохиолд гарч байгаа газар усны нэр нь тухайн хэлний газар усны нэрийн нэгэн бүрэлдэхүүн хэсэг, мөн түүхэн нэр зүйд ашиглаж болох нэгэн зүйл баримт гэж үзэлтэй.

Монголын уран зохиол дах газар усны нэр болбоос маш олон зүйлийн мэдээллийг агуулж байдаг учраас бүр нарийн судлавал газар усны нэрийн судалгаанд өвс ургамалын байдал, газар орны өөрчлөлт, нэрийн хувьсал өөрчлөлт, түүхэн үйл явдал болсон газар орон зэрэг олон зүйлийг хэлж өгөх, боломжтой гэж дүгнэж байна.

Abstract

Toponym is the general term for any place or geographical entity. The toponyms are both the real names and the geographical names in the Modern Mongolian literature. They are related to the history of literature because we can find out a lot of its sources. We may conclude that these names are best-known places for authors. We can know a lot of things and the sources, because toponyms contain types of information. These are the one component of the languages

НОМЗҮЙ

- Я.Баатар, (2001) “Уран зохиолын нэр судлал”, Уб.,
Д.Бадамдорж, (2001) “Монгол хэлний утга судлал”, Уб.,
Д.Бадамдорж, (2006) “Монгол хэлний үгийн сангийн утга зүй”, Уб.,
Ж.Бат-Ирээдүй, (2009) “Монгол газар усны нэрийн сан”, Уб.,
Э.Равдан, (2004) “Монголын газар нутгийн нэрийн хэлбэр, утга зүйн судалгаа”, Уб.,
Э.Равдан, (2009) “Монгол газар нутгийн нэр зүй”, Уб.,
Ж.Сэржээ, (2010) “Орчин цагийн монгол хэлний оноосон нэрийн судалгаа”, Уб.,
Ж.Сэржээ, (2014) “Монгол хэлний нэрзүй, утга зүйн судалгааны зарим асуудал”, Уб.,
Д.Галбаатар, (2012) “Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл нэвтэрхий толь”, Уб.,

Монголын орчин үеийн яруу найргийн шинэтгэл шинж

Р.Бигэрмаа*

Хүн төрөлхтөний түүхэнд оршин тогтнож буй улс үндэстэн бүхэн бичгийн соёлын гайхамшигт уламжлалтай байдаг. Тухайн үндэстэн бүхний энэхүү соёл нь эдүгээ үе хүртэл уламжлагдан, улам боловсронгуй болж, шинэчлэгдсээр ирсэн бөгөөд үе бүхэн өөрийн өвөрмөц онцлог, манлайлагчид, уншигчидтай байх бөгөөд эдгээр нь цаг хугацааны шүүлтүүрээр шүүгдэн, шилдэг сайн нь үлдэн хоцорч хэдэн үеэр дамжихаас гадна дараа, дараагийн үеийнхэндээ уламжлал болон үндэс суурь нь болсоор ирдэг ажээ.

Монголын ард түмэн мянгаад жилийн бичиг соёлын түүхэн уламжлалтай бөгөөд түүний нэгэн бүрэлдэхүүн хэсэг нь уранзохиол, ялангуяа яруу найраг юм. Яруу найраг нь сэтгэлгээний урлаг учраас тухайн нийгэм, цаг үеийг хамгийн бодитой, шуурхай тусгадаг уран зохиолын нэг төрөл юм. Энэхүү яруу найргийг монголын сод найрагчидгүйгээр төсөөлөхийн аргагүй. Ялангуяа авьяаслаг яруу найрагч Д.Нацагдорж, Б.Явуухулан, Б.Лхагвасүрэн нарыг дурдахгүй байвал алдас болноо. Эдгээр яруу найрагчид нь тухайн амьдарч асан үеийнхээ нийгэм цаг үеийг өөрсдийн уран бүтээлээр тусган илэрхийлж, сод бүтээлүүдээрээ тодорхой цаг үеийг төлөөлөн, бидний үе хүртэл оршин тогтносоор ирсэн төдийгүй дэлхий дахинаа нэр алдраа дуурсган “монгол гэдэг нэрийг ертөнцийн чихнээ дуурсгаж” байгаа билээ.

Эдгээр яруу найрагчид ур чадвар, уран дүрслэл, сэтгэлгээний өвөрмөц онцлогоороо үе, үеийн манлайлан хошуучлагчид байж, тухайн үеийнхээ шинэчлэгчид харин хойч үеийнхээ уламжлал нь болж ирсэн билээ. Монголын орчин үеийн яруу найргийн судлалд эдгээр шилдэг яруу найрагчдын ур чадвар, сэтгэлгээний онцлогийг харьцуулан, уламжлал шинэчлэлийн холбоонд нь судалж, тэдний яруу найргийн үнэт чанар, хөгжлийн шинэчлэлийг тодруулан гаргах нь чухал юм.

Иймд өчүүхэн миний бие энэхүү нэрт яруу найрагчдын эх орны сэдэвт шүлгүүдээс ажигласнаа та бүхэнд толилуулъя.

Дэлхий нийтээр “Тогтвортой хөгжлийн зуун” хэмээн яригдаж буй өнөө үед энэхүү тогтвортой хөгжлийн тулгын гурван чулууны нэг болсон “Байгаль эх”-ээ хайрлах хамгаалах тухай үзлийг уншигчдад төлөвшүүлэх нь манай нийгмийн тулгамдсан чухал асуудлын нэг юм. Нөгөө талаас аль ч улс үндэстний яруу найрагт зонхилж байдаг эх орны сэдэвт уянга билээ. Энэ нь монгол яруу найрагт эртнээс уламжилж ирсэн үндсэн сэдэв юм. Ийм ч учраас дээрх яруу найрагчдын уран бүтээлд энэхүү сэдэв голлох байрыг эзэлдэг.

Д.Нацагдоржийн “Миний нутаг” найраглал нь монголын орчин үеийн яруу найргийн сод бүтээлийн нэг билээ.

“Миний нутаг” найраглал нь “Алтайн магтаал”, “Хангайн магтаал”, “Хан Хөхүйн магтаал”, “Их богдын магтаал” зэрэг магтаалуудын шууд уламжлал болон зохиогдсон бөгөөд монгол орны өргөн уудам нутгийг байгалийн баялаг, хүн ард, өнгөрсөн түүх, соёл зан заншлын өвөрмөц онцлогийг магтан алдаршуулж, ирээдүйн сайн сайханд уриалан дуудсан агуулгатай.

Ингэж дүрслэхдээ:

1. Монгол орны үзэсгэлэнт байгалийг тодорхой нэг хэсгээр нь бус, ерөнхийлөн маягаар монгол сэтгэхүйгээр нээн харуулсан. Шүлгийг бүхэлд нь авч үзвэл: Говь, хангай хосолсон өргөн уудам нутгийг ерөнхийлөн дурдаад, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсэг болсон гол ус, уул даваа, цаст өндөр хайрхнууд, уудам амьсгалт талууд, малын сайхан бэлчээр... зэргийг тодорхойлон задалж өгүүлсэн бөгөөд эцэст нь монголын ард түмний цаг агаар уур амьсгалын онцлог, эртний соёл түүхийн улбаа, тусгаар тогтнол, ирээдүйн сайн сайхныг бэлгэдэхдээ илүү өргөн утга агуулгатай “нутаг, орон” үгсээр буцаан ерөнхийлснөөс гадна “Энэ бол миний төрсөн нутаг Монголын сайхан орон” гэж бадаг бүрийнхээ төгсгөлд монгол хүний сэтгэхүйн

*МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын докторант

онцлогоор нэгтгэн зангидсан байна.

2. Эртний нүүдэлчин монголчуудын ахуй амьдралын онцлогийг өвөрмөц маягаар илэрхийлсэн. Тухайлбал: “...он онд идээшсэн, хар бага наснаас хөндлөн гулд давхисан, нарийн өвс ургасан малын сайхан бэлчээрт таван хошуу мал тал дүүрэн бэлчсэн нутаг”

3. Монгол орны өнгөрсөн, одоо, ирээдүйн сайн сайхныг “Хүннү Сүннүгийн үеэс хөгшид өвгөдийн минь нутаг Хөх монголын цагт хүчирхэг боссон орон Он онд идээшиж олон жилд дассан нутаг Одоогийн шинэ Монголын улаан туг бүрхсэн орон, Хувьтай эх орондоо хувьсгалт улсаа мандуулж Хойчийн шинэ ертөнц дээр хүндтэй гавьяаг байгуулья” хэмээн гүн ухааны аястай сэтгэсэн.

4. Эх орноо магтан дуулж, хайрласан үзэл санааны уламжлал дээр суурилж, ардын аман зохиолыг үндэслэн, агуулга, найруулга, утгын өргөн шинэчлэлтийг хийсэн. Үүгээрээ 1930-аад оны яруу найрагт бичгийн уран зохиолын хэвшмэл загвар болж байсан- ардын аман зохиол, магтаалын ерөнхий шинж болох магтан дуулах дүрслэгдэхүүнийг өөрчилж, Монгол орныг бүтнээр нь танин мэдүүлэх шинжтэй дүрсэлснээрээ шинэчлэлт хийсэн.

Шүлгийн хэлбэр, зохиомжийн онцлог:

Энэ нь тус бүр 4 мөр 12 бадаг шүлэг бөгөөд бадаг бүрийн төгсгөлд “Энэ бол миний төрсөн нутаг Монголын сайхан орон” хэмээн дүгнэж өгсөн, зохиомжийн нарийн бүтэцтэй. Энэ нь монголчуудын тооны бэлгэдлийн өвөрмөц онцлог болгон бадгийг зохиомжилсон.

Эхний 4 бадагт хангай, говь хосолсон өргөн уудам газар нутгийг дэвсгэрлэн,

Хэнтий, Хангай, Саяаны өндөр сайхан нуруунууд

Хойд зүгийн чимэг болсон ой хөвчин уулууд

Мэнэн, Шарга, Номины өргөн их говиуд

Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далайнууд

хэмээн хангай нутгийг бүтээж байгаа салшгүй хэсэг болсон ой хөвч, уулс бүхий хангай нутгийн онцлог; говь нутгийг бүтээж байгаа Мэнэн, Шарга тэргүүтэй 33 их говь, тэднийг бүрдүүлэгч элсэн манхан говийн онцлогийг эхлэн гаргаж, үүнийгээ цааш нь дараагийн 4 бадагт задлан монгол орны асар уудам байгалийн байдлыг зураглан харуулжээ. Ингэхдээ шүлэглэх арга зүйн хувьд ч сүүл холбох уламжлалт бичлэгээс зайлсхийн, сүүл холболтыг нэр үгээр хийж, бадгийн доторх мөрийг нэрлэсэн өгүүлбэрээр дүрсэлсэн нь өвөрмөц шинэлэг болжээ. Жишээ нь:

Холхи газраас гялалзсан цаст өндөр хайрханууд

Хөх тэнгэр цэлмийсэн хөдөө хээр цайдмууд

Холын бараа харагдсан ноён шовх сарьдгууд

Хүний сэтгэл тэнийсэн уудам амьсгалт талууд

Ингээд дараагийн 3 бадагт

Өвлийн тасхийм цагт цасан мөсөн бүрхээд,

Болор шилийн өнгөн гилтэгнэж гялалзсан орон

Зуны нартай улиралд цэцэг навч дэлгэрээд

Жигүүртэн шувуу холоос ирж гангар гунгар донгодсон орон

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

Алтайн Хянганд хоёрын завсарт атар баялаг орон

Аав ээжийн минь оршсон ашдын заяасан нутаг

Алтан нарны туяанд энхжин тогтсон орон

Мөнгөн сарны гэрэлд мөнхжин гялалзсан газар

гэсэн дараагийн 2 бадагт монгол орны уур амьсгалын онцлог байдлыг шим ертөнцийн хөгжил дэвшлийн хуультай холбон, 9 эрдэнийг хорвоо дэлхийг гийгүүлэгч нар сартай уялдуулан, үүрд мөнх хөгжин дэвшиж байхыг бэлгэдсэн бол

Хүннү Сүннүгийн үеэс хөгшид өвгөдийн минь нутаг

Хөх монголын цагт хүчирхэг боссон орон

Он онд идээшиж олон жилд дассан нутаг

Одоогийн шинэ Монголын улаан туг бүрхсэн орон

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

Өссөн төрсөн бидний үндэсний хайртай нутаг

Өнгөлзөгч дайсан ирвэл үтэр өшиглөн хөөнө
 Хувьтай эх орондоо хувьсгалт улсаа мандуулж
 Хойчийн шинэ ертөнц дээр хүндтэй гавьяаг байгуулья
 Энэ бол миний төрсөн нутаг
 Монголын сайхан орон

гэсэн сүүлчийн 2 бадагт дээр өгүүлсэн байгалийн зураглал, хүн ардын ахуй амьдрал, зан заншлын онцлогоос хальж, монголын эртний түүх, одоогийн улс төрийн байдал, ирээдүйд мандан дэгжихийн бэлгэдлээр цар хүрээгээ тэлжээ.

XX зууны 60-70-аад оны яруу найрагт өөрийн сод бүтээлүүдээр “Дорнын их яруу найрагч” хэмээх алдрыг хүртсэн Б.Явуухулангийн шүлгээс мөн энэ сэдэвт шинэчлэлт хийсэн хэмээн ихэнх судлаачид хүлээн зөвшөөрдөг “Би хаана төрөө вэ?” шүлгийг авч үзье.

Шүлэг 12 бадаг, бадаг бүр нь 5 мөрөөр зохиомжлогдсон байдаг. Энэ нь монголчуудын эртнээс нааш бэлгэдэж ирсэн тооны болон цаг хугацаа, орон зайн бэлгэдэлтэй нягт холбоотой. Үүнд: 12 гэдэг нь монгол бэлгэдэл зүйд цаг хугацааны бэлгэдэл болсоор иржээ. Энэ тухай профессор С.Дулам “Арван хоёроор эс бэлгэдэх цагийн хугацаа гэж үгүй... Чухам ийм учраас тооны бэлгэдлийн цогцолборт тэгш тооны тэнхлэг буюу хавтгай тэнхлэг дээр дөрвөн зүг, найман зовхисын хамт орон зай- цаг хугацааны цогцолборыг үүсгэн заларч байгаа юм” хэмээн өгүүлжээ.

Эндээс ургуулан үзвэл, монгол гүн ухаанд хүний нас, биеийн нэг үеийг цаг хугацааны мөчлөгөөр тодорхойлон өгүүлж, 12 бадгаар бадаг бүр нь бие даасан утгатай, таван мөртэй санамсаргүй бус “арван хоёр цаг, арван хоёр сар, дөчин найман улирал, арван хоёр жил, түүнийг тав дахин нугалсан жарны тоолол”³ болох нь шүлэгт тусгалаа олжээ. Үүгээрээ яруу найрагч үеийн үед хэдэн жаранд монгол хүн, монгол орноо эзэгнэнхэн аж төрж, монголчуудын амьдрал тэмцэл эцэс төгсгөлгүй юм гэсэн санааг илэрхийлжээ.

Монгол шүлгийн 4 мөрөөр бадагладаг уламжлалыг баяжуулан, таван мөрөөр зохиомжилж, 1 ба 5 дахь хашлага, бадгийн утга санаагаа тодотгосон нь учиртай. Монгол ёсонд тавын тооны бэлгэдэл эв нэгдэл, хүч чадал, сайн сайхны бэлгэдэл болдог. Иймээс шүлгийн мөрийг таваар журамласан нь монголчуудын эв нэгдэл, дотоод хүчин чадал нь үүрд мөнх байхын бэлгэдэл гэж болох юм.

“Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө би

Хөмсгөн сарны аялах алсын алс тойрогт

Холын хоёр одны тохиох бяцхан чөлөөнд

Хоёр нүдний үзүүрт цэнхэрлэх төдий тэртээд

Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө би...” хэмээн эхэлж буй дээрх шүлэгт эх орны тухай ойлголтыг “холын хоёр одны тохиох бяцхан чөлөө” хүртэлх алсаас цаст цагаан уул, онгон цэнхэр тал, мөрөн голын ус, үнэр ялдам агь ганга хүртэл ерөнхийгөөс тусгай руу буулган нарийсгаж, монгол хүний байгаль, эх орноороо бахархах сэтгэлийг гүн ухааны сэтгэлгээгээр дүрсэлжээ. Тухайлбал:

“...Цаст цагаан уулыг эзэгнэнхэн төрлөө би

Цан хүүрэг савсаж үүлс ороох оргилд

Цасан ширхэг царцаж мөс болох халилд

Царгиа хүйтэн өвөл сарлагийн бух дошсон

Цаст цагаан уулыг эзэгнэнхэн төрлөө би

Онгон цэнхэр талыг эзэгнэнхэн төрлөө би

Орог саарал зэрэглээ хавар сүүмэлзэх хөндийд

Орсон буурын шүд өвөл хангинах хоолойд

Үлэг гүрвэлий мөрийг өдий хүртэл хадгалсан

Онгон цэнхэр талыг эзэгнэнхэн төрлөө би...” хоёр бадагт сансар огторгуйгаас цаст цагаан уул, онгон цэнхэр талд бууж ирэхдээ хүний таван махбодын нэг шороон махбодыг тусгасан байх магадлалтай бөгөөд хүний гар хүрээгүй онгон талыг сайн сайхан, говь нутгийн байгалийн өвөрмөц төрх болох зэрэглээг саарал өнгөтэй хоршуулан дүрслэхдээ бүхэл бүтэн эрин үе, түүх соёлын дурсгалтай нь багтаан дүрсэлжээ. Ингэхдээ сав ертөнцийг бүтээгч уул, ус, газар шороо эртний шим ертөнцийн үнэтэй дурсгалыг дүрсэлж, түүнийгээ монгол орны байгалийн эрс тэс уур амьсгалын онцлог, тэрхүү хүйтэнд хувьсан өөрчлөгдөх байгалийн өөрчлөлтийг шинжлэх ухааны үндэстэйгээр тусгасан нь содон юм.

“...Үнэр ялдам агь гангыг эзэгнэнхэн төрлөө би

Үүр шөнийн завсар шүүдэр буух навчинд

Үрэл усан шүүдэрт нь одод гялалзах дэлбээнд

Үхэлгүй мөнхийн бэлгэдэл цагаан уул цэцгэнд
Үнэр ялдам агь гангыг эзэгнэнхэн төрлөө би...”

Энэхүү бадагт шим ертөнцийн нэг болох ургамлын сайхнаар төлөөлүүлэн, үхэлгүй мөнх байх санааг бэлгэдсэн аж. Учир нь монголчууд цагаан уул цэцгийг үхэлгүй мөнхийн бэлгэдэл хэмээн эртнээс үзэж, мөн мандан бадрахын бэлгэдэл галыг хэт, цагаан уул цэцгээр бадраан асаадаг, тэрчлэн үүрээр буух цэцгийн шүүдэр ариун тансагийн бэлгэдэл учраас шүүдрийн дусал цуглуулан, ээждээ цай чанаж өгвөл ачийг нь хариулна хэмээн үздэг зэргээс илэрхий. Ингэж энгийн атлаа гүн санааг уянга ухаарлын аясаар дүрслэн харуулсан байна.

Энэ мэтчлэн, бадаг бүрт ерөнхийгөөс тусгай руу уусан орж, эхний 5 бадагт эх орны байгалийн байдал, ариун дагшин байдлыг илэрхийлсний зэрэгцээ дараа дараагийн бадгуудад монгол нүүдэлчин ард түмний ахуй амьдрал, зан заншил, сэтгэлгээний үндэсний онцлогийг өвөрмөцөөр дүрслэн харуулахдаа энэ бүхнийг эзэгнэн төрсөн монгол хүний үндэсний бахархал, энэ бүхний эзэн нь би юм шүү гэсэн бяцхан омгорхолыг уянга ухаарлын гүнээс тод томруун дүрсэлснээрээ энэхүү шүлгийн шинэчлэлт чанар, ач холбогдол оршино. Жишээ нь:

“...Зүүрмэглэгч хун шиг гэрийг эзэгнэнхэн төрлөө би
Зүйдэлгүй цагаан өрхийн хоймсолж томсон оосорт
Зүрхэн улаан галтай ган тулгын тогтонд
Зуун түмэн үед монгол хүний идээшсэн
Зүүрмэглэгч хун шиг гэрийг эзэгнэнхэн төрлөө би...”

Нүүдэлчин монголчуудын амьдралын гол хэрэгсэл монгол гэрийг тэдний тотем болсон хун шувуутай зүйрлэн, хайр сэтгэлт хосуудын жаргалтай амьдрах, өрх гэрийн мөнх оршихуйн бэлгэдэл болгон дүрсэлжээ. Мөн нүүдэлч монголчуудын амьдралын онцлогт тохирсон, эд өлгийн өвөрмөц чухал дурсгал болох монгол гэрийг дэлхий ертөнцийн загвар болгон, тэгш хэмийн зарчмаар бэлгэдэж, хүн амьтныг дулаацуулан амьдруулагч, орчлонгийн гэрэл гэгээний эх үүсгэл болсон алтан нараар тооноо, түүний цацрагаар унийг төлөөлөн тав тухтай амьдрал, айл гэрийн аз жаргалыг өгүүлсэн нь сонирхолтой юм. “Зүйдэлгүй цагаан өрх” гэсэн хэллэгээр тооно, өрхийг монгол гэрийн бэлгэдэлд гэрийн гал голомттой салшгүй холбоотой хэмээн үздэг заншил тэрчлэн хамгийн сайн сайхан бүхнийг эхийн цагаан сүүтэй зүйрлэн хиргүй тунгалаг, цэвэр ариун болохыг, “Зүрхэн улаан галтай ган тулгын тогто” хэллэгээр айл гэрийн тулга нь эртнээс гал голомтоо мандаан бадраадаг ариун зүйл бөгөөд улаан өнгө нь энэхүү галын өнгө учир сүрлэг бадрангуй, мандан бадрахын бэлгэдлийг илэрхийлдгийг тус тус харуулжээ.

“...Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би
Тэлмэн жороо морины шанхны үзүүрийн чичиргээнд
Тэнгэрийн салхинаас бусдыг дээрээ гаргаж үзээгүй
Тэнэгэр говийн сүрэг онгон хулангийн нуруунд
Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би...”

Малчин монголчуудын дээдлэн хүндэлдэг таван хошуу малын нэг нь морь билээ. Морийг эр хүний сайн нөхөр, молор эрдэнэ хэмээн дээдэлж, төрийн сүлдэндээ хүртэл морио дээдэлдэг. Эр чадлын бэлгэ тэмдэг болсон эрийн гурван наадмын нэг хурдан морины уралдаан, айргийн тавд орсон морины эзнийг хийморьтой гэдэг, түрүүлсэн морины хөлсөнд хүрвэл бүтэн жилжингээ од хийморьтой байна гэдэг монголчуудын сэтгэхүйн онцлог ч туссан байна. Тэрчлэн энэхүү сайн сайхан, хүндлэл бишрэлийг, шандаст хурдан хүлгийн уг гарваль болох тэнгэрийн унага хулан, тахийн удамтай нь дүрсэлснээрээ монгол орны байгалийн баялаг ан амьтан дуусаж дундаршгүй санааг илэрхийлжээ.

“...Хөх тэнгэрийн орныг эзэгнэнхэн төрлөө би
Хөх Монгол алдаршсаны үе дамжсан домогт
Хүчирхэг дээдсийн нутагт мандсан хувьсгалын дөлөнд
Хөрст алтан дэлхийн үрчлээт магнай болсон
Хөх тэнгэрийн орныг эзэгнэнхэн төрлөө би...”

“Хөх тэнгэрийн орныг эзэгнэнхэн төрлөө би” гэсэн энэхүү шадаар дээрх бүх бадгуудын санааг нэгтгэн дүгнэж, эх нутгийн төгс төгөлдөрийг дүрслэхдээ хөрст алтан дэлхийн үрчлээт магнай болсон хөх монголчуудын эртний болон эдүгээгийн түүх соёл, дэлхийн түүхийн салшгүй хэсэг болж, хөх тэнгэрийн орныг эзэгнэж байгаа монгол хүний сэтгэлийг дуулал, омог бахархал болж чадсан байна.

Ингэж Б.Явуухулан, их найрагч Д.Нацагдоржийн “Миний нутаг” найраглалд дүрсэлсэн санаа, утга агуулга, дүрслэлийг өөрийн гүн ухааны аяс бүхий өвөрмөц содон дүрслэлээрээ баяжуулан хөгжүүлж, 1960-

аад оны яруу найрагт дахин давтагдашгүй шинэчлэлтийг хийсэн билээ.

Монголын орчин үеийн яруу найрагт сонин содон бүтээлүүдээрээ өөрийн орон зайг эзэлсэн ардын уран зохиолч Б.Лхагвасүрэнгийн “Боржигоны бор тал” шүлгийг авч үзье.

Яруу найрагч нэгэн удаа өөрийн төрсөн Өнжүүл сумын нутаг болох, Даацын хоолой, Борын болон Жарангийн хөндий зэрэг олон газраар явж байхдаа өссөн төрсөн нутгаа харж бахдан шүүрс алдаж, “Боржигоны бор тал” хэмээн анх шүлгийн нэр нь орж иржээ. Энэ нутагт эртнээс нааш олон овог ястан холилдон нутаглаж ирсэн ирсэн бөгөөд түүний нэг нь боржигон овогтон байж. Найрагч өөрөө энэ овгийн хүн гэх дээр дурдсан хөндий, хоолойнууд ч “Боржигоны бор талын” үргэлжлэл ажээ. Бусад шүлгүүдээ бодвол харьцангуй хурдан бөгөөд намар таана толгойлсон талын тухай бодож байгаад

...Таанын цагаан толгойноос өөр

Тайтгаруулах цэцэггүй нүцгэн тал минь... хэмээн бичсэн ажээ.

Энэ тухай зохиолч “Шүлэг бичнэ гэдэг нь зүгээр нэг үгийн далайг шүүрдэж байгаад хэдэн мөр толгой холбон бичнэ гэвэл их эндүүрэл, ташаа ойлголт буй заа. Шүлэгт үзэл санаа, дүр, агуулга гэх мэт наад захын олон зүйлс байдаг” гэжээ.

Яруу найрагч энэхүү шүлэгтээ “хүн төрсөн цагаасаа эхлэн эх газар төрсөн нутагтайгаа амин холбоотой байж, насан эцэслэхдээ хүртэл газар дэлхийнхээ “элгийг цөмлөн эх газартаа уусдаг” учрыг оновчтой илэрхийлсэн юм.

Профессор Д. Галбаатар “Хүн байгаль хоёрын харьцааг маш нарийн боловсруулсан шүлэг гэхэд бараг буруудахгүй биз. Тэнгэр тийчиж төрөхдөө ч тал дээрээ, тэнгэр амьдралыг орхиод явахдаа ч талдаа л шингэнэ гэсэн санаа урьд өмнө давтагдаагүй билээ” хэмээн бичжээ.

“Боржигоны бор тал” шүлгийг зохиомжийн талаас нь үндсэн хоёр хэсэгт хувааж болмоор ажээ.

1. Өөрийн нутаг ус “Боржигоны бор тал”-аараа бахархсан монгол найрагчийн сэтгэлийн хандлага
2. Энэ сайхан тал нутгийн эзэн болж төрсөн хувь заяагаа насан хутгийг олтол, энэ нутагтай салшгүй холбоотой гэж үзсэн гүн ухааны хэсэг гэж өөрөө ч өгүүлсэн нь бий.

Зохиомжийн эхний хэсэгт:

...Санаа алдахад эхийн сүү

Тагнайд амтагдаж

Салхины үзүүр залгихад

Агь хоолойд аргасан... хэмээх дүрсэлж эхлээд

...Чиний шарх

Зүрхний шархнаас хождож анина тал минь... гэсэн хэсэг хүртэл 6 бадаг буюу 28 мөр хамаарагдаж байгаа бол харин хоёрдугаар хэсэгт:

...Тугалын бэлчээрээс эхлэн

Тоглоом дэлгэсэндээ чи

Намайг эрх болгосон ...гэх мөрөөс эхлээд

...Элгий чинь цөмлөн шингэнэ

Боржигоны бор тал минь хэмээх хүртэл 8 бадаг буюу 27 мөр шүлгээр шүлгийнхээ үндсэн агуулга, санаагаа нээн илэрхийлсэн бөгөөд эхлэл хэсэгт тал нутгийн байгалийн сайхныг харж бахархсан сэтгэл, харин төгсгөл хэсэгт тэр сайхан нутгаараа бахархан хайрлаж, “насан эцэслэхдээ ч түүнд л шингэнэ” гэсэн бодол эргэцүүллийг бий болгосон нь уг шүлгийн зохиомжийн онцлог юм.

“Боржигоны бор тал” шүлэгт эртнээс нүүдэлч амьдралтай монголчуудын зан заншил, амьдрал, эх нутаг хүн хоёрын хүйн холбоо, эх орноо хайрлан түүгээр бахархах монгол хүний сэтгэлийн тэмүүлэл, омгорхлыг үгийн их өвөрмөц утга найруулгаар гаргаж үгийн шинэ шинэ утга харьцааг нээснийг тэмдэглүүштэй.

...Тэргэл саран туулж баралгүй хээр хонодог

Тэнгэрийн хэвтэр буурал тал минь... гэхэд үнэхээр л монголын тал, тэнгэр хоёрын сайхныг харьцаа, орон зай, байрлалын талаас нь шагшин гайхахуйц тод дүрсэлсэн бол

...Нандин, эрхэмсэг, эгэл боргилын туйл

Нар хур царайчилсан газрын саальтай хормой минь зэрэг бадгууд дахь үг сонголт, сонгосон үгийн утга илэрхийлэл нь өөр ямар ч найрагчийн бүтээлд давтагдаагүй бөгөөд бага наснаасаа эхлэн мал адгуулан, төрсөн хүүхдийнх нь тоглоом хүртэл малынх бэлчээрт өрөөстэй байдаг монгол дэлгэр нутаг, мөнх бусыг үзүүлэхдээ ч хүртэл газартаа уусан шингэдэг өвөрмөц заншил, монгол үндэстний сэтгэлгээ цөм нүднээ дурайн бууж байна. Үүнд:

1. Монгол ахуй амьдрал, байгалийн төгс зохицлыг “Агь хоолойд аргасан, газрын саальтай хормой, сартай

шөнийн чинь чимээнд зангирах цагаан аялгуу” зэрэг дүрслэлээс харж болно.

2. Байгалийн чулуу-Хүүхдийнх нь тоглоом. Түүгээр дамжин монгол орны дэлгэр уужим нутаг, амгалан энх амьдралын бахархал хүн байгалийн харьцаа илэрхийлэгджээ.

3. “Сэтгэл сэргэм байгалиа хараад л дотор уужирлаа гэсэн дүгнэлт гарч ирж байгаа нь дээрх санааны тодотгол болж байна.

4. Хүн бол байгалийн бүтээгдэхүүн ийм учраас эргээд байгальдаа шингэдэг гэсэн гол санаагаа хүний амьдралын үхэх төрөх мөнхийн холбоонд дүрсэлсэн ажээ. Тухайлбал:

... Байдуу мянган уулсаа дууриан
Толгойд буурал сууж
Багадаа хөхсөн эхийн сүү
Гадагшлахын цагт...
...Сүүдрээ дарж унахдаа
Элгийг чинь цөмлөн шингэнэ

Боржигоны бор тал минь гэсэн мөрүүд илэрхийлж байна.

5. Байгаль хүнд хэрхэн нөлөөлөх вэ гэдэг асуулгад философийн шалтгаан үр дагаврын холбоогоор харуулсан нь шүлгийг гүн ухааны аястай болгосон юм. Үүнийг (уянгын “би” баатар) тоглоом дэлгэсэндээ “эрх”, сургамжийг хэлээгүйдээ “гэнэн” булгийн ундарга нь “эрэмгий”, уулсын орой нь “бадрангуй”, цагаан аялгуу нь “уяхан”, нутгийн түмэн нь “хүн” болгосон гэх зэрэг дүрслэлүүдээс харж болно.

“Боржигоны бор тал” шүлэг бол өөрийн төрсөн тал нутгаар төлөөлөн монгол хүн, амьтны амьдрал зохилдлогыг зураглаж, байгалийн гоо сайхныг дэлгэн харуулахдаа тал нутгаа амьдчилан гүтгэж дүрсэлсэн нь шинэ эрэл болжээ. Тухайлбал:

...Жаргал зовлон хоёрыг амсаж эдэлж
Чулуун дээр чинь баяр гунигийн нулимс унагахад
Эр хүн шиг нуруутай бай гэсэн шиг
Эргүүлж над руу цацан хатуугаас хатуу байсан чи...
Ботго нь үхсэн ингэний
Чинэсэн хөхийг нь амирлуулсан...гэх мэтээс харж болно.

Нөгөө талаас тал нутгаа дээдэлж, байгалийн гоо сайхан, нандин ихэмсгийг нь магтан дуулсан уянгын “би” баатар гэсэн хоёр дүр гарч байна. Жишээ нь: Тоглоом нь эрх, гашуун сургамжийг хэлээгүйдээ гэнэн, булгийн усны догшин цамнаа эрэмгий, уулсын орой нь байгалийн тансаг зураглал гэсэн өвөрмөц дүрслэлүүд батлах бизээ. Үүнийгээ:

...Нутаг усны минь хаяа өлзийтэй түмэн
Нуур тойрмын ширхэг чулуу хүртэл
Намайг хүн болгосон... хэмээн дүгнэж өгснөөс үзэж болно.

Шүлгийн хэл найруулгын онцлогийг ялгаж харахын тулд юуны өмнө холбоцод ажиглалт хийж үзье.

Толгой сүүл холбоц гэдэг мөрийн эхлэл, төгсгөлийг авиа, үсэг, үе, үг, хэлцээр ялгаруулан шүлгийн бадгийг тэгшлэн үүсгэдэг. Холбоцын ачаар шүлгийн хэмжээ, байгуулалт улам тодорхой, эмх цэгцтэй болдог.

...Тэнгэр тийчиж намайг төрөхөд тал минь
Торго шиг зөөлөн байсан чи
...Эр хүн шиг нуруутай бай гэсэн шиг

Эргүүлж над руу цацан хатуугаас хатуу байсан чи... мэтчлэн хагас холбоцоор яруу хандлагыг зохистой илэрхийлжээ.

Энэ нь нэгэн зүйл эн зэрэгцүүлэл болсон бөгөөд уламжлалт хос уянгын хэлбэрийг олжээ.

1. Яг адил биш боловч зарим авиаг төстэй байдлаар нь холбож давталт маягаар ашигласан байна.

2. Тэнгэр торго, жаргал, чулуун гэх мэт үгс нь хоорондоо бараг адил төстэй зүйлгүй боловч цөм нэрийн айд хамаарч тийн ялгалын нөхцөлөөр толгой холбосон байх юм.

Шүлгийн айзмыг тодруулагч хоёр дахь гол зүйл бол мөр бүрд орсон үе ба үгийн тоо юм. Зохиолч шүлгээ эхний мөрд 2, дараагийн мөрд 4, 3 дахь мөрд 3, 4 дэх мөрд 3, 5 дахь мөрд 3 үгээр гэхчилэн үгийн тоог ягштал тэнцүүлээгүй боловч тодорхой журмаар хоорондоо холбогдсон утга санаагаа чөлөөтэй илэрхийлэх хэлбэр задгай шүлгийн маягаар бичжээ. Тухайлбал:

...Хөрөөний ир шиг алсын намхан уулсын чинь орой
Хөх галын чинь ирт улаан дөл
Намайг бадрангуй болгосон... гэх мэт.

Уртавтар мөртэй шүлгийн хэмжээг тод болгох зорилгоор дунд нь зориуд зогсоц хийх, эсвэл мөр хагаслан бичих өөр нэг арга болох таслал буюу (цезура)-ыг өргөн ашиглажээ.

“Тэргэл саран, цагаан голгой, нүцгэн тал, гашуун сургамж, нүдэн булаг, догшин цамнаа, намхан уулс, хөх гал, цагаан аялгуу” гэх мэтээр тэмдэг нэр, “торго шиг зөөлөн тал, хөрөөний ир шиг уулс, хөх гал шиг уулсын

орой” гэх мэт зүйрлэл, “нандин эрхэмсэг, эгэл-боргил, гандах элэгдэх” гэхчлэн ойролцоо нэр, “жаргал-зовлон, нар-хур, баяр-гуниг” мэтчлэн эсрэг нэр, “тал минь, хатуугаас хатуу, боржигоны бор тал минь, болгосон” гэх мэт давталтыг өргөн ашигласан зэрэг нь түүний дүрслэлийн онцлог юм.

Мөн “талыг”

а. үгээр (бор, буурал, нүцгэн...)

б. холбоо үгээр (нандин эрхэмсэг...)

в. гишүүн өгүүлбэрээр (нар хур царайчилсан...) гэх мэтээр тус тус тодруулан, дэлгэрүүлсэн нь бас л нэг онцлог мөн.

Тэрчлэн

...Торго шиг зөөлөн байсан чи

Хатуугаас хатуу байсан чи...

...Хэлж зүрхлээгүйдээ чи... гэж өгүүлбэрийн. байгуулалтыг зориудын хүчжүүлсэн хандлыг ашигласан нь шүлгийн найруулга, өвөрмөц, айзмыг жигдрүүлэн, сонсоход уянгатай болгожээ.

Яруу найрагчийн үг сонголт оновчтой төдийгүй ул дол болсон улиг үгээс ихээхэн хөндийрч чадсан юм. Жишээ нь:... Боржигоны бор талын уужим тэнэгэр, саруул гэгээн болохыг зүгээр нэг тоочсонгүй. Харин ч түүнийг тодруулах үүднээс “саран ч туулаад бардаггүй” гэсэн амьдчилсан ихэсгэлийн аргыг хэрэглэсэн бол

... Тэргэл саран туулж баралгүй хээр хонодог

Тэнгэрийн хэвтэр буурал тал минь... гэж газрын дүрслэлийг байршлаар нь маш зөв илэрхийлж чадсан аж. Үүнээс гадна

... Чи л залгилж, зовлонг нь хугасалж

Чинэсэн хөхийг нь амирлуулсан

Дээдсийн шарил, харваж унасан тэнгэрийн солирыг ч

Дэлхийн төвтэй чи л нийлүүлсэн... гэх мэтээр монгол шүлгийн айзмыг тодруулагч нэг чухал зүйл болох эн зэрэгцүүллийн ёсыг салаавчлан ашигласан нь найрагчийн ур чадварын илэрхийлэл мөн.

1. Өсөж төрсөн эх нутаг монгол орноороо бахархах сэтгэл

2. Энэ нутаг төрсөн өөрийн хувь заяа, төрснөөсөө эхлэн эцэслэтлээ эх нугагтайгаа хүйн холбоотой байж, түүнийгээ хайрлан хамгаалах ёстойн учир хийгээд монгол ёс жудаг, амьдрал ахуйн мэдлэг олгоно.

3. Эх орныхоо байгалийн баялаг, гоо үзэсгэлэн, хагацашгүй үнэ цэнэ, нутаг орны байршил, онцлогтой танилцуулна.

Дүгнэлт:

Дэлхийн яруу найргийг их уст мөрөн хэмээн үзвэл, монголын яруу найраг түүн лүү цутгаж буй нэгэн цутгалан, салшгүй нэгэн бүрэлдэхүүн хэсэг. Энэ усыг бүрдүүлж буй олон яруу найрагчид бий. Гэвч тэдгээрийн дотроос үе үеийн уншигчдын зүрх сэтгэлийг эзэмдэн мартагдалгүй, харин ч удах тусам улам үнэ цэнээ олох уран бүтээл төрөх нь ховор. Эдгээрийн нэг нь дээрх яруу найрагчдын шүлгүүд юм.

Дээрх зүйлүүдээс дүгнэлт хийвэл:

Эдгээр яруу найрагчдын амьдарч буй орчин, цаг хугацааны хувьд ялгаатай ч эх орны тухай алдаршуулан дуулсан дуулал нь адилхан агуулгатай бөгөөд өмнөх үеийнхээ уламжлал дээр суурилан, өөрсдийн авьяас чадвараар баяжуулан шинэчилсэн байна. Энэ нь Д.Нацагдорж өөрийн шүлгийг бичихдээ монгол орны онцлогийг 12 бадагтаа тараан цацаж, эргээд түүнийгээ “Энэ бол миний төрсөн нутаг, монголын сайхан орон” гэсэн уянгын цацал болсон 2 мөрөөр буцааж хураангуйлан бичсэн бол, Б.Явуухулан бадгаа хашин, хашсан санаагаа нэмэн дэлгэрүүлж, эргүүлээд тэр санаагаа хураасан, тэгвэл Б.Лхагвасүрэн “Хүн бол байгалийн бүтээгдэхүүн ийм учраас эргээд байгальдаа шингэдэг” гэсэн гол санаагаа хүний амьдралын үхэх төрөх мөнхийн холбоонд дүрсэлсэн байх жишээтэй.

- Монгол ахуй, зан заншлыг илэрхийлж буй сэтгэлгээний онцлог өвөрмөц өөр, өөр. Тухайлбал,

- Шүлэглэх ур чадвар, дүрслэлийн арга барил бие биеэс ялгарах өөрийн гэсэн өнгө аястай. Тухайлбал: Тал нутгийг дүрсэлсэн дүрслэгдэхүүнийг авч үзье.

Д.Нацагдорж:

Хангай говийн хооронд

Халхын уудам нутаг

Хар бага наснаас хөндлөн гулд давхисан газар

Гөрөөс араатан авласан урт урт шилүүд

Хүлэг морин уралдсан хөндий сайхан хоолойнууд

Энэ бол миний төрсөн нутаг

Монголын сайхан орон

Р.Бигэрмаа

Б.Явуухулан:

Онгон цэнхэр талыг эзэгнэнхэн төрлөө би
Орог саарал зэрэглээ хавар сүүмэлзэх хөндийд
Орсон буурын шүд өвөл хангинах хоолойд
Үлэг гүрвэлий мөрийг өдий хүртэл хадгалсан
Онгон цэнхэр талыг эзэгнэнхэн төрлөө би...”

Б.Лхагвасүрэн:

...Тэргэл саран туулж баралгүй хээр хонодог
Тэнгэрийн хэвтэр буурал тал минь...
Нандин, эрхэмсэг, эгэл боргилын туйл
Нар хур царайчилсан газрын саальтай хормой минь

ABSTRACT

Generally, the literature of any nation evolves in a similar way with development of its history, society and culture. The history of written literature in Mongolia accounts over 1000 years and the poetry is rightfully acclaimed as having the deepest roots of tradition and widest popularity among people. Poetry is a sumptuous merit of the national mentality, the inner world of the human soul, its desires, goals as well as its cultural and artistic world.

The contemporary poetry in Mongolia is considered started after the national revolution. Its history begins with a revolutionary thematic song - “Shivee Khiagt”, which was created among soldiers. Since that time, the Mongolian poetry has been developing and improving during over eighty years, on basis of a rich heritage of the written literature and the national folklore, adopting the best experiences of the world classical literature as well as reflecting the demands of the present time.

In this article, author proved that the specific feature of poetry by D.Natsagdorj, B.Yavuukhulan and B.Lkhagvasuren. The main purpose of this article is to mention about Innovation.

“Innovation” in literature is seen as a process where young poets enrich the poetic legacy of the predecessors with their thinking, skills of representation, rhyming style, methods and rules, which ultimately results in creation of a new approach, image, thought and artistic shapes that are accredited by public and has own successors.

However, the experience of previous poets and the anthological base that they leave for next generations to start their work onto and to continue the poetry succession is called “tradition”. Tradition and innovation are two inseparable sides of a whole integration, where any loose ties between them can eliminate any possibility to further advancement or poetic invention and prevent the essential development and periodic rearrangements.

Tradition and innovation exist in a tight nexus, where the differences between previous and present generations of creators become the very innovation.

Д.Норовын “Тэжээвэр” туужийн дүрийн сэтгэлзүй

Р.Алтансайхан*

Өнгөрөгч зууны дундуур монгол туужийн төрөлд орж ирсэн нэг том төлөөлөгч бол Төрийн шагналт зохиолч Д.Норов юм. Хүүрнэл зохиолын бүх жанраар бүтээлээ туурвидаг уянгын өгүүллэг, тууж, хэд хэдэн роман бичжээ. Түүний зохиолын хэв маяг, арга барил нь түрүү үеийн Д.Мягмар, С.Эрдэнэ, С.Пүрэв зэрэг томоохон хүүрнэл зохиолчдын урлах арга зүйтэй ойролцоо, уянга-туульсын хосолмол хэв шинж бүхий, хэлбэр хийгээд агуулга, зохиомж ба ерөнхий байгууламж, уран сайхны сэтгэлгээний хэв маягийг хослуулсан нь уншигчдыг их татдаг. Тогтсон хэв маягт баригдаагүй, элдэв номлол сургаал шинжтэй бус харин чөлөөтэй сэтгэж, хэрэг явдлыг логикийн үүднээс нягт нямбай бодож боловсруулсан, сайн найруулгаараа үеийнхэн дотороо илт ялгардаг. Ялангуяа Д.Норовын өмнө хийгээд одоох туурвилд өгүүллэг, туужууд гол байр суурь эзэлдэг гэж болно. Тууж өгүүлэгийн дүрийн сэтгэлзүйн асуудал, дотоод ертөнцийг нээж, сэтгэлгээ ба ахуйг гүн шүтэлцүүлсэн хэв шинж, онцлог нь олны анхаарал, сонирхол татдаг билээ.

Д.Норовын “Тэжээвэр” /1989 он/ туужийн тухайд доктор Д.Галбаатар ““Тэжээвэр” туужийн гол баатар хайгуулчин Гөлгөө хуучин социализмын үеийн хүнд суртлын систем, нийгмийн дотоод ялзралыг нийгмийн дээд хэсэгт хамаарах нэгэн яамны орлогч сайд, мөн нэгэн генерал, түүнийг тойрон хүрээлэгчид ба бусад үе залгамжлагчид /сайдын охин Туяа, генералын охин Саргай, Орлогч сайдын ивээлд багтсан мэргэжилгүй мэргэжилтэн буюу долгомцог Цогтоо, жинхэнэ сайдад эхнэрээ булаалгаж, орлогч сайдын асрамжинд өсөөд дараа нь нууц амраг нь болсон Цэнгэл /тэр эцэг нэг, эх ондоо төөрөлдсөн ах дүүс/ нарын баатруудын бусармаг, ичгүүрт амьдралын түүхийг зохиолч /хэсэг бүлэг хүмүүсийн үйл ажиллагааны явц дундаас нээн илчлэгч, баалан яллагч, аянгын хүрд болсон” /“Монгол уран зохиолын дээжис” 86 дугаар боть, Уб., 2007., 16 дугаар тал/ хэмээн дүгнэжээ.

Бид сэтгэлзүйн зохиол /дүр/ гэхээр Ф.Достоевскийн “Гэм зэм” романы Родион Раскольников шиг далд ухамсарт нуугдаж байдаг “айдас”-таа хөтлөгдөн хүний амь нас бүрэлгэсэн эмгэнэлт дүрээр төсөөлдөг, судалгааны тийм нэг цаг үе байсан нь нууц биш. Уянгын зохиолын баатрын сэтгэлзүйн асуудал түүний сэдэл санааны ертөнцийг/мотивууд/-ыг шинжлэх үзэх нь орчин үеийн утга зохиол судлалын гол анхаарлаа хандуулж буй чиглэл бөгөөд орчин үеийн шинжилгээний арга барил ихээхэн өөрчлөгдсөн хэдий ч хэт хэлбэр хийгээд үйлдлийг хөөсөн тайлбар тайллуудыг уншигчид төдий л ойшоохгүй болжээ.

Энэ туужийн олон асуудлын нэг яах аргагүй тухайн үеийн ёс суртахууны асуудал юм. Ер нь ёсзүй, ёс суртахууны асуудал аль ч цаг үед анхаарлын төвд байсан бөгөөд хэзээ ч ач холбогдолоо алдаж байгаагүй чухал сэдэв.

Д.Норовын эл туужийн гол дүр Гөлгөөг бид сэтгэлзүйн зөрчил, дотоод ертөнц, амьдралыг үзэх үзэл төлөвшин тогтоход хүний бага нас, аж төрж, туулан өнгөрүүлсэн ахуй амьдралын хэв маяг, жаргал зовлон, удамшил, ойр дотны хүмүүсийн харилцаа хэрхэн нөлөөлж байдгийг илтгэсэн сэтгэл зүй, уран сайхны дүр хэмээн үзэж байна.

Зохиолч Д.Норов “Тэжээвэр” туужийнхаа гол баатар хайгуулчин Гөлгөөгийн амьдралыг Цэнгэлийн нөхөр хөдөө хүргэнийдээ амарч байхдаа малын эрэлд явж байгаад хээр тааралдсан хайгуулчийн майханд ороод сураггүй алга болсон эхнэрийнхээ зургийг олж, мөн Гөлгөөгийн өдрийн тэмдэглэлээс /*зохиолд нийтдээ 39 өдрөөр хөтөлсөн урт богино хэмжээтэй өдрийн тэмдэглэл бий*/ түүний бага нас хийгээд амьдрал, үйл явдлыг сонирхолтойгоор тайлан өрнүүлэх өвөрмөц зохиомжийг ашигласан байна.

Дүрийн зан төрхийг бусад дүрийн бодол санааны элементүүдийг ашиглан оновчтой нээсэн аж.

Гөлгөө бол этгээд зожиг, ганцаардмал зан араншинтай нэгэн болохыг туужийн эхэнд “... зэлүүд мал дагасан чоно боловч тогтомгүй агаад бас халууныг яана. Гэтэл ганц хүн тавтайяа суурьшин, ажил албаа гүйцээнэ гэхэд санаанд багтамгүй. Уйдаж үхмээр газар.” гэж Цэнгэлийн нөхрийн бодлын урсгалаар нээн тодорхойлжээ. Зохиолын цаашдын өрнөлөөр түүний майхнаа барьсан газар буюу “Сүжийн ус” нэртэй газрын тухайд: “Сүжийн усанд ойр гэсэн бол ядаж Даамангийн тэр сайхан саравчтай хаашаатай бууцны дэргэд, зүлгэн дээр буучихаж болно оо доо. Гэвч энэ хүн тэгсэнгүй, заавал өөд өгсөж, хүн тавьдаг хонд

*МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын докторант

барааддаг байна шүү. Нутаг мэдэхгүй болоод тэр байх даа. Ер нь мэдсэн ч зориуд тэнд буух хүн шиг санагдаад байлаа” /Д.Норов “Хөх туужис”, Уб., 2001, 6 дугаар тал/ гэжээ.

Баатрын өөрийнх нь дотоод ертөнц: “Цогтын зохион байгуулсан зугаа цэнгэлийн тухайд туужийн баатар “Тэднийг балчигт живүүлж үлдээгээд, би орхин одох нь тун эвгүй зүйл болно гэдгийг гадарлажээ. Гэтэл тэдний надад тулган хүлээлгэх гээд байгаа зүйл нь миний зан суртахууны чанар, хүсэл шуналаас даанч доогуур бохир зүйл байв.” /гэсэн Гөлгөөгийн өөрийнх нь тодорхойлолтын өнгө аяс нь тухайн үеийн нийгэм дэх залуусын хөнгөн хөвсрөгө амьдрал, сонирхол, нууж хааж үздэг хориотой порно хийгээд эротик кино, зугаа цэнгэл Гөлгөөгийн сонирхлыг огт татахгүй байгаа нь түүний цэвэр цэнгэг сэтгэлийн ертөнц төдийгүй зохиолчийн сэтгэл санаа түүнтэй нэгдэн нийлж, баатрын дотоод ертөнцийг нээх боломжийг бий болгож байна. Ялангуяа Гөлгөөтэй хамт ажилладаг Цогт, Саргай, Туяа, Туяад санаархагч найрагч нарыг дөнгөсөн хэсэг юм. Иймээс ёсоор бол Гөлгөө бусдын сэтгэл санаа, үйл хөдлөлийг дагуулан өөрийнхөө оновчтой шийдэл, сэтгэл зүйн арга барилаар эргүүлж, бас түүнээсээ сэтгэл ханамж, таашаалыг авдаг этгээд, гаж гэмээр хувийн зан араншинтай бөгөөд энэ нь түүний сэтгэл зүйн орон зайд орогносон сэтгэл зүйн олдмол хэв шинж буюу эмгэг нь юм. Гэвч энэ дүрийг гаргаснаараа “Тэжээвэр” тууж нь урлаг, уран зохиол дахь гедонизм /Чухам энэ үүднээс сэтгэлийн таашаал өгөх болоод авах оюун санааны цэнгэл эдлүүлэх нь уран зохиолын үүрэг томилол мөн. С.Энхбаяр “Утга зохиолын онол” Уб., 2011, 83 дугаар тал/-ын онол үүргээ биелүүлсэн юм.

Гөлгөө хэдийгээр хатуу чанга, этгээд нэгэн боловч дотроо туйлын өрөвч зөөлөн сэтгэлтэй, түүний амьдрал хар нялхаасаа хатуу хөтүү аснаас үүдэлтэй, үүнээс нь амьдралд өширхсөн сэтгэл зүй бий болж, хүний дор орохгүй, хүнд муугаа үзүүлэхгүй гэсэн нэг ёсондоо “аминчхан” үзэлтэй хүн болгосон аж.

Хойд эцгийн харгис зодуур, эхийг нь хэмлэн зовоох хүнд бэрх амьдралын дарамтыг Гөлгөө багаас амссан юм. Үүнийхээ хэр хэмжээгээр Гөлгөө бүхнийг шүд зуун тэвчдэг нэгэн болсон байлаа. Тэр үүнийгээ: “Би чинь тэжээвэр нохойн гөлөг нэртэй өслөө шүү дээ. Аав намайг өөрөөр нэрлэдэггүй байсан юм. Ээж нохой, би гөлөг нь. Эцгийгээ зодоход шүд зуун яаж ч зодсон дуу гаргадаггүй, тэгэхэд нь эцэг улам хорсон галзуурах шахдаг байлаа. Би бах таваа ингэж л хангадаг байлаа” /Д.Норов “Хөх туужис”, Уб., 2001, 62 дугаар тал / гэсэн өчиглөл түүнийг хар нялх наснаасаа харгислал, хэрцгий зодуур, доромжлолоос нь бяцхан хүүгийн өөрийн сэтгэлзүйн хат, өширхүү хатуу сэтгэлтэй болж төлөвшихөд нөлөөлсөн аж. Тэр, “хар нүд хөмсөгнөөс гадуур” гэгчээр л явж баймаажин хүн болсон нэгэн. Гөлгөөгийн хувьд туулсан амьдрал, хувь хүний хүмүүжил, биологийн дадал зуршил, дотоод, төрөлх ухамсрын ертөнцөд хураагдсан түүний амьдралын маш олон тохиолдолд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж буй нь уг тууж сэтгэл зүйн хэв шинж бүхий сонирхолтой туурвил болохыг харуулдаг билээ. Түүний амьдралын гол зарчим болгодог “Хүнд муугаа үзүүлэхгүй байх”, “Хүний дор орохгүй байх” / Д.Норов “Хөх туужис”, Уб., 2001, 23 дугаар тал/ зэрэг энгийн юм шиг ойлголтууд нь өөрөө өөртөө бий онцгой маягийн “объект” басхүү түүний эхийнх “үр зулзагаа үлдээх” тэмцлийн явцад бий болсон олдмол хэв шинжүүд билээ. Нэг талаас байгальлаг шинж, оршихуйн төлөөх тэмцлээр буй болж байгаа захиас юм. Үүнийг хүнд заяасан, байгаль эхээс өгсөн хүчирхэг инстинкт / зөн билэг/далд ухамсарын нийлэгшил хэв шинжтэй гэж болно.

Гөлгөөгийн тухайд ээжийнх нь аж төрөл, яриа хөөрөө, захиа сургаал нь сэлт амьдралынх нь улаан шугам болсон аж. Гөлгөө энэ тухайгаа Туяад итгэж ярьсан боловч түүгээр өрөвдүүлэхийг харин огтхон ч хүсээгүй юм. Гөлгөө сургуулийн хоёр найз, Саргай ба бусад эрээвэр хураавар хүмүүсээс илүү дотно найз, нөхөд гэж байхгүй. Тэр хэнд ч өөрийгөө нээж, хүсэл мөрөөдөл, шаналал зовлонгоо хуваалцдаггүй хүн.

Тэрээр өөрийн тухайд: “Надад зан суртахуун, оюун санааны хэрэгцээ байдаг юм. Би хэн нэгтэй тэрсэлж, дайжигнаж, оюун ухаанаараа түрээ барьж, дээгүүрээ туг доогуураа шалдан умахум юмнуудаар наадах дуртай. Ер нь би этгээд аранишин, хоёрдмол сэтгэл, хорон санаатай, хэрцгий этгээд байж болно шүү дээ. Үүгээрээ би ямар ч бузар хэрэг хийгээгүй” / Д.Норов “Хөх туужис”, Уб., 2001, 75 дугаар тал / гэжээ. Ухамсарын гадаад сэтгэцийн хүрээ нь юуны өмнө хүрээлэн буй орчноос мэдрэхүйд өртсөн ямар нэг хүчин зүйлээр дамждагийн адил Гөлгөөгийн бага насны амьдрал түүнийг хүнд итгэдэггүй, хүнийг сэтгэл санааг зовоож, хүмүүсийн харьцаа ээдрээг нь хянаж түүгээрээ сэтгэл санааны таашаал авдаг этгээд дүр юм.

Гөлгөөгийн хайр сэтгэлийн асуудал мөн сонирхолтой. Амьдралд нийтлэг байдгаар бол албан тушаал, бэлэнчлэх сэтгэл, ерөөс биеийн амрыг харвал царайлаг бас амьдралын боломжтой, өөрт нь сэтгэлтэй Туяаг сонгож болох ч Гөлгөө харин ч эсрэгээрээ Цэнгэлийг сонгоно. Энэ түүний экзистенци юм. Төрөлхийн бус нийгмийн дотроос улбаалж гарсан олдмол зан төрхийн нэг жишээ юм. “Эго гэдэг нь бид өөрсдийн дотоод ертөнцдөө арчлан ургуулсан өвөрмөц бүрдэл юм. Тэр бидний анхаарал, хүсэл зоригийн төвд байрлах бидний ухамсарын төв. /К.Юнг “Бэлгэдэлт амьдрал”, Уб., 2011, 6 дугаар тал/

Бид “Тэжээвэр” туужийн Гөлгөөгийн дүрийн сэтгэл зүйн зарим нэг ойлгомжгүй, уншигчид анзаардаггүй асуудлыг тодруулахыг хичээсэн билээ. Иймд дараах хэдэн зүйлийг голлон тодорхойлж гаргахыг оролдсон юм.

1. Уран сайхны дүрийн төлөвшилд баатрын ухамсар-сэтгэхүйн хэлбэршлүүд нь хүрээлэн буй орчин, ахуй нөхцөлөөс мэдрэхүй ухамсарт өртсөн байх бөгөөд ой санамж зэрэг субъектив зүйлүүд ч түүнд эх үүсвэр нь болж байдаг. Баатрын дүрд хүүхэд насных ахуй нөхцөл шууд нөлөөлжээ. Тиймээс “Тэжээвэр” туужийн гол

дүр Гөлгөө бусдаас өөрийгөө өөр гэж бодох, үүнийгээ “Би чинь хүйтэн салхи, жихүүн хавар шүү дээ” гэж тодорхойлох шалтгааныг бий болгожээ.

2. Хүн эхийгээ хайрлах гэдэг ухамсар, оюун ухааны үйл биш. Энэ нь зүгээр төрөлхийн зөн /инстинкт/ гэдгийг Гөлгөөгийн эхийгээ шүтэх, хүндлэх сэтгэлзүйн байдал бүрэн харуулж байна. Зохиолд “Аавыг ууртайхан юмуу, согтуу байвал ээж намайг хурдхан гаргаж холдуулахыг хичээнэ. Гэвч би явдаггүй байлаа. Намайг байхгүй бол ээжид уур хорслоо гаргах болно. Тэрний оронд өөрөө зодуулж байхад сэтгэл шархирах нь бага... Миний хүү хүнд битгий муугаа үзүүлээрэй, өөрийнхөө яаж өссөнийг, ээж нь яаж амьдрасныг битгий мартаарай” /Д.Норов “Хөх туужис”, Уб., 2001, 63 дугаар тал / гэж захисныг тэрээр хэзээ ч мартсангүй.

3. Багаасаа хайр энэрлийг зохих хэмжээгээр эдлээгүй хүн бусдыг дутуу хайрлах, хэрцгий, заримдаа бүр гаж гэмээр зан чанараар нь илэрдэг гэдгийг Гөлгөөгийн дүр харуулна. ...Цэнгэл, Туяа хоёрыг тэрсэлдүүлэн тэмцэлдүүлж, өөрөө “...Хамгийн хөөрхөн нь ав гэж хаясан тэр алимь хоёр бүсгүйн хэн нь ч шүүрч авахаар завдаагүй байсан юм. Одоо шүүрэлцэнэ. Би түүнийг хажуугаас нь харж суух болно. Гэвч хэргийн гол нь алимь хэн авахад бус, харин тэр алим нь ямар амттайд л байгаа юм. Харахад алим боловч хазахад даанч гашиун даа. Миний зүрх сэтгэл ийм юманд салшгүй хомхой” гэх өөрийнх нь бодол илтгэх бөгөөд “Сэтгэл татагдах тусам өөртэйгөө төдий чинээ тэрсэлдэж, өөртэйгөө үхэн хатан тэмцдэг. Сэтгэл зүрх минь дийлнэ үү, оюун ухаан минь ялна уу тэрнээс л бүх юм шийднэ.” /Д.Норов “Хөх туужис”, Уб., 2001, 74 дүгээр тал/ зэрэг баримтууд баатрын сэтгэл зүйг байнга хянаж өөрөө өөртэйгөө зөрчилдөж, заримдаа санаатайгаар өөрийгөө шийтгэх байдлаар илэрч байна.

4. Гөлгөө бол амьдралд хорсолтой, тэрээр эхээсээ бусад баатруудтай сэтгэл зүйн хувьд ямагт зөрчилдөж байна. Үүнд: хойд эцэг-Гөлгөө; хадам аав-Гөлгөө, Туяа-Гөлгөө, Цогт-Гөлгөө гээд зохиолын ихэнх дүртэй ер таарч тохирдоггүй нь Гөлгөөгийн өөрийнх дүр дотооддоо хичнээн их зөрчил буйг илтгэнэ. Зохиолд үүнийг баатрын өөрийн өчилөөр “Миний сэтгэлд асар их зөрчилдөөн болж байдаг. Тэр маань намайг хэдэн хэсэг тасчин хуваааж, зовоож шаналгаж, заримдаа нэгдэн дийлж намайг дийлсний төлөө хөлгүй найр хийж, сүнс сүлдээр минь тоглодог. Заримдаа хар хор, атаа жсөтөө, үзэн ядалт, уйтгар, цөхрөл болж байдаг. Заримдаа уярааж, хүйтэн цэвдэг бүхнийг минь хайлуулж, хайр нигүүлсэл, мөрөөдөл, бишрэлээр бялхуулж байдаг.” /Д.Норов “Хөх туужис”, Уб., 2001, 75 дугаар тал/

5. Хүүхэд ахуйн дурсамжууд сэргэж, сэтгэцийн үйл явцад нөлөөлөн, бие хүн эсвэл түүний эсрэг хандуулах ба хүүхдийн дарамтлагдсан хүслийн хор хөнөөл тод илэрч байхад нөгөө талаасаа сэтгэл зүйн баримтыг /амьдрал дахь таагүй дурсамж/ ой санамжаас устгах боломжгүйг Гөлгөөгийн дүр харуулжээ. Энэ нь Фрейдийн ухамсарыг мэдрэхүйн өгөгдөхүүнээс гаралтай гэж үздэггүй хэрнээ ухамсарт бус зүйлийг ухамсараас гаралтай гэж үздэг рациональ үзэлтэй зөрчилдөж, харин эсрэгээрээ мэдрэхүй бол харин ч ухаалаг бус иррациональ шинжтэй гэдэгтэй санал нийлэхэд хүрнэ.

Сэтгэх, мэдрэх хоёр эсрэг тэсрэг зүйл тул сэтгэхүй нь мэдрэхүйн үнэт зүйлийг шууд няцааж орхидог шиг Гөлгөөгийн дүр нь амьдралын хоорондох холбоог илтгэх үнэлэмж, сэтгэцийн дотоод зөрчилтэй хүчин зүйлтэй тэмцэлдсэн сэтгэлзүйн дүр юм.

Summary

In this paper author discusses the psychological conflict of Gölögö, a main character of the novel “Tejeever” by D.Norov and his inner nature and values of life, which are formed in childhood and human lifestyle that how happy or sad situation deals with and how communication with home-folks influences on. This character is considered to be a character of psychology that shows the value and psychological inner universe in a feel-thinking way.

Ном зүй:

1. Д.Норов “Хөх туужис”, Уб., 2001 он
2. “Монгол уран зохиолын дээжис” 86 дугаар боть, Уб., 2007 он
3. С.Энхбаяр “Уран зохиолын онол”, Уб., 2011 он
4. К.Юнг “Бэлгэдэлт амьдрал”, Уб., 2011 он

С.Надмидын “Хүйтэн сэтгэл”-ийн халуун үйл явдал

Д.БАТЖАРГАЛ*, Э. АМАРЗАЯА **

Түлхүүр үг: Хүүхдийн богино өгүүллэг, түүний нас сэтгэхүйн онцлог, туурвил зүй, уран чадварыг шинжлэх асуудал

Үлгэр бүхэн сайхнаар төгсдөг нийтлэг тайлал, хэв шинжтэй байдаг. Үлгэрийн энэ шинж төлөв нь уншиж, сонсож байгаа хүүхдийг хүмүүжүүлэх үүрэгтэйгээс гадна хүүхдийн сэтгэл дэх нуугдмал зөн билэг нь энэхүү сайхан төгсгөлийг сайшааж “чухам ингэх л ёстой доо!” гэсэн дэмжсэн байрнаас урам, хөөртэй хандаж байдаг. Үлгэр муухай төгсдөг бол хүүхдүүд таашааж сонирхон дурлахгүй байсан биз ээ.

Өвөг дээдсээс үр ач нартаа ярьж өгдөг байсан үлгэрээс гараагаа эхэлж эдүгээ цагт “хүүхдэд зориулсан өгүүллэг” гэх зүүлт нэрийг олоод байгаа уран зохиол дахь туульсийн төрөлд хамаарах энэ тусгай зүйл ч анхдагч зүй тогтол мөн чанараас гажихгүй нь тодорхой.

“Уран зохиол хүүхдийг ариун гэгээн, шударга хүмүүс болгох, амьдралын үнэний сайн мууг ялган, сайныг дэмжих, мууг жигших сэтгэлийг төрүүлдэг шидэт урлаг тул зохиол уншсан хүүхэд ямар нэг муу үлгэр дууриалаас татгалзаж чаддаг аж”¹

Хүүхдийн уран зохиолын туурвилзүй хэмээх ойлголтод өгүүллэгийн агуулга, хэлбэр, зориулалт онцлог зүйчлэл, бичих арга зүй, үүдэл санаа, өгүүлэмжийн дэлгэрүүлэлт зэргийг хамааруулан ойлгож байна.

Зохиол дахь өгүүлэмж, үйл явдлыг өсвөр насны уншигчид өөртөө шууд тусган авдаг тул хүүхдэд зориулсан өгүүллэгт энэ онцлогийг сайтар харгалзана. Иймээс эр эмийн бэлгийн харилцаа, хүйсийн ялгамжтай байдал, амьдралын жам ёсны төгсгөл, мөхөл гэх зэрэг сэдвээр товойлгон бичдэггүй нь уран бүтээлчийн хаалттай нөхцөл гэхээсээ илүү хүүхдийн нас сэтгэхүйн эмзэг байдлыг хамгаалж харгалзаж буй хэрэг.

Эддрээтэй, нийлмэл нарийн бүтэцтэй, олон талт ойлголтыг хөнгөрүүлсэн байдлаар, зөөлрүүлсэн хэлбэрээр бичиж туурвих энэ нөхцлөөс уран дүрслэл, туурвихуйн уран чадварыг тодорхойлж болно. Туурвихуйн уран чадвар бол өөрийн гэсэн ур дүй, зүйрлэл дүрэм горимтой байна.

Эдүгээ хүүхдэд зориулсан өгүүллэг нь анхдагч хэв маягаасаа ихэд өөрчлөгдөн, хөгжиж сэдэв, агуулга, хэлбэрийн хувьд илүү баяжиж байна. Үүнийг дагаад хүүхдэд зориулсан уран зохиолыг хүүхдийн насны онцлогоос илэрч байдаг сэтгэл зүйн өвөрмөц байдалтай харьцуулан судлах байдлыг орхигдуулсанаас өгүүллэгийн төрөл ангилал, туурвилзүйн тухай ойлголтыг нарийвчлан судлах асуудал гарч ирж байна.

Хүүхдэд зориулсан өгүүллэгийн өвөрмөц онцлог, туурвилзүйн ур чадварын асуудлыг дэлгэн шинжлэхийн тулд С. Надмид “Хүйтэн сэтгэл”², өгүүллэг нь утга зохиолын онолын хүрээнд урьд судлагдаж байгаагүй агаад хойшид үнэ цэнээ алдахгүй, өсвөр насны уншигчдад нөлөөлөх уртай, өгүүлэмжийн баялаг хэллэгтэй, сайн бүтээл мөн тул туурвилзүйн задлал, хүүхдийн сэтгэл судлалын арга тайлбартай хослуулсан судалгаа хийж, ур чадварын үнэлэлт тайлбар хийхийг зорилоо.

С. Надмидын “Хүйтэн сэтгэл” өгүүллэг нь (1981он) туурвилзүйн далайц, сэдэв агуулгын хувьд зохиолч П. Пүрэвсүрэнгийн “Өшөө”³ өгүүллэгтэй дүйхүйц юм. Ийм нарийн өгүүлэмж, гүнзгий сургамжтай санааг хүүхдийн уран зохиолд зоримогоор дүрслэн гаргана гэдэг туурвилзүйн гүнзгий ур чадвар шаардагдана. Уг өгүүллэг Баяраа нэртэй нэгэн хүүгээс найзууд нь дөлж зугтааж байгаагаар эхэлнэ.

“Баярааг найзууд нь тоохоо больжээ. Орой нь зүв зүгээр байсан хүүхдүүд өглөө гэхэд л түүнээс зугтаах болов. Зарим нь бүр адгийн муухайгаар хялайн харж байлаа.” Энэ бүгдээс болж Баяраа гайхахад хүрч байна.

“...Ноднин самрын модноос унаж хөлөө гэмтээхэд хүүхдүүд ингэж муудаагүй. Харин ч гэрээр эргэж ирдэг байсан. Хамгийн муу жаал Боорой хүртэл надад бүтэн гөөхий авчирч өгсөн. Гэтэл энэ зун эв эрүүл байгаа. Хэнийг ч шоглоогүй. Элдэв муу үгээр доромжлоогүй. Яагаад манай зуслангийн жаалууд надтай тоглохоо болив?...” Түүнийг харсан хүүхэд болгон мангас харсан мэт зугтах тул Баяраа найзуудаасаа орхигдож ганцаардаж эхлэв.

“...Баяраа ганцаарджээ. Нуруугаа үүрээд, өвгөн шиг бөгтөгнөн, зүүн уул өөд алхав. Долоохон хоногийн

*МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын багш, доктор

**МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын магистрант

¹ Д. Галбаатар “УРАН ЗОХИОЛ: онол, түүх, шүүмжлэл” Уб, 2012, 484 дугаар тал

² С. Надмид “Жаран дэгдээхэй” Уб, 2013, 176 дугаар тал

³ Г. Аюурзана, Л. Өлзийтөгс. Монголын сонгомол өгүүллэг. Уб, 2007, 86 дугаар тал

дотор өвгөн болчихсон юм шиг санагдлаа. Сүүдрээ хараад тэгж бодов. Тэр зүүн уулын наад талын халцгай дээр байдаг томоос том чулуун дээр удаан суухдаа зуслангийн олон эгнээ алаг байшин, оройн намуунд хөгжилтэйгээ наадаж байгаа хүүхдүүдийн шуугианыг сонсож байв...” Түүнээс бүгд дөлж зайгаа барив. Баяраа энэ явдлын учрыг хичнээн тунгаахч олж эс чадав. Өгүүллэг уншигчдыг үл мэдэгдэх учир явдлын үзүүрт хөтөлж ирэв. Цааш хэрхэн өрнөх бол?

“...Хичнээн сайхан өдөр байсан гэж санана. Ёстой л тоглож баймаар. Хэн ч муу муухай юм бодохын аргагүй цэлмэг, сэрүүхэн. Шөнө бороо орж, өглөө цэлмэсэн болохоор хурын чийг, цэцгийн үнэртэй холилдон сэнгэнээд гоёхон. Байгалийн энэ тансаг сайхан Баяраагийн уйтгарыг хөөн, сэтгэлийн ариусгах шиг болжээ. Хүүхдүүд шуугилдсаар... Баяраа хэдхэн харайгаад найзууд дээрээ очжээ. Гэвч түүнийг урьдын адил хэн нь ч харсангүй...” Хамт тоглодог байсан найзууд өөрөөс нь яагаад холдсоныг Баяраа ухаж үл ойлгон гайхширч улмаар ганцаардалд автаж сэтгэлзүйн цочрол, сэтгэхүйн уналтанд орж байна. Учрыг нь үл ухах таамаг бодлууд хөвөрсөөр. Баяраа руу өөрийг нь сайн мэдэх Сувдаа хэмээх найз нь харлаа. Одоо л мэндлэх байх даа? гэж уншигчид найдсаар байна.

“...Харин Сувдаа охин харав... Харах ч гэж дээ, жигшсэн нүдээр хялайн, цэвэрлэсэн лууван шиг хурц улаан хэлээ гарган, ширэв татлаа. Баяраа буцаад гүйв...” Эндээс Баярааг яагаад найзууд нь үзэн ядах болсон шалтгаан нь тодорч эхэлнэ.

“...Юу гэвэл долоо хоногийн өмнө Баяраа найзуудтайгаа ууланд явсан юм. Тэр эр зоригийн тухай нөхдөдөө сайрхан ярьж явлаа.

-Би юунаас ч айдаггүй гэж түүнийг хэлэхэд, найзууд нь:

-Нээрээ юу? гэв.

-Нээрээ шүү! гэж Баяраа хэлжээ. Нэг мэдсэн Баяраа алга болов. Хаана, юу хийж явааг бүү мэд. Тэгсэн чинь амьсгаадсаар гүйж ирэв. Цамцандаа ямар нэг амьд амьтан боосон бололтой. Жирх барьжээ.

-Хаанаас барив. Яаж барив? хэмээн хүүхдүүд тал талаас нь шалгаав. Баяраа:

-Би юунаас ч айдаггүй. Үзэх үү, та нар!

-Амьдаар нь өвчинө! гэж сайрхжээ...” Тэр үүнийгээ хэрэгжүүлж, байшингийн арын банзанд арьсыг нь цовдлон татжээ. “Амьдаар нь өвчинө!” гэсэн үг энэ өгүүллэгийн хамгийн ширүүн бөгөөд туйл болсон утгын илэрхийлэл юм. Энд өргөн хэмжээний утга тайлал өрнүүлэхээр байна. Жишээлбэл:

Энэрэн нигүүлсэхүйн үүднээс бол байгаль дээр оршигч аливаа бодгаль бүхэн, бяцхан жирх хүртэл амьд явах, модондоо гүйж харайх, өөрт ноогдсон баяр баясгалангаа эдлэх эрхтэй. Үүнийг хэдий оюун ухаантай, том биетэй ч хүн гэгч амьтан зөрчих эрхгүй юм. Энэ үзэгдлийн харьяалах хэм хэмжээг Баяраагийн найз хүүхдүүд бяцхан зүрхэндээ ойлгоцгоож жирхийг хөнөөж арьсыг нь өвчсөн Баярааг үзэн ядаж, хялайн харж өөрсдөөсөө холдуулж байна.

Энэ харгис явдлыг хүүхдүүд өөрсдийн сэтгэхүйн хүрээлэлд өөгшүүлэн дэмжсэн бол Баяраа удалгүй муурын зулзага, нохойн гөлгийг барин авч тамлан хөнөөж, арьсыг нь өвчих болж улмаар том болоод П. Пүрэвсүрэнгийн “Өшөө” өгүүллэгт гардаг “хэнийг ч хайрладаггүй адал балмад, хүйтэн сэтгэлтэй Дориг” мэтийн харгис хүн болох эхлэл тавигдах нь магад.

Бодит байдал дээр хүүхэд бүрийн цагаан сэтгэлд нуугдаж байдаг бяцхан амьтдыг хайрлах нинжин хайр, харгис муухай явдлыг үл дэмжих, төлөв байдал нь өгүүллэг дэх Баяраагийн энэ явдлыг жигших хана болсон төдийгүй хүнлэг байдлыг илтгэх зөн билгийн инстект нь энэ муухай харгис явдлыг дэмжсэнгүй. Тийм болохоор нөхөд нь түүнээс ум хумгүй дүрвэн холдож, түүнтэй харьцахгүй болж байна. Баярааг хүн гэж үзэхээ болж тоглох хүүхдийн тооноос хасаж байна.

Найзуудынхаа анхаарлыг татах олон арга байх боловч, ойгоос хурдан хөдөлгөөнтэй жирхийг барьсан нь түүнийг улам онгироож, би бүхнийг чадна гэсэн сэдэлд хөтөлж цааш даварсаар харгис үйлдэлд аваачжээ. Баяраа жирхийг өвчсөн нь хорон санааны үүднээс биш цэвэр хүүхдийн гэнэн сэтгэлээр бусад хүүхдүүдийн анхаарлыг онцгой байдлаар өөртөө татах гэсэн оролдлого юм. Бусдын анхаарлыг өөр рүүгээ татах, “тоглоомын төв дунд нь байх” гэж оролдох нь өсвөр насны хүүхдийн сэтгэлзүйн онцлог тал байдаг.

“Өсвөр насны хүүхдийн сахилга бат алдахын нөгөө нэг шалтгаан бол эрэлхэг зориг, аймшиггүй чанар, шийдвэр хатуужлын тухай буруу ойлголт буруу төсөөлөлд ордог явдал юм”⁴

Баяраа жирх хэмээх гэмгүй номхон амьтнаар дамжуулж өөрийгөө баатар бүхнийг чадагч мэтээр бусад харагдахыг хүссэн нь найзуудынх нь зөв төлөвшлийн ухамсартай зөрчилдөж тэдэнд гадуурхагдахад хүргэжээ.

“Өсвөр насны үед хүүхдийн хүртэхүй нь ямагт юм үзэгдлийг өрөөсгөл нэг талаас нь тусган авдаг онцлогтой учраас тэдний хүртэхүйд эндэгдэл гарч гаж буруу тусгал явагдаж болно. Үүний шалтгаан нь энэ насанд хүүхэд өөрөө хурц тод бөгөөд сонин хачин сэтгэгдэл төрүүлсэн зүйлсийг хамгийн түрүүн тусган авч, юмны гол шинж чанар, харилцаа холбоог өөрийн анхаарлын хүрээнээс орхидогт оршино.”⁵

Үүнтэй зэрэгцүүлэн зохиолч П. Пүрэвсүрэнгийн “Өшөө” өгүүллэгийн өгүүлэмжинд Дориг эх чоныг амьдаар нь өвчиж байгаа харгис үйлдэл нь “бидэрт буурал” хэмээх сайн хүлэг мориныхоо өшөө авах

⁴ Д. Санжав Хүүхдийн нас зүй сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал УБ. 1977.131 дугаар тал

⁵ (Мөн номын 107 дугаар тал)

сэтгэлээс гадна үүгээрээ дамжуулж нэг нутаг усныханыгаа айлгах, цочроох би ийм хүчтэй чадалтай хүн гэж дөвийлгөж харуулах улмаар нутагтаа эзэн ноён шиг суух, дураараа авирлах байдал руу хөтөлж байгаа юм. Нөгөө талаар хүний хэрхэн хүмүүжих, ямар хүн болж өсөх нь хүүхэд насандаа үзсэн туулсан зүйлээс хамааралтай.

Дамбийжанцан хүнийг амьдаар нь өвчсөн гэх аман яриа байдаг. Энэ нь тэр хүнд өшсөн хорсол гэхээсээ илүү энэ цочирдом үйлдлээр далимдуулан гэмгүй номхон нутгийн олон түмнийг айлгах, эрхэндээ оруулах гэсэн башир арга, олон нийтийг өөртөө үг дуугүй захируулах гэсэн хорон санаа байв.

Харгисаар алагдсан эх чонын золоор амьд гарсан бэлтрэг хожим том болоод Дориг руу сэм дайрч улмаар амийг нь хөнөөж толгойг нь тасалж хаядаг. Харин хүүхдийн зохиолд дээрх өшөө авалтын тайлал нь гэмгүй явж байгаад амь эрсэдсэн “жирхний төлөөх хатуу шийтгэл бол найз нөхөд нь Баяраагаас харилцаагаа бүрэн таслах, түүнийг жигшиж муухайгаар хялайн харж хэлээ гаргах явдал” юм.

“...Зарим нь бүр адгийн муухайгаар хялайн харж байлаа... Тэд харуут амандаа ямар нэг юм шивнэлдэн ярих шиг болсноо түргэн түргэн алхсаар алга болж өглөө... Боорой өөр үг хэлсэнгүй, өөдөөс нь удаахан ч харсангүй гишүүгээ чирсээр одлоо... Сувдаа охины мэгшин уйлах, хэлээ гаргаж, муухайгаар хялайн харах дүр харагдсаар...” Эдгээр өгүүлбэр нь Баяраад хандсан найзуудынх нь жигшил зэвүүцлийг бүрэн илтгэж байгаа юм. Гадуурхал нь Баяраад өгч болох хамгийн хүнд шийтгэл билээ.

Энэ бяцхан өгүүллэгийг уншсанаар “...бусдын анхаарлыг татаж эр зоригтой мундаг хүн шиг харагдахын тулд заавал онцгой харгис үйлдэл хийх хэрэггүй. Хэрэв тийм үйлдэл гаргавал өөрт чинь хүнд хэцүү ганцаардал, сэтгэлийн зовлон бий болдог” гэдэг гаргалгааг уншигч хүүхдүүд сайтар ойлгож авах юм.

“...Баяраа гэртээ гүйсээр ирэв. Сувдаа мэгшин уйлах, хэлээ гаргаж, муухайгаар хялайн харах дүр харагдсаар... Тэр гэртээ ирүүт байшингийн арын банзанд цовдлон татсан жирхийн судалт бяцхан арьсыг хуу татан авч хаялаа.

Ээ дээ, Баяраа минь! Арьсыг авч хаяснаар бүх юм сайн сайхан болох ч бил үү дээ..”. (178 дугаар тал) гэж зохиолч өгүүллэгээ төгсгөжээ. Амьдрал дээр тэр болгон тохиолддоггүй харгис явдлыг болсон мэтээр дүрслэх, улмаар уншигч хүүхдийг ухааралд хөтлөн энэрэн нигүүлсэх үзэлд автуулах нь хүүхдийн уран зохиолын үндсэн зорилгуудын нэг байдаг гэдгийг С. Надмид зохиолч чадварлагаар урлан харуулжээ. Үүнийг туурвилзүйн уран чадвар гэж болно.

Summary

In this article, writer Nadmid.S described tough action which rarely happens in life. Therefore he illustrated that leading children to understanding sympathize is one of the main idea of children's literature.

Ном зүй

1. Д. Санжжав “Хүүхдийн нас зүй сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал” Уб, 1977
2. С. Надмид “Жаран дэгдээхэй” түүвэр өгүүллэг, Уб, 2013 он
3. Г. Аюурзана, Л. Өлзийтөгс. Монголын сонгомол өгүүллэг. Уб, 2007 он
4. Д. Галбаатар. “УРАН ЗОХИОЛ: онол, түүх, шүүмжлэл” Уб, 2012он,

“Яриа” зохиолын дүр, дүрслэлийн онцлог

Д.Галбаатар*, Г.Нарантунгалаг**

“Яриа” зохиолын бүтэц, зохиомжийн онцлогоос шалтгаалан дүр нь: амьгүй эд юмсыг амьдчиллын аргаар дүрсэлж тэдгээрийн үйлдлийг бус харин хүншүүлсэн баатруудынхаа бодол санаа, хүсэл зорилгыг харилцан ярианы хэлбэрээр нээхэд, амьтдын хоорондын зөрчил маягаар хүний явдлыг далд ёгт үлгэрчлэлийн аргаар нээсэн, мөн амьтад ба хүн хоёрын хоорондын зөрчил мэтгэлцээний маягаар зохиомжилсон холимог дүрийн системтэй, үзэл, үйлийн зөрчилт талын ямар нэг шалтгаанаар юмуу нэгэн зорилго, хүсэл зорилго бүхий анги гарал бүхий хүмүүсийн үзэл бодол хоорондын харилцааны ижил төсөө байдлыг илтгэсэн дүрийн хэд хэдэн төрөлд хуваан үзэж болох билээ.

Ялангуяа “Яриа” зохиолын амьтан юмс, хүн баатар бүхий бүтцэд сөргөлдөгч талын зөрчил бус харин нэг анги, давхрага, хүсэл бодолтнуудын хоорондын зөрчил мэтээр илэрхийлдэг бол дүрийн бусад систем бүхий “яриа” ба “жүжиг”-т сөргөлдөгч анги хэсэг бүлгийн эсрэг тэсрэг байр суурийг үндсэн зөрчил болгож үзүүлсэн онцлог бий.

Яриа зохиол нь бичгийн уран зохиолын бие даасан төрөл зүйл төдийгүй нийгмийн хөгжлийн шилжилтийн онцлог үе шатуудыг дамжиж хөгжсөн учраас түүний урлал зүй, ялангуяа уран сайхны хэрэглүүр, өгүүлбэр зүйн уран маяг, утга шилжүүлэх ёс, үгийн сангийн сонголт, хэл найруулга нь тухайн үеийн аман ярианы найруулгын онцлогийг хадгалж иржээ.

Судлаачид 1920-30-аад оны уран зохиолд амьдралыг идэвхгүй хуулбарладаг натуралист бичлэг нэлээд тохиолддог тухай тэмдэглэсэн байдаг. Натурализм нь амьдралын бодот үнэнийг мөрдөн бичих зарчимд суурилдаг тул уран сайхан, дүр дүрслэлийн уран сайханд төдий л ач холбогдол өгдөггүй, шүүмжлэлт аяс хандлага давамгайлсан тал харагддаг. Гэхдээ энэ нь 1920-30-аад оны “Яриа” зохиол ба энэ үеийн шог ший, жүжгийн анхны бүтээлүүдэд уран сайхны сонирхолтой шийдэл, уран дүрслэл, хэлний тансаг байдлыг үгүйсгэж байгаа хэрэг бус, харин төрөл зүйлийн онцлог, зориулалт, бичлэгийн хэлбэрээсээ шалтгаалж асныг тайлбарлахыг хичээсэн хэрэг юм. Доктор Л.Түдэв Үлгэр-өгүүллэгийн тухайд сонирхолтой дүгнэлт хийжээ. Тэрбээр:

“Ардын аман зохиол сайн мэддэг, хуучин утга зохиолын зарим дурсгалыг уншсан хүнд үлгэр бол хоёр үндсэн ач тустай байжээ. Нэгд, боловсрол багатай, бичиг муу мэдэх хүмүүст суртал нэвтрүүлэхэд үлгэр нийтэд хүртээлтэй, ойлгомжтой байж. Хоёрт, реализмын утга зохиол бага мэддэг, туршлага нимгэнтэй залуу зохиолчдод үлгэрийг өгүүллэг болгон боловсруулах ажил уран бүтээлийн сургууль дадлага болж”¹ гэж дүгнэсэн нь бидний үзэл, байр суурьтай нэлээд талаараа холбогдох юм.

Яриа зохиолын уран сайхны онцлогийн талаар зарим жишээг үзье. Д.Нацагдорж “Хөгшин хүний өгүүлэл” зохиолынхоо төгсгөлд: Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод ирсэн нэг өвгөн ханиад хүрээд, эм залахаар явж байтал “Эрүүлийг хамгаалах газар”-ын хашаа дайралджээ.

-Ийм газрыг чинь ямар буянтай хүн байгуулсан юм бэ? гэвэл

-Буянтай хүн ч бус, өршөөлтэй засаг чинь байгуулсан юм гэнэ² гэжээ. Энгийн харвал хоёр хүний энгийн ярианы хэсэг юм. Харин дүрслэл талаас нь үзэхүл хэн нэг “буянтай хүн бус” гэсэн эхний субъектыг үгүйсгэх, харин “өршөөлтэй засаг чинь” гэж тодотгосон хоёрдугаар субъектыг нотлох хэрэглүүр болгон ашиглаад улмаар энэ хоёр дүрслэлээ харшууллын уран маяг болгон холбож, зохиолынхоо ерөнхий утга санааг тов тодорхой болгосон нь хэн нэг буянтны хүч гэж амьдралыг ойлгодог асан хуучны хүлцэнгүй үзэл бодлыг үгүйсгэн өршөөлт шинэ засгаараа бахархсан өнгө аяс, сэтгэлийн хандлагыг нээн илэрхийлж чадсан аж. Мөн зохиолчийн “Нянгийн яриа” шүлэглэсэн яриа зохиолд “яр тэнбүү”, “хижиг” хоёр өвчний нянгийн тус тусын зорилгыг бадаг бүрт тэгш хуваарилан яриа хэлбэрт оруулж, тэдгээрийг “салхи хөлөглүүлэн”, мөн нэг хоосон орон зайд тусгаарлан уулзуулж, нэг нь хот хүрээ газар руу, нөгөө нь хөдөө сэлүү аюулгүй газрыг зорьж яваад бие биеэсээ хүрээ хот, хөдөөгүй “хүний цусанд эм хийж, манийг алаад байх болов”³ очих газаргүй сандарч буйг нэгэн зүгт хамтдаа одохоос өөр аргагүй болж байгааг:

* МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Sc.D профессор

** МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын докторант

¹ Л.Түдэв МАХН-аас утга зохиолын тухайд явуулсан бодлого. УБ. 1971 38-39-р тал

² Б.Содном “Нацагдоржийн намтар зохиол” УБ.1966 185-р тал

³ Д.Нацагдорж “Зохиолууд” УБ. 1961. 179-р тал

Хоёр нян хоорондоо ийн ярилцаад: “хурдан хурдан” гэлцээд “Хуй салхи хөдөлгөөд хуврагийн оронд очих зам...-аар⁴ хийсэн одох зэрэг нь дээрх аргын нэг хувилбар болох эсрэгцүүлэл хийгээд мөн чанарыг далдуур адилтгах аргаар нээн дүрсэлсэн нь “хурдан хурдан” гэлцээд “хуй салхи хөдөлгөөд” зэрэг цаг хугацааны эрхээр бачимдаж яваа нянгуудын зовлон хийгээд дотоод ертөнцийн бачим сандруу шинжийг илтгэхийн ялдамд, үүгээрээр хөдөлгөөний шинэ мэдрэмжүүдийг үүсгэж чадахуйц үгс ба үйлдэл хөдөлгөөнийг хамсруулж хэрэглэсэн нь зохиолын баатруудын хэв шинж, сэтгэл зүй дотоод ертөнцийн байдлыг оновчтой зөв нээх, зохиолын өрнөлийг эрчимжүүлж уран хошин аяс, ёгт далд, шүүмжлэлт санааг илэрхийлсэн нь зохиолчоос өөрийн ард түмнээ гэгээрүүлэн сэнхрүүлэх, суртал нэвтрүүлэх хүсэл зорилготой нь яв цав нийлсэн уран дүрслэл болжээ.

Иймэрхүү хэв маягийн уран дүрслэлүүдийг бие биеэсээ илүү их эрдэм чадалтай хэмээн маргаж буй бичгийн гурван хэрэгслийн маргаанаар хэрэггүй зүйлд өөрийг ихэд дөвийлгөн тоох зан суртахууныг ёгтлон дүрслэхдээ бийр янтайгаар хуучин цагийн сэхээтний хуучинсаг зан байдал, үзгээр шинэ сэхээтний хувьсган шинэчлэгчийн байр суурь, үзэл санааны сөргөлдөөнийг /зөрчил/ давхар нээсэн Чинбатын “Бийр, үзэг, харандаа гурвын үлгэр” /1929/ энэ мэт нийгэм-амьдралын өөр өөр салбар дахь эмзэг асуудлуудыг хөндсөн С.Буяннэмэхийн “Том, жижиг тугалган үсгийн уран хошин яриа”, Занабазарын “Таван цогцос харилцан тэмцсэн нь” олон тооны яриа зохиолуудаар төлөөлүүлж, ур хийц, утга агуулга, уран хошин егөө, ёгт санааг “яриа” хэмээх өвөрмөц бүтэц бүхий олон тооны зохиол 1920-30 оны уран зохиолд бие даан хөгжсөн ажээ.

С.Буяннэмэх дээрх зохиолдоо өөрсдийнхөө ном хэвлэлийг бүтээхэд өөр өөрийн гүйцэтгэх үүрэг, ач тус ихийг товойлгон тодорхойлж, өрсөлдөн магтаж, өөр зуураа маргах том хар үсэг, арван хоёртын жижиг үсэг хоёрын маргаан хийгээд тэр нь арван зургаатын дунд үсэгний оновчтой сургаалын үр дүнд цугаар эв зүйгээ олж буйг өгүүлэхдээ, далдуур сонин хэвлэлийн олон талын ашиг тусыг ухуулж, ялимгүй зүйлээр өөрийг дөвийлгөх хүсэл хийрхэл хаа сайгүй дэлгэрснийг ёгтлосон юм. Энэ яриа дахь: Том хар үсэг:

“ - Би бол тодорхой мөртэй, тун их хүндтэй, толгой тэргүүний зэрэгт явдаг”⁵ гэх мэтээр өөрийн үнэ цэн, нэр хүнд, ашиг тусыг уран тоочлогын аргаар дүрслэхдээ шүлэглээгүй боловч шүлэгтэй адил эхэн ба адгийг давтан холбож тодорхой хэмнэл үүсгэн, өөрийн хөргийг товч тодорхой илэрхийлж цааш нь: “Ахаа гэж хүндлэхийг мэдэхгүй, тэргүүн гэж тэтгэмжлэхийг мэдэхгүй”⁶ зэрэг үгс нь Том үсэгний өөрийг ихэд бодсон сагсуу зан авирыг илэрхийлсэн нь оновчтой, ойлгож тогтооход хялбар, сонирхолтой ёгтлол болсон бол үүнийг сонсоод Арван хоёртын жижиг үсэг түүнийг “-Хэвлий чинь бүдүүн, хэрэг чинь бага, хэвлэл сонин дээр тавихад, хэдхэн мөрд л хэмжээгүй газрыг эзэлж”⁷ байдаг зэргээр шүүмжлэн мэтгэсэн дүрслэл шүлэглээгүй ч шүлэг мэт нарийн хэмнэл үүсгэж, уг дүрээ хөрөгчлөн тодруулж, далдуур шүүмжлэн цэцлэхэд: Том үсэг: “-Чи дэмий бүү цэцэрхэгтүн. Намайг үгүй бол чамайг хэн үзэх вэ. Эхгүй бол хүүхэд хаанаас гарах вэ. Захгүй бол дээл яахин бүтэх вэ. Би хэдий бүдүүн ч...”⁸ зэргээр мэтгэн баалсан дээрх дүрслэлийн өнгө аяс нэлээд өөрчлөгдөж, улмаар нэгэн логикт захирагдсан ахиулал болон алслалтын уран маягийн үүргээр зөрчлийг хурцатган гүн ухааны аястай болгож буй нь ардын аман зохиолын дайралцаа үг, цэцлэлийн уран найруулгын уламжлалыг бүтээлчээр ашиглажээ гэдэг нь тодорхой харагддаг. Улмаар Жижиг үсэг: “- ..Гэгээн тунгалаг бодлоготон, гэрэлт тодорхой эрдэмтэн, цэцэн сэргэлэн ардууд, сэхээтэн мэргэн хүмүүс намайг үзэхээс чамайг үздэггүй болой”⁹ зэрэг дүрслэг хэллэгүүд нь ардын ерөөл магтаалын “харилцаа цэцлэлийн хэв шинж”-ийг санагдуулахуйц шүлгийн хэллэг, хэлбэр галбир, хэмжээ хэмнэл, уламжлалыг чөлөөтэй ашигласан нь энгийн хүмүүст ойлгоход ойр, бас ч уг мэтгэлцээ зохиолынхоо сонирхогдох тал, маргалдагчдын сэтгэл хөдлөлийн байдлыг уран сонсголонтой болгоход чухал үүрэг гүйцэтгэжээ. Эл зохиолын дүрслэл ерөнхийдөө шүлэглээгүй шүлэг, оноч мэргэн үг, уран дүрслэл, ёгт хэллэг, сэцлэл хосолсон сонирхолтой бүтээл юм.

Ц.Дамдинсүрэнгийн “Янагийн үнсэлт” хэмээх сонин зохиол буй. Эл зохиол бүхэлдээ харилцан яриа, мөн бяцхан хүүрнэл /төгсгөл-дүгнэлт/-ээс бүтжээ. Энэ зохиолын тухай профессор Д.Цэнд “Янагийн үнсэлт” мэтийн натуралист дүрслэл бүхий зохиол бий”¹⁰, Г.Жамсранжав “С.Буяннэмэхийн “Моторт тэрэгний хэрүүл” зэрэг ёгт өгүүллэгийг мөн ингэж хэлж болно... үнэнийг урнаар илтгэхийн оронд болхиор хуулж, заваан үг, хараал зүхэл их хэрэглэсэн”¹¹ зэргээр шүүмжлэн тайлбарлаж байв. Уг зохиол нь:

“-Ай хүү минь, миний хүү?

-За за юү гэвээ? Эргэж хараад ирэв.

-Чи надад дуртай юу?

-Дуртай.

-Надад хайртай юу?

-Хайртай.

4 Д.Нацагдорж “Зохиолууд” УБ. 1961. ᠔᠑᠘-р тал

5 С.Буяннэмэх “Түүвэр зохиолууд” УБ.1968 96-р тал

6 Мөн тэнд

7 Мөн тэнд

8 Мөн тэнд

9 С.Буяннэмэх. Түүвэр зохиол 1968. 96р тал

10 Д.Цэнд. Монголын уран зохиол. УБ. 1965 141-р тал

11 Г.Жамсранжав. Анхны алхам. УБ. 1969. 103-р тал

-Үнэхээр үү?

-Үнэхээр.

-За чингэвэл намайг гурав дахин үнс! хэмээн хүзүүгээр чанга тэвэрч инээмсэглэн мишээлзэж бүхий царай юугаа алгуурхнаар ойртуулж ахуйд хоёр биеийн цог мэдрэл хямралдаж, шүд ам давжигнатал чичрэн хоёр бие лугаа бүх чадлаар чанга тэвэрч, нэгэнт цэнгэлийн үнсэлтийг авалцаж, хоёр хушуугаа нийлүүлэн шимэлцэхийн үед нэг мөсөн амрагийн зүрх уяраад, янагийн гал шатаж, оюун ухаан сэлтээр энэхэн зуурын буданд төөрөгдөж, гадны айлын хүн ирж харахад мэдсэнгүй наалдсаар нэг цагийн төдий болж, сая арайхан салалцахад дэргэд нь ах дүү, эцэг эх гайхан зогсжээ”.

Хоёр залуу ичингүйрэн цочиж гадна зугатан оджээ.¹² гэсэн ярианд суурилсан бичил зохиолын хэлбэр юм. Янагийн үйлийн үүтгэлд автсан залуусын харилцаа шивнээний аяс анир, үйлийн үргэлжлэлд өдөөсөн гурван үнсэлт “хоёр биеийн цог, мэдрэл хямралдаж”, “шүд, ам давжигнатал чичрэн”, “хоёр бие лугаа тас тэвэрч”, “хоёр хушуугаа нийлүүлэн шимэлцэхийн үед”, “янагийн гал шатаж”, “энэхэн зуурын буданд төөрөгдөж” /утга шилжүүлэх, хүчжүүлэх, харшуулах уран маягийг мэдэрхүйд нөлөөтүүлэн найруулсан нь зохиолыг уран сонирхолтой болгожээ/ ахуйд дэргэдээ хүмүүс ирэхийг мэдээгүйдээ ичингүйрэн зугатаах залуусын хөгжилтэй дур хүслэнгийн эрчимт, хяслант байдлыг дүрслэхдээ хэт махбодчилон үйлдэл бүрийг угсруулан ахиулсан гүнзгийрэлт нь хүмүүний ахуй хийгээд оюуны хяналтаас ангид огт өөр цэвэр физиологийн болзолт бус нөхцлийг харуулсныг “...хүний ухамсаргүй үйл ажиллагааг шохоорхох... биологийн зөн совинт чанар, төрмөл бус рефлекс чанар уран сайхны практикт голлох үүрэгтэй”¹³ гэж үздэг өрнөдийн биологизмын чиглэлийн онол зарчмын үүднээс үзвэл эл бичил яриа зохиолыг натурализм, садар самууны гэх мэтээр үгүйсгэх боломжгүй юм.

Профессор Д.Галбаатар эл зохиолыг натурализмын дотоод урсгал болох биологизмын урсгалд хамаарах хийгээд уран сайхан чанарын талыг “Хүний биологийн нууцлаг үйлдлийг эрчимт орон зай руу гүн нэвтэрсэн эдгээр дүрслэлүүдээс хайр дурлалын оргил агшин ба хүсэл цэнгэл, тайтгарал нь хэн хүний биологийн хэрэгцээг тэтгэгч нийтлэг мөн чанар, өвөрмөц маягийн эрчимт дур хүслэн, тааламжит байдал уншигчдад төрүүлэх нь ойлгомжтой зүйл. Зохиолоос төрөх сэрэл, мэдрэхүй, ичингүйрэл, дурсамж, дур хүсэл, тайтгарал зөвхөн уншигчийн сэтгэл зүрхнээ үүсч байгаа нь уг бүтээлийн ур чадварыг төдийгүй урлагийн үнэ цэнэт зүйлс тээснийг илтгэдэг”¹⁴ гэжээ.

Үнэхээр энэ үеийн яриа хэлбэрийн зохиолуудад натураль бичлэгийн ийм шинж тэмдэг тод бөгөөд энэ нь монголын уран зохиолын өв сан төдийгүй залуу уран зохиолчдын хувьд тийм өнгийж болохгүй орон зай, буруу зам байгаагүй бөгөөд “дүрслэл дэх негатив мөн чанарын үүргийг дутуу үнэлэн, позитив мөн чанарт илүү ач холбогдол өгдөг”¹⁵ тийм тодорхой цаг үе үндэстний уран зохиолд тохиолддогтой холбоотой юм.

1920-30-аад оны “Яриа” зохиол хэлний талаасаа хуучин бичиг зохиолын хэлний уран яруу найруулгыг ашигласан, дүрслэх болон яруу хэрэглүүрийг оновчтой хэрэглэсэн байдаг ч ерөнхийдөө бодит байдал голчлон хөнддөг.

“Яриа” зохиолд байх нэг онцлог бол хар ярианы найруулга, бичгийн хэлний аялгыг их хэрэглэсэн нь зарим тохиолдолд уран сайхны болон хэлний соёлын хувьд сул дутагдалтай болгодог тал ажиглагддаг. Мөн зөвхөн драм буюу жүжигчилсэн зохиолд ч биш, энэ нь нийгмийн шинэ нөхцөл байдал өгүүлэлт зохиолын хөгжилд шилжилтийн үе таарч, мөнхүү тухайн үед нийгмийн хөгжлийн түвшин, уран бүтээлийн шинэ найруулах ёс бүрэлдэн төлөвшөөгүй, шинэ залуу уран бүтээлчдэд ур зүйн туршлага дутагдалтай асантай холбоотой байна.

“Яриа” зохиол нь дүрийн хувьд хүншүүллийн аргыг ашиглан дүрсэлсэн амьтад, юмсын дүр голлох байртай, харин хүний дүрийг ёгтлол, төлөөлөл, бэлгэдлийн хэлбэрээр хослуулсан байх төдийгүй хүн, амьтан, юмс өөр хоорондоо зөвхөн хүний хэлээр чөлөөтэй харилцан хэлэлцдэг явдал юм. Тухайлбал: Агваанхайдавын яриа зохиолуудад үхэр, хонь, ямаа гурав өөр хоорондоо хэлэлцэхийн хамт гэлэн лам хийгээд яргачинтай хүний хэлээр ч чөлөөтэй хэлэлцдэг нь үлгэр, домгийн арга зүйн нэг нөлөөлөл юм. 1920-30-аад оны үе хамаарах Г.Навааннамжилийн “Хулгана зурамын яриа” зохиолын хулгана, гэлэн ламтай хэлэлцсэн яриа, эсвэл С.Буяннэмэхийн “Том, жижиг тугалган үсэг”-нүүдийн амьдчилал, уран цэцэн, учир ухуулсан ярианы хэлбэр эртний үлгэрийн амьтан баатруудад түгээмэл байдаг төдийгүй зохиолыг сонирхолтой, уран сайхан болгодог дүрслэлийн үндсэн аргын нэг юм. “Үнэг, туулай, зараа гурвын үлгэр”, “Далантай өвгөн”, “Болдоггүй бор өвгөн” ардын богино үлгэрийн дүрийн системтэй ижил төдийгүй ихэсгэл багасгал, хэтрүүлэл, ёгтлол, егөөдлийн уран маягуудыг баялаг хэрэглэж байв.

Гэхдээ 1920-30-аад оны “Яриа” зохиолуудад нийтлэг байдаг гол дутагдал бол уран сайхны үүргийг бага анхаарч сурталчлах, ухуулах, шүүмжлэн сэнхрүүлэх талд их анхаарснаас уран дүрслэлийн хувьд ардын үлгэрийн уран чадвараас дутмаг шинжтэй байгаа нь залуу зохиолчдын урлах туршлагатай холбоотой юм.

Орчин үеийн богино хэмжээний хүүрнэл зохиолд дүрийн ийм систем байдаг боловч хүн хүнийхээ явдлаар, харин амьтан юмсын дүр нь тэрхүү гол баатрын зан төрх, үзэл бодол, явдал түүхийг нэмэн тодотгох үүрэгтэй

¹² “Уран үгсийн чуулган” 1929 УБ. 2013 69-р тал. Монгол бичгээс хөрвүүлж, өмнөтгөл бичиж, эрхлэн хэвлүүлсэн Г.Галбаяр

¹³ История Французской литературы. М. 1981 стр 100

¹⁴ Д.Галбаатар Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд. УБ. үгүйс. үйс-р тал

¹⁵ Гульельми А. Назавать вещи своими именами. Вкн: “Группа 63”. М. 63-64

Д.Галбаатар, Г.Нарантунгалаг

хоорондоо хэлэлцдэггүй баатрууд болж хувьссан байна. Тухайлбал С.Эрдэнийн “Өнчин янзага” өгүүллэгт эзнийх нь эндүүрч эхийг буудсан өнчин янзагатай дассан анч Барс нохой хоёрын нөхөрлөлийн тухай өгүүлсэн боловч түүний эзэн анч өвгөний дүрийн сэтгэл зүйг нээхэд л үүрэгтэй оролцож байна. Өөрөөр хэлбэл хүн хүнийхээ явдлаар, нохой, янзага амьтныхаа жамаар /инстинкт/, зөвхөн агуулга утга санааг нэгтгэхэд л үүрэгтэй болохоос бус үлгэрийнх шиг харилцан хэлэлцэж, хамтран үйлдэхгүй болж хувьссан байна.

SUMMARY

Oral narratives employ anthropomorphic imagery, in which animals and objects act as primary characters, while human characters take forms that combine allegory, metaphor, and symbolism, and where humans, animals, and objects communicate freely amongst themselves using human speech.

A common shortcoming of *yaria* narratives published in the 1920s and 1930s is their lack of attention to literary function, with a greater emphasis on propaganda, critique, and didacticism. The lower literary refinement of imagery in these works, as compared to traditional legends and stories, can be related to the level of experience of their young authors.

НОМ ЗҮЙ

1. Буяннэмэх С. Түүвэр зохиол. УБ.1968
2. Галбаатар Д. Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд. УБ.2001
3. Гульельми А. Назавать вещи своими именами. Вкн: “Группа 63”. М.1986
4. Жамсранжав Г. “Анхны алхам” УБ.1969
5. Жамсранжав Г. “Шинэ замаар” УБ.1978
6. История Французской литературы. М.1981
7. Лувсанвандан С. “Монголын орчин үеийн уран зохиолын онол, түүхийн асуудлууд” УБ. 1973
8. “Монголын орчин үеийн уран зохиолын түүх” I боть. УБ. 1985
9. Нацагдорж Д. “Зохиолууд” УБ.1961
10. Содном Б. “Нацагдоржийн намтар зохиол” УБ.1966
11. Түдэв Л.МАХН-аас утга зохиолын тухайд явуулсан бодлого. УБ.1971
12. Уран үгсийн чуулган. 1929 УБ. 2013 Монгол бичгээс хөрвүүлж, өмнөтгөл бичиж, эрхлэн хэвлүүлсэн Г.Галбаяр
13. Цэнд Д. Монголын уран зохиол. УБ.1965

Characteristics of image and imagery in *yaria* narratives

Монгол шүлэг судлалын өнгөрсөн хийгээд ирээдүй

Г. Галбаяр*

Хүн төрөлхтний бүтээсэн оюуны соёлын гайхамшигт зүйлүүдийн нэг нь урлаг, уран зохиол билээ. Хүн сэтгэхүйтэй сэтгэлийн амьтны хувьд мэдэрч ухаарсан ямар нэг зүйлээ үндэснийхээ хэлний хамгийн төгөлдөр бүтэц, зүй тогтлын хүрээнд дүрслэн илэрхийлдэг. Үүнийг хүн төрөлхтөн шүлэг хэмээн нэрлэж заншжээ. Шүлэг найраг туурвигч үндэстнийхээ зөн мэдрэмж, сэтгэлийн илэрхийлэл, аж амьдралын дүр зураг болох тул тухайн үндэстний сэтгэлгээний ерөнхий хэв загварыг хадгалдаг гэж ойлгогдоно. Аливаа үндэстэн шүлэг найрагаа гадаад дотоод олон талаас нь учир шалтгаант зүйлсийнх нь хүрээ хамааралд нарийвчлан судлан шинжилж өөрсдийн өнгөрсөн түүхэн ул мөр, ирээдүйн хөгжил дэвшлийн зам мөрөө томъёолох нь жам. Тиймд шүлэг яруу найргийг хүн төрөлхтөн ихэд хүндэтгэн эрхэмлэн дээдэлж өөрсдийн өнгөрсөн амьдралын нууц өв сан, ирээдүйн амьдралын зөнч түүхээ хэмээн ухаардаг байна.

Шүлэг найргийг судлан шинжилж, түүнд хадгалагдсан аж амьдралынхаа өнгөрсөн хийгээд ирээдүйн мөн чанар, учир холбогдлыг ухаарахаас гадна тэрхүү шүлэг найраг ямар аргаар, ямар зүй тогтлоор бүтдэг онцлогийг судлан шинжлэх зайлшгүй шаардлагатай асуудал. Учир нь аливаа үндэстний шүлэг найргийн бүтэц тогтолцоо тухайн үндэстнийхээ сэтгэлгээний ерөнхий хэв загварын төлөөлөл болдогтой холбоотой. Энэ утгаараа шүлэг туурвигч үндэстнийхээ хэлний олон талын онцлог шинжүүдийг цогцоор нь хадгалж байдаг өвөрмөц урлаг билээ.

Монгол шүлэг түүхэн урт удаан хугацаанд маш нарийн тогтолцоонд орж, гадна дотны олон зүйлийн учир шалтгаанд хөгжин хувьсаж ирсэний хувьдаа нарийвчлан судлуулж олон асуудлыг бий болгосон юм. Монгол шүлгийг судлан шинжлэх ажил нэн эртний түүхтэй ч шинжлэх ухааны үндэслэлтэй судалсан нь XIX зуунаас эхэлж, XX зуунд тодорхой амжилтанд хүрчээ.

Бид энэ удаа доорх хэдэн зүйлийн зорилго тавьсан болно. Нэгд, монгол шүлэг судлалаар хийгдсэн судалгаа шинжилгээг нэгтгэн дүгнэх, хоёрт, монгол шүлэг судлалаар шийдвэрлэгдсэн гол асуудлуудыг тодорхой болгох, гуравт, цаашид монгол шүлэг судлалын хүрээнд судлан шинжлүүштэй асуудлуудыг гаргаж тавихыг зорьж байна.

Нэг. Монгол шүлгийг судлан шинжлэх ажил нэн эрт үеэс эхэлж, өдгөө шинжлэх ухааны тогтолцоотой салбар ухаан болж хөгжсөн байна. Монгол шүлгийг судлан шинжлэхдээ үе үеийн судлаачид шүлгийн тухай ерөнхий онол ухагдахууны үүднээс авч үзсэн төдийгүй оюуны соёлын хувьд эртнээс холбоо харилцаатай явж ирсэн улс орнуудын шүлэг найрагтай холбогдуудан судлан шинжилсээр ирсэн онцлог харагдаж байна. Монгол шүлгийн тогтолцооны асуудал судалгаанд хэдий үеэс татагдан орсон, ямар шийдэлд хүрсэн, цаашид аль талын ямар судалгаа дутагдаж байгаа зэргийг нэн тэргүүнд авч үзэх нь чухал юм. Ингэж үзвэл нэлээд сонин зүйл ажиглагдаж байна. Учир нь монголчууд сүүлийн хэдэн зуун жил монгол шүлгийн судлал, хөгжил дэвшлийн тухай олон арван сүмбэм туурвисан ч ихэвчлэн Энэтхэгийн дуун ухаантан, зохист аялгуун онолч Дандиний “Гавьяадарша” буюу “Зохист аялгуун онол”-ын үлгэрээр шүлэг зохиол хэрхэн бичих хийгээд “Зохист аялгуун онол”-ын тухай тайлбар сэлт үйлдсээр ирсэн болохоос биш яг монгол шүлгийн дотоод мөн чанарын онцлог, тогтолцооны асуудлыг нарийвчлан авч үзсэнгүй. Тийм ч учраас хожим Оросын монголч эрдэмтэн А. М. Позднеев монгол аман зохиолын тухай өгүүлсэн “Ардын аман зохиолын жишээ” хэмээх бүтээлдээ “монгол шүлгийн тухай түүнийг сонсоход эвтэй бөгөөд ойлгоход хялбар үгээр бадаг бадгийн мөрийг аль болохуйц тэгшээр орчуулах ёстой гэж “Мэргэд гарахын орон” гэдэг нэр томъёоны толь бичигт хэдхэн мөр үг байдгаас өөр монголчуудын бичсэн шинжилсэн зүйл байхгүй”¹ гэж цохон тэмдэглэсэн байна.

Монгол шүлгийн тогтолцоог дагнан судлах ажил XIX зууны үеэс эхэлж, өнгөрсөн зуунд нэлээд эрчимтэй өрнөсөн ч монгол шүлгийг хэн хэн гэдэг судлаачид аль өнцгөөс нь хэрхэн судалж, ямар шийдэлд хүрснийг нэгтгэн багцалж үзсэн нь үгүй байна. Монгол шүлгийн тогтолцоог судалсан эрдэмтэн, судлаачдын судалгааг нэгтгэж үзвэл доорх шийдэлд хүрсэн нь харагдаж байна. Үүнд: нэгдүгээрт, хамгийн анх оросын нэрт монголч эрдэмтэн Б. Я. Владимирцов “Монгол бичгийн хэл ба халх аялгууг харьцуулсан хэлний зүй” /1929/ гэдэг бүтээлдээ халх ардын дуун дээр ажиглалт хийж “Халхын уянгын дуу нь ихэвчлэн өргөлтийг

*МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын багш

¹ Позднеев А. М. Образцы народной литературы монгольских племен. Вып I. Спб., 1880. срт-232

тэгштгэх зарчмаар зохиогдсон тул өргөлтөт шүлэг болно”² гэж таамаглал дэвшүүлснийг оросын монголч эрдэмтэн Н. Н. Поппе 1936 онд хэвлүүлсэн “Халх-монголын баатарлагын туульс” бүтээлдээ дэлгэрүүлэн монгол шүлгийн үндсэн хэмжээ нь Б. Я. Владимирцовын авч үзсэнчлэн 3-7 орчим өргөлтөт үеэс бүрдэж байна гэж тэмдэглэжээ. Түүний дараа буриадын эрдэмтэн А. Хамгашалов 1940 онд хэвлүүлсэн “Буриад-монгол шүлэг зохиолын шинжилгээний туршлага” бүтээлдээ “Буриадын шүлэгт өргөлтөт шүлгийн тогтолцоо нь зөвхөн өнөөдөр ноёлох төдий байртай биш чухамдаа өнөөдрийг хүрч иртэл аман ба бичгийн зохиолд бараг ганцаараа ноёрхож байгаа юм. Буриад-монголын шүлгийн зохион байгуулалтыг үзэхэд шүлгийн мөр дэх үгийн тоог тэгштгэх аргыг баримталсан нь үгийн өргөлт ямагт нэгдүгээр үедээ байдгаас шалтгаалсан байна”³ хэмээн дүгнэжээ. Тэдний энэ саналыг манай эрдэмтэдээс Ц. Дамдинсүрэн, М. Гаадамба, Н. Жамбалсүрэн, Д. Жамба, Ч. Чимид зэрэг хүмүүс дэмжиж, өөр өөрийн судалгаа, түүнээс гарсан дүгнэлтээрээ гүнзгийрүүлэн батлахыг зорьжээ. Тухайлбал Ц. Дамдинсүрэн “Олег цэцний орчуулгын тайлбар” хэмээх 1937 онд бичсэн өгүүлэлдээ “Монгол үгийн тогтвортой бат эгшиг нь үгийн эхний өргөлтөт эгшиг мөн. Энэ эгшиг бол шүлгийн гол багана тулгуур мэт тул “Олег цэцний дуулал”-ыг орчуулахдаа энэ өргөлтөт эгшигийг гол болгон баримталж, энэ өргөлтөт эгшигийг тэгштгэн хэрэглэсэн билээ”⁴ гэж тэмдэглэсэн нь монгол шүлгийн тогтолцооны талаар өөрийн саналыг хэлсэн төдийгүй орос хэлнээс шүлэг орчуулахдаа өргөлтөт эгшигийг тэгштгэх журмыг баримтлах нь зохихыг тэмдэглэсэн хэрэг бололтой. Мөн М. Гаадамба “Монгол үгэнд үг нэг бүр нэг өргөлттэй учир мөр дэх өргөлтийн тоо тэнцүү байна гэдэг бол мөр бүрийн үгийн тоо тэнцүү байна гэсэн санаа мөн. Шүлгийн мөр бүрд орсон өргөлтөт үеийн тоо тэнцүү байхад үндэслэдгээс монгол шүлэг бол үндсэндээ тоник буюу өргөлтийн шүлэг болно”⁵ хэмээн үзсэн байхад Н. Жамбалсүрэн “Шүлгийн мөрт үгийн тоо тэгш байх нь монгол шүлгийн үндсэн хэмжээ байдаг гэж А. Хамгашалов зүйтэй дүгнэжээ. Шүлгийн мөр 2-10 хүртэл /өргөлт/ үгтэй. Бадгийн доторх мөрүүд адил байвал үлгэр үзэмж байгууламжийн хувьд жигд сайн болдог байна. Гол өргөлтийн тоог ямар нэг хэмжээгээр тэгш байлгах нь монгол шүлгийн үндсэн хэмжээ болсоор ирсэн, хойшид ч сайн шүлгийн хэмжээ болж чадна. Энэ хэмжээ ерөнхийдөө шүлгийн мөрийн дотор адил тоотой байдаг бол өргөлтөөс тогтож байна. Монгол шүлгийг шүлэг болгож байгаа ганц тулгуур нь тоник /өргөлтөд/ хэмжээ мөн”⁶ гэж авч үзжээ. Тэгвэл Д. Жамба “Монгол бичгийн айзамт хэл нь /тогтолцоо нь/ шүлгийн мөр бүрт орох өргөлтөт үеийн тоог тэнцүүлэн бүтээдэг нь тодорхой. Монгол хэлний үгийн өргөлт нь тогтмол нэгдүгээр үедээ байдаг учраас шүлгийн мөр бүрт биеэ даасан үг хичнээн байвал өргөлт үеийн тоо төчнөөн байх нь мэдээж хэрэг ээ! Тиймийн тул шүлгийн мөр бүрт орох өргөлтөт үеийн тоог тэнцүүлэн монгол шүлгийн айзамт хэлийг бүтээдэг нь шүлгийн мөр бүрт биеэ даасан үгийг тэнцүү оруулж байгаад монгол шүлгийн айзамт хэлийг бүтээдэг гэж үзэхэд болно”⁷ гэж үзжээ. Мөн Ч. Чимид “Монгол үгийн хамгийн тод үе нь өргөлтөт үе юм. Тэр нь үгийн бусад эгшиг зарим гийгүүлэгчийг зохицуулах бусад үеийн огцом эгшигийг “баллаж” байгаа юм. Ийм хүчирхэг үеийн тоог нийлүүлж шүлэг бичнэ гэдэг нь тоник /өргөлтөт/ шүлгийн зохион байгуулалтын үндэстэй нягт холбоотой юм. ... Монголын одоогийн шүлгийн гол тогтолцоо нь өргөлтөт үеийн тоог тэгшитгэн, урт хос эгшигийн тоог гүйцэтгэх чиглэлтэй тоник тогтолцоо /өргөлтөт шүлэг/ байна”⁸ хэмээн үзсэн байна. Эдгээр судлаачдын судалгаа шинжилгээний үр дүнг нэгтгэн үзвэл:

-Монгол шүлэг өргөлтөт шүлэг

-Монгол шүлгийн өргөлт үгийн тэргүүн үедээ байна

-Монгол шүлгийн өргөлт үгийн тэргүүн үедээ байдаг нь цаад мөн чанартаа мөр хоорондын үгийн тоо тэнцүү байдаг гэсэн утгын илэрхийлэл. Энэ нь нэг мөрийн өргөлтөт үгүүд нь өгүүлэх эрхтний тогтолцоонд захирагдан хэмнэл үүсгэдэг онцлогийг хадгалж байна.

-Монгол шүлэгт өргөлтөт шинж чухал ч холбоцод давхар захирагддаг. Тэр дундаа монгол шүлэг толгой холбоцод захирагддаг онцлогтой байна.

Хоёрдугаарт, Германы монголч эрдэмтэн Б. Лауфер, буриадын шүлэг судлаач Г. Туденов, манай эрдэмтэн Б. Ринчен, Д. Цэрэнсодном нар монгол шүлгийг судлаад монгол шүлэг бол үет шүлэг гэж үзжээ. Тодруулбал, буриадын үлгэрийн шүлгийг дагнан судласан эрдэмтэн Г. Туденов “Үлгэрийн шүлгийг судлан үзвэл түүний яруу найргийн урлаг нь толгой холболт, өгүүлбэрийн гишүүдийн ангилалт, үеийн тоог тэгштгэх ба эн зэрэгцүүлэх эдгээр хэмжээт шүлгийн дөрвөн аргаас бүрдэж байна. Шүлгийн айзамыг бүрдүүлэх энэхүү аргыг бид уг хамаарагдаж буй төрөл зүйлийн шинжээр нь үлгэрийн шүлгийн тогтолцоо гэж нэрлэж байна. Энд өгүүлсэн дөрвөн аргаас шүлэг судлалын өнөөдрийн баримталж буй нийтлэг ойлголттой харьцуулан үзвэл хэмжээт шүлгийн ганц арга нь мөрийн доторх үеийг харьцангуйгаар тэгштгэх явдал юм. Хэн бүхэнд мэдээжээр шүлэгт үеийг тэгшитгэх зарчим нь үеийн шүлгийн /силлабик/ тогтолцоог дээр суурилдаг байна”⁹

² Владимирцов Б. Я. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Л., 1929. стр-98

³ Хамгашалов А. М. Опыт исследования бурятского стихосложения. Улан-Удэ., 1940. стр-32-33

⁴ Монгол хэл бичгийн тухай эмхэтгэл. Уб., 1957 25 дугаар тал

⁵ Гаадамба М. Утга зохиолын онолын товч. Уб., 1957 143 дугаар тал

⁶ Жамбалсүрэн Н. Монгол шүлэг. Утга зохиол сонин 1956. №8

⁷ Жамба Д. Монгол шүлгийн хэлний тухай. Монгол түүх хэлбичиг сэтгүүл. Уб. 1958. №3. 76 дугаар тал

⁸ Чимид Ч. Монгол шүлгийн тогтолцоо. “Үгийн ид шид” түүвэр Уб. 1968. 97-98 дугаар тал

⁹ Туденов Г. Бурятской стихосложение. Улан-Удэ., 1958. стр 82-83

хэмээн үзсэн бол манай эрдэмтэн Д. Цэрэнсодном “Монгол шүлгийг үзэхэд бичгийн шүлэг, аман бичгийн шүлэг, ардын аман яруу найраг гэдэг гурван зүйл гарна. Эдгээр нь чухамхүү шүлгийн хэмнэл айзам тааруулах тэргүүтэн ерөнхий зарчмын хувьд адил байна. Шүлгийн мөрийн хэмжээг ямар нэг нэгжээр тодорхой хэмжээнд журамлан бичдэг учир уг чухал оролцоотой нь үнэн боловч уг, түүнийг бүтээх үе хоёрын харьцааг эрэгцүүлэн бодох ёстой. Олонхи шүлгийг үзэхэд үгийн тоо зөрүү, тэнцүү янз бүр байх авч үеийн тоог яв цав тохируулан бичих нь гол зуршил бололтой байна. Монгол шүлгийн системийн /тогтолцооны/ талаар гэвэл ялангуяа ардын аман зохиол, хуучин уран зохиолын хувьд мөр бүрийн үеийн тоог чандлан бичдэг силлабик /үеийн/ шүлгийн зарчимтай байна”¹⁰ гэх мэтээр авч үзсэн байна. Энэ хэсгийн судалгааны үр дүнг нэгтгэн авч үзвэл:

-Монгол шүлэгт холбоц чухал үүрэгтэй. Тэр дундаа монгол шүлэг толгой холбоцод шууд захирагддаг.

-Монгол шүлэгт мөр бүрийн үгийн тоо тэнцүү байхыг чухалчлах ч цаад мөн чанартаа үгээс илүү мөр бүрийн үеийн тоог тэнцүүлж, нэг цогцолбор үүсгэх нөгөө мөртэйгөө тэгш хэмнэлт эн зэрэгцүүлэл үүсгэдэг гол онцлогтойг өгүүлсэн байна.

Гуравдугаарт, Оросын монголч эрдэмтэн А. М. Позднеев, германы монголч эрдэмтэн Г. К. Габленц нар монгол шүлгийн тогтолцоо тийм гэж хэлэхэд төвөгтэй, олон янзын нэгдмэл онцлогтой болохыг өгүүлээд яг ямар тогтолцоотой шүлэг болохыг нь өгүүлсэнгүй.

Дөрөвдүгээрт, Оросын монголч эрдэмтэн Л. К. Герасимович 1975 онд хэвлүүлсэн “Монгол шүлгийн тогтолцоо” бүтээлдээ монгол шүлгийг туршилт авиа зүйн аргаар судлаад “монгол шүлэг бол жигд цагтайгаар үл барам, үеийн тоогоор ч гэсэн ойролцоо ижилхэн байх нь ээ гэдэг дүгнэлт гаргахад хүргэв”¹¹ гэж бүр монгол шүлгийг өмнө судласан бүх эрдэмтдийн саналыг няцааж цоо шинээр “монгол шүлэг зохиол бол уугуул байгуулалынхаа цаг тооны шүлэг /квантитативный/ мөн”¹² хэмээн үзжээ.

Тавдугаарт, Өвөрмонголын эрдэмтэн Бүрэнбэх, Хишигтогтох, Сайшаалт, Сүюүгэ зэрэг судлаачид монгол шүлэг судлалаар их бага ямар нэг хэмжээгээр ажилласан ч монгол шүлгийн ерөнхий гол тогтолцоо, онцлогийн тухай цогцоор нь төдий л авч үзэлгүй түүхэн хөгжил хувьслын үүднээс хэсэг тасгаар нь олон янзаар судалсаар иржээ. Магадгүй тэдний судлал шинжлэлийн арга барил өөр байдагтай холбоотой биз. Гэхдээ л монгол шүлэг судлалд Өвөрмонголын судлаачдын бүтээлийг онцлон авч үзэх хэрэгтэй байгааг тэмдэглэе.

Монгол шүлгийн онцлогийг судалсан судлаачдын судалгаа дээрх хэдэн хэсэгт багцлагдах ч харьцангуй өөр өөр дүгнэлтэд хүрчээ. Ийнхүү монгол шүлгийн тогтолцооны асуудал өдгөө хүртэл нэг мөр шийдэгдээгүй ирсний учир нь дээрх судлаачид судалгаандаа хам хум, хайнга хандсан юмуу эсвэл элдэв олон янзын харийн онолын загварт монгол шүлгийг тавьсанд биш гагцхүү монгол шүлгийн өөрийнх нь өвөрмөц онцлогийн дотоод зүй тогтол руу зөв зам мөрөөр ороогүйтэй холбоотой бололтой. Шүлэг байгалиас хүний мэдрэхүйд өгөгдсөн айзам хэмнэл, өнгөний дагуу үгийн шүтэлцээ үүсгэж, тэдгээр үгс дотооддоо нарийн зохион байгуулалтанд орж, шүлгийн мөр улмаар бадаг үүсгэдэг онцлог нь бусад төрлийн зохиолоос ялгарах гол ялгаа нь болохыг онцлон судлах ёстой байжээ.

Хоёр. Монгол шүлгийг судлан шинжилсэн судлаачид судлан шинжилсэн асуудал бүрдээ тодорхой үнэлэлт дүгнэлтэд хүрсэн ч тэднийг цогцоор нь нэгтгэн дүгнээд үзвэл санал нийлсэн зүйл харьцангуй бага гэж хэлж болохоор байна. Энэ нь монгол шүлэг судлалд олон асуудлыг дахин нарийвчлан судлан шинжлэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байгаа хэрэг. Монгол шүлэг судалсан судлаачдын судалгаанд хүлээн зөвшөөрөгдсөн нь харьцангуй цөөн ч доорх хоёр чухал асуудал нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөн байна.

-Монгол шүлэг толгой холбоцод захирагддаг

-Монгол шүлэг тэргүүн үедээ өргөлттэй. Тэр өргөлт нь толгой холбоцтойгоо уялддаг. /Тэргүүн үедээ өргөлттэй төдийгүй, урт хос эгшиг өргөлттэй, сонсголт шуугиант гийгүүлэгчийн өмнөх юмуу хойтох эгшиг өргөлттэй/

Монгол шүлэг судлалаар ажилласан судлаачдын судалгаа шинжилгээний үр дүн яагаад ийм дүгнэлтэд хүрснийг ажиглаад доорх хэдэн зүйлийг өгүүлэх байна.

1. Монголчуудын аж амьдралын хэвшил, иргэншил, соёл сэтгэлгээний гүн утга агуулгатай судалгаа шинжилгээгээ хослуулалгүй хэтэрхий ганцаардуулан тусгаарлаж авч үзсэн
2. Монгол хүний аливаа зүйлийг ойлгох онцлог, түүнийгээ илэрхийлэн дүрслэх зүй тогтлыг сайн харгалзаж үзээгүй
3. Монгол шүлгийн онцлогийг уугуул монгол бичгийн хэлний зүй тогтлын үүднээс авч судлаагүй
4. Монгол шүлгийн төлөөлөл болохуйц үе үеийн шүлэгт цогц судалгаа хийлгүй хэсэг тасгаар хандсан байна.

Гурав, Монгол шүлэг судлалын түүхэн хөгжил хувьсал, гарсан үр дүнд тулгуурлаж цаашид монгол шүлэг судлалд доорх хэдэн зүйлийг нэн тэргүүнээ шийдвэрлэх нь тулгамдсан асуудал болжээ. Үүнд,

1. Шүлэг, яруу найраг, холбоо, хоршоо гэх зэрэг үгсийн гарал, түүхэн хөгжил хувьсал. Эдгээр үгс

¹⁰ Цэрэнсодном Д. Монгол шүлгийн тухай. Цог 1964 №4. 94-103 дугаар тал

¹¹ Герасимович Л. К. Монгольской стихосложение. М., 1975. стр-124

¹² Герасимович Л. К. Монгольской стихосложение. М., 1975. стр-125

хэдий үеэс хэрэглэгдэж, шүлэглэсэн зохиолыг нэрлэх болсон. Орчин үед тус бүрийнх нь нэршил, үүрэг, цаад агуулагдах утгыг тодорхой болгох.

2. Монгол шүлгийн холбоц, үе, өргөлт, айзам хэмнэлийн асуудлыг орчин үеийн техник технологийн дэвшлийг ашиглан шинээр судлан шинжлэх.

3. Монгол шүлгийг монгол хэл, нүүдлийн иргэншил, монгол хүний сэтгэлгээний мөн чанарын үүднээс цогцоор нь судлан шинжлэх.

4. Монгол шүлгийн гадаад хэлбэрийн ерөнхий тогтолцоо-зүй тогтлыг шүлгийн дотоод дүрслэгдэхүүнүүдтэй уялдуулан холбож судлах.

5. Дэлхийн уран зохиол дахь шүлэг судлалын хөгжилд гарч буй дэвшилттэй зүйлүүдийг харгалзан үзэж суурь шинжлэх ухаануудын нэгдэл бэлчир дээр тэдгээр ухаануудын судалгааны арга барилуудын үүднээс судлан шинжлэх.

6. Монгол шүлгийн дүрслэлийн ур маягуудыг цаад мөн чанар, дотоод учир шалтгааных нь үүднээс тогтолцоотой судлах.

Шүлэг үндэстний сэтгэхүй, хэл, соёлын цөм хэв загварын илэрхийлэл болдог учир түүнийг нарийвчлан судлах нь зайлшгүй чухал юм. Монгол шүлэгт хүн төрөлхтний шүлэг найрагт байх түгээмэл шинжүүд байх ч ямар нэг харь орны шүлэг найргаас зээлдэн авсан нь цөөн, зөвхөн өөрийн гэсэн өвөрмөц онцлог бүтэц тогтолцоотой болох нь тодорхой ажээ. Энэ л шинжнээс монгол шүлгийг цаашид судлан шинжлүүштэй юм.

Resume

Since poets are seen as expression of their national soul and living scenes, it is understood that poems keep a nation's basic mind styles. It is natural for any nation to determine their own history in the past and their future progress and development paths, having accurately studied their verse in many aspects both from outside and inside, within motivated scopes. Therefore, humankind highly respect and honor verse and comprehend it as their mirror to the past and diviner towards future.

Verse must be studied well so that we could study features of verse which method and regularities it is created, besides understanding past of living, future essence, and correlations kept in poems. Because it is related to that verse represented the basic mindset styles of the nation. It keeps all aspects of national language features.

Though history of Mongolian verse study had been started since the ancient times, however proper science based studies had been started from 19th century, and by 20th century many issues had been solved. Throughout the historical long terms Mongolian verse had gained quite systematized structure and due to evolution and development through many external and internal causes it has brought many issues for detailed study.

We have following goals for the purpose of this speech, which are, the first of all, to make integrated analysis on all studies on Mongolian verse made so far; the second, to determine main issues that were solved through the Mongolian verse study, and the third, to define issues that need to be studied within the framework of Mongolian verse study.

One. Mongolian verse study have taken its start from ancient years, and today it has been a systematized science branch. We have found that researchers from each generation have not only considered basic theory concepts of Mongolian verse, but also, studied it in connection with verse from other countries which had relationships in mind arts since ever.

Two. As a result of integrated analysis on researchers' studies in the past, we have found that though each researcher had reached conclusions at the end of his/her study, but the conclusions rarely meet each others vision. This means there are still need of re-study on many issues in the Mongolian verse study. However, as we observed, many researchers agree on fact that «Main feature in Mongolian poems is alliterativeness».

Three. Due to the finding that «Main feature in Mongolian poems is alliterativeness» or a concept that alliterativeness masters all other things in Mongolian verse, we consider that the following kinds of studies must be done:

- Some issues connected to rhymes, accents and metrics in Mongolian poems need to be re-studied with the use of advanced modern techniques and technologies;

- We face requirements to study Mongolian verse in complexity based on Mongolian language, traditional nomadic civilization and Mongolians mindset essence. Former researchers had studied Mongolian verse in non-complexity and we consider that many issues in doubt are connected to this.

- External basic structure-regularities of Mongolian verse must be studied in connection with its internally described objects.

Ном зүй

1. Аристотель Туурвил зүй. Орчуулсан М. Гаадамба. Уб., 1969
2. Байгалсайхан С. Уран зохиол шинжлэлийн удиртгал. Уб., 1995
3. Билигсайхан Ч. Ухаарахуй (Шинэ үеийн уран зохиолын онол) Уб., 2003
4. Буяннэмэх С. Утга зохиолын үүд. (Гар бичмэл эх) 1935
5. Владимирцов Б. Я. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия. Л., 1929
6. Гаадамба М. Утга зохиолын онолын товч. Уб., 1957
7. Гаадамба Ш. Утга зохиолын онолын үндэс. Уб., 1989
8. Галбаатар Д. Уран зохиол: онол, түүх, шүүмжлэл. Нэвтэрхий толь. Уб., 2012
9. Галбаяр Г. Уран зохиол шинжлэлийн лекц. Уб., 2002
10. Герасимович Л. К. Монгольское стихосложение. Л., 1975
11. Гуляев Н. А. Теория литературы. М., 1985
12. Гүлранса, Данзанванжил, Хишигбат Түүвэр. Хөх хот., 1959
13. Дамдинсүрэн Ц. Гадаад хэлнээс шүлэг орчуулах тухай өгүүлэл. “Шинэ толь” сэтгүүл. Уб., 1938. №2 (14)
14. Дамдинсүрэн Ц. Олег цэцэний орчуулгын тайлбар. Монгол хэл бичгийн тухай эмхэтгэл. Уб., 1957
15. Дулам С., Хасбаатар Ц. Утга зохиолын үүд. Уб., 1980
16. Жамба Д. Монгол шүлгийн хэлний тухай өгүүлэл. Монгол түүх хэл бичиг сэтгүүл. Уб., 1958. №3
17. Жамбалсүрэн Н. Монгол шүлэг. Утга зохиол сонин 1956. №8
18. Жирмунский В. Теория стиха. Л., 1975
19. Инжаннаши В. Хөх судар. Тэргүүн дэвтэр. Хөх хот., 1959
20. Квятковский А. Поэтический словарь. М., 1983
21. Монгол хэл бичгийн тухай эмхэтгэл. Уб., 1957
22. Нацагдорж Дашдоржийн Бүрэн зохиол. Уб., 1996
23. Основы литературоведения (под редакцией В. П. Мещерякова) М., 2000
24. Отгонсүрэн Д. Д. Нацагдоржийн зохиолын хэл найруулга уран сайхны онцлог. Уб., 1984
25. Позднеев А. М. Образцы народной литературы монгольских племен. Вып 1. Спб., 1880
26. Поуха П. “Монголын нууц товчоо”-ны зарим нэгэн шинэ судалгаа. Монгол судлал. Уб., 1968
27. Ransom J. *Poems and essays*. N.Y., 1955
28. Ринчен Б. Монгол шүлгийн учир. “Хэл зохиол” цуврал бичиг. Уб., 1969
29. Руднеев А. Образцы монгольской народной словесности. СПб., 1880
30. Содном Б. Д. Нацагдоржийн уран зохиолын тухай. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал. IV дэвтэр. Уб., 1962
31. Содном Балданы Монгол шүлгийн арга маяг. Зохиол судлал. Уб., 2008-2009
32. Туденов Г. Бурятской стихосложение. Улан Удэ., 1958
33. Түдэв Лодонгийн Шүлэглэсэн туульс. Бүтээлийн чуулган VI. Уб., 2002
34. *Uran üges-ün ёйүлүн*. Qubisqal-un uran jokiyałci nar-un бүligüm-eёe keblegүlbei. Mongyol keblel-ün qoriyan-a Ulaýan bayatur qotan-a., 1929
35. Хамгашалов А. М. Опыт исследования бурятского стихосложения. Улан-Удэ., 1940
36. Хүрэлбаатар Л. Сонгодог уламжлал, монгол яруу найраг. Уб., 1989
37. Цэдэв Д. Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл. Уб., 1974
38. Цэнд Д. Монгол шүлгийн тогтолцооны асуудалд. “Монголын уран зохиолын хөгжлийн асуудалд” Уб., 1979
39. Цэрэнсодном Д. Монгол шүлгийн тухай. Цог 1964 №4.
40. Цэрэнсодном Д. Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал. Уб., 1977
41. Чимид Ч. Монгол шүлгийн тогтолцоо. “Үгийн ид шид” эмхэтгэл. Уб., 1968
42. Энхбаяр С. Утга зохиолын онол-туурвил зүй. Уб., 2000

**ОЮУ ЧИХТ ХАН ХӨВГҮҮНИЙ ТУУЖ ОРШИВ
ЗОХИОЛЫН ЭХ СУРВАЛЖУУД**

А. Мөнхцэцэг*

XVII-XVIII зууны үед бурхны шашны дахин дэлгэрэлтийн үе нь бурхны шашин суртахууны зохиол ихээр нэвтэрсний зэрэгцээ Энэтхэг, Түвд, Монгол “номт гурван улс”-ын түүх, шашин, уран зохиолын харилцан нөлөөллийг тодорхой харуулсан түүхэн хөгжлийн үе хэмээн үздэг.

Тухайн үеийн уран зохиолын хөгжил үүслийн тухай академич Д.Цэрэнсодном “энэ үеийн хүүрнэл зохиол нь гол төлөв Энэтхэг, Түвдийн үлгэр домгийн шинж чанартай зохиолуудыг зохиомжлон орчуулсан буюу түүнээс сэдэвлэн монгол ахуй нөхцөлдөө нийцүүлэн найруулан зохиосон шинжтэй”¹ хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг.

Энэхүү илтгэлийн гол зорилго нь баруун монгол болон халхын зарим нутгаар бичмэл болон аман хэлбэрээр дэлгэрсэн “Оюу чихт хан хөвгүүний тууж оршив” хэмээх нэгэн зохиолыг Монголын уран зохиолын дурсгал хэмээн үзэх үндэслэлийг гаргахыг зорьж байна. Энэхүү үндэслэлээ дараах хоёр чиглэлээр буюу

1. Хойт эх дагавар хүүхдийн сэдэвт зохиолын үндсэн чиг шугамыг баримталж, тэдгээр адил төстэй зохиолуудаас нэгэн зохиолыг онцлон харьцуулж,

2. XIV зууны үеийн Энэтхэгийн Сажав Сономжалцангийн “Тэгээн толь” зохиол дахь Нүдээр үзэгч бодьсадвагийн хойт төрлийн нэгэн цадигийн утга агуулгыг харьцуулан үндэслэлийг тайлбарлах болно.

1. Оюу чихт хан хөвгүүний тууж оршив зохиолын сэдэв, зохиомжийн эх сурвалж

Энэтхэг, Түвдийн уран зохиолууд хийгээд тэдгээрээс сэдэвлэн зохиомжлон найруулсан хувилбар шинжтэй зохиолууд монгол хэлээр нилээн өргөн хүрээнд дэлгэрсэн байдгаас хойт эх-дагавар хүүхдийн хоорондын зөрчил тэмцлийг дүрсэлсэн *Бигармижид хааны гурван намтар*², *Арташид хан хөвгүүний цадиг*, *Эндүүрэл хааны тууж* зэрэг зохиолууд нь XVII-XVIII зууны үеийн монголын уран зохиолын түүхэнд зохих байр сууриа нэгэнт эзэлсэн байдаг. Дээр дурдсан зохиолууд нь өөр өөрийн өвөрмөц онцлогоор нэг нь нөгөөгөөсөө ялгаатайгаас гадна нэг нэгэндээ ууссан зохиолууд байдаг.

Дээрхи агуулга хүрээнд багтсан нэгэн зохиол бол зохион найруулагч хийгээд зохиогдсон он цаг нь тодорхойгүй Нүдээр үзэгч бодьсадва нь Энэтхэгийн төв дундад орны Малаяагийн ой³ н нэгэн улст Оюу чихт хан хөвгүүн болон төрөөд тэр орны Үнэхээр төрөлхт сайн хаан эцэг хийгээд хамаг амьтныг шулмасын зовлонгоос салгасан тухай өгүүлдэг 4 бүлэг бүхий томоохон тууж бүхий тод-монгол үсгээрхи *Оюу чихт хан хөвгүүний тууж оршив*⁴ болон *Үнэхээр төрөлхт сайн хааны тууж оршив*⁵ гэсэн зохиол

* МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын докторант

¹Д. Цэрэнсодном, 2008: 63

²Шидэт хүүрийн үлгэрийн Түвдийн 13 бүлэгт “Шидэт хүүрийн үлгэр”-ийн “Нарны гэрэл ах дүү хоёр”-ын 5-р бүлэг, 35 бүлэгт Монгол Шидэт хүүрийн үлгэрийн “Аваргасан хааныг хөөсөн” 8-р бүлэг”, Кэсэнэ хааны туужийн 31-р хэсэг “Кэсэнэ хаан Нага мангасыг сургасан” болон “Монгол Бигармижид хааны намтар” буюу Арж Борж хааны туужийн *Бигармижид Оюу чихт хан хөвгүүний* 14-р бүлэг

³“Тансан ламын баруун этгээдэд зорчсон тэмдэглэл” дэх “Малаяагийн уулын зүүн тал” гэсэн нь Боталака уул юм. Уулын орой дээр толь мэт тусах цэнгэг устэй нэгэн нуур бий. Нуурын хажуугаар Дэвагийн хадан гэр буй бөгөөд тэнд эрхин Нүдээр үзэгч (Авалокитешвара) залран суусан байна. ... Энэ уулнаас зүүн хойт зүгт явахад далайн захад нэгэн хот байдаг бөгөөд эндээс Шанхалагийн орон болон өмнөд далай эхэлдэг. Шанхалагийн оронд очиход зүүн хойт зүгт 3000 ли буюу ойролцоогоор 1500 км явна.” гэжээ. (А. М. орчуулга.) Hüan-tsang Si Yu Ki: Buddhist Records of the Western World. Vol.2. Translates by Samuel Beal, 230-234 тал.

⁴ОЧХХ. Х1.; Х. Лувсанбалдан, 1975.; Г. Гэрэлмаа, 2005.; Д. Ганболд, 2005.

⁵ҮТХХТ. Х2.; ҮТХХТ. Х2. ; Б. Тунгалаг, 2006.

байдаг. Энэхүү зохиол нь хойт эх-дагавар хүүхдийн эсрэг тэсрэг тэмцлийн тухай өгүүлдэг сэдэв, зохиомжийн хувьд ижил төстэй бусад зохиолуудтай харьцуулан үзвэл сонирхолтой зүйлс их ажиглагддаг. Энэхүү зохиол нь бурхны шашны энэрэн нигүүлсэхүйн эрхин Нүдээр үзэгч бодьсатва⁶ Оюу чихт хан хөвгүүнд төрөл аван Албинга нэрт шулмасыг дарсан тухай цадиг бөгөөд энэ хорвоод төрүүлж өсгөсөн эцэг эхийн ачийг хариулах сургаалыг номлосон шашны болоод иргэний шинжтэй уран зохиол юм.

Ер нь хойт эх дагавар хүүхдийн сэдэвт зохиолуудын үндсэн үйл явдал ерөнхий нэг гинжин шугамын дагуу зохиогдсон байдаг. Тэр нь

- Хааны хатан нас барж, хаан дахин шинэ хатан авна.
- Хатан өмнөх хатны хүүхдэд атаархан тэднийг үгүй хийхийн тулд хуурамчаар өвдөж, хүүхдийн элэг, зүрх (хэл, бөөр)-ийг идэх гэнэ.
- Хүүхдүүдэд сайн санаатан туслаж, тэднийг хол газарт явуулна.
- Хүүхдүүд замдаа өлсч ундаасаад ахмад нь дүүгээ аврах гэж байх үедээ санамсаргүй байдлаар хоёр хүүхэд сална.
- Дүү нь ганцаар тэнэн явсаар нэгэн улст очиж тэр орны хаан болно.
- Хоёр хүүхэд дахин уулзаж хамтдаа амьдарна.
- Дүү нь нутагтаа буцан ирж, шулмасын хорыг дарж эцэг хийгээд ард олноо аварна.

Оюу чихт хан хөвгүүний тууж зохиолтой үйл явдал хийгээд зохиомжийн талаар хамгийн төстэй байгаа нэг зохиол нь “Богд Бигармижид хааны тэргүүн дэвтэр” гэсэн гарчигтай “Монгол Арж Борж хааны намтар” хэмээх зохиолын “Хэлбэр хаан шулмаст баясч, охин нуган хоёр хүүхэд хол газар тэнэсний эцэст шулмасыг дарсан” 14-р бүлэг юм.⁷

1.1. Бидний судалгааны хүрээнд авч үзэж байгаа дээрхи хоёр зохиол зохиомжийн талаараа бусад ижил сэдэв бүхий зохиолуудыг бодвол илүү төстэй дүрслэл, зохиомжууд байдаг⁸. Үүнд:

- Зохиолын үйл явдлын баатар нь эгч, дүү хоёр
- Хатны өнгө зүс буурч (их ад орхиж), хүндээр өвдөнө.
- Хамаг олон 3 он (сар) болтол их гасланд нэрвэгдэнэ.
- Өмнөх хатныг хорлосон шулмас үзэсгэлэнт охины дүрд хувирч хааны хатан болно.
- Хааны их түшмэл хаан хийгээд ард олныг гашуугаа тайлахыг зөвлөнө.
- Их түшмэл охиныг шинжин үзээд, сэтгэлд тааламжгүй мэдрэмж төрнө.
- Хаан үзэсгэлэнт охиныг хараад дурлаж, бүх зүйлээ умартана.
- Хаан хоёр хүүхдээ алуулахаар хиа (яргачин) нараа илгээнэ.
- Ер бусын зүйл болж, хүүхдийг алахаар ирсэн хүнийг зэмлэнэ.
- Оюу чихт хаан хөвүүн шулмасыг дарж, эцгийгээ аврахаар явна.
- ⁹Урьдын сайн санаат их түшмэлтэй уулзаж, нутаг орны байдлыг мэдэж авна.
- Шулмасыг алж, их гал асаалгаж, шатааж ална.

1.2. Түүнээс гадна уг хоёр зохиолыг төстэй болгож байгаа нэгэн зүйл нь үйл явдлыг давтаагүй боловч ерөнхий утгыг нь алдагдуулалгүйгээр харин өөр үйл явдлаар солин найруулсан, зохиолын үйл явдлын далд агуулгыг дэлгэрүүлэн тодорхой болгон өгүүлсэн эсвэл тухайн санааг өөр хэсэгт найруулан оруулсан хэсгүүд нилээдгүй байдаг.

⁶(*Skt.* Avalokiteśvara; *Tib.* Sphyan ras gzigs)

⁷МУЗТ. II, 1977: 306-323.

⁸А. Мөнхцэцэг, 2014.

⁹Оюу чихт хан хөвгүүний туужид түшмэл хоёр хүүхдийг зүүн зүгийн Шанхалагийн оронд явах зам зааж өгч гаргаж өгдөг бол Бигармижидийн дурдсан бүлэгт цагаа загас болон аварга могой хоёр хүүхдийг аварч хол газарт явахыг зөвлөдөг бөгөөд Оюу чихтийн туужид бурхны шашны нөлөө ихээр туссан байдаг бөөл Бигармижидийн бүлэгт домог үлгэрийн шинжтэй зохиомжууд олон байдаг нь уг хоёр зохиолын гол ялгаа юм.

- Хальсгүй нэгэн их цагаан загас болон хадны завсраас хүрэн эрээн аварга могой гарч ирж хоёр хүүхдэд туслана.

- Шулам хатнаас зугтан явж байхдаа дүү нь өлсөн ундаассан цагт эгч нь ус хайсан ч олсонгүй. Нэгэн морины шинэ баасан байдал байхыг эгч нь амаараа шимж шүүсийг нь хоёр алгаа дүүргээд дүүдээ өгье гээд авна.

- Дүү нь мөн эгчийгээ хайн явсаар нэгэн улст очиж, үр удамгүй тэр хаант улсын эзэн сууна, эгч нь дүүгээ хайн явсаар тэр улст ирэхэд нь эгчийгээ таньж, эгч дүү хоёр уулзана.

- Үр удамгүй хаант улсын дараачийн хааныг ард олноос сонгохоор нэгэн их ухаант зааны хамарт рашаан дүүрсэн алтан хумхыг уяж тэр рашааныг өгсөн хүнд хаан ширээг өгөхөөд болоход заан хөндий модонд рашаантай бумбыг 3 удаа тавьснаар тэр модны хөндийд суугаа хүүг олж хаан болгоно.

- Оюу чихт хаан болсны хойно өдөр бүр давхар байшингийн дээр сандал тавьж зүг зүгт эгчийгээ харж сууж байтал нэгэн өдөр эгч нь ирнэ.

- Эгчийг үзвээс, өмссөн дээл нь бие лугаа наалдаад, малгай нь үс лугаа ширэлдээд, бөөс хуурс дүүрэн цуглажээ.

- Их түшмэл нэгэн их ууттай унгас өгнө.

1.3. Дурдсан хоёр зохиолыг өөр хооронд нь ялгаатай болгож байгаа буюу бие даасан хоёр өөр зохиол болгож байгаа зохиомж нь:

- Шулам хатны бараа бологч “уршигт эм” хоёр хүүхдийг алаагүй хэмээн ховлоно.

- Оюу чихтийн очсон тэр хаант улсын эзэн нь үр хүүхэдгүй тул хааны түшмэл сайдууд нь хэлэлцээд, “ухаант зааны хамарт рашаан дүүргэсэн хумхыг уяад” сайн язгуурт хэн хүн дээр тавибал тэр нь хаан болно гэж зөвлөлдсөн ба тэр заан хөндий хонгил модны дээр гурван удаа аваачсанд тэр модны дотор суугаа хүүг үзээд хаан орны эзэн болгоно.

- Гаслангаас нөгчсөн эх нь Диваажингаас ирнэ.

- Арван зүгийн бурхан бодьсатва нар ирж, нигүүлсэхүйн гараа хөвүүний тэргүүнд тавихад огторгуйд нэг хар өчүүхэн үүл тулан тулснаар Дүрст орны тэнгэр нэрийн охин хөвүүн ирж, найман үе төгссөн рашааны ус оруулснаар нуурмалаг ус тогтсонд эгч нь дүүдээ өгнө.

- Үзэсгэлэнт охины дүрд хувирсан шулмасын тухай тодорхой болгосон байна. Албинга хааны үхэрчийн охиныг юүтгэн өөрөө биенд нь юүдэн үзэсгэлэнт охинд хувирна.

- Шанхалын орны эзэн Цог төгссөн цагаан хутагтын гэгээн бэлгэ билгийн нүдээр харж, эрхин Нүдээр үзэгч бодьсатваг мэднэ.

- Оюу чихт хан хөвүүн 19 нас хүрсэн цагтаа харшийн дээр гараад өөрийн нутаг орныг билгийн нүдээр харна.

- Хөвүүнийг харвал гуйранчийн байдалтай боловч Сайваар одсоны зүрхний хөвүүнд үзнэ.

- Сэтгэлийн чимэг хоёр уут морины эмээлд уяж өгнө. Хүү нутагтаа ирээд тэр уутанд байгаа захиаг уншина.

ялгаатай болгож байгаа буюу бие даасан

- Оюу чихт хан хөвүүн шулмасын “баад дарагдан” ухаан сэхээгүй байгаа хаан эцгээсээ шулмасыг устгах зарлиг хүсэхдээ эцгийг титмийг хаанд үүсгэсэн түүнийг өөрийн тэргүүнд өмсч хааны зөвшөөрлийг авч байгаа малгайг хүндлэх бэлгэдлийн аргыг ашигласан болон,

- Оюу чихт хан хөвүүн Шанхалын орны эзний дүү Сэтгэлийн чимэг хэмээх үзэсгэлэнт охинтой гэрлэж, Эрдэнэ авхай

цэцэг Саналын чимэг хэмээх хөвүүний гэргий болно. зэрэг үйл явдлыг дурдаж болно.

Оюу чихт хан хөвгүүний шулмасыг алж, өөрийн эцэг хийгээд ард иргэдээ аван, Шанхалын улс руу дүрвэн явдаг.

Дээрхи хоёр зохиолын сэдэв зохиомжийн маш ойролцоо төстэй байдлаас үзвэл Оюу чихт хан хөвгүүний тууж зохиол нь Бигармижид хааны намтар зохиолын 14-р бүлгийн сэдэв, үйл явдал, зохиомжинд тулгуурлан зохиогджээ гэж үзэх үндэслэл байгаа юм.

2. Оюу чихт хан хөвгүүний тууж оршив зохиолын шашны утга агуулгын эх сурвалж¹⁰

Ойрадын Зая бандида Намхайжамц (1599-1662)-ын тууж *Сарны гэрэл*¹¹ зохиол дахь Заябандида хийгээд түүний шавь нарын орчуулсан бүтээлүүдийн жагсаалтанд XIV зууны үеийн Түвдийн Сажав Содномжалцан (1312-1375)-гийн зохиосон *Gegeen toli*¹² хэмээх зохиол багтсан байдаг.

Уг зохиолд Энэтхэг, Хятад, Монгол, Түвдийн номын хаадын түүх хийгээд бурхны шашны энэрэн нигүүлсэхүйн эрхин Нүдээр үзэгчийн “Хязгаар хөшүүн Цаст орон¹³”-ыг гурван цагийн мянган бурхны өмнө өөрийн “номхтголын орон”¹⁴ хэмээн ам гарч, тэр орны хамаг амьтныг номонд оруулсан тухай зэргийг өгүүлдэг Нүдээр үзэгч бодьсатвагийн хойт төрлийн цадиг зэрэг багтсан байдаг.

Энэхүү *Гэгээн толь* зохиолын орчуулгын хэл найруулга нь Оюу чихт хан хөвгүүний тууж зохиолын хэл найруулгатай төстэй байдгаас гадна, зарим нэгэн үг хэллэг болоод цогц санаанууд ч төстэй байдаг.

“Хязгаар номхтгох хийгээд бас номхтгох сүм хийгээд их Зуу хийгээд бага Зуу нугуудыг сайтар босгосон” 14-р бүлэгт Хятад төрхөт Ногоон дара¹⁵ Цастын орныг үзээд “эм мангас гэдрэг хэвтсэн дүртэйд мэдэн, Сүн далай үүнийг эм мангасын зүрхний цусанд мэдэн, гурван уулыг зүрхний ясанд мэдэн, энэ газар эм мангасын зүрхэн дээр тогтсонд мэдэн тэр шулмас эмийн орныг бурхны сүм барих газар болгосон”¹⁶ тухай өгүүлдэг хэсэг бөгөөд Оюу чихт хан хөвгүүний тууж зохиолд дээр өгүүлсэн хэсэгтэй яг адилхан дүрслэл байдаг нь “Оюу чихт хан хөвгүүн өөрийн эцгийг аварч Албинга нэрт таван хорт сэтгэлт шулмас хатныг алаад, “арьсыг өвчин тэлж их алтан дэлхийд хувилган, махы нь цогцлоон Сүмэр уул болгон, цусы нь дөрвөн их далай”¹⁷ болгодог бөгөөд “Урьд Үнэхээр төрөлхт хааны баясгалангийн ой цэцэрлэг өдгөө мангар шумну эмийн хорт амь таслагч тэрсийн орны нүгэлт цэцэрлэг”¹⁸ болсон тухай өгүүлдэг юм.

¹⁰ А. Мөнхцэцэг, *Оюу чихт хан хөвгүүний тууж зохиолын зохиогчийн тухай* Acta Mongolica 2013. Vol.14 (400): 162-167.

¹¹ Ratnabhadra (Ratnabhadra) *Rabjamba Cay-a bandita Saran-u gerel oruṣibai*. 1959, 1967.

¹² ГТО. X1. УҮННСанд байгаа уг зохиолын төгсгөлийн үгэнд Сойвон Сайн эрдэнэ (Раднаабадраа) орчуулав гэснээс үзвэл энэхүү зохиолыг бүтээсэн хүн мөн болох нь харагдаж байна. А. Мөнхцэцэг, 2013.; Энэхүү зохиолыг XV зууны үед Сажа Дондов тойны орчуулсан монгол бичгийн хувилбар зохиол бас байдаг тухай доктор Л. Хүрэлбаатар, 1995: 49-69 бичсэн байдаг.

¹³ Одоогийн Түвд улс.

¹⁴ Нүдээр үзэгч эрхт тэр, Хязгаар хөшүүн орон тэр ч миний номхтголго болтугай. Би чөтгөр, мангас тэргүүтэн тэд бүгдийн эцэг эх мэт болтугай ...Гурван цагийн бурханд сүслэн дуршихуй Хамаг түүнчлэн бологсод зарлиг болсон хамаг ном Хязгаар хөшүүн орон тэнд өргөжин дэлгэрэн өнөд орших болтугай. Амьтан тэд дээд гурван эрдэнийн нэр сонсоод итгэл явуулснаар Өндөр язгуурт амгалант амьтны бие олон дээд ном эдлэх болтугай. Би аль алинаар номхтгосон амьтан нугууд боловсрон гэтлэн, Хязгаар хөшүүн тэр ч Эрдэнийн тив мэт болтугай. Тэд бүгд ямагт болох болтугай хэмээх ерөөл тавив. Нүдээр үзэгчийн номхтгохуй орон болсон учир шалтгаан тэр ч мөн. ГТО. X1., 16a14-16b68

¹⁵ Гагц тэнгэр тэр ертөнцөөс ялангуяа гарсан улбар ногоон, амнаас хөх удбалын үнэр анхилан, ухааны хамаг шастирт эрхшил олсон ... Хятад төрхөт Ногоон дара (*Chin. Wengcheng Gōngzhū*) мөн. ГТО. X1., 34б: 17-23.; Ch. Bawden, 2004: 3-4.

¹⁶ ГТО. X1.: 71a30-71b66.

¹⁷ ОЧХХ X1.: 9367.

¹⁸ ОЧХХ X1.: 11.

Дээр иш татсан жишээнээс үзвэл, Хязгаар хөшүүн Цастын тэр орон нь урьд Үнэхээр төрөлхт сайн хаан шулам хатантай нөхцсөнөөр “Шулмасын нүгэлт цэцэрлэг” болсон тэр Малаяагийн жаргалант ой байж болох юм.

Эндээс үзвэл, Оюу чихт хан хөвгүүний тууж зохиолын агуулга нь Нүдээр үзэгч бодьсатвагийн “урьдны ерөөлийн хүчин”-ээр “Цастын орны номхтголын эзэн болох” хожмын шалтгаан болох юм.

Өөрөөр хэлбэл, Нүдээр үзэгч бодьсатва Түвдийн орныг өөрийн ивээлд авах болсон гол шалтгаан нь урьд төрөлдөө Үнэхээр төрөлхт сайн хааны Оюу чихт хан хөвүүн болон төрөөд, өөрийн эцгийн орныг “Шулмасын нүгэлт цэцэрлэг”-т хувилгасан тэр дараах төрөлдөө Шударга төлгөн номын хаан¹⁹ болж ирээд, тэр орны хамаг амьтныг номхтгох буяныг үйлдсэн Номын их хаан болсныг тодруулсан тайлал зохиол болсон хэмээн үзэх үндэслэл байна хэмээн үзэж байна.

ABSTRACT

From the Buddhist expansion in the 17th century, India, Tibet, and Mongolia became connected through literature as they influenced each other in that regard. One such example is a text known as ‘The legend of Prince *Gyü čiketü*’ whose main topic, composition, and story line is inspired by Buddhist doctrine of filial piety. A comparative study of this Mongol text reveals similarities with the following Indian and Tibetan texts.

1. A Mongol version of the Indian legend about King Vicrāmadya, (*Boγda Biγarmijid qayan-u terigün debter*) in its Volume 1, section 14 that reads: ‘The tale of the vampire wife is the 13th chapter of the Mongol collection of tales concerning king Vikramaditya and his throne, *Bigarmijid*’, translated by and was published in Bawden, C. R. 1960. *Tales of King Vikramaditya and the Thirty-two Wooden Men*. New Delhi. 155-162, no. 13. The text portrays King Vicrāmadya as *Gyü čiketü* (prince Turquoise-ears) who defeated the devil and inspired by the main topic in literature, the young prince goes to live with his step-mother.

2. In a rich blend of history, legend, poetry, adventure and romance, Sakyapa Sonam Gyaltzen (1312-1375)’s *Clear Mirror on Royal Genealogy* (edited by Ratnabhadra who was the ‘latest disciple’ of the Oirat-Mongolian master Zayapandita, Nammkha’i Rgya-mtsho) tells the story of the Buddhist bodhisattva Avalokiteśvara (*Tib.* Sphyan ras gzigs) ‘from whose heart rose a ray of light that reached Tibet and entered the womb of king’s consort. After nine months had passed and when the tenth month had begun, an especially sublime son was born. And he therefore became known as Songtsen Gampo (*Tib.* Srong-btsan-sGam-po). Accordingly, during the reign of the Tibetan Dharma King, Green Tara (*Chin.* Wengcheng Gōngzhǔ) who was skilled in astrology predicted that a sleeping female devil will rise in that land and her statue will be erect in the temple. Inspired by the above mentioned literature, ‘the rising of a sleeping female devil’ spread as literary topic in Tibet according to which “I perceive that this Land of Snow, the kingdom of Tibet, is it in the form of an ogress lying upon her back. I perceive that the lake at Otang, the Plain of Milk, is the ogress’s heart-blood and that the three mountains are the bones

¹⁹ (*Tib.*) Srong-btsan-sGam-po, Түвдийн хаан. Нүдээр үзэгч бодьсатвагийн зүрхнээс цацарсан гэрэл Түвдийн их оронд одон, Цаст Түвдийн хамаг орой гэрлээр дэлгэрүүлэн үйлдэн, Түвдийн Шударга хаан (*Tib. gNam-ri srong-btsan*, Түвдийн 32 дахь хаан.)-ы хатан ‘bri төрхөт Цагаан гавалт (Driza Tokarma)-ын умайд орон, 9 сар аравны нүүр болоход, нэгэн хөвүүн гал эм үхэр жилд гэгээн хувиран, ...хутагт Нүдээр үзэгч урьдны ерөөлийн хүчинд шүтэж, ... эгэл олон амьтан нугуудын үзэгдэлд хаанд адилтгал тэнгэлээс хагацсан гайхамшигтай нэгэн хөвүүн болсонд, ... олон эрдэм лүгээ төгссөн түшмэл нугууд өгүүлэв. Маньг тэтгэгч эзэн энэ олон эрдэм лүгээ төгссөн, сэтгэл маш төлгөн хэмээсэнд, нэр ч Шударга төлгөн хэмээн алдаршив. ГТО. XI., 34630-3567.

of heart. As this lake is directly above the ogress's heart, it will be necessary to fill in with soil and build a shrine upon it.”

Similar to this literary motive, the legend of the beautiful prince *Gyü čiketü* tells the story of this prince's previous life where he conquered the land of his father defeating a female devil queen.

Ном зүй.

1. *Artasiddhi qayan köbegün-ü čadig*. (Монгол бичгээр.)
2. Ch. Bawden *Mongolian Traditonal Literature: An Anthology*. London. 2004.
3. “The tale of the vampire wife is the 13th chapter of the Mongol collection of tales concerning king Vikramaditya and his throne, *Bigarmijid*”, translated by and was published in Bawden, C. R. 1960. *Tales of King Vikramaditya and the Thirty-two Wooden Men*. New Delhi. 155-162, no. 13. <http://members.home.nl/marcmarti/yugur/folktale/tale16b.htm>.
4. А. П. Бенингсен, *Легенды и сказки Центральной Азии*. Санкт Петербург 1912. #30. Сказка обь Онохорь-Турлектэ хане 57-68 стр.
5. *Boγda Biγarmijid qayan-u terigün debter* (Монгол бичгээр). УҮННСанд 1639. 179-199 тал.
6. *Оюу чихт хан хөвгүүний тууж тэргүүтэн монголын сонгодог уран зохиолын хэдэн дурсгал*. Эрхэлсэн Д. Ганболд. Уб., 2005.
7. *Gegeēn toli orošiboi* /ГТХ1/ (Тод үсгээр). УҮННСанд 8409/96 294.3.Г-897.
8. *Gegeēn toli orošiboi* /ГТХ2/ (Монгол бичгээр). УҮННСанд 8434/96.294.Г-897.
9. Г.Гэрэлмаа, *Хэл зохиолын хүрээлэнд хадгалагдаж буй тод номын товч бүртгэл*. Уб., 2005.
10. Лувсанбалдан, Х. *Тод үсэг, түүний дурсгалууд*. Уб., 1975.
11. *Монголын уран зохиолын тойм II*, ред. Ц. Дамдинсүрэн, Уб., 1977.
12. А. Мөнхцэцэг, *Оюу чихт хан хөвгүүний тууж зохиолын зохиогчийн тухай* Acta Mongolica 2013. Vol.14 (400): 162-1676
13. А. Мөнхцэцэг, *XVII зууны үеэс Монголд дэлгэрсэн хойт эх-дагавар хүүхдийн сэдэвт зохиолуудын харьцуулалт*. (Хэвлэлтэнд.)
14. *Оуи čikitü хаān köböini toiji orošiboi* /ОЧХХ, X1/ (Тод үсгээр). ХИС. ТоБ №95.
15. *Rabjamba Say-a bandita-yin tuuji saran-u gerel kemekü ene metü bolai* (Монгол бичгээр). CSM. T-V, Fasc.2. Уб., 1959.
16. Sakyapa Sonam Gyaltsen *The Clear Mirror*. Translated by. McComas Taylor and Lama Choedak Yuthor. New-York, 1996.
17. Тунгалаг, Б. *МУҮНС дахь тод бичгийн судрын гарчиг*. II. Уб., 2006.
18. *Ünekeēr törölkitü sayin хаāni toiji orušibui.* / X2. (Тод үсгээр.) УҮННСан 8308/96 401.
19. *Üneker törülkitü sayin qayan-u tuuji orušibui.* / X3. (Монгол бичгээр.) УҮННС 7963/96 89 v-856.
20. Л. Хүрэлбаатар, “XV-XVI зууны үеийн орчуулгын зохиол” *Монгол орчуулгын товчоон (Сонгодог орчуулгын зарчим, уран чадварын асуудал)*. Уб., 1995.; *Тод бичиг болон Зая бандида Намхайжамц судлалын асуудал* Bibliotheca Oiratica-XIII. Уб., 2009: 95-105.
21. Цэрэнсодном, Д. “XVII-XVIII зууны үеийн уран зохиол” *Монголын уран зохиолын судлалын шинэ хандлага*. Уб., 2008.

**Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН “ГОЛОГДСОН ХҮҮХЭН”
ТУУЖИЙН ДҮРИЙН ШИНЭЧЛЭЛ**

Д.Галбаатар*, Г.Батсуурь**

Ардын уран зохиолч Ц.Дамдинсүрэнгийн “Гологдсон хүүхэн” тууж монголын шинэ үеийн уран зохиолын уран сайхны анхны тууж юм. Үүнээс өмнө 1922 онд Ц.Дамбадоржийн “Толбо нуур” нэрт нэг бүтээл гарсан нь шинэ үеийн тууж бичлэгийн түүхэнд шинэ хуудас нээжээ. Ц.Дамбадоржийн “Толбо нуур” тууж түүхэн бодит үйл явдлаас сэдэвлэсэн баримтат зохиол юм.

Харин Ц.Дамдинсүрэнгийн “Гологдсон хүүхэн” тууж бол уран сайхны тууж. Уг бүтээлийн талаар “Ц.Дамдинсүрэн анхны зохиолуудаа «Рашааны дусал» зэрэг Энэтхэг үлгэрээс сэдэвлэн сургаалын маягаар бичсэн бол «Гологдсон хүүхэн» туужаа хувьсгалт шинэ орны амьдралаас үндэслэн зохиожээ”¹ гэсэн нь мөн туужийн уран сайхны талыг тодорхойлсон дүгнэлт бол, “«Гологдсон хүүхэн» тууж нь тухайн цаг үеийн бодит байдлыг үзүүлж, хөдөлмөрчин ардын дүрийг бүтээсэн... том хэлбэрийн ... дорвитой зохиол юм”², мөн “*«Хувьсгалын соёлыг яруугаар найруулж, харанхуй мунхгийн сэжиг, балар хоосон үзэл хийгээд дарлах дарлагдах суртал ба байдал лугаа тэмцэе» гэсэн үндсэн зорилгоор бичсэн “Гологдсон хүүхэн” хэмээх туужид ядуу зүдүү амьдралтай эгэл олон шинэ гэрэл гэгээт замд давшиж байгаа төвөг ээдрээтэй замыг харуулсан юм*”³ зэргээр дүгнэсэн байна. Оросын монголч эрдэмтэн Л.К.Герасимович “«Гологдсон хүүхэн»... эгэл жирийн хүн ардыг хувьсгалт ухамсраар хүмүүжүүлэхэд идэвхтэй үүрэг гүйцэтгэсэн юм. Ц.Дамдинсүрэнгийн ертөнцийг үзэх хувьсгалт үзэл түүнээс хувьсгалт тэмцлийн практиктай нягт холбоотой байсан явдал нь уг туужийн үзэл санааны үндсэн чиглэлийг тодорхойлж байна”⁴ зэргээр гол төлөв улс төр-үзэл суртлын талаас нь анхаарч иржээ.

“Гологдсон хүүхэн” 1929 оны 5-р сарын 1-нд⁵ анх хэвлэгдсэн тухай зохиолч: “**1929 оны нэгдүгээр сарын 9-нд уран зохиолчдын бүлгэмийг анх байгуулахад элсэн орж тэргүүлэгчээр нь сонгогдсон ба мөн бүлгэмийн даалгавраар “Гологдсон хүүхэн” гэдэг анхны туужаа бичиж хэвлүүлсэн**”⁶ зэрэг түүхэн үндэс хийгээд зохиол бичигдсэн нөхцөл байдлын талаар олон эрдэмтэд нарийвчлан судалжээ. 1929 он буюу Зохиолчдын бүлгэм байгуулагдах үеийн монгол уран зохиолын шинэ төлвийг үзэхэд МААЗ-ын уламжлал, бичгийн зохиолын уламжлалт төрөл зүйлүүд зонхилж асан ба орчин цагийн уран зохиол эх сууриа дөнгөж тавьж асан үе байв. Тодруулбал: аман зохиолын төрөл зүйлс: үлгэр, домог, хууч яриа, баатарлаг туульс, ардын дуу, оньсого таавар, зүйр цэцэн үг, ертөнцийн гурав зэрэг, бичгийн зохиолд голдуу сургаал зохиол (Оюунтүлхүүр, “Чингисийн билэг”, “Авах гээхийн дөрвөн мөрт” гм), тууж (“Гэсэр”, “Шар тууж”, “Эндүүрэл хааны тууж”, “Нарангэрэл дагины тууж” гм), намтар зохиол (Нэйж тойн... зэрэг), Энэтхэг- Төвдийн уламжлал бүхий бичгийн зохиолуудын (монгол “Ганжуур”, “Данжуур”, “Үлгэрийн далай”, “Таван сургамж”, “Эрдэнийн сан Субашид” гэх мэт) уламжлал голлож байв. Өөрөөр хэлбэл XX зууны 1930-аад оны үе хүртэл монгол уран зохиол дундад зууны үеийн уран зохиолын чиг хандлагаас ангижраагүй шахам байв.

* МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын /Sc.D/ профессор

** МУИС-ийн ШУС-ХУС-ын докторант

¹ С.Лувсанвандан, Г.Жамсранжав, С.Дашдэндэв (1968) “Ц.Дамдинсүрэнгийн уран бүтээл” Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх. УБ. хуудас 155

² С.Лувсанвандан, Г.Жамсранжав, С.Дашдэндэв (1968) “Ц.Дамдинсүрэнгийн уран бүтээл” Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх. УБ. хуудас 159

³ Д.Цэдэв(2008)“Ц.Дамдинсүрэнгийн зохиол бүтээлүүд”Эмхэтгэж редакторласан Л.Хүрэлбаатар Академич Цэндийн Дамдинсүрэн. дурсгалын түүвэр. УБ. хуудас 148-149

⁴ Л.К.Герасимович (1965) Литература Монгольской Народной Республики (1921-1964 годов)МЛГУ, стр 92

⁵ С.Лувсанвандан, Д.Цэдэв, Ц.Мөнх, Ч.Билигсайхан, Д.Дашдорж (1985) “Тэмдэглэлт үйл явдлын жагсаалт” Монголын орчин үеийн уран зохиолын түүх. УБ. хуудас 431

⁶ Д.Цэдэв (1998) “Өөрийн намтар” Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. хуудас 20

Ардын аман зохиолын төрөл зүйлүүд дүрслэлийн хувьд сайн муу, сайхан муухай гэх хоёр туйлд хуваагдсан шинжтэй бөгөөд уран зохиолын дүрслэгдэхүүн талаас үзэхүл уран зохиолын төв байрыг хүн эзлэхээс өмнө үед хамаарах юм. Дараах үед уран зохиолын дүрслэлийн төв рүү хүн орж ирсэн хэдий ч эртний бичгийн зохиолууд ба дундад зууны бичгийн зохиолуудад хэн нэгэн хүчирхэг баатар эр, эзэн хаан эсвэл ер бусын хүччадал, ид шидтэй, хувилгаан чанарт дүрүүд дүрслэгдсэн аж. Монгол уран зохиолын түүхээс үзвэл эгэл хүний дүр уран зохиолын Төв байрт гарч ирэх хүртэл багагүй хугацааг зарцуулсан ба манай уран зохиолын тухайд ХХ зууны 30-аад он хүртэл эгэл жирийн хүний дүр уран зохиолд жинхэнэ утгаараа дүрслэгдээгүй байсан гэж үзэж болно. Тодруулбал: ардын үлгэрт шагайгаар нь шар эсгий цувсан, борвиор нь бор эсгий цувсан, хамуутай хар даагатай нусгай бор хүү дүрслэгдэх ба гэнэтийн тохиолдлоор мөнөөх өнчин хүү хосгүй хүч чадал, эрдэм чадал төгс төгөлдөр бүрдсэн баатар эр болон хувирч арван таван толгойт атгаалжин хар мангасыг дарж, ард олноо амар жимэр жаргуулснаар төгсдөг загвартай байв.

Бичгийн уран зохиолд ч эл уламжлал удтал хадгалагдан оршсоор асан агаад хэн нэгэн баатар сайн эр, хосгүй ухаан билэг төгс, эсвэл харгис хааны тухай өгүүлэмж зонхилж байв. Ойрын жишээ нь Их эзэн богд Чингис хааны дүрийг туульсын баатрын дүрд хувилган дүрсэлж ирсэн нь нэн түгээмэл. Үүнийг “Аргасун Хорчийн домог”-ын эгэл бүхэн утга учрыг тайлж эс чадах далд санааг Чингис хаан төвөггүй тайлах, “Чингисийн есөн өрлөгтэй өнчин хөвгүүний цэцэлсэн шаштир”-ын Чингис хаан бүхний учир начрыг нарийн ялган хэлэхээс, “Чингисийн эр хоёр загалын тууж”-ийн Чингис хаан мэргэнээр зүүдсэлсэн зэргээс үзэж болно. Эл уламжлал 1930-аад оны үеийг хүртэл хадгалагджээ. Монгол шинэ уран зохиолын анхны тууж гэдэг Ц.Дамбадоржийн 1922 онд бичсэн “Толбо нуур”-ын гол дүрд нь Хасбаатар, Байкалов, Абмад (Дамбадорж) нарын бодит түүхэн, хувьсгалч дайчин хүмүүс байна. Үйл явдал нь Ховдын хязгаар Саруул гүний хүрээнээ өрнөх ба цагаантанд бүслэгдэн 42 хоног идэх хоолгүй зовж, хэрхэн золоор амь мултарсан тухай өгүүлдэг. Туужийн дүрүүд туульсын сүүл үеийн элементүүдийг агуулсан бөгөөд үйл явдал нь туурьлаг шинжтэй аж. Туурь, амьдралд тэр бүр тохиолддоггүй ер бус сонин үйл явдалд шүтсэн онцлогтойг *“...Өгүүллэгтэй харьцуулбал хурц зөрчил, хураангуй өгүүлэмж, үйл явдлын эргэлт бүхий уран /санаанд оромгүй эсрэг байдалд/ тайллаар ялгардаг богино хэмжээний хүүрнэл зохиолыг туурь гэнэ”*⁷ тодорхойлолтоос харж болох юм. Уг төрөл зүйл уран зохиолын түүхийн нэлээд эрт үед их дэлгэрч асан нь дундад зууны сүүл сэргэн мандалтын эхэн үеийн Италийн зохиолч Ж.Боккаччогийн арван өдрийн туурь буюу “Декамерон” хэмээх алдарт бүтээлийн жишээнээс харагддаг. Ингэхээр Ц.Дамбадоржийн “Толбо нуур” туужид түүхэн бодит хүмүүс, мөн болсон үйл явдлыг дүрсэлсний хувьд баримтат зохиол, дүрслэл өгүүлэмжийн хувьд туульсын ба туурийн уламжлалтай, жирийн хүмүүсийн дүрээс илүүгээр удирдагч баатруудын дүр голлон дүрслэгдсэн дундад зууны уламжлал нь давамгайлсан шинжтэй зохиол юм.

Гэтэл уг бүтээлээс 7 оны хойно бичсэн Ц.Дамдинсүрэнгийн “Гологдсон хүүхэн”⁸ туужийн гол дүрүүд: Цэрэн, Долингор, Мятаг, баян Болд, Дэжид, Ловон лам, хоньчин хүү Дамдин, түүний эх, хүү Данзан, Лувсан гэлэн, түшмэл На, Хуяг тайж, Цэрэнгийн нөхөр буюу “Хөсрий илүүр” хочит Буян цугаар эгэл жирийн хүмүүсийн дүр юм. Цэрэн хүүхний намтар гэдэх эл тууж өгүүлэмжийн хувьд ардын үлгэрийн уламжлалтай. Үлгэрийн гол баатар анхандаа их зовлон бэрхийг туулж аз жаргалд хүрдгийн адил Цэрэн хүүхэн ч төрмөгцөө гологдож, ад үзэгдэн, нас биед хүрмэгцээ “Хөсрий илүүр” Буянд богтлогдож хэдэн оныг зарагдан өнгөрүүлж, эцэст оргон зайлж, бичиг номд суралцан, ирсэн сайн цагийн авралаар эцэгтэйгээ уулзаж аз жаргалд хүрсэн сюжет нь үлгэрийн бодот уламжлал юм. Хэдий өгүүлэмж нь үлгэрийн уламжлалтай ч дүрслэл нь бодит амьдралаас үүтгэлтэй агаад эгэл хүмүүс дүрслэгдсэний хувьд шинэ цагийн реалист уран зохиолын үндэс суурийг үнэхээр тавьсан бүтээл юм.

Зохиолын гол дүр Цэрэнг *“...Жич мэргэн зурхайчаас даруй үхнэ гээд нэг ч амьтан хэрэглэхгүй байсан Цэрэн, төрснөөс хойш эцэг эхээ нэг ч айлгасангүй найм есөн нас хүрчээ. Энэ охиныг харин Болдын эхнэр гар хөлийн үзүүрт зарах сайн зарц болгон, зун бол хурга тугал хариулгаж, халуун наранд хатаана...”*⁹ гэх зэргээр бага насыг нь дүрсэлж, нас биед хүрсэн үеийг: *“...1923 он болоход Мятагийн хүүхэн Цэрэн 18 нас хүрч ухаан сэргэлэн, өнгө зүс сайтай, бичиг үсэг муухан төсөөлөх болсон ажээ...”*¹⁰ гэсэн нь цугаар эгэл хүний дүр, явдал бөгөөд ямар нэг үлгэрчилсэн хэтрүүлэггүй тухайн үеийн нийгмийн эгэл нэг гишүүний төлөөлөл дүр болжээ. Долингорыг *“...Энэ хүн бол гучаад настай, махлаг хөх царайтай, толгойд хир болсон хөх цууямбуу зангиджээ...”*, *“...50-аад нас хүртэл насан туршаар зовсон Долоодойн хоёрдугаар баяр нь энэ билээ. Долоодой Мятагийг мэнд сайн сууж байгаа гэхийг сонсож, эдүгээ хүүхэнтэйгээ уулзсанаар үл барам, Мятагтай бас уулзах болно гэж...”*¹¹ зэргээр дүрсэлсэн буй. Зохиолын эсрэг дүр баян Болдыг аман зохиолын эсрэг дүрийг дүрсэлдэг шиг хэт муухайчлан харуулаагүй байгаа нь сонирхол татна. Тухайлбал: *“...Баян Болдын нас нь дөчөөд, толгой нь халзан, гэдэс нь бүдүүн, сахал нь битүү, нүд нь улбар, зан*

⁷ Д.Галбаатар. (2012) “Туурь” Уран зохиолын нэвтэрхий толь. УБ. хуудас 362

⁸ Ц.Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” Д.Цэдэв. (1998) Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. хуудас 6-38

⁹ Ц.Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” Д.Цэдэв. (1998) Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. хуудас 15

¹⁰ Ц.Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” Д.Цэдэв. (1998) Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. хуудас 32

¹¹ Ц.Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” Д.Цэдэв. (1998) Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. хуудас 38

*нь төв боловч заль нь их бололтой. Чисчүүнээс дээш хувцас үл эдлэх бөгөөд сайн хувцасгүй...*¹² гэсэн хэсэг анхаарал татна. Манай уран зохиолд сүүлдээ баян хүнийг ихээхэн гоё ганган, юу ч хийдэггүй залхуу, идэмхий уумхай байдлаар харуулах хандлага их дэлгэрчээ. Уг дүрийн уламжлалыг хөгжүүлсэн өөр нэг дүр нь Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романы баян Итгэлтийн дүр. Зохиолч Ц.Дамдинсүрэн Болдын дүрийг хэдий баян ч өмсөж эдлэхдээ гар татуу, зальтай байдлаар үзүүлсэн нь амьдралд ойрхон төдийгүй дүрийг хэт зохиомол байдлаар дүрсэлдэг дундад зууны үеийн дүрслэлийн уламжлалаас холдож, шинэ үеийн монгол уран зохиолын дүрийн санг шинэ дүр баяжуулжээ. Мөн зохиолын цаг хугацааг ч их тодорхойгоор “...1918 оны цагаан сар болж...”¹³ гэх ба “...1923 он болоход...”¹⁴ зэргээр бичсэн нь зохиолын үйл явдал, амьдрал байдлыг бодитой, үнэмшилтэй болгосон юм. Бодитчилох хандлагатай ч бас уран сайхны дүр дүрслэлийг орхигдуулалгүй “...Байдалд зохист намар цаг, сэтгэлд зохист яруу газар, Бэлэн далай хэмээх зөөлөн говь нутагт...”¹⁵ гэх байгалийн зураглал, баян Болд ба эхнэрийг: “...Түүний эхнэр Дэжид нас 40 хэр, ааш зан хурдан, үг хэл ширүүн, санаа сэтгэл сайнгүй, эд юманд харамч...”¹⁶ зэргээр дүрсэлсэн хөрөг дүрүүд хийгээд бусад олон дүрслэлээс харж болно.

Өнөөгийн уран зохиолын төвд зөвхөн хүн байраа олжээ. Энэ байр сууринд гурван замыг туулсан бөгөөд эртний туульсын зохиолд бурхан тэнгэрүүд төв байрнаа дэвшиж дүрслэгдэх ба хүн тэрхүү бурхан тэнгэрийн хайр хишгийг хүртэгч эсвэл гэсгээл цээрлэлийг хүлээгч маягаар дүрслэгдэж ирсэн буй. Хөгжлийн дараагийн шатанд хүн-байгаль, хүн-амьтны завсрын шинжтэй дүрүүд уран зохиолд дүрслэгдэж ирсэн бөгөөд хүний нийгэм хөгжихийн хэрээр урлаг уран зохиолын хөгжил улам бүр нарийсч нийгмийн амьдрал, хүний аж төрөл, тэдгээрийн учир зүй, холбоо хамаарал уруу гүнзгийрэн орж эдүгээгийн төлөв хандлага бий болж хүн уран зохиолын төв байрыг эзэлсэн билээ. Дундад зууны үеийн уран зохиолд ихэвчлэн баатар сайн эрс, хүчирхэг хаад ноёд, хувилгаан лам хутагтуудын дүр зонхилж ирсэн ба эгэл жирийн хүн, манай уран зохиолын хувьд гэвэл жирийн малчин ардын дүр уран зохиолын төв байранд дүрслэгдэх хүртлээ нэлээд урт удаан хугацааг туулж XX зууны 30-аад оныг хүрчээ.

Тийн явсаар эгэл жирийн хүн уран зохиолын төв байранд жинхэнэ утгаараа дүрслэгдсэн нь Ц.Дамдинсүрэнгийн “Гологдсон хүүхэн” туужийн баримт болж байна. Хэдийгээр “Гологдсон хүүхэн” тууж нь зарим алдаа дутагдалтай 1975 онд зохиолчийн өөрийнх нь дүгнэсэнчлэн “олон дутагдалтай анхны оролдлого зохиол”¹⁷ боловч дундад зууны үеийн уран зохиолын уламжлал болох туульс дүрслэлийн уламжлалыг даван гарч эгэл жирийн ардын дүрийг уран зохиолын төв байранд оруулж ирснээрээ цоо шинэ бүтээл болж чадсан билээ. Энэ нь уг туужийн хувьсгалт шинэ үзэл санааг илэрхийлсэн, хуучин нийгмийн гишүүдийг шүүмжилсэн, анхны уран сайхны тууж гэдгээс илүү нийт монголын уран зохиолын түүхийг алхам урагшлуулсан дэлхий нийтийн уран зохиолын чиг хандлагад өөрийн үндэстний уран зохиолыг нийцүүлсэн томоохон шинэчлэл хийсэн бүтээл гэж дүгнэх боломжтой юм.

Ном зүй

1. Батсуурь.Г. (2010) Удиртгал. УБ.
2. Батсуурь.Г. (2012) Ц.Дамдинсүрэнгийн яруу найргийн аман зохиолын уламжлал. УБ.
3. Гаадамба.Ш. (1989) Утга зохиолын онолын үндэс. УБ.
4. Галбаатар.Д. (2009) Монголын уран зохиолын онол түүхийн зангилаа асуудлууд. УБ.
5. Галбаатар.Д. (2012) Уран зохиолын нэвтэрхий толь. УБ.
6. Герасимович.Л.Г.(1965) Литература Монгольской Народной Республики (1921-1964 годов) МЛУ
7. Лувсанвандан.С. Жамсранжав.Г. Дашдэндэв.С.(1968) Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх. УБ.
8. Хүрэлбаатар.Л.(2008) Академич Цэндийн Дамдинсүрэн. дурсгалын түүвэр. УБ.
9. Цэдэв.Д. (1998) Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. 1-р дэвтэр. УБ.
10. Цэдэв.Д.(1998) Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. 2-р дэвтэр. УБ.
11. Лувсанвандан.С. Цэдэв.Д. Мөнх.Ц. Билигсайхан.Ч. Дашдорж.Д. (1985) Монголын орчин үеийн уран зохиолын түүх. УБ.
12. Пүрэвжав.Э.(2008) Их эрдэмтэн академич Цэндийн Дамдинсүрэн. УБ.
13. Энхбаяр.С. (2011) Утга зохиолын онол.УБ.

¹² Ц.Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” Д.Цэдэв. (1998) Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. хуудас 8

¹³ Ц.Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” Д.Цэдэв. (1998) Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. хуудас 19

¹⁴ Ц.Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” Д.Цэдэв. (1998) Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. хуудас 32

¹⁵ Ц.Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” Д.Цэдэв. (1998) Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. хуудас 6

¹⁶ Ц.Дамдинсүрэн “Гологдсон хүүхэн” Д.Цэдэв. (1998) Цэндийн Дамдинсүрэн Бүрэн зохиол. УБ. хуудас 6-7

¹⁷ Э.Пүрэвжав (2008) “Үргэлжилсэн үгийн зохиол” Их эрдэмтэн академич Цэндийн Дамдинсүрэн. УБ. хуудас 67

Товъёг

Ж.Бат-Ирээдүй	ИХ БРИТАНИЙН НЭРТ МОНГОЛ СУДЛААЧ, АКАДЕМИЧ ЧАРЛЬЗ БАУДЕНЫ АМЬДРАЛ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН ТУХАЙ	5
Л.Чулуунбаатар	Ч.БАУДЕНЫ МОНГОЛ-АНГЛИ ТОЛЬ БИЧГИЙН ТУХАЙ	9
ТҮҮХ СОЁЛ, НИЙГЭМ		
Л.Баасандорж	“МОНГОЛ НУУЦ ТОВЧОО” ДАХЬ ЗАРИМ АСУУДЛЫГ ДАХИН СУДАЛЖ АВЧ ҮЗЭХ НЬ	13
Ч.Золзаяа	THE METAPHORICAL CONCEPTUALIZATION OF EMOTIONS IN THE SECRET HISTORY OF THE MONGOLS	33
Kunio Minato	MONGOLIAN TOLERANCE AND INTOLERANCE TOWARD DIFFERENT CULTURES: AN EXPLORATION BASED ON ANALYSES OF CROSS-NATIONAL SURVEY DATA	41
Тамира	НЭГЭН ХУВЬ МОНГОЛ ТҮҮХЭН СУРВАЛЖААС БААРИН БАРУУН ХОШУУН ДАХИ МАНЖ МОНГОЛЫН УРАГ ХОЛБООГ ХАРАХ НЬ	47
Maria Magdolna Tatár	TAM, THE DRINK OF MÖNGKE KHAN	53
Sarolta Tatár	THE PECHENEG SETTLEMENT ALONG HUNGARY’S NORTHWESTERN FRONTIER	57
Б.Мөнхцэцэг	ТУВА БӨӨГИЙН БӨӨ БОЛГОХ ЁС	67
Б.Бөхчулуу	ХОТЖИЛОЛТЫН ЯВЦ ДАХИ ӨВӨРМОНГОЛЧУУДЫН БАЯР ЁСЛОЛЫН ХУВИРАЛТ <i>/Хотын Монголчуудын Гал тахилгын ёслолын жишээн дээр/</i>	71
Krisztina Teleki	THE OLD JAMBAL’S ACCOUNT ABOUT CERTAIN ARTIFACTS PRESERVED IN URGA	79
А.Орхонсэлэнгэ	RESPONSE OF MONGOLIAN NOMADS TO CLIMATE CHANGE DURING THE PAST 800 YEARS: STOCHASTIC PROXIES FOR RECONSTRUCTION	85
Д.Баасанбат, Мехмет Саглам	МОНГОЛ ЗҮЙР ЦЭЦЭН ҮГЭЭР “ЭМЭГТЭЙ” ХҮНИЙ ЭЕРЭГ ҮНЭЛЭМЖИЙГ ИЛЭРХИЙЛЭХ ОНЦЛОГ	89
Kim Ki-Sun Lee Jong-Oh	THE STUDY OF HOUSING-RELATED TABOOS IN KOREA AND MONGOLIA	93
Л.Хэрлэн	ХӨӨМЭЙ ХАМ ШИНЖИТ УРЛАГ БОЛОХ НЬ	101
Ж.Дэлгэрмаа	НҮҮДЭЛЧИД БА ЗАХ ЗЭЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ	105

ХЭЛШИНЖЛЭЛ, ЭХ БИЧИГ СУДЛАЛ

<i>Ц.Отгонсүрэн</i>	ХАРЬЦАА ЗААСАН НЭГЖ ӨГҮҮЛБЭРИЙН ГИШҮҮДИЙГ ХУРААХ ХЭРЭГЛҮҮР БОЛОХ НЬ	111
Б.Мөнгөнцэцэг	МОНГОЛ ХЭЛНИЙ ХЭЛЦЭД “ТЭНЭГ” ХЭМЭЭХ УТГЫГ ИЛЭРХИЙЛЭХ НЬ	123
С.Булгантамир	ЭГШИГ АВИАГ ТУРШИЛТ АВИАЗҮЙН АРГААР СУДЛАХ НЬ	129
Д.Энхжаргал	ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ ҮГҮЙСГЭХ ӨГҮҮЛБЭР ТӨЛӨӨЛӨХ ХЭЛБЭР БҮЮУ “PRO-FORM”-ООР ИЛРЭХ НЬ	133
Naoki UETA	PITCH PATTERNS OF MONGOLIAN COMPOUND PLACE NAMES	139
М.Энхжаргал	МОНГОЛ ХЭЛНИЙ –Ч ДЭД БҮТЭЭВРИЙН ОНЦЛОГ, НАЙРУУЛГЫН ҮҮРЭГ	145
Yu Wonsoo	DOCUMENTATION OF ALTAIC LANGUAGES BY KOREAN SCHOLARS	151
А.Мөнхцэцэг	OBSERVATION ON THE TRANSCRIPTION OF THE CLEAR MONGOL SCRIPT'S LONG VOWELS	165
С.Мөөмөө	Э.РАВДАН “ХЭРЭГЛЭЭНИЙ ХЭЛ ШИНЖЛЭЛ” (ХЭЛ СУРАХУЙН ОНОЛ) (УЛААНБААТАР, 2013, 244 ТАЛ)	171
Johannes Reckel	CHANGES OF THE USE OF THE OIRAT SCRIPT IN SINKIANG (XINJIANG) BETWEEN 1950 AND TODAY	175
Б.Түвшинжаргал	THE ANALYSIS OF ERROR IN THE USEGE OF THE COMPLEMENT QUANTITY IN CHINESE AMONG MONGOLIAN STUDENTS	177
<i>Н.Наранбуян</i>	ХЯТАД МОНГОЛ ХЭЛНИЙ ХАР БОЛОН ЦАГААН <i>ӨНГӨНИЙ БЭЛГЭДЭЛ</i>	191
Ж.Бат-Ирээдүй	ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛЫН УРАН ЗОХИОЛ ДАХ ГАЗАР УСНЫ НЭРИЙН СУДАЛГААНЫ АСУУДАЛД	197

УТГА ЗОХИОЛ

Р.Бигэрмаа	МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН ЯРУУ НАЙРГИЙН ШИНЭТГЭЛ ШИНЖ	181
Р.Алтансайхан	Д.НОРОВЫН “ТЭЖЭЭВЭР” ТУУЖИЙН ДҮРИЙН СЭТГЭЛЗҮЙ	209
Д.Батжаргал, Э.Амарзаяа	С.НАДМИДЫН “ХҮЙТЭН СЭТГЭЛ”-ИЙН ХАЛУУН ҮЙЛ ЯВДАЛ	213
Д.Галбаатар,		

Г.Нарантунгалаг	“ЯРИА” ЗОХИОЛЫН ДҮР, ДҮРСЛЭЛИЙН ОНЦЛОГ	217
Г.Галбаяр	МОНГОЛ ШҮЛЭГ СУДЛАЛЫН ӨНГӨРСӨН ХИЙГЭЭД ИРЭЭДҮЙ	221
А.Мөнхцэцэг	ОЮУ ЧИХТ ХАН ХӨВГҮҮНИЙ ТУУЖ ОРШИВ ЗОХИОЛЫН ЭХ СУРВАЛЖУУД	227
Д.Галбаатар, Г.Батсуурь	Ц.ДАМДИНСҮРЭНГИЙН “ГОЛОГДСОН ХҮҮХЭН” ТУУЖИЙН ДҮРИЙН ШИНЭЧЛЭЛ	233